

# МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ ТҮҮВЭР СУДАЛГАА-2006

*Мөнгөний Бодлого Судалгааны Газар*

## **1. Оршил**

Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар МУИС-ийн Социологийн тэнхимтэй хамтран Монгол Улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтийн дунд 2006 онд санал асуулга явуулж, өмнөх оны мөн үеэс хэр өөрчлөгдсөнийг харьцуулан дүн шинжилгээ хийснээ та бүхэнд толилуулж байна. Энэхүү судалгааны ажлаар өмнөх онуудын суурь дээр тулгуурлан иргэдийн санал бодол өнгөрсөн оныхоос хэр өөрчлөгдсөнийг харуулсны зэрэгцээ судалгаанд оролцсон иргэдийг оршин суугаа газар, нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлаар нь ангилан тус бүрээр нь тайлбар хийлээ. Мөн энэхүү судалгаагаар мөнгөн дэвсгэртүүдийн талаар иргэдийн санаа бодлыг тусгасан нэг бүлэг нэмлээ.

2006 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар мөнгөний нийлүүлэлтийн (M2) хэмжээ 1,497.8 тэрбум төгрөг; хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн түвшин оны эхнээс 5.9 хувь, жилийн инфляци 1.8 хувь, банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн өрийн үлдэгдэл 1,107.7 орчим тэрбум төгрөг, нийт хадгаламжийн хэмжээ 1,172.8 тэрбум төгрөг, нэгдсэн төсөв 163.9 тэрбум төгрөгийн ашигтай, улсын гадаад цэвэр албан нөөц 435.5 сая америк доллар, гадаад худалдааны алдагдал 4.8 сая америк доллар байна.

Олон улсын статистикийн лавлахууд дээр гарсан тоон үзүүлэлтүүдээс харахад: хамгийн сүүлийн мэдээгээр Монгол улсын хүн амын 36.3 хувь нь ядуурлын түвшинд (Human development report 2005, UNDP), хүний ядуурлын индексээр авч үзвэл дэлхийн улсуудын 44-т, нийгмийн орлогын (баялаг) 69.7 хувь нь тэгш бус хуваарилагддаг, хүн амын 27.0 хувь нь өдрийн 1.0 америк доллароос доогуур орлоготой (Key indicators 2005, ADB), Хүний хөгжлийн түвшинг харуулсан индекс 2003 оны байдлаар 0.679 буюу дэлхийн улсуудын 114-т (Human development report 2005, UNDP), 2005-2004 онд хүн амын өсөлт 1.2 хувь, 2005 оны эцсийн байдлаар хөдөлмөрийн насны хүн амыг хүйсээр нь ангилж үзвэл эрэгтэйчүүдийн 64.8 хувь, эмэгтэйчүүдийн 62.2 хувь нь эдийн засгийн идэвхтэй байдалд, 2005 оны улсын нэгдсэн төсвийн орлого 837.9 тэрбум төгрөгт хүрч урсгал зардалд 600.3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 89.8 тэрбум төгрөг, цэвэр зээлд 74.5 тэрбум төгрөг зарцуулж 73.3 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Шилжилтийн эдийн засагтай бусад орнуудын зарим үзүүлэлтийг манай улсын үзүүлэлттэй харьцуулан Хүснэгт 1-ээр харуулав. Манай улс шилжилтийн эдийн засагтай орнуудын дунд ядуурлын түвшингөөр 11-т, орлогын хувиарлалтыг харуулдаг Gini индексийн үзүүлэлтээр 10-т, хүний хөгжлийн индексээр 17-д, нэг хүнд ногдох гадаад өрийн хэмжээгээрээ 10-т, Атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох үндэсний нийт орлогоор 21-т жагсаж байна. Хүснэгт 1-д үзүүлсэн бусад үзүүлэлтийн хувьд манай улс дундаж үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 1. Шилжилтийн эдийн засагтай орнуудын зарим үзүүлэлтүүд /2004 он/\***

Үзүүлэлтүүд	Монгол	Армени	Азербайжан	Беларус	Босни	Болгар	Хорват	Чех	Эстони	Гүрж	Унгар	Казакстан	Киргиз
Хүн ам /сая/	2.5	3.0	8.3	9.8	3.9	7.8	4.4	10.2	1.3	4.5	10.1	15.0	5.1
Хүн амын өсөлт /хувиар/	1.4	-0.4	0.9	-0.5	-0.2	-0.8	0.0	0.1	-0.3	-1.0	-0.2	0.6	1.1
Хотын хүн ам /нийт хүн амын хувь/	56.9	64.3	50.0	71.3	44.9	70.2	59.4	74.4	69.6	51.7	65.5	55.9	33.9
Газар нутгийн хэмжээ /мянган хавтгай дөрвөлжин км./	1,567	30	87	208	51	111	57	79	45	70	93	2,725	200
Ядуурлын түвшин /хүн амын хувь/	36	51	49	42	20	13	-	-	9	55	17	35	48
Gini индекс	30.3	37.9	36.5	30.4	26.2	31.9	29.0	25.4	37.2	36.9	26.9	32.3	34.8
Хүний хөгжлийн индекс	0.68	0.76	0.73	0.79	0.79	0.81	0.84	0.87	0.85	0.73	0.86	0.76	0.70
Нэг хүнд ногдох өрийн хэмжээ /ам. доллар/	603.2	404.5	239.1	378.4	819.1	2,017.9	7,101.6	4,459.7	7,419.0	460.8	6,248.9	2,154.9	412.3
Гадаадын шууд хөрөнгө оруулалт /цэвэр/	93	219	3,556	169	613	2,005	1,243	4,454	1,049	499	4,608	4,104	77
Санхүүгийн хөрөнгө оруулалт	0	1	0	1	0	0	177	738	176	0	1,491	-14	0
Тусламж /техникийн туслалцааг хасаад/	72	62	59	21	277	393	63	243	120	138	254	24	51
Нийт өр/экспорт	106.6	92.3	44.2	23.5	66.8	109.3	161.9	57.4	108.3	106.9	92.6	140.0	185.4
Нийт өр/ҮНО	94.7	39.2	25.4	16.2	36.5	66.1	94.1	44.9	95.1	39.3	66.8	85.1	99.3
Нийт зээлийн үйлчилгээ/экспорт	2.9	8.0	5.2	2.1	3.7	17.1	27.2	10.5	15.7	11.2	25.2	38.0	14.2
Валютын нөөц/гадаад өр	16.5	47.0	54.9	22.5	75.2	59.6	27.8	62.4	17.9	18.4	25.3	28.7	26.9
ДНБ /тэрбум ам. доллар/	1.6	3.1	8.5	23.0	8.5	24.0	34.0	107.0	11.0	5.2	101.0	41.0	2.2
ДНБ жилийн өсөлт /хувиар/	10.7	7.0	10.2	11.0	6.2	5.6	3.8	4.4	7.8	6.2	4.6	9.4	7.1
ДНБ дефлятор /жилийн өсөлт, хувиар/	18.1	0.6	6.4	21.8	2.9	4.2	3.3	3.0	3.1	9.6	4.6	9.8	4.8
Бараа, үйлчилгээний экспорт /ДНБ-ний хувь/	75	39	50	68	26	58	47	72	78	31	64	55	43
Бараа, үйлчилгээний импорт /ДНБ-ний хувь/	87	53	74	74	55	69	56	72	86	47	68	46	53
Нийт хөрөнгө оруулалт /ДНБ-ний хувь/	37	20	54	28	21	24	30	28	31	29	24	24	14
Төв Засгийн Газрын орлого /ДНБ-ний хувь/	37.9	19.9	-	30.6	41.2	38.2	41.9	32.4	28.0	15.8	37.1	16.0	16.1
Төсвийн ашиг/алдагдал /ДНБ-ний хувь/	-0.5	-0.9	-	-0.2	1.8	1.6	-4.0	-3.3	0.9	0.5	-6.2	0.2	-0.8
Нэг хүнд ногдох ҮНО /Атлас-ын арга, ам. доллар/	600	1,060	940	2,140	2,040	2,750	6,820	9,130	7,080	1,060	8,370	2,250	400

\* Эх үүсвэр: Дэлхийн Банк, НҮБ-ын эмхэтгэлүүд

**Хүснэгт 1. Шилжилтийн эдийн засагтай орнуудын зарим үзүүлэлтүүд /2004 он/\*, үргэлжлэл**

Үзүүлэлтүүд	Латви	Литва	Македони	Молдав	Польш	Румын	ОХУ	Серб	Словак	Таджик	Украин	Узбекстан
Хүн ам /сая/	2.3	3.4	2.0	4.2	38.2	21.7	143.8	8.1	5.4	6.4	47.5	26.2
Хүн амын өсөлт /хувиар/	-0.5	-0.5	0.2	-0.3	0.0	-0.3	-0.5	-0.1	0.1	1.1	-0.8	1.5
Хотын хүн ам /нийт хүн амын хувь/	66.1	66.7	59.6	46.2	62.0	54.7	73.3	52.2	57.7	24.5	67.3	36.5
Газар нутгийн хэмжээ /мянган хавтгай дөрвөлжин км./	65	65	26	34	313	238	17,098	102	49	143	604	447
Ядуурлын түвшин /хүн амын хувь/	-	-	-	49	24	22	31	-	-	-	20	28
Gini индекс	33.6	31.9	28.2	36.9	34.1	30.3	31.0	-	25.8	32.6	29.0	26.8
Хүний хөгжлийн индекс	0.84	0.85	0.80	0.67	-	-	-	-	0.85	0.65	-	-
Нэг хүнд ногдох өрийн хэмжээ /ам. доллар/	5,474.3	2,757.9	1,006.7	442.8	2,597.8	1,385.0	1,371.8	1,949.5	4,100.0	139.3	456.3	191.0
Гадаадын шууд хөрөнгө оруулалт /цэвэр/	699	773	157	81	12,613	5,440	12,479	966	1,122	272	1,715	140
Санхүүгийн хөрөнгө оруулалт	23	8	15	-2	1,913	111	528	0	60	0	-2,204	0
Тусламж /техникийн туслалцааг хасаад/	149	237	141	39	1,424	739	658	737	184	83	159	43
Нийт өр/экспорт	194.7	77.2	87.9	91.4	99.4	109.1	91.7	-	-	60.8	53.7	-
Нийт өр/ҮНО	92.0	43.9	38.5	63.7	41.7	41.8	34.7	67.0	54.2	44.9	33.7	42.0
Нийт зээлийн үйлчилгээ/экспорт	21.1	14.3	10.5	12.1	34.6	17.2	9.8	-	-	6.8	10.7	-
Валютын нөөц/гадаад өр	16.0	37.9	48.5	25.2	37.1	53.6	64.0	-	67.6	19.2	44.0	-
ДНБ /тэрбум ам. доллар/	14	22	5.4	2.6	242	73	581	24	41	2.1	65	12
ДНБ жилийн өсөлт /хувиар/	8.3	6.7	2.9	7.3	5.4	8.3	7.1	8.2	5.5	10.6	12.1	7.7
ДНБ дефлятор /жилийн өсөлт, хувиар/	7.2	3.3	1.5	8.0	2.9	15.8	18.1	8.9	4.6	16.9	15.1	15.0
Бараа, үйлчилгээний экспорт /ДНБ-ний хувь/	44	54	40	51	39	37	35	24	77	46	61	40
Бараа, үйлчилгээний импорт /ДНБ-ний хувь/	60	61	61	82	41	46	22	52	79	65	54	33
Нийт хөрөнгө оруулалт /ДНБ-ний хувь/	33	23	22	25	20	25	21	17	26	9	19	20
Төв Засгийн Газрын орлого /ДНБ-ний хувь/	25.9	28.1	-	28.8	35.0	25.8	27.3	35.8	35.2	13.5	30.7	-
Төсвийн ашиг/алдагдал /ДНБ-ний хувь/	-1.0	-1.6	-	0.4	-3.4	-2.0	5.4	-3.0	-3.3	-6.6	-3.2	-
Нэг хүнд ногдох ҮНО /Атлас-ын арга, ам. доллар/	5,580	5,740	2,420	720	6,100	2,960	3,400	2,680	6,480	280	1,270	450

\* Эх үүсвэр: Дэлхийн Банк, НҮБ-ын эмхэтгэлүүд

Энэхүү судалгааны ажлыг жил бүр тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд үр дүн нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цаг тухай бүртээ танилцуулагдсан билээ. Өмнөх судалгааны ажлаар 2005 оны санал асуулгыг 2003 оны санал асуулгатай, өөрөөр хэлбэл УИХ-ын сонгуулийн өмнөх болон дараахи жилүүдийн санал асуулгыг харьцуулснаараа онцлог байсан. Энэ жилийн судалгааны ажлын хувьд оны эхээр Засгийн газар солигдсон, улс төрийн хувьд тогтворгүй байдал үүссэн, зарим хадгаламж зээлийн хоршоо дампуурч гишүүддээ их хэмжээний хохирол учруулсан, гаалийн газрын удирдах албан тушаалтнууд хээл хахуулийн хэрэгт сэжиглэгдсэн, зарим иргэд газар шорооныхоо төлөө тэмцэл өрнүүлсэн, татварын багц хуулиуд болон гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиудад өөрчлөлт оруулсан, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт шинээр 40 мянган айлын орон сууц барьж байгуулах болон 18-аас доош насны хүүхэд бүрт сар бүр гурван мянган төгрөг, шинээр гэр бүл болох залуу хосуудад нэг удаагийн 500 мянган төгрөгийн тэтгэмж олгох өгөөмөр хөтөлбөрүүд тусгагдсан үед явагдсанаараа онцлог байлаа. Монгол улс зах зээлийн эдийн засагтай ардчилсан нийгэм байгуулах сонголт хийснээс хойш бараг 16 жил өнгөрч, энэ хугацаанд манай улс чамлахааргүй ололт амжилтанд хүрчээ. Ололт амжилтын тухай хангалттай мэдээлэгддэг учир энд манай улсын өмнө тулгарч байгаа зарим бэрхшээл, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг дурдъя. Юуны түрүүн хүн амын ядуурлын түвшин өндөр байна. Ядуурлыг бууруулна гэсэн ажил хөтөлбөр нэмэгдэх тусам ядуурал буурах биш өсөөд байдаг нь манай улсын парадокс болж байна. Дараагийн асуудал бол эдийн засгийн өсөлт тогтворгүй, гадаад хүчин зүйлсээс хүчтэй хамааралтай байсаар байна. Эдийн засаг тогтвортой өсч чадахгүй байгаа нь эргээд иргэдийн орлого тогтвортой өсөх замыг хааж нийгэмд бухимдал үүсгэж байна. Нэгэнт эдийн засагт шинээр бий болж байгаа баялаг тогтвортой өсч чадахгүй байгаа, нийгмийн баялаг тэгш бус хуваариглагдаж байгаа нөхцөлд баян хоосны ялгаа газар авч байна. Дээр нь гадаад өрийн хэмжээ өндөр, эдгээр өр, зээлийн үйлчилгээ төсөвд дарамт учруулах нь ойлгомжтой. Ийм нөхцөлд ямарч бодлого боловсруулагч “манай иргэд эдгээр бэрхшээлтэй асуудлаар юу бодож явдаг, бидний үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байгааг” сонирхох нь мэдээж юм. Ингээд та бүхэнд 2006 оны санал асуулгын дүнг толилуулья.

## **2. Судалгааны ажлын үндсэн зорилт**

### *2.1. Судалгааны ажлын зорилго*

Судалгааны ажлын зорилго нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн ерөнхий байдал, татварын тогтолцоо, банк санхүүгийн салбарын хөгжил, банкны хадгаламж, зээл, бичил санхүү, мөнгөн тэмдэгтийн талаар иргэдийн дунд товч санал асуулга явуулж, нэгтгэн дүгнэж өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад оршино. Түүний зэрэгцээ судалгаанд оролцсон иргэдийг нас, хүйс, харьяалал, боловсрол, ажил эрхлэлтийн байдлаар нь бүлэглэн дүнг тус бүрээр нь нэгтгэн харуулахыг зорьлоо. Санал асуулгын дүнг үндэслэн Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш өнөөг хүртэлх хугацаанд нийгэм эдийн засаг ялангуяа банк санхүүгийн салбарын хөгжлийг дүгнэж цаашдын чиг хандлагыг тодорхойлохыг зорьж байна.

### *2.2. Судалгааны ажлын хамрах хүрээ, хугацаа*

Түүвэр судалгааг манай улсын эдийн засгийн том төвүүд болон орон нутгийн дийлэнхийг хамруулан 2006 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс 6 дугаар сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын бүх дүүргүүд болон Төв,

Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай, Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай, Өвөрхангай, Булган, Орхон, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Увс, Хөвсгөл, Өмнөговь, Дорноговь зэрэг аймгуудад явуулав.<sup>1</sup> Санал асуулгыг тусгай баталсан удирдамжийн дагуу МУИС-ийн социологийн тэнхим, Монголбанк гэсэн 2 багт хуваагдан дээрх хот, аймгуудад хийж гүйцэтгэлээ.

### 2.3. Судалгааны ажлын мэдээллийн сан

Энэ жилийн судалгаанд нийт 6401 иргэд оролцсон нь өнгөрсөн оныхоос 996 хүнээр буюу 18.4 хувиар өссөн байна. Үүний 18.8 хувь нь Улаанбаатар хотын, 5.0 хувь нь Архангай, тус бүр 4.7 хувь нь Төв, Говь-Алтай, Дорноговь, Өмнөговь, тус бүр 4.6 хувь нь Өвөрхангай, Ховд, Хэнтий, Сүхбаатар, тус бүр 4.5 хувь нь Хөвсгөл, Сэлэнгэ, Увс, тус бүр 4.4 хувь нь Баян-Өлгий, Дорнод, 4.3 хувь нь Дархан-Уул, 4.2 хувь нь Завхан, 4.1 хувь нь Эрдэнэт, 4.0 хувь нь Булган аймгуудын оршин суугч нар байв. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан аймгуудаас (Улаанбаатар хотоос бусад) бараг жигд асуулга авч чадсан байна. Түүний зэрэгцээ уламжлал ёсоор аймгийн төвүүдээс гадна зарим сумдаар явж судалгаа явууллаа.<sup>2</sup>

**Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо, хот аймгуудаар**

		Хүн амын тоо, мянган хүн	Хувийн жин	Судалгаанд оролцсон хүн	Хүн амд эзлэх хувийн жин	Судалгаанд эзлэх хувийн жин
1	Улаанбаатар	965.3	37.7%	1205.0	0.12%	18.8%
2	Хөвсгөл	121.7	4.7%	290.0	0.24%	4.5%
3	Өвөрхангай	113.8	4.4%	295.0	0.26%	4.6%
4	Баян-Өлгий	100.0	3.9%	281.0	0.28%	4.4%
5	Сэлэнгэ	99.8	3.9%	286.0	0.29%	4.5%
6	Архангай	93.8	3.7%	322.0	0.34%	5.0%
7	Төв	87.4	3.4%	302.0	0.35%	4.7%
8	Дархан	87.7	3.4%	274.0	0.31%	4.3%
9	Ховд	87.9	3.4%	296.0	0.34%	4.6%
10	Баянхонгор	83.6	3.3%			
11	Увс	80.6	3.1%	291.0	0.36%	4.5%
12	Завхан	80.1	3.1%	270.0	0.34%	4.2%
13	Эрдэнэт	79.0	3.1%	264.0	0.33%	4.1%
14	Дорнод	73.4	2.9%	282.0	0.38%	4.4%
15	Хэнтий	70.8	2.8%	293.0	0.41%	4.6%
16	Говь-Алтай	60.4	2.4%	301.0	0.50%	4.7%
17	Булган	59.9	2.3%	258.0	0.43%	4.0%
18	Сүхбаатар	56.0	2.2%	292.0	0.52%	4.6%
19	Дорноговь	53.3	2.1%	299.0	0.56%	4.7%
20	Дундговь	49.6	1.9%			
21	Өмнөговь	46.1	1.8%	300.0	0.65%	4.7%
22	Говьсүмбэр	12.2	0.5%			
Нийт		2562.4	100.0%	6401.0	0.25%	

<sup>1</sup> 2005 онд Улаанбаатар хот болон Орхон, Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говь-Сүмбэр, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Төв аймгуудад явуулсан.

<sup>2</sup> Үүнд: Архангай аймгийн Тариат, Батцэнгэл, Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Баян-Өлгий аймгийн Толбо, Ховд аймгийн Буянт, Мянгад, Завхан аймгийн Алдархаан, Завхан гол баг, Говь-Алтай аймгийн Тайшир, Жаргалан, Шарга, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Булган аймгийн Орхон, Хишиг-Өндөр, Хэнтий аймгийн Баянхутаг, Бэрх, Мөрөн, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат, Халзан, Дорнод аймгийн Чойбалсан, Сэргэлэн, Баянтүмэн, Увс аймгийн Сагил, Түргэн, Хөвсгөл аймгийн Арбулаг, Хатгал, Алаг-Эрдэнэ, Дорноговь аймгийн Замын-Үүд, Өмнөговь аймгийн 2 сумд орно. Нийт аймгийн төвөөс гадна 32 сумд судалгаанд хамрагджээ.

Хүснэгт 2-оос харахад Монгол улсын нийт хүн амын 0.25 хувь нь түүвэр судалгаанд хамрагдсанаас судалгаанд оролцсон нийт иргэдийн тоонд эзлэх хувиараа Улаанбаатар хот хамгийн их буюу 18.8 хувь, бусад аймгууд 4.0-5.0 хувьтай оролцжээ.

Судалгаанд оролцсон иргэдийн 41.4 хувь нь эрэгтэй, 57.6 хувь нь эмэгтэй байсан нь өнгөрсөн оныхоос эмэгтэйчүүдийн тоо 1.6 нэгжээр өсчээ. Эрэгтэйчүүдийн идэвхи жилээс жилд буурч байна. Насны байдлаар нь авч үзвэл 16.5 хувь нь 25-аас доош, 30.3 хувь нь 25-34, 26.7 хувь нь 35-44, 17.5 хувь нь 45-54, 6.1 хувь нь 55-64, 2.3 хувь нь 65-аас дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна. Үүнээс үзэхэд санал асуулгад 25-44 насны иргэд болон эмэгтэйчүүд идэвхтэй оролцсон байна. Өнгөрсөн оныхоос 25-34 насныхны идэвх (0.9 нэгж) өссөн бол 25-аас доош насных (2.6 нэгж) буурсан байна. Харин бусад насны ангиллын иргэдийн идэвхи өнгөрсөн оны түвшинд байна (Хүснэгт 3).

Боловсролын түвшингээр ангилбал 11.9 хувь нь бүрэн бус дунд, 25.8 хувь нь бүрэн дунд, 16.1 хувь нь тусгай дунд, 45.4 хувь нь дээд боловсролтой байлаа. Дээрхээс харахад дээд болон бүрэн дунд боловсролтой иргэд хамгийн их оролцож санал бодлоо тусгасан байна. Өнгөрсөн онтой харьцуулахад бүрэн бус дунд (0.6 нэгж), бүрэн дунд (4.2 нэгж), тусгай дунд (5.2 нэгж) боловсролтой иргэдийн идэвх суларсан бол дээд (9.2 нэгж) боловсролтой иргэдийн идэвх дээшилсэн байна.

Судалгаанд оролцсон иргэдийн 29.9 хувь нь улсын, 26.3 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 20.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 15.0 хувь нь ажилгүй, 7.1 хувь нь бусад гэсэн ангилалд багтаж 1.1 хувь нь хариулаагүй байна. Улсын болон хувийн байгууллагад ажилладаг иргэд маань илүү идэвхтэй оролцсон нь санал асуулгын дүнгээс харагдаж байна. Хувийн байгууллага, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ажилгүй болон бусад гэсэн ангилалд хамрагдсан иргэдийн хувийн жин өнгөрсөн оныхоос (0.6 нэгж) буурсан бол улсын байгууллагад ажилладаг иргэдийнх бага зэрэг (0.3 нэгж) өсчээ.

**Хүснэгт 3. Судалгаанд оролцсон иргэдийн талаархи мэдээлэл**

		Хүйс		Нас		Боловсрол		Ажил эрхлэлт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хүйс	эр	2651	41.4%						
	эм	3685	57.6%						
Нас	25 доош			1059	16.5%				
	25-34			1939	30.3%				
	35-44			1707	26.7%				
	45-54			1119	17.5%				
	55-64			389	6.1%				
	65 дээш			146	2.3%				
Боловсрол	бүрэн бус дунд					763	11.9%		
	бүрэн дунд					1654	25.8%		
	тусгай дунд					1028	16.1%		
	дээд					2909	45.4%		
Ажил эрхлэлт	улсын							1911	29.9%
	хувийн							1684	26.3%
	ХХЭрхэлдэг							1317	20.6%
	ажилгүй							962	15.0%
	бусад							456	7.1%
Хариулаагүй		65	1.0%	42	0.7%	47	0.7%	71	1.1%
Нийт		6401	100.0%	6401	100.0%	6401	100.0%	6401	100.0%

Нийтэд нь дүгнэж хэлэхэд энэхүү судалгаанд дээд боловсролтой, улсын болон хувийн байгууллагад ажилладаг, 25-45 насны, эмэгтэй иргэд түлхүү оролцсон байна.

#### *2.4. Судалгааны ажлын бүтэц, аргачлал*

Судалгааны ажил нь оршил, үндсэн зорилт, үр дүн, дүгнэлт гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэхээс гадна хавсралт I-VI-г агуулсан болно. Нэгдүгээр хэсэг буюу оршил хэсэгт Монгол улсын нийгэм эдийн засгийн сүүлийн үеийн байдлыг товч дурьдан бусад шилжилтийн эдийг засагтай орнуудтай харьцуулсан, хоёрдугаар хэсэг буюу үндсэн хэсэгт судалгааны ажлын зорилго, хамрах хүрээ, мэдээллийн сан, бүтэц болон аргачлалын талаар дэлгэрэнгүй тайлбарласан, гуравдугаар хэсэг буюу энэ ажлын хамгийн чухал хэсэгт санал асуулгын ерөнхий дүнг нэгтгэн өнгөрсөн онтой харьцуулан дүгнэлээ. Ингэхдээ санал асуулгад тусгагдсан 38 асуултыг утга агуулгаар нь ангилан 8 дэд бүлэг болгож, нийгэм, эдийн засгийн бодит байдалтай харьцуулан асуулт бүрээр дэлгэрэнгүй тайлбар өгөв. Тухайлбал:

1. Эдийн засгийн ерөнхий асуудлууд,
2. Нийгмийн тулгамдсан асуудлууд,
3. Татварын талаар,
4. Банк санхүүгийн салбарын тулгамдсан асуудлууд,
5. Хадгаламж, хуримтлал,
6. Зээлийн талаар,
7. Бичил санхүүгийн талаар,
8. Мөнгөн тэмдэгтийн тухай.

Дөрөвдүгээр хэсэг буюу сүүлийн хэсэгт дээр дурьдсан 8 дэд бүлгийг тус бүрээр нь нэгтгэн дүгнэж, цаашид авах арга хэмжээ, сургамжуудын талаар санал дэвшүүлсэн болно. Хавсралт I-V-д судалгаанд хамрагдсан иргэдийг орон нутгийн харьяалал, нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлаар нь 5 хэсэгт бүлэглэн, бүлэг тус бүрээр нь тайлбарлан дүгнэлээ. Сүүлийн хавсралтанд (VI) иргэдийн хариултыг нэгтгэн хүснэгтэнд тоон үзүүлэлт, болон хувиар хувьчлан тусгав.

Санал асуулгад оролцсон иргэдийн цөөн хувь нь зарим асуултанд хариулаагүй учир асуулт бүр 100 хувийн хариулт авч чадаагүй болно. Мөн зарим асуултууд давхардсан хариулттай байсан учир нийт хариулт нь 100 хувиас илүү гарсан болно.

### **3. Судалгааны ажлын дүн**

Тухайн улсын нийгмийн байдал, эдийн засгийн хөгжлийг тодорхойлдог статистикийн олон үзүүлэлтүүд байдаг. Эдгээрийн дотор дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлт, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ, хэрэглээний барааны үнийн өөрчлөлт (инфляци), гадаад худалдааны тэнцэл, банк санхүүгийн салбарын хөгжлийн тоон үзүүлэлтүүд, үндэсний валютын тогтвортой байдал, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн урсгал, гадаад өр, төсвийн алдагдал болон ажилгүйдэл, ядуурлын түвшин, татварын тогтолцоо зэрэг үзүүлэлтүүд гол үүрэг гүйцэтгэж, тухайн улсын дүр төрхийг харуулдаг байна. Энэ санал асуулга нь манай улсын нийгэм, эдийн засгийн байдал, түүний дотор банк санхүүгийн салбар зах зээлийн системд шилжиж орсноос хойш өнөөг хүртэл хэрхэн өөрчлөгдсөн, одоо ямар байдалд байгааг жирийн иргэдийн зүгээс яаж дүгнэн цэгнэж байгааг харуулахын зэрэгцээ бодит байдалтай (статистикийн тоон үзүүлэлтүүдтэй)

харьцуулан дүгнэхэд чиглэгдсэн юм. Түүний зэрэгцээ иргэдийн санал бодол жилийн дараа хэрхэн өөрчлөгдсөнийг харуулахыг зорьлоо.

### 3.1. Эдийн засгийн ерөнхий асуудлууд


Санал асуулгын ерөнхий асуулт (1.1.) буюу "Монгол улсын эдийн засгийн байдал таны бодлоор ямар байна вэ?" гэсэн асуултанд нийт оролцогчдын 26.0 хувь нь сайжирч байна, 35.9 хувь нь хэвэндээ гэж үзсэн бол 30.0 хувь нь муудаж байна, 8.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Энэ дүнг өнгөрсөн оныхтой харьцуулахад эдийн засгийн байдал сайжирч байна гэсэн үнэлгээ 0.9 нэгжээр өсч, нөгөө талаас муудаж байна гэсэн нь 0.3 нэгжээр буурсан байна. Эдийн засгийн байдал муудсан гэж хариулсан иргэдийн тоо сайжирсан гэсэн хариултаас их байгаа нь анхаарал татаж байна. ҮСГ-ын мэдээгээр ДНБ-ний өсөлт 6.2 хувь байгаа нь чамлахааргүй өндөр өсөлт юм. Хэрвээ энэхүү өсөлтийг тогтвортой хадгалж чадах юм бол 11.2 жилийн дараа эдийн засаг маань хоёр дахин нэмэгдэх боломжтой. Гэвч энэхүү өсөлт иргэдэд төдийлөн мэдрэгдээгүй нь нийгмийн баялгийн тэгш бус хуваарилттай холбоотой байж болзошгүй. Зураг 1-д ДНБ-ний өсөлтийн динамикийг 1990 оноос 2005 он хүртэл үзүүлэв. Зах зээлийн эдийн засагт шилжих эхний жилүүдэд эдийн засаг уналтанд орж ДНБ-ний өсөлт сөрөг байсан бол 1994 оноос эхлэн эдийн засаг сэргэж ДНБ-ний өсөлт эерэг түвшинд тогтворгүй хэлбэлзэж байна. Манай улсын экспортын гол түүхий эд болсон зэс, алтны дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэл манай эдийн засгийн өсөлтийг тодорхойлсон хэвээр байна. Хэдийгээр сүүлийн 11 жилийн турш эдийн засгийн өсөлт эерэг түвшинд, 1990 оноос хойш нийт өсөлтийн нийлбэр 26.0 хувь байгаа ч жилийн дундаж өсөлт 1.6 хувь, сүүлийн 12 жилийн дундаж нь 4.2 хувь байгаа нь зах зээлийн системд шилжин орж буй болон хөгжиж байгаа орнуудын хувьд сул үзүүлэлт юм. 2005 онд ДНБ-ний өсөлт 6.2 хувьтай гарсан нь 2004 оныхоос даруй 4.5 нэгжээр бага байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлт тогтворгүй байгааг харуулж байна.

#### 1.1. Монгол улсын эдийн засгийн байдал таны бодлоор


	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Сайжирч байна	1336	25.1%	1642	26.0%	0.9%
Муудаж байна	1612	30.3%	1896	30.0%	-0.3%
Хэвэндээ	1926	36.2%	2268	35.9%	-0.3%
Мэдэхгүй	442	8.3%	518	8.2%	-0.1%
Нийт	5316	100.0%	6324	100.0%	0.0%
Хариулаагүй	89	1.6%	77	1.2%	-0.4%
Нийт	5281		6401		

ДНБ өсч байгаа хэдий ч өсөлт нь хүн амын өсөлтийг гүйцэхгүй байх тохиолдол байдаг. Иймд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ нь иргэдийн амьжиргааны нэг чухал үзүүлэлт болж өгдөг байна. Уг үзүүлэлтийг Дэлхийн банкны Атласын аргаар тооцож бусад улсуудтай харьцуулалт хийх нь түгээмэл байдаг. Атласын аргаар тооцоолоход шаардлагатай тоо баримт байхгүй байгаа тул Монгол улсын хувьд уг үзүүлэлтийг энгийн аргаар тооцож үзвэл 1990-2005 онуудын дундажаар 406.6 ам. доллар, 2005 оны эцсийн байдлаар 724.4 ам. доллартай тэнцэж байгаа нь хүн амын бодит орлого багатай улсуудын тоонд багтаж байна (Зураг 2). Гэсэн хэдий ч бусад улс орнуудтай харьцуулалт хийхийн тулд эдгээр үзүүлэлтүүдийг худалдан авах чадварын паритетээр засварлах ёстой байдаг. Иймд цаашид нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг Атласын аргаар, худалдан авах чадварын паритетээр засварлаж тогтмол тооцоолж байх шаардлага байна.

**Зураг 1. ДНБ-ний өсөлт, хувиар**



**Зураг 2. Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ, ам. доллар**



ДНБ-ний өсөлт сүүлийн жилүүдэд өсч байгаа, энгийн аргаар тооцсон нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ ч мөн адил дээшилж байгаа хэдий ч санал асуулгад оролцсон иргэдийн зүгээс өнөөгийн эдийн засгийн байдал өнгөрсөн оныхоос бараг өөрчлөгдөөгүй гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Энэ нь манай улсын эдийн засгийн хэмжээ бага, ямар нэг уул уурхайн олборлолт явагдаж эхлэхэд эдийн засгийн өндөр өсөлтийг бий болгодогтой холбоотой болов уу. Ялангуяа уул уурхай мэтийн капитал түлхүү шаарддаг салбарын өсөлт өргөн олныг хамарч, ажлын байр олноор бий болгодоггүй. Харин татварын орлогыг нэмэгдүүлж, улсын төсөвт эерэг нөлөө үзүүлдэг. Иймд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжье гэж их яридаг боловч яг бодит амьдрал дээр хийгдсэн зүйл хангалтгүй байна. Экологийн хувьд цэвэр ДНБ-нийг (Green GDP) тооцох тохиолдолд эдийн засгийн өсөлт нилээд буурч гарах магадлалтай. Монгол улс эрдэс баялгийн хорогдлоороо шилжилтийн эдийн засагтай орнуудыг тэргүүлж байгаа нь (Дэлхийн Банк, "The Little Green Data Book 2006" эмхэтгэл) үүний нэг нотолгоо юм. Ер нь одоогийн эдийн засгийн өсөлтийг алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлт бий болгож байгаа. Энэхүү алт, зэсийн үнийн өсөлтөөр бий болж буй санхүүгийн эх үүсвэрийг урсгал зардалд зарцуулахаас зайлсхийж ирээдүйд үр ашиг авчиргах капиталын хөрөнгө оруулалт хийх, хуримтлал бий болгох шаардлагатай байна. Мөн нэгэнт эдгээр эрдэс баялаг нөхөн сэргээгдэхгүй учир дараа дараагийн үеийнхэнд эдийн засгийг тэтгэх нөөцийн санг цаашид байгуулах нь зүйтэй болов уу.

"Эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?" гэсэн асуултанд (1.2.) судалгаанд оролцогчид нэгээс илүү хариултыг сонгосон бөгөөд нийт хариултын тоо нь 10722 болсон байна.

**1.2. Таны бодлоор эдийн засгийн өсөлтийг хангахын тулд**

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Татвар бууруулах	2357	25.5%	2634	24.6%	-0.9%
ГХО-ыг нэмэгдүүлэх	1094	11.8%	1294	12.1%	0.3%
Зээлийн хүүг багасгах	2292	24.8%	2677	25.0%	0.2%
Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих	2617	28.3%	3013	28.1%	-0.2%
Бизнесменүүдийг дэмжих	717	7.8%	939	8.8%	1.0%
Бусад	167	1.8%	165	1.5%	-0.3%
<b>Нийт</b>	<b>9244</b>	<b>100.0%</b>	<b>10722</b>	<b>100.0%</b>	<b>0.0%</b>



Нийт	-3839 5405	-71.0%	-4321 6401	-67.5%	3.5%
------	---------------	--------	---------------	--------	------

Иргэдийн 28.1 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 25.0 хувь нь зээлийн хүүг багасгах, 24.6 хувь нь татварын хэмжээг бууруулах, 12.1 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, 8.8 хувь нь бизнесменүүддээ урамшуулал хөнгөлөлт үзүүлэх, 1.5 хувь нь бусад хүчин зүйлсээс хамаарч эдийн засаг өснө гэж хариулжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад татварын хэмжээг бууруулах шаардлагатай байна гэж хариулсан иргэдийнх 0.9 нэгжээр буурсан нь татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт хийсэн нь иргэдийн сэтгэл зүйд нөлөөлсөн байж болзошгүй. Харин бизнесменүүддээ урамшуулал хөнгөлөлт үзүүлье гэсэн иргэдийн тоо 1.0 нэгжээр өссөн байна. Энэ асуултанд өмнөх онуудын нэгэн адилаар иргэдийн ихэнх нь үндэсний үйлдвэрээ дэмжиж, зээлийн хүүг бууруулж, татварын ачааллыг багасгавал эдийн засгийн өсөлтийг хангаж чадна гэж үзжээ. Энэ гурван хариулт хоорондоо их уялдаа холбоотой юм. Зээлийн өндөр хүү, татварын дарамт нь үндэсний үйлдвэрлэлийг сэргэхэд сөргөөр нөлөөлсөөр байна. Монголбанкны зүгээс зээлийн хүүний ерөнхий түвшинг байнга анхааралтай ажиглаж тооцоо судалгаа хийж байгаа бөгөөд банкуудын эх үүсвэрийн зардал тодорхой хэмжээгээр буурсан үед зээлийн хүү аяндаа буурна гэсэн хүлээлттэй байна. Мөн инфляцийг 2-3 жилийн туршид жилийн 5-6 хувиас дээшгүй тогтвортой барих тохиолдолд иргэдийн инфляцийн хүлээлт буурна. Монголбанкнаас зээлийн хүүг бууруулах тал дээр банкуудад тогтоож буй заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулснаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, зээлийн тодорхой хэмжээний эх үүсвэрийг бий болгон улмаар зээлийн хүүнд нөлөөлөх, банкуудын заавал байлгах нөөцөнд хүү тооцон урамшуулал олгох, гадаадын хөнгөлттэй зээлийг зуучилж өгөх, Төв банкны үнэт цаасны хэмжээг бууруулж банкуудын эх үүсвэрийг нэмэгдүүлэн хүүнд нөлөөлөх өргөн арга хэмжээг авахаар зэхэж байна. Банкны системийн татан төвлөрүүлсэн хөрөнгө их хэмжээгээр нэмэгдэж буй 2004-2006 онуудад зарим банкуудын хадгаламжийн хүү бага зэрэг буурсан боловч нийт системийн хэмжээгээр дорвитой доошилсонгүй. Энд хадгаламж, зээлийн хоршоо хэт өндөр хадгаламж, зээлийн хүү амлан хүүгийн системийг гажуудуулж байсныг дурьдах нь зүйтэй болов уу. Зээлийн хүү буурахгүй байгаа бас нэг шалтгаан бол банкуудын татан төвлөрүүлсэн нэг төгрөг тутамд Монголбанк заавал байлгах нөөцөд 14 хувийг татдаг, санхүүгийн зохих харьцаануудын шалгуур үзүүлэлтүүдийг хангахын тулд тухайн татан төвлөрүүлсэн хэмжээнд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлага гарна. Иймд банкууд жижиг байгаа нөхцөлд хүү буурах боломж хязгаарлагдмал байгаа юм. Банкууд нэгдэн томорч оновчтой менежмент хийсэн тохиолдолд зээлийн хүү буурах болов уу.

"Манай улсын ямар салбар эдийн засгийн өсөлтөнд их үүрэг гүйцэтгэх вэ?" гэсэн асуултанд (1.3.) судалгаанд оролцсон иргэд мөн нэгээс илүү хариулт өгсөн ба 29.6 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрлэл, 22.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 16.4 хувь нь аялал жуулчлал, 12.8 хувь нь хөдөө аж ахуй, 8.7 хувь нь банк санхүү, 7.9 хувь нь худалдаа үйлчилгээ, 1.8 хувь нь бусад салбар гэж хариулжээ. Уул уурхай, олборлох үйлдвэрлэл салбар эдийн засгийг түргэн хөгжүүлнэ гэсэн хариулт өссөн бол түүнээс бусад салбаруудын хариулт буурчээ. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн салбаруудын өсөлт ямар түвшинд байгаа, ДНБ-ний өсөлтөнд яаж нөлөөлж буйг дараах хэдэн өгүүлбэрээр тайлбарлая. 2005 оны эцсийн байдлаар эдийн засгийн салбаруудын ДНБ-д эзлэх хувийг авч үзвэл: худалдаа, засварлах үйлчилгээ 24.8 хувь, ХАА, ан агнуур, ойн аж ахуй 21.7 хувь, уул уурхай, олборлох үйлдвэрлэл 20.4 хувь, тээвэр, агуулах, холбоо 12.2 хувь, боловсруулах үйлдвэрлэл 4.4 хувь, санхүүгийн үйлчилгээ 3.9 хувь, төрийн

удирдлага, батлан хамгаалах, даатгал 3.3 хувь, боловсрол болон цахилгаан, дулаан, ус 3.1 хувь, барилга 2.3 хувь, эрүүл мэнд, халамж 1.6 хувь, үл хөдлөх хөрөнгө, түрээс 1.3 хувь, зочид буудал, зоогийн газар 1.0 хувь, бусад 0.5 хувийг тус тус эзэлж байна (Хүснэгт 4). Сүүлийн жилүүдэд уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин өсөх хандлагатай байхад боловсруулах салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурах хандлагатай байна. Бусад салбаруудын ДНБ-д эзлэх хувийн жин харьцангуй тогтвортой түвшинд байна.

### 1.3. Таны бодлоор ямар салбар эдийн засгийг түргэн хөгжүүлэх вэ

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Уул уурхай	2182	23.5%	3192	29.6%	6.1%
Боловсруулах	2311	24.9%	2450	22.7%	-2.2%
Хөдөө аж ахуй	1271	13.7%	1383	12.8%	-0.9%
Аялал жуулчлал	1626	17.5%	1767	16.4%	-1.1%
Банк санхүү	912	9.8%	935	8.7%	-1.1%
Худалдаа үйлчилгээ	775	8.4%	847	7.9%	-0.5%
Бусад	194	2.1%	196	1.8%	-0.3%
Нийт	9271	100.0%	10770	100.0%	0.0%
	-3866	-41.7%	-4369	-68.3%	-26.6%
Нийт	5405		6401		

Хүснэгт 4-өөс харахад бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ нь ДНБ-ний хамгийн их буюу 24.8 хувийг эзэлж байгаа бөгөөд санал асуулгад оролцсон иргэдийн 7.9 хувь нь эдийн засгийн өсөлтийг тодорхойлно гэж үзсэн нь 2005 оныхоос бага зэрэг буюу 0.5 нэгжээр буурсан байна. Энэ салбарын өсөлт 2001 оноос 2005 он хүртэл эерэг, өндөр түвшинд, дундаж өсөлт нь 8.8 хувь байгаа бөгөөд тухайн салбар хамгийн том ажил олгогч байдаг билээ. Иргэд маань энэ салбар эдийн засгийн өсөлтөнд багагүй хувь нэмэр оруулна гэж хариулсан хэвээр байна.

ДНБ-ний хамгийн их хувийг эзэлж байсан ХАА-н салбарын үйлдвэрлэл (2005 оны байдлаар худалдааны салбарын дараа хоёрт байгаа) сүүлийн жилүүдэд дорвитой өссөн хэдий ч 2001, 2002 онуудын ган, зуд гэх мэт байгалийн бэрхшээлүүдээс шалтгаалан сүүлийн 5 жилийн дундаж өсөлт нь сөрөг хэвээр байна. Монгол улс бол эртнээс хөдөө аж ахуй эрхэлдэг орон. Иймээс энэ салбарын өсөлтийг дэмжихгүйгээр эдийн засаг маань дорвитой өсөхгүй нь тодорхой. 2005 онд судалгаанд оролцсон иргэдийн 13.7 хувь нь ХАА-н салбар эдийн засгийн өсөлтийг тодорхойлно гэж үзэж байсан бол энэ онд тэр хувь 0.9 нэгжээр буурч 12.8 хувьд хүрчээ. ХАА-н салбарт үзүүлж буй иргэдийн найдвар, итгэл ийнхүү суларсан нь хөдөө орон нутагт амьдралын байдал хүнд хэцүү хэвээр байгаа, сүүлийн жилүүдэд хотжих хөдөлгөөн ихэссэний зэрэгцээ дэд бүтцийн хөгжил сул, цахилгаан эрчим хүч, усан хангамжийн дутагдалтай байгаа зэрэгтэй холбоотой байж болох юм. Иймээс ХАА-н салбарт дорвитой өөрчлөлт хийх шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйг дан ганц байгалийн үзэгдлийн урсгалаар бус орчин үеийн фермерийн аж ахуйн хэлбэрээр өсгөх хэрэгтэй байна. Газар тариалангийн хувьд гадагш нь импортлодоггүй юм аа гэхэд дотоодын хэрэгцээгээ хангахуйц үйлдвэрлэл явуулж болно гэж үзэж байна. Үүний тулд зарим ХАА-н түүхий эд, бараа бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн албан татварыг нэмэгдүүлсэн байгаа. Дээр нь нэмж хэлэхэд ХАА-н бүтээгдэхүүний түүхий эдийн экспортын хэмжээг багасгаж дотооддоо боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг орчин үеийн технологийн үндсэн дээр бий болговол эдийн засгийн өсөлт хөгжилтөнд илүү хувь нэмэр оруулах болно.

Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар нь ДНБ-ний 20.4 хувийг эзэлж байгаа бөгөөд 2001 оноос хойшхи жилийн дундаж өсөлт нь 8.6 хувьтай байна. Санал асуулгад оролцсон иргэдийн 29.6 хувь энэ салбар эдийн засгийн өсөлтийг хангана гэж хариулсан нь 2005 оныхоос 6.1 нэгжээр илүү байна. 2002, 2003 онуудын уналтыг эс тооцвол энэ салбарын өсөлт тогтмол эерэг хурдацтай байсан байна (Хүснэгт 4).


**Хүснэгт 4. ДНБ-ий өсөлт, салбаруудаар**

	2001	2002	2003	2004	2005	Дундаж	Хувийн жин
ДНБ	1.0%	4.0%	5.6%	10.7%	6.2%	5.5%	100.0%
Худалдаа, засварлах үйлчилгээ	8.6%	12.8%	7.1%	6.3%	9.4%	8.8%	24.8%
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	-18.3%	-12.4%	4.9%	17.7%	7.7%	-0.1%	21.7%
Тээвэр, агуулах, холбоо	12.9%	15.9%	11.1%	10.6%	10.7%	12.2%	12.2%
Уул уурхай, олборлох үйлдвэр	8.1%	-8.2%	-2.3%	34.3%	11.3%	8.6%	20.4%
Боловсруулах үйлдвэр	35.3%	19.0%	4.3%	1.3%	-24.1%	7.2%	4.4%
Санхүүгийн үйлчилгээ	21.1%	6.6%	24.5%	19.5%	16.7%	17.7%	3.9%
Боловсрол	1.1%	4.7%	-4.3%	-6.6%	-5.3%	-2.1%	3.1%
Төрийн удирдлага, батлан хамгаалах, даатгал	-5.7%	0.8%	-2.5%	4.0%	3.4%	0.0%	3.3%
Барилга	12.4%	14.9%	44.2%	0.1%	11.9%	16.7%	2.3%
Цахилгаан, дулаан, ус	2.7%	3.2%	1.1%	6.3%	4.2%	3.5%	3.1%
Эрүүл мэнд, халамж	3.8%	1.2%	-2.1%	5.3%	3.1%	2.3%	1.6%
Үл хөдлөх хөрөнгө, түрээс	6.0%	23.4%	21.1%	16.4%	5.4%	14.5%	1.3%
Зочид буудал, зоогийн газар	-6.9%	3.7%	0.5%	17.3%	6.3%	4.2%	1.0%
Бусад	9.5%	48.0%	-1.5%	19.9%	3.3%	15.8%	0.5%


Эх үүсвэр: Монгол улсын статистикийн эмхэтгэл, 2005 (ҮСГ)

2004 онд энэ салбарын өсөлт дээд цэгтээ буюу 34.4 хувьд хүрсэн нь гадаадын хөрөнгө оруулалттай алтны үйлдвэрүүдийн үйл ажиллагаанаас голчлон шалтгаалжээ. 2005 онд манай гол экспортын бүтээгдэхүүний нэг болох зэсийн баяжмалын (35 хувийн агуулгад шилжүүлснээр) үйлдвэрлэлт 361.6 мянган тоннд хүрсэн нь 2004 оныхоос 9.8 мянган тонноор бага байгаа боловч дэлхийн зах зээлийн зэсийн үнийн өсөлтөөс шалтгаалан үнийн дүнгээр өссөн дүн гарчээ. Харин цэвэр катодын зэсийн (99 хувийн агуулгатай) үйлдвэрлэлт 2474.5 тоннд хүрч 2004 оныхоос 98.4 тонноор өссөн үзүүлэлттэй байна. Дэлхийн зах зээлийн нэг тонн цэвэр катодын зэсийн дундаж үнэ 2003 онд 1,779.1 ам. доллар, 2004 онд 2,862.7 ам. доллар, 2005 онд 3,678.3 ам. доллар байсан бол 2006 оны эхний 8 сарын дундаж үнэ 6,481.0 ам. доллар болж огцом өсчээ (Зураг 4). Мөн 2005 онд 24.1 тонн алт олборлосон нь 2004 оныхоос 4.7 тонноор их байна. Дэлхийн зах зээлийн алтны үнэ сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байсан нь манай эдийн засаг өсөхөд таатай нөлөө үзүүлжээ. Тухайлбал, дэлхийн зах зээл дээрх нэг трой унци алтны дундаж үнэ 2003 онд 367.8 ам. доллар, 2004 онд 410.5 ам. доллар, 2005 онд 444.9 ам. доллар байсан бол 2006 оны эхний 8 сарын дундаж үнэ 601.7 ам. доллар болж өсчээ (Зураг 3.). Дээр дурьдсан манай улсын экспортын гол түүхий эдийн үнийн өсөлт ДНБ-ий өсөлтийг хангахаас гадна манай улсын эдийн засагт шууд нөлөөлж гадаад валютын дотогшоо урсгал нэмэгдэн улсын валютын нөөц өсөх, валютын ханш тогтворжих, төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, улсын төсөв илүүдэлтэй гарахад голлох үүрэг гүйцэтгэлээ. Хэдийгээр 2006 он гарсаар дээрх түүхий эдүүдийн үнэ өссөөр байгаа ч Монголбанкинд тушаасан алтны хэмжээ эрс буурлаа. Үүнийг голчлон УИХ-аас шинээр баталсан зарим төрлийн бүтээгдэхүүнд үнийн өсөлтийн албан татвар ногдуулах тухай хуультай холбон тайлбарлаж байгаа бөгөөд Монголбанкнаас алт олборлогч компаниудад олборлосон алтаа хуулийн дагуу Монголбанкинд дэлхийн зах зээлийн үнээр тушаахыг уриалсан билээ.

**Зураг 3. Алтны үнийн динамик**



**Зураг 4. Зэсийн үнийн динамик**



Боловсруулах үйлдвэрлэл манай улсын эдийн засагт их үүрэг гүйцэтгэнэ гэж иргэдийн 22.7 хувь үзсэн нь 2005 оныхоос 2.2 нэгжээр буурсан байна. Боловсруулах салбар 2005 онд уналтанд орсон гэж хэлж болохоор байгаа (24.1 хувиар буурсан) бөгөөд энэ нь Хятад улс Дэлхийн Худалдааны Байгууллагад элссэнээр тус салбарын Хятад улсын хөрөнгө оруулалттай зарим үйлдвэр үйл ажиллагаагаа зогсоох, үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээг хумих зэргээс шалтгаалжээ. Сүүлийн дөрвөн жилийн байдлаар боловсруулах үйлдвэрлэлийг авч үзвэл: 2005 онд ДНБ-ний 4.4 хувийг эзэлж, 2001 оноос 2005 хүртэлх жилийн дундаж өсөлт нь 7.2 хувь буюу салбаруудын дунд эзлэх байр суурь нь эрс буурчээ. Тухайн салбарын үйлдвэрлэл буурсан нь экспортын орлого буурах, ажилгүйчүүдийн эгнээ нэмэгдэх, улмаар эдийн засгийн үйл ажиллагаанд сөрөг үр дагавар авчирлаа. Ийнхүү тус салбарын үйл ажиллагаа хумигдсан нь иргэдийн зүгээс боловсруулах салбар эдийн засгийг түргэн хөгжүүлнэ гэсэн хариулт багасахад нөлөөлжээ. Харин 2006 он гарсаар Европын холбоо манай улсын сүлжмэл болон оёмол бүтээгдэхүүнд экспортын хөнгөлөлт үзүүлэх болсон, Засгийн газраас нийгмийн даатгалын шимтгэл дээр зохих хөнгөлөлтийг үзүүлснээр уг салбар эргээд сэргэх хандлага ажиглагдаж байна.

Банк санхүүгийн үйл ажиллагаа нь 1996-1998 оны банкны хямралын үед уналтанд орж байсан хэдий ч 1999 оноос эргээд сэргэж, 2001-2005 онуудын жилийн дундаж өсөлт нь 17.7 хувь буюу өсөлтөөрөө эдийн засгийн салбаруудыг тэргүүлж байна. Санал асуулгад оролцогчдын 8.7 хувь нь банк санхүүгийн салбарын үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ гэсэн нь 2005 оныхоос 1.1 нэгжээр буурчээ. Банк санхүүгийн салбар маань хичнээн тогтвортой, үйл ажиллагаа нь төдий чинээ өргөжин тэлэх нь бусад салбаруудын өсөлт хөгжилтөнд их үүрэг гүйцэтгэх болно. Банк санхүүгийн үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувийн жин жилээс жилд нэмэгдэж 2005 оны байдлаар 3.9 хувийг эзэлж байна. Энэ салбарын үйл ажиллагааны талаар дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй дурьдах тул энд товч өгүүлэв.

Аялал жуучлалын салбарыг (шинэ ангиллаар зочид буудал, зоогийн газар) судалгаанд оролцсон иргэдийн 16.4 хувь эдийн засгийн өсөлт хөгжилтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзсэн нь 2005 оныхоос 1.1 нэгжээр буурчээ. 2001-2005 онуудад тус салбарын жилийн дундаж өсөлт 4.2 хувь, ДНБ-ний 1.0 хувийг эзэлж байгаа нь доогуур үзүүлэлт бөгөөд энэ нь мал амьтны гаралтай халдварт өвчин өнгөрсөн онуудад гарч байсантай холбоотой. Харин НҮБ-аас Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойг 2006 онд тэмдэглэн өнгөрүүлэх тухай шийдвэр гарсантай холбогдуулан манай улс “Их Монгол 800” хөтөлбөр боловсруулсны үр дүнд 2006 он гарсаар манай улсад зочлох жуулчдын тоо эрс нэмэгдсэн. Энэ нь манай улсын эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулах нь дамжиггүй. Монгол улс эртний түүх уламжлалтай, байгаль орчноо онгон зэрлэг байдлаар нь хадгалж үлдсэн

цөөхөн орнуудын нэг учраас энэхүү салбарын ирээдүйн хөгжлийг дэмжиж, таатай орчныг бий болгож чадвал багагүй хэмжээний хөрөнгийн урсгал орж ирнэ гэдэгт асуултанд хариулсан иргэд болон бусад хүмүүс санал нэгтэй байгаа гэдэгт итгэлтэй байна.

Санал асуулгын хариултын хүрээнд хамрагдаагүй зарим гол салбаруудын талаар товчхон дурьдая. Тухайлбал; тээвэр, агуулах, холбооны салбар нь ДНБ-ний 12.2 хувийг эзэлж байгаа бөгөөд 2001 оноос хойшхи жилийн дундаж өсөлт нь 12.2 хувь, боловсролын салбар нь ДНБ-ний 3.1 хувь, дундаж өсөлт нь сөрөг 2.1 хувь, барилгын салбар нь ДНБ-ний 2.3 хувь, дундаж өсөлтөөрөө банк санхүүгийн салбарын дараа хоёрт буюу 16.7 хувь байна.

"Хэрэглээний барааны үнэ таны бодлоор" гэсэн асуултанд (1.4.) 90.4 хувь нь өсч, 2.1 хувь нь буурч, 5.4 хувь нь тогтворжиж, 2.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. 2005 онтой харьцуулахад үнэ буурч байна гэсэн хариулт 0.5 нэгжээр нэмэгдсэн бол, өсч байна, тогтворжиж байна гэсэн хариултауд тус тус 0.4, 0.5 нэгжээр багасчээ. 1990 оноос эхлэн захиргаадалтын үнийг чөлөөлсний дараа үнийн өсөлт огцом явагдаж (хайперинфляци), 1994 оноос буурч, 1998 оноос эхлэн тогтворжин нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх болсон. 2000 онд үнийн өсөлт бага зэрэг явагдаж хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байсан хэдий ч 2001 оноос 2004 оны 8-р сар хүртэл эргээд нэг оронтой тоонд шилжсэн байна. Харин 2004 оны дунд үеэс эхлэн дэлхийн зах зээлийн шатахууны үнэ өсч эхэлсэн, дотооддоо бензин шатахууны хомсдолд орсонтой холбоотойгоор суурь инфляци, улмаар түүнийг даган хэрэглээний барааны үнэ өсч иргэдийн амьдралд хүндээр туссан байна. Гэвч 2005 оны эцэст үнийн өсөлт буурч эргээд нэг оронтой тоонд орсон бөгөөд буурч тогтворжих хандлагатай болсон нь иргэдийн санал асуулгатай ижил байна (Зураг. 5). Хэдийгээр инфляцийн түвшин буурсан ч иргэдийн 90.4 хувь нь үнэ өсч байна гэсэн нь нийгэмд өндөр инфляцийн хүлээлт үүссэн байгааг илтгэж байна.


#### 1.4. Өргөн хэрэглээний барааны үнэ таны бодлоор

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Өсч байна	4894	90.8%	5775	90.4%	-0.4%
Буурч байна	84	1.6%	136	2.1%	0.5%
Тогтворжиж байна	316	5.9%	347	5.4%	-0.5%
Мэдэхгүй	94	1.7%	130	2.0%	0.3%
Нийт	5388	100.0%	6388	100.0%	0.0%
Хариулаагүй	17	0.3%	13	0.2%	-0.1%
Нийт	5405		6401		

2006 оны 7-р сарын байдлаар жилийн инфляцийн түвшин 1.8 хувьтай тэнцүү байгаа бөгөөд цаашид тогтворжих хандлага ажиглагдаж байна. Үнийн өсөлт бага, эерэг түвшинд, тогтвортой байна гэдэг эдийн засгийн өсөлт хөгжилт болон иргэдийн амьжиргааны түвшин дээшлэхэд их үүрэг гүйцэтгэнэ. Харин манай улс нээлттэй жижиг зах зээл учир дотоодын үнийн өөрчлөлт гадаад зах зээлийн үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамаардаг болохыг мартаж болохгүй. Тухайлбал, 2006 оны 8, 9 дүгээр саруудад ОХУ шатахууны экспортын татвараа нэмснээс шалтгаалан шатахуун импортлогч компаниуд шатахууны үнийг өсгөсөн байгаа. Энэ нь бүх бараа үйлчилгээний үнэд нөлөөлөх нь ойлгомжтой. Дэлхийн зах зээлийн газрын тосны үнэ Израил, Арабын ээлжит мөргөлдөөний улмаас тогтворгүйтэж, Ливанд гал зогсоосны дараа буурах хандлага ажиглагдаж байгаа ч манай улсад шатахууны үнэ өссөөр байна. Энэ нь ОХУ өөрийн газрын тосны бүтээгдэхүүнээ дэлхийн зах

зээлийн үнээс доогуур үнээр экспортлож байсантай холбоотой. Дэлхийн зах зээлийн газрын тосны үнэ, ОХУ-ын экспортын үнэ хоёрын зөрүү нь ОХУ-ын Засгийн газарт гадаад бодлогодоо маневр хийх орон зай бий болгож байсан бөгөөд энэхүү зөрүү сүүлийн жилүүдэд улам багассаар байна. Цаашид манай улс эрчим хүчний найдвартай нийлүүлэлтийг хангахын тулд олон талын нийлүүлэгчтэй болох, бусад төрлийн эрчим хүч ашигласнаар шатахуунаас хамаарах хамаарлыг багасгах, шатахууныг дэлхийн зах зээлийн үнээр авч хэрэглэх, ингэснээр шатахууны үнэ цэнийг зөв тодорхойлж манай улсын эдийн засгийн үнийн түвшин зөвөөр бүрэлдэн тогтоход ач холбогдолтой.

**Зураг 5. Хэрэглээний барааны үнийн өөрчлөлт**



Манай улсын хувьд үнийн өсөлтийг бий болгож байгаа гол шалтгаан нь эдийн засгийн бүтцийн онцлог буюу өөрөөр хэлбэл шатахуун түлшээ 100.0 хувь импортоор авдаг, хэрэглээний сагсны 13.0 орчим хувийг эзэлдэг махны үнийг цөөн тооны махны наймаа эрхлэгчид тогтоодогтой холбоотой байна. Дээрх бүтцийн шинж чанартай үнийн өсөлтийг бууруулахад Төв банкны зүгээс бодлогоор нөлөөлөх боломж хязгаарлагдмал байна. Өнөөгийн байдлаар Монголбанк олон улсын жишгийн дагуу суурь хүүгээ өсгөх, ТБҮЦ-аар дамжуулан мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна. Түүний зэрэгцээ ХҮИ-ээс үнийн хэлбэлзэл ихтэй дээрх бүтээгдэхүүнийг хасч цэвэрлэсэн суурь инфляцийг тооцон хэрэглэж байгаа болно. 2005 оны сүүлээс Засгийн газрын зүгээс махны үнийг зохицуулах зорилгоор мах бэлтгэлийн үеэр мах нөөцлөн хавар махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч эхэлсэн. Энэ нь махны үнийн зохиомол хөөрөгдлийг багасгаж улмаар инфляцийн түвшинг бууруулсан байж болох талтай. Цаашид Монголбанкны зүгээс мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд юуны түрүүнд мөнгөний зах дээр мөнгө (liquidity)-ний хомсдол (shortage)-ыг бий болгох шаардлагатай байна. Ингэснээр Монголбанкны суурь хүүний өөрчлөлт эдийн засагт мөнгөний бодлогын хүүний дамжих механизмаар нөлөөлөх боломжтой болохоос гадна инфляцийг илүү үр дүнтэй удирдах болов уу. Одоогийн байдлаар Монголбанк мөнгөний захаас мөнгө (liquidity) татах зорилгоор суурь хүүгээ зарлаж ТБҮЦ гаргаж байгаа учир хүүгийн сигнал санхүүгийн захад тэр бүр нөлөөлж чадахгүй байна. Мөнгөний зах дээр мөнгө (liquidity)-ний хомсдол (shortage)-ыг бий болгох нь түвэгтэй ч юуны түрүүнд мөнгөний нийлүүлэлтийг санамсаргүй нэмэгдэхээс сэргийлэх зорилгоор алт худалдан авах, цэвэршүүлэх, экспортлох үйл ажиллагааг өөр институтэд шилжүүлж, эдийн засагт эргэлдэж буй мөнгө (liquidity)-р хийх шаардлагатай байна. Мөн нэгэнт Монголбанк тогтмол валютын ханшны болон бие даасан (independent) мөнгөний бодлого нэгэн зэрэг

хэрэгжүүлэх боломжгүй учир гадаад валютын ханшийг үнэ тогтвортой байх үүднээс дотоодын үйлдвэрлэл сэргэтэл интервенци хийн барих, нийлүүлэгдсэн мөнгө (liquidity)-ийг стерилизаци хийн татах, цаашилбал өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болсон цагт чөлөөт хөрвөх ханшийн бодлого явуулах нь тохиромжтой болов уу. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх өөрөөр хэлбэл баялаг бүтээх замаар валютын ханшийн үнэд нөлөөлөх нөлөөллийг бууруулахгүйгээр мөнгөний зах дээр мөнгө (liquidity)-ний хомсдол (shortage)-ыг бий болгох нь тун бэрхшээлтэй. Эдгээрээс гадна хөрөнгө (asset)-ийн үнийн динамикийг Монголбанк анхааралтай ажиглах нь зүйтэй болов уу. Учир нь үл хөдлөх хөрөнгийн үнийн зохиомол хөөрөгдөл эдийн засагт үлэмж их хохирол авчрах эрсдэлтэй байдаг.

### 3.2. Нийгмийн талаархи асуудлууд

"Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд" гэсэн асуултанд 19.6 хувь нь дээшилсэн гэж хариулсан нь 2005 оныхоос 3.1 нэгжээр өссөн, 26.3 хувь нь доошилсон гэж үзсэн нь 5.7 нэгжээр буурсан, 52.1 хувь нь хэвэндээ гэсэн нь 2.7 нэгжээр өссөн дүн гарчээ. Харин 2.0 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (2.1.). Энэ хариултаас харахад иргэдийн хориод хувь нь өрхийн амьжиргааны түвшин 2005 оныхоос дээшилсэн (3.1 нэгж) гэсэн байхад ихэнх иргэдийн (52.1 хувь) амьжиргааны түвшин төдийлөн өөрчлөгдөөгүй хэвээр байна. Амьжиргааны түвшин дээшилсэн гэж хариулсан иргэдийн тоо бага боловч нэмэгджээ. Сүүлийн 2 жилийн эдийн засгийн өсөлт 16.9 хувь байгаа ч өрхийн амьжиргааны түвшин хэвэндээ, доошилж байна гэж дийлэнх иргэд хариулсан нь нэг талаас эдийн засагт бий болж буй баялаг олон хүнд хүртэхгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Энэ нь эдийн засгийн өсөлтийг алт, зэсийн үнийн өсөлт бий болгож байгаа учир бий болсон баялаг тухайн салбарынханд ногдсон, мөн тус салбарт гадаадын олон компани үйл ажиллагаагаа явуулдаг учир бий болсон баялаг гадагшаа ногдол ашиг хэлбэрээр гарсан байж болно. Үүний зэрэгцээ 26.3 хувь нь амьдрал хэцүү байна гэсэн нь 2004 оны байдлаар Монгол улсын хүн амын 36.3 хувь нь ядуурлын түвшинд байна (Human development report 2005, UNDP) гэсэн баримтанд дөхөж очиж байна.

#### 2.1. Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Дээшилсэн	886	16.5%	1243	19.6%	3.1%
Доошилсон	1717	32.0%	1675	26.3%	-5.7%
Хэвээрээ	2652	49.4%	3312	52.1%	2.7%
Мэдэхгүй	110	2.1%	128	2.0%	-0.1%
Нийт	5365	100.0%	6358	100.0%	0.0%
Хариулаагүй	40	0.7%	43	0.7%	0.0%
Нийт	5405		6401		

Зах зээлийн системд шилжин орсноос хойш манай улсад баян, ядуу, дунд зэрэг нийгмийн янз бүрийн давхаргууд (баян хоосны ялгаа) бий болж тэдний хоорондох ялгаа эрс мэдрэгдэх болсон билээ. Өмнөх нийгмийн тогтолцооны үед нийгмийн баялгийг тэнцүү хуваан авах зарчимтай байсан бөгөөд шинэ тогтолцоо буюу зах зээлийн системд энэ бүхэн өөрчлөгдсөнийг та бүхэн мэдэж байгаа. Үүнтэй уялдан хувь хүний болон өрхийн амьжиргааны түвшин өөр өөр болж, тэдгээрийн ялгаа эрс өөрчлөгдсөнийг мартаж болохгүй. Харин төр засгаас зохицуулалт хийж бага боловч тэрхүү ялгааг багасгах шаардлагатай байна. Засгийн газраас 18-аас доош насны хүүхэд бүрт сар бүр гурван мянган төгрөг, шинээр гэр бүл болох залуу хосуудад нэг удаагийн 500 мянган төгрөгийн тэтгэмж олгох өгөөмөр хөтөлбөрүүд

хэрэгжүүлж эхэлсэн нь өрхийн амьжиргааны түвшинд бага боловч нэмэр болж байгаа ч энэ нь төсөв ашигтай байгаа үеийн цаг зуурын бодлого бөгөөд төсөв алдагдалтай хэцүү үед яаж шийдвэрлэх нь тодорхойгүй. Мөн эдгээр өгөөмөр бодлого нь эргээд иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх сонирхолыг бууруулах, социалист сэтгэлгээгээсээ салж ядаж байгаа манай орны хувьд улам сэтгэлгээний доройтолд орох, бүхнийг төрөөс нэхэх, төрөөс авах тэтгэлэг тэтгэмжийг нэмэгдүүлэх эцэс төгсгөлгүй шаардлага гарах, улсын төсөвт дарамт учруулах сул талтай.

Санал асуулгад оролцсон иргэдийн 75.4 хувь нь хүн амын ядуурал нэмэгдэж байна гэсэн нь 2005 оныхоос 3.1 нэгжээр буурсан бол, 7.0 хувь нь буурч байна гэсэн нь 0.7 нэгжээр, 14.1 хувь нь хэвэндээ байна гэсэн нь 2.3 нэгжээр тус тус өсчээ. Харин 3.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (2.2.). Ядуурал нэмэгдэж байна гэсэн хариулт 2005 оныхоос буурсан ч санал асуулгад оролцсон иргэдийн дөрөвний гурав нь ядуурал нэмэгдэж байна гэж үзсээр байна.

## 2.2. Хүн амын ядуурал таны бодлоор

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдэж байна	4210	78.5%	4791	75.4%	-3.1%
Буурч байна	340	6.3%	447	7.0%	0.7%
Хэвэндээ байна	631	11.8%	893	14.1%	2.3%
Мэдэхгүй	184	3.4%	221	3.5%	0.1%
Нийт	5365	100.0%	6352	100.0%	0.0%
Хариулаагүй	40	0.7%	49	0.8%	0.1%
Нийт	5405		6401		

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс гаргадаг статистикийн лавлах дээр 2004 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын 36.3 хувь нь ядуурлын түвшинд, 27.0 хувийнх нь орлого буюу хэрэглээ өдрийн нэг америк доллараас доош түвшинд, эдийн засгийн баялгийн 70.0 орчим хувь нь тэгш бус хуваарилагддаг гэж дурьджээ. Ядуурлын түвшингийн динамик өөрчлөлтийг авч үзвэл, 1985 онд 15.0 орчим байсан бол 1990 онд 10.0 орчим хувь болж буурчээ. Харин 1995 онд 36.3 хувь, 1998 онд 35.6 хувь, 2002 онд 36.1 буюу тогтмол өндөр түвшинд байна (Зураг 7). Хүн амын гуравны нэг гаруй нь ядуурлын түвшинд байна гэдэг бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад тийм ч өндөр биш боловч ядуурлын түвшинд байна гэж ойлгож болно. Ядууралтай тэмцэх үүднээс Засгийн газар ОУВС-тай хамтран 2000 оны 9-р сараас эхлэн "Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах" (PRGF) хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлэн 2005 оны 7 сараар дуусгавар болжээ. Уг хөтөлбөрийн хүрээнд 28.5 сая зээлжих тусгай эрх (SDR)-ийн хөнгөлөлттэй зээл авахаар тохиролцоноос манай улс 12.2 сая зээлжих тусгай эрхийн зээл авч ашиглажээ. ЯБӨХ хөтөлбөр манай улсад ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангахад тодорхой хувь нэмэр оруулсан нь дамжиггүй. Одоо уг хөтөлбөрийг цааш нь үргэлжлүүлэн сунгах, ядуурлыг хэрхэн бууруулах талаар авах арга хэмжээний талаар ОУВС, Засгийн газар, Монголбанк хамтран зөвшилцөж байна. Дээрх хөтөлбөрөөс гадна иргэд маань өөрсдөө хувиараа хөдөлмөр эрхэлж ирээдүйн хуримтлалаа бага боловч бий болгож чадвал нийт хүн амын ядуурал буурах болно. Энэ үйлсэд төр засгийн оролцоо ч (татвар бууруулах, бодит орлогыг бүрдүүлэх суурийг тавьж өгөх, ажлын байрыг шинээр бий болгох, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтыг зөв зохистой хуваарилах, г.м.) их үүрэг гүйцэтгэнэ.




Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор гэсэн асуултанд 76.2 хувь нь нэмэгдэж байна, 7.1 хувь нь буурч байна, 12.2 хувь нь хэвэндээ байна, 4.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (2.3.). 2005 онтой харьцуулахад нэмэгдэж байна гэсэн хариулт 4.8 нэгжээр буурч, буурч байна, хэвэндээ байна гэсэн нь тус тус 2.0, 2.2 хувиар нэмэгджээ. Мөн дээрх асуултын адил ажилгүйчүүдийн тоо нэмэгдэж байгаа гэж хариулсан иргэдийн тоо 2005 оныхоос 4.8 нэгжээр буурсан ч санал асуулгад оролцсон иргэдийн дийлэнх нь ажилгүйчүүдийн тоо нэмэгдэж байна гэж үзсээр байна.

### 2.3. Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор


	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдэж байна	4357	81.0%	4842	76.2%	-4.8%
Буурч байна	276	5.1%	453	7.1%	2.0%
Хэвэндээ байна	538	10.0%	773	12.2%	2.2%
Мэдэхгүй	206	3.8%	285	4.5%	0.7%
Нийт	5377	100.0%	6353	100.0%	0.0%
Хариулаагүй	28	0.5%	48	0.7%	0.2%
Нийт	5405		6401		

ҮСГ-аас гаргадаг статистикийн мэдээллээс харахад хөдөлмөр эрхлэлтийн албанд албан ёсоор бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 1990 онд 45.7 мянга, 1994 онд 74.9 мянга байсан бол 2002 онд 30.9 мянга болж буурч байсан хэдий ч 2005 оны байдлаар бага зэрэг өсөх хандлага ажиглагдан 32.9 мянга болжээ. Мөн Зураг 6.-аас харахад ажилгүйдлийн түвшин 1990 онд 5.5 хувь, 1994 онд 8.7 хувь байсан бол 2002 онд буурч 3.4 хувь болсон байна. Харин 2002-2004 онд бага зэрэг өссөн ч тогтворжих хандлага ажиглагдан 2005 онд 3.3 хувь болжээ (Зураг 6). 2005 онтой харьцуулахад ажилгүйдэл ихэсч байна гэж иргэдийн дийлэнх хариулсан байхад статистикийн тоон үзүүлэлтүүд өөр дүр зураг харуулж байна.

Зураг 6. Ажилгүйчүүдийн тоо, түвшин (мянган хүн)



Зураг 7. Ядуурлын хамралтын хүрээ



Монгол улсад төр засгаас ажлын байр нэмэгдүүлэх шат дараалсан тодорхой арга хэмжээ авч байгаа, АХБ-аас ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлж байгаа, ажиллах хүчнээ гадаадад бага боловч гаргаж байгаатай уялдан ажилгүйчүүдийн дундаж түвшин сүүлийн жилүүдэд багасч байна гэж ҮСГ-ын статистикийн мэдээлэл дээр дурьдаж байгаа хэдий ч судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх нь ажилгүйчүүдийн тоо ихэсч байна гэж үзсэн хэвээр байна. Үүнээс харахад статистикийн тоон мэдээлэл иргэдийн хариулт хоёрын хооронд нилээд зөрүү байгаа нь илэрхий байна. Манай улсын олон иргэд БНСУ-д албан ёсны

зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлдэг. БНСУ-ын Ерөнхийлөгч Монгол улсад айлчлах үеэр хоёр тал “Нийгмийн хамгааллын хэлэлцээр”, түүнийг хэрэгжүүлэх “Удирдлагын тохиролцооны гэрээ”-нд үсэг зурж, хоёр орны иргэдэд нийгмийн даатгалын шимтгэлийг давхардуулан ногдуулахыг болиулж, хөдөлмөр эрхлэгсдийн нийгмийн хамгааллыг сайжруулахад тустай алхам хийлээ.

#### 2.4. Газар хувьчлалыг

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Дэмжиж байна	3395	63.6%	3546	56.4%	-7.2%
Дэмжихгүй байна	1332	25.0%	1882	29.9%	4.9%
Мэдэхгүй	607	11.4%	862	13.7%	2.3%
Нийт	5334	100.0%	6290	100.0%	0.0%
Хариулаагүй	71	1.3%	111	1.7%	0.4%
Нийт	5405		6401		

Судалгаанд оролцсон иргэдийн 56.4 хувь нь газар хувьчлалыг дэмжиж байна, 29.9 хувь нь дэмжихгүй байна, 13.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (2.4.). Иргэдийн талаас илүү хувь нь газар хувьчлалыг дэмжиж байгаа ч 2005 оныхоос дэмжиж байгаа нь 7.2 нэгжээр буурч, харин дэмжихгүй байгаа нь 4.9 нэгжээр өссөн байна. Газрыг хувьчлах нь газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, улсын мэдэлд байгаа газар хувь хүмүүст шилжин газартай холбоотой хүнд суртал, хээл хахууль, маргаантай асуудлуудад цэг тавих давуу талуудтай. Газар хувьчилж эхлээгүй байгаа боловч одоогийн байдлаар газрыг урт хугацаа (15 жил)-гаар түрээслүүлж байна. Газартай холбоотой хэрүүл маргаан хот суурин газруудад газар авч байгаа бөгөөд газар эзэмших зөвшөөрлийн олголт хот төлөвлөлтөд нийцэхгүй замбараагүй бодлогогүй байна. Газар хувьчлалыг дэмжиж байгаа иргэдийн тоо 7.2 нэгжээр буурсан нь газрын зөвшөөрлийн олголт шударга бус, хувьчилсан тохиолдолд хувьчлалыг ямар арга замаар хэрхэн явуулах нь тодорхойгүй, газрын байршил, үржил шимтэй эсэх болон бусад олон асуудлуудтай холбоотой байж болно. Эдгээрээс шалтгаалан газар хувьчлах үйл явц удааширсаар байна.

### 3.3. Татварын талаар

Дээр эдийн засгийн ерөнхий асуулгад татварын тухай дурьдсаныг та бүхэн санаж байгаа байх. Судалгаанд хамрагдсан иргэдийн ойролцоогоор дөрөвний нэг нь татварын ачааллыг багасгавал эдийн засгийн өсөлтөнд зохих хувь нэмрээ оруулна гэж хариулсан байгаа. Одоо татварын ерөнхий түвшингийн талаар юу бодож байгааг сонирхоё (3.1.). Нийт иргэдийн маань 72.9 хувь нь өндөр гэж хариулсан нь 2005 оныхоос 1.8 нэгжээр буурч, 15.2 хувь нь боломжийн гэсэн нь 0.8 нэгжээр өсчээ. Харин 11.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь 1.0 нэгжээр өссөн байна. Мөн татварын ачаалал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн гэж 64.1 хувь нь үзэж байхад хэвэндээ гэж 18.7 хувь, буурсан гэж 3.7 хувь нь хариулсан байна. 2005 онтой харьцуулахад татварын ачаалал нэмэгдсэн гэж хариулсан нь 3.6 нэгжээр буурсан бол хэвэндээ гэсэн нь 0.5 хувиар, буурсан гэсэн нь 1.5 хувиар тус тус өссөн байна (3.2.).

#### 3.1. Монгол улсад үйлчилж буй татварын ерөнхий түвшин таны бодлоор

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Өндөр	4025	74.7%	4630	72.9%	-1.8%

Боломжийн	773	14.4%	964	15.2%	0.8%
Мэдэхгүй	587	10.9%	758	11.9%	1.0%
Нийт	5385	100.0%	6352	100.0%	0.0%
Хариулаагүй	20	0.4%	49	0.8%	0.4%
Нийт	5405		6401		


Татварын ачаалал 2005 оны байдлаар 30.5 хувь байгаа нь өндөр гэж үзэж байна. Одоо үйлчилж буй татварын хувь хэмжээ 100 сая төгрөгөөс доошхи орлоготой аж ахуйн нэгж 15 хувь, түүнээс дээш орлоготой аж ахуйн нэгж 40 хувь байгаа. Манай улсад 40 хувиар татвар төлдөг аж ахуйн нэгжийн тоо цөөн, ихэнх аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэгчид 100.0 сая төгрөгийн орлогод хамрагдахаасаа өмнө аж ахуйн нэгжээ жижиг болгон өөрчлөн байгуулах, олон жижиг аж ахуйн нэгж болгон хуваах замаар 15 хувийн татвар төлдөг. Иймд ихэнх аж ахуйн нэгж 15 хувийн татвар төлж байхад үйлчилж буй татварын хувь хэмжээ 30.5 хувь байгаа нь хуульд заасан хувиас өндөр, татварын дарамт байгааг илтгэж байна. Иргэдийн 70 гаруй хувь нь татварын ерөнхий түвшин өндөр, татварын ачаалал нэмэгдсэн гэж хариулсан нь татварын багц хуулинд өөрчлөлт ороход нөлөөлсөн болов уу.

### 3.2. Татварын ачаалал сүүлийн жилүүдэд

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдсэн	3619	67.7%	4042	64.1%	-3.6%
Хэвэндээ	973	18.2%	1182	18.7%	0.5%
Буурсан	119	2.2%	232	3.7%	1.5%
Мэдэхгүй	638	11.9%	850	13.5%	1.6%
Нийт	5349	100.0%	6306	100.0%	0.0%
Хариулаагүй	56	1.0%	95	1.5%	0.5%
Нийт	5405		6401		

Зураг 8.-аас харахад манай улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш 1999 он хүртэл татварын ачаалал боломжийн хэмжээнд явж ирсэн бол 2000 оноос хойш өсөн 30 орчим хувьд хадгалагдсаар байна. Энэ нь Засгийн газрын хуримтлагдсан өр өндөр, яаралтай хүлээгдэж буй санхүүжилт их байсантай холбоотой болов уу. Төсвийн зарлагын ачаалал яваандаа хөнгөрөх үед татварын дарамт буурах нь ойлгомжтой бөгөөд энэ талаар ч тодорхой ажил хийгдээд явж байна.

### Зураг 8. Татварын хэмжээ ба ачаалал, сая төгрөг



Энэ хэсэгт бас нэг чухал зүйлийг хэлэхэд татварын түвшин өндөр, ачаалал их байгаа үед татвараас зайлсхийх явдал нийтлэг байна гэж санал асуулгад оролцсон иргэдийн 68.1 хувь үзсэн нь үүний нэг баталгаа болов уу. Харин 10.6 хувь нь бага, 21.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (3.3.). Өнгөрсөн онтой харьцуулахад нийтлэг байна гэж хариулсан нь 1.6 нэгжээр, бага байна гэсэн нь 1.1 хувиар тус тус өсч, мэдэхгүй гэсэн нь 2.6 хувиар буурчээ. Татвараас зайлсхийх явдал нийтлэг байна гэсэн иргэдийн дүгнэлт өндөр хэвээр байна.

### 3.3. Татвараас зайлсхийх явдал таны бодлоор

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нийтлэг байна	3553	66.5%	4279	68.1%	1.6%
Бага байна	510	9.5%	668	10.6%	1.1%
Мэдэхгүй	1278	23.9%	1340	21.3%	-2.6%
Нийт	5341	100.0%	6287	100.0%	0.0%
Хариулаагүй	64	1.2%	114	1.8%	0.6%
Нийт	5405		6401		

### 3.4. Банк санхүүгийн салбар

2006 оны 7-р сарын 31-ний өдрийн байдлаар Монгол улсад 16 банк, 162 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж, 266 хадгаламж зээлийн хоршоо Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэгдсэн байна. Эдгээр санхүүгийн байгууллагуудын гол ялгарах шинж нь үйл ажиллагааныхаа эх үүсвэрийг хэрхэн бий болгосон, үүсэх эрсдэлийг хэн үүрэх вэ гэдэгт оршино. Банк иргэд, аж ахуйн нэгжээс эх үүсвэр татан төвлөрүүлэх бөгөөд эндээс үүсэх эрсдэлийг банк өөрөө хариуцдаг. Иймдээ ч Монголбанкны хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг. Банк бус санхүүгийн байгууллагын хувьд бусдаас хөрөнгө татан төвлөрүүлэх эрхгүй бөгөөд зөвхөн өөрийн хөрөнгийн хэмжээгээр үйл ажиллагаа явуулж үүсэх эрсдэлийг өөрсдөө хариуцдаг. Харин хадгаламж зээлийн хоршооны хувьд иргэд өөрсдийн санаачилгаараа хөрөнгө нийлүүлэн зөвхөн хоршооны гишүүдийн дунд үйл ажиллагаа явуулах ба үүсэх эрсдэлийг гишүүд дангаараа хариуцдаг. Судалгаанд хамрагдсан иргэдийн 49.7 хувь нь үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог боломжийн, 38.5 хувь нь олон байна, 6.6 хувь нь цөөн байна гэж хариулжээ (4.1.). Судалгаанд оролцсон иргэдийн тал орчим хувь нь үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог боломжийн гэж үзсэн нь өнгөрсөн оныхоос 4.2 нэгжээр

өссөн, олон байна гэсэн нь 1.5 нэгжээр буурсан байна. Харин мэдэхгүй гэж 5.1 хувь нь хариулжээ.

#### 4.1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоо таны бодлоор

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Олон	2151	40.0%	2451	38.5%	-1.5%
Цөөн	428	8.0%	420	6.6%	-1.4%
Боломжийн	2449	45.5%	3163	49.7%	4.2%
Мэдэхгүй	355	6.6%	326	5.1%	-1.5%
Нийт	5383	100.0%	6360	100.0%	0.0%
Хариулаагүй	22	0.4%	41	0.6%	0.2%
Нийт	5405		6401		

Ихэнх иргэд маань одоо үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог боломжийн гэж үзэж байна. Энд зарим иргэд маань банк гэсэн ойлголтонд санхүүгийн бусад байгууллагуудыг оруулж ойлгосныг үгүйсгэхгүй. Сүүлийн жилүүдэд олон арван ББСБ болон бусад санхүүгийн байгууллагууд бий болж банкны зарим үйл ажиллагааг бичил түвшинд гүйцэтгэж өрсөлдөөнийг бий болгож байна. Монголбанкны зүгээс банкуудын хэмжээг томсгох, үйл ажиллагааг нь чанаржуулах үүднээс банкуудын дүрмийн санг 2006 онд 8.0 тэрбум төгрөг болгосон билээ. Банкуудын хэмжээ томрсон ч тоо нь хэвээрээ, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Харин банкны зарим үйл ажиллагааг доод түвшинд банкуудтай зэрэгцэн санхүүгийн бусад байгууллагууд гүйцэтгэнэ.

Энд нэг зүйлийг нэмж хэлэхэд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбаруудын тоо тогтмол өсч байхад ББСБ-уудын өсөлт удаашралтай байна.

#### 4.2. Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Найдвартай	2417	44.9%	3230	50.9%	6.0%
Эргэлзээтэй	2083	38.7%	2227	35.1%	-3.6%
Найдваргүй	347	6.4%	469	7.4%	1.0%
Мэдэхгүй	535	9.9%	423	6.7%	-3.2%
Нийт	5382	100.0%	6349	100.0%	0.0%
Хариулаагүй	23	0.4%	52	0.8%	0.4%
Нийт	5405		6401		

Манай улсын банк санхүүгийн салбарын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд сайжирч байна гэж мэргэжилтнүүд болон олон улсын судлаачид дүгнэж байгаа. Харин иргэдийн зүгээс хэрхэн дүгнэж байгааг сонирхоё. Санал асуулгад оролцсон иргэдийн 50.9 хувь нь банк санхүүгийн салбарын үйл ажиллагааг найдвартай гэсэн нь 2005 оныхоос 6.0 нэгжээр өссөн, 35.1 хувь нь эргэлзээтэй гэсэн нь 3.6 нэгжээр буурсан, 7.4 хувь нь найдваргүй гэж хариулсан нь 1.0 нэгжээр өссөн байна. Харин 6.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (4.2.). Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ жилээс жилд арилж, найдвар төрүүлж байгаа нь дээрх хариултаас харагдаж байна. Банкны үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ тийм ч бага биш хувийг эзэлж байгаа, 1990-ээд оны банкны системийн удаа дараалсан хямралууд нь зарим иргэдийн оюун санаанд хадгалагдсаар байгаа, нөгөө талаас Хадгаламж зээлийн хоршоодын буруутай үйл ажиллагаа нь нийт салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байгаатай холбоотой байж болох юм.


Банкинд итгэх итгэл нэмэгдсэн гэж иргэдийн 42.9 хувь нь үзэж байгаа бол 37.7 хувь нь хэвэндээ, 10.8 хувь нь буурсан, 8.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (4.3.). Өнгөрсөн онтой харьцуулахад нэмэгдсэн гэсэн хариултынх 1.0 нэгжээр буурч, буурсан, хэвэндээ гэж хариулсных тус тус 1.4, 2.8 нэгжээр өссөн байна. Энд мөн хадгаламж зээлийн хоршоодын буруутай үйл ажиллагаа нь банкуудын нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн байж болох талтай. Ерөнхийдөө, иргэдийн банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ багасч, итгэх итгэл нь нэмэгдэж байгаа гэж дээрх хариултуудаас дүгнэж болохоор байна. Үүнийг мөн тоон үзүүлэлтүүдээс ч харж болно.

#### 4.3. Банк санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл


	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдсэн	2361	43.9%	2726	42.9%	-1.0%
Буурсан	505	9.4%	689	10.8%	1.4%
Хэвэндээ	1876	34.9%	2400	37.7%	2.8%
Мэдэхгүй	631	11.7%	543	8.5%	-3.2%
Нийт	5373	100.0%	6358	100.0%	0.0%
Хариулаагүй	32	0.6%	43	0.7%	0.1%
Нийт	5405		6401		

Өнөөгийн байдлаар банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа нь өргөжиж, найдвартай болж байгаа нь иргэдийн итгэл ийнхүү дээшлэхэд нөлөөлсөн байх. Үүний нэг илрэл бол иргэд байгууллагуудын банк дахь хадгаламж, харилцахын хэмжээ тогтмол өсч байгаа явдал юм.

Зураг 9. Хадгаламж, тэрбум төгрөг



Зураг 10. Харилцах, тэрбум төгрөг



Зураг 9-өөс харахад төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн хэмжээ 1991 оноос 1997 он хүртэл тогтмол өсч ирсэн ба банкны салбарын хямралын оргил үе болох 1998 онд буурч, 1999-2005 онуудад огцом өсөлттэй явж 901.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. М2-т эзлэх хувийн жингээрээ 2000 оноос эхлэн тогтмол өсч, 2005 оны байдлаар 77.0 орчим хувийг эзэлж байна. Харилцах дансны өөрчлөлт хадгаламжтай адил түвшинд явж 2001 оноос хойш огцом өссөн байна (Зураг 10). Хадгаламжийн огцом өсөлттэй уялдан харилцахын М2-т эзлэх хувийн жин нь 1998 оноос хойш тогтмол буурч 2005 оны байдлаар 10.0 хувийг эзэлж байна (2001 оныг эс тооцвол). Банкуудын найдвартай үйл ажиллагааг хангах үүднээс Монголбанк банкуудад тавих хяналт шалгалтаа чангатгаж, зээлийн өрийн үлдэгдэлд хязгаарлалт тавих, заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоон мөрдүүлэх зэрэг хэд хэдэн арга хэмжээг авсан ба банкуудын касс дахь бэлэн мөнгөний хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж, ингэснээр харилцагчдын төлбөр, тооцоог түргэн шуурхай

гүйцэтгэдэг болсон нь иргэдийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

Банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа олон нийтэд сайн сурталчилж байгаа нь дараах хариултаас харагдаж байна. Иргэдийн дийлэнх буюу 64.8 хувь нь чадаж байна гэсэн хариулт өгсөн нь өнгөрсөн оныхоос 1.4 нэгжээр буурч, чадахгүй байна 2.3 нэгжээр нэмэгдэж 22.1 хувьд, мэдэхгүй гэсэн хариулт 0.9 нэгжээр буурч 13.1 хувьд хүрчээ (4.4.).

#### 4.4. Банк санхүүгийн багууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Чадаж байна	3552	66.2%	4112	64.8%	-1.4%
Чадахгүй байна	1065	19.8%	1403	22.1%	2.3%
Мэдэхгүй	750	14.0%	829	13.1%	-0.9%
Нийт	5367	100.0%	6344	100.0%	0.0%
Хариулаагүй	38	0.7%	57	0.9%	0.2%
Нийт	5405		6401		

Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ багассан, итгэх итгэл нь нэмэгдсэн энэ үед үйлчилгээ нь хэр зэрэг түргэн шуурхай явагдаж байгааг сонирхоё. Асуултанд хариулсан иргэдийн 57.3 хувь нь хувь хүнд хүрч түргэн шуурхай байна гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос 1.2 нэгжээр буурчээ. Харин 32.6 хувь нь хүнд сурталтай чирэгдэлтэй байна гэсэн нь 3.5 нэгжээр өсч, 10.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (4.5.).

#### 4.5. Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Хувь хүнд хүрч, хэвийн байна	3121	58.5%	3631	57.3%	-1.2%
Хүнд сурталтай, чирэгдэлтэй	1555	29.1%	2063	32.6%	3.5%
Мэдэхгүй	660	12.4%	638	10.1%	-2.3%
Нийт	5336	100.0%	6332	100.0%	0.0%
Хариулаагүй	69	1.3%	69	1.1%	-0.2%
Нийт	5405		6401		

Танд мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандвал боломжтой вэ гэсэн асуултанд 52.9 хувь нь банк, 19.7 хувь нь хувь хүн, 14.3 хувь нь ломбард, 4.3 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 4.2 хувь нь ББСБ, 4.6 хувь нь бусад эх үүсвэр гэж хариулжээ (4.6.). Өнгөрсөн оныхоос банкнаас гэсэн хариулт өссөн байхад бусад төрлийн санхүүгийн байгууллагад хандана гэсэн хариулт буурчээ. Хүнд мөнгөний хэрэгцээ гарвал хамгийн түрүүнд банкинд, дараа нь найз нөхөд, дотны хүмүүс болон ломбарданд ханддаг байна. Банкуудын үйл ажиллагаа сайжирч, үйлчилгээнийх нь төрөл ихэссэн, зөвхөн цөөн тооны найдвартай харилцагчдад их хэмжээний зээл олгохын зэрэгцээ цалин тэтгэврийн болон бусад төрлийн бичил зээлийг (үйлчилгээ) өргөн хүрээтэй олгож байгаа нь иргэдийн тэмүүллийг өөрсдийн зүг татаж байгаагийн илрэл юм.

#### 4.6. Танд мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ?

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Банк	3217	45.2%	4060	52.9%	7.7%
ББСБ	414	5.8%	324	4.2%	-1.6%
Хадгаламж зээлийн хоршоо	486	6.8%	332	4.3%	-2.5%
Ломбард	1109	15.6%	1095	14.3%	-1.3%
Хувь хүн	1506	21.2%	1509	19.7%	-1.5%
Бусад	388	5.4%	354	4.6%	-0.8%
Нийт	7120	100.0%	7674	100.0%	0.0%
Хариулаагүй	-1715	-31.7%	-1273	-19.9%	11.8%
Нийт	5405		6401		

Бусад санхүүгийн байгууллагуудын хувьд тоо хэмжээ, төрөл нь хурдтайгаар өсч байгаа хэдий ч санал асуулгын хариултанд эзлэх хувийн жин нь их бага байна. Энэ нь үйл ажиллагаа нь төлөвшиж тогтворжоогүй, үйлчилгээ нь олон нийтийг зөв хамруулж чадахгүй байгаатай холбоотой.

Өнөөгийн байдлаар Монгол улсад нийт 162 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа явуулж, хот, хөдөө орон нутгийн иргэдийг өөрсдийн харилцагчдаа болгон тэдэнд тодорхой хэмжээний банкны зарим үйлчилгээ үзүүлж байна. Судалгаанд оролцсон иргэд маань ББСБ-ын талаар хэр мэдлэгтэй байгааг сонирхоё. Асуултанд хариулсан нийт иргэдийн 29.6 хувь нь ББСБ-аар үйлчлүүлдэг, 67.2 хувь нь үйлчлүүлдэггүй, 3.3 хувь мэдэхгүй гэж хариулжээ (4.7.). Өнгөрсөн онтой харьцуулахад үйлчлүүлдэг гэсэн хариулт 8.3 нэгжээр буурч, үйлчлүүлдэггүй гэсэн хариултын тоо 9.0 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултын тоо 0.6 нэгжээр буурсан байна.

#### 4.7. Та банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг үү?

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	2027	37.9%	1872	29.6%	-8.3%
Үгүй	3117	58.2%	4255	67.2%	9.0%
Мэдэхгүй	211	3.9%	207	3.3%	-0.6%
Нийт	5355	100.0%	6334	100.0%	0.0%
Хариулаагүй	50	0.9%	67	1.0%	0.1%
Нийт	5405		6401		

Үүнээс дүгнэхэд тоо нь олширч байгаа хэдий ч ББСБ-ууд маань цөөн тооны харилцагчдын хүрээнд үйлчилгээ явуулж байна. Мөн энд нэмж хэлэхэд сурталчилгаа сайн явуулж иргэдийг олноор татах шаардлагатай байна. ББСБ нь манай улсын хувьд шинээр бий болж буй санхүүгийн байгууллагын нэг хэлбэр юм. Удирдах байгууллагуудын зүгээс түүний хөгжлийг дэмжиж байгаа хэдий ч ажлын дадлага туршлага, боловсон хүчний мэдлэг, ур чадвар дутмаг байгааг хэлэхэд илүүдэхгүй биз. Нөгөө талаас банк, ББСБ, бусад санхүүгийн байгууллагууд зах зээлийн зарчмын дагуу өрсөлдөөнийг бий болгож чадвал хүүний түвшин буурч хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэн үйлчилгээ нь хувь хүнд хүрнэ гэдгийг хэлмээр байна.

Сүүлийн үед хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны талаар иргэдийн зүгээс гомдол их гарах болсон. Зарим хадгаламж зээлийн хоршоод дампуурсан нь байдлыг хүндрүүлж иргэдийг хохироосоор байна. Иймд иргэд маань хадгаламж зээлийн хоршооны талаар хэр зэрэг ойлголттой байгааг сонирхвол санал асуулгад оролцсон иргэдийн 41.6 хувь нь хадгаламж зээлийн хоршооны талаар



ойлголттой, 41.1 хувь нь ойлголтгүй, 17.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад ойлголттой гэсэн хариулт 4.7 нэгжээр буурсан бол ойлголтгүй гэсэн хариултын тоо 5.6 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултын тоо 0.8 нэгжээр буурсан байна. Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааг зохицуулах ажил ид явагдаж байгаа учир иргэдийн ойлголт эргэлзээтэй, хүлээлтийн байдалтай байна. Санхүүгийн Зохицуулах хороо байгуулагдахаас өмнө Татварын Ерөнхий газрын Улсын Бүртгэлийн албанд 845 хадгаламж зээлийн хоршоо бүртгэлтэй байсан байна. Харин Санхүүгийн Зохицуулах Хороо байгуулагдан хадгаламж зээлийн хоршоодыг тоолох, хаягийг нь тодруулах, үйл ажиллагаатай нь танилцахад улсын хэмжээгээр 266 гаруй хадгаламж зээлийн хоршоо бүртгэгджээ. Ихэнх хадгаламж зээлийн хоршоод бүртгэлтэй байсан боловч үйл ажиллагаагаа эхлээгүй байна. Санхүүгийн Зохицуулах хороо бүртгэлдээ авсан хадгаламж зээлийн хоршоодоос хууль журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж буй хоршоодод үйл ажиллагаа явуулах лиценз олгож эхлээд байна.

#### 4.8. Та хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой юу

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	2477	46.3%	2639	41.6%	-4.7%
Үгүй	1900	35.5%	2606	41.1%	5.6%
Мэдэхгүй	970	18.1%	1095	17.3%	-0.8%
Нийт	5347	100.0%	6340	100.0%	0.0%
Хариулаагүй	58	1.1%	61	1.0%	-0.1%
Нийт	5405		6401		

Судалгаанд оролцсон иргэдийн 10.0 хувь нь хадгаламж зээлийн хоршооны гишүүн, 86.9 хувь нь гишүүн бус байлаа. Харин 3.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (4.9.). Өнгөрсөн онтой харьцуулахад гишүүдийн тоо 2.6 нэгжээр буурсан бол гишүүн бусын тоо 4.5 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултын тоо 2.0 нэгжээр буурсан байна. Зарим хадгаламж зээлийн хоршоод иргэдэд үнэн зөв мэдээлэл өгдөггүй, хэт өндөр хүү амладаг, хууль бус зар сурталчилгаа явуулдаг, удирдлагууд нь мэргэжлийн ур чадваргүй, хууль бус үйл ажиллагаа явуулдаг, хуурч мэхэлдэг зэргээс шалтгаалан хоршооны гишүүн иргэдийн тоо буурсан байх магадлалтай.

#### 4.9. Та хадгаламж зээлийн хоршооны гишүүн мөн үү

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	672	12.6%	635	10.0%	-2.6%
Үгүй	4410	82.4%	5520	86.9%	4.5%
Мэдэхгүй	272	5.1%	195	3.1%	-2.0%
Нийт	5354	100.0%	6350	100.0%	0.0%
Хариулаагүй	51	0.9%	51	0.8%	-0.1%
Нийт	5405		6401		

Иргэдийн зүгээс хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хуулийн дагуу зөв явагдаж байна гэж 21.0 хувь нь үзсэн байхад хууль бус буюу буруу гэж 29.3 хувь нь дүгнэжээ. Харин ихэнх нь буюу 49.7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь иргэд маань төөрөлдсөн хэвээр байгааг харуулж байна (4.10.). Өнгөрсөн онтой харьцуулахад хуулийн дагуу зөв гэсэн хариулт эрс буурч (11.2 нэгж) харин буруу хууль бус гэсэн хариулт эрс өссөн (18.0) байна. Зарим хадгаламж зээлийн хоршоо хууль бус үйл ажиллагаа явуулан дампуурсан нь иргэдийн санал эргэхэд нөлөөлсөн болов уу.

#### 4.10. Та хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Зөв буюу хуулийн дагуу	1719	32.2%	1325	21.0%	-11.2%
Буруу буюу хууль бус	605	11.3%	1844	29.3%	18.0%
Мэдэхгүй	3017	56.5%	3128	49.7%	-6.8%
Нийт	5341	100.0%	6297	100.0%	0.0%
Хариулаагүй	64	1.2%	104	1.6%	0.4%
Нийт	5405		6401		

Өнөөдөр манай улсад гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай хэд хэдэн банк, ББСБ-ууд үйл ажиллагаа явуулж байна. Гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь манай улсад орж ирэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн улмаар үндэсний үйлдвэрлэлийг сэргээж дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ. Түүний зэрэгцээ манай улсын банк санхүүгийн салбарт зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож банк санхүүгийн байгууллагуудыг чанаржуулахад тус дөхөм болно.

#### 4.11. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг оруулж ирэх нь

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Ач холбогдолтой	2484	46.5%	2697	42.8%	-3.7%
Ач холбогдолгүй	1065	20.0%	1515	24.0%	4.0%
Мэдэхгүй	1789	33.5%	2090	33.2%	-0.3%
Нийт	5338	100.0%	6302	100.0%	0.0%
Хариулаагүй	67	1.2%	99	1.5%	0.3%
Нийт	5405		6401		

Одоо манай иргэдийн зүгээс гадаадын банк болон санхүүгийн байгууллагуудыг Монголд оруулж ирэх нь ямар ач холбогдолтой вэ гэдгийг сонирхоё. 42.8 хувь нь ач холбогдолтой гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос 3.7 нэгжээр буурсан, 24.0 хувь нь ач холбогдолгүй гэсэн нь 4.0 нэгжээр өссөн, 33.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь 0.3 нэгжээр багассан байна (5.9.). Хэдийгээр иргэдийн төлөөллийн зөв буюу ашигтай гэж үзэж байгаа хувь буурсан ч иргэдийн дийлэнх нь ач холбогдолтой гэж хариулсан нь дээрх санаатай нэг байна гэсэн үг. 2005 оны байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай 6 банк байгаагаас 5 банкны хяналтын багц гадаадын хөрөнгө оруулагчдын мэдэлд байна. Дээрх гадаадын хөрөнгө оруулалттай банкууд банкны салбарын нийт хадгаламжийн үлдэгдлийн 10.8 хувь, харилцахын үлдэгдлийн 8.5 хувийг төвлөрүүлж байна. Үүнээс гадна, гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай 13 банк бус санхүүгийн байгууллага манай улсад үйл ажиллагаа явуулж, тэдгээрийн нийт актив 11.3 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаадын банк санхүүгийн байгууллагуудыг оруулж ирэх нь манай улсын эдийн засгийн өсөлт хөгжилтөнд ашигтай харин улсынхаа эдийн засгийн багтаамж, зах зээлийн байдал, банк санхүүгийн салбарын хөгжил түүнд учруулж болзошгүй эрсдэлийг сайн тооцоолж тодорхой хэмжээгээр оруулах нь зөв болов уу.

Өнгөрсөн онуудын судалгаагаар бэлэн бус тооцоо болон түүний хэрэгслүүдийн (картууд) талаар нилээд дэлгэрэнгүй санал асуулга явуулж нэгтгэн дүгнэсэн болно. Иргэдийн ихэнх хувь нь ойлголт байхгүй түүний давуу талыг мэдэхгүй байсан. Харин одоо байдал өөрчлөгдөж байгаа дүр зураг харагдаж байна. Бэлэн бус тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан иргэдийн 31.3 хувь нь тийм, 63.8 хувь нь үгүй, 4.8 хувь нь

мэдэхгүй гэж хариулсан байна (4.12.). Өнгөрсөн онтой харьцуулахад карт хэрэглэдэг иргэдийн тоо 9.9 нэгжээр өссөн байна. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картын хэрэглээ жилээс жилд өсч байгаа ч иргэдийн дийлэнх нь карт хэрэглэдэггүй хэвээр байна.

#### 4.12. Та бэлэн бус тооцооны хэлбэр болох картыг хэрэглэдэг үү?

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	1143	21.4%	1978	31.3%	9.9%
Үгүй	3760	70.5%	4031	63.8%	-6.7%
Мэдэхгүй	431	8.1%	305	4.8%	-3.3%
Нийт	5334	100.0%	6314	100.0%	0.0%
Хариулаагүй	71	1.3%	87	1.4%	0.1%
Нийт	5405		6401		

### 3.5. Хадгаламж, хуримтлал

"Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ?" гэсэн асуултанд давхардсан тоогоор 33.7 хувь нь банкинд хадгалуулдаг, 7.1 хувь нь бусдад зээлдүүлдэг, 26.3 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 1.5 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 2.1 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 29.1 хувь нь бусад гэсэн хариултыг өгчээ. Өнгөрсөн оныхтой харьцуулахад банкинд хадгалуулдаг гэсэн хариулт хамгийн ихээр (6.3 нэгжээр) өссөн байхад хувьцаа худалдаж авдаг, үнэт цаасанд байршуулдаг гэсэн хариултууд бага зэрэг буюу тус бүр 0.7, 0.3 нэгжээр өсчээ. Харин бусдад зээлдүүлдэг, худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, бусад хэлбэрээр гэж хариулсных тус тус 0.6, 0.3, 2.6 хувиар буурсан байна. Иргэд хуримтлуулсан мөнгөө банкинд ихээр хадгалуулах болсон нь банкны үйл ажиллагаа сайжирсантай холбоотой. Харин худалдаа наймаа хийдэг иргэдийн тоо тогтвортой байхад бусад гэсэн хариултанд хуримтлуулах мөнгөгүй эсвэл мөнгөө бэлнээр гар дээрээ байлгадаг иргэд хамрагдсан болов уу гэсэн таамаглалыг төрүүлж байна.

#### 5.1. Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ?

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Банкинд хадгалуулдаг	1615	27.4%	2224	33.7%	6.3%
Зээлдүүлдэг	454	7.7%	471	7.1%	-0.6%
Худалдаа наймаа хийдэг	1568	26.6%	1734	26.3%	-0.3%
Үнэт цаасанд байршуулдаг	71	1.2%	102	1.5%	0.3%
Хувьцаа худалдаж авдаг	80	1.4%	139	2.1%	0.7%
Бусад	1864	31.7%	1920	29.1%	-2.6%
Нийт	5885	100.0%	6590	100.0%	0.0%
Хариулаагүй	-480	-8.9%	-189	-3.0%	5.9%
Нийт	5405		6401		

"Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулдаг вэ?" гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан иргэдийн 65.3 хувь нь бэлэн мөнгөний хэлбэрээр, 15.1 хувь нь бэлэн бус мөнгөний хэлбэрээр, 3.9 хувь нь үнэт цаасанд, 4.0 хувь нь хувьцаанд, 11.7 хувь нь бусад хэлбэрээр байршуулдаг гэж хариулжээ (5.2.). Банк санхүүгийн байгууллагуудын тоо, үйлчилгээний төрөл олширч (хүн ам төвлөрсөн газруудад), бэлэн бус төлбөр тооцооны систем хөгжиж буй энэ үед иргэдийн 65.3 хувь нь мөнгөө бэлнээр хадгалж байгаа нь нэгд, бэлэн бус төлбөр тооцооны систем буюу шаардлагатай үед бэлэн мөнгө авах нөхцөл нийт нутаг дэвсгэрийг хамарч чадаагүй, ялангуяа хөдөө орон нутагт огт хөгжөөгүй, хоёрт, санхүүгийн зах зээлийн хөгжил

сул дорой учир үнэт цаас, хувьцаа болон бусад хэрэгслүүдэд мөнгөө байршуулах боломжоор хязгаарлагдмал, гуравт, ямар нэгэн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх мөнгөгүй зөвхөн амьжиргааныхаа хэдэн төгрөгтэй байдаг иргэд олон байгаатай холбоотой гэж үзэж байна.

### 5.2. Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ


	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Бэлэн мөнгөөр	3550	63.0%	4148	65.3%	2.3%
Бэлэн бус мөнгөний хэлбэрээр	853	15.1%	957	15.1%	0.0%
Үнэт цаасаар	245	4.3%	246	3.9%	-0.4%
Хувьцаагаар	198	3.5%	256	4.0%	0.5%
Бусад хэлбэрээр	788	14.0%	746	11.7%	-2.3%
Нийт	5634	100.0%	6353	100.0%	0.0%
Хариулаагүй	-229	-4.2%	48	0.7%	4.9%
Нийт	5405		6401		

Дээрх асуултуудтай уялдсан бас нэг сонирхолтой асуултанд юу гэж хариулсныг сонирхоё. Танд хэмнэх мөнгө гараад түүнийгээ банкинд юм уу эсвэл өөр ямар нэгэн газар байршуулах бол ямар валютыг илүүд үзэж байна вэ гэсэн асуултанд 87.2 хувь нь төгрөгөөр, 8.4 хувь нь америк доллараар, 4.5 хувь нь бусад валютаар гэж хариулжээ (5.3.). Өнгөрсөн онтой харьцуулахад төгрөгөөр гэсэн нь 1.4 нэгжээр буурч, америк доллар гэсэн нь 2.1 нэгжээр буурсан байна. Хэдийгээр төгрөгөөр хадгалуулна гэсэн иргэдийн хариулт өнгөрсөн оныхоос бага зэрэг буурсан ч дийлэнх иргэд маань үндэснийхээ валютаар хуримтлалаа байршуулахыг илүүд үзэж байгаа нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшны уналт харьцангуй багассан, төгрөгийн хадгаламжийн хүү өндөр байгаатай холбоотой болов уу. Мөн банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд илт сэргэсэн, Монгол улсын хүн ам төвлөрсөн нутаг дэвсгэрт төгрөгийн бэлэн бус төлбөр тооцооны шинэ хэрэгслүүд эрчимтэй хөгжиж байгааг дурьдахад илүүдэхгүй биз. Түүний зэрэгцээ хөдөө орон нутагт зөвхөн төгрөгөөр голчлон үйлчилгээ явагдаж байна.

### 5.3. Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Төгрөгөөр	4442	88.6%	5311	87.2%	-1.4%
Америк доллараар	318	6.3%	511	8.4%	2.1%
Бусад	252	5.0%	272	4.5%	-0.5%
Нийт	5012	100.0%	6094	100.0%	0.0%
Хариулаагүй	393	7.8%	307	4.8%	-3.0%
Нийт	5405		6401		

Зураг 11. Төгрөгийн болон валютын хадгаламж, Зураг 12. Хадгаламжийн хүү ба инфляци, тэрбум төгрөг



Зураг 11.-ээс харахад иргэд банк дахь өөрийн хадгаламжаа төгрөг америк доллараар бараг тэнцүү харьцаатай байлгасаар иржээ. Иргэд ихэвчлэн валютын ханшийн эрсдэлээс хамгаалан хадгаламжаа америк доллараар байлгаж байгаа бол мөн гадаад төлбөр тооцооны зорилгоор байлгаж байгаа нь ч цөөнгүй байна. Сүүлийн жилүүдэд валютын ханшийн хэлбэлзэл багасч, гадаад валютын дотогшоо урсах урсгал нэмэгдсэний дүнд төгрөгийн хадгаламжийн хэмжээ америк долларынхаас илүү гарчээ.

Өрхөд нь хэмнэх мөнгө гардаг болон гарах тохиолдолд иргэдийн 33.7 хувь нь банкинд мөнгөө хадгалуулдаг гэж хариулсныг санаж байгаа байх. Одоо харин тэдгээр иргэдээс болон бусад санал асуулгад оролцсон хүмүүсээс өнөөгийн хадгаламжийн хүү ямар түвшинд байгааг асууя. Асуултанд хариулсан иргэдийн 29.3 хувь нь одоогийн хадгаламжийн хүүний түвшин боломжийн байна, 56.3 хувь нь бага байна, 14.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (5.4.). Өнгөрсөн онтой харьцуулахад бага байна гэсэн хариултынх 1.3 хувиар буурсан байхад боломжийн байна гэснийх 1.7 хувиар нэмэгдсэн байна. Иргэд маань аль болох өндөр хүүтэйгээр хадгаламжаа байршуулахыг хүсэх нь мэдээж. Харин эдийн засгийн болон зах зээлийн байдлыг сайн судалж аль болох найдвартай, ашигтай зүйлд хөрөнгөө байршуулах нь зөв юм. Магадгүй энэ тал дээр мэдээлэл хомс, үйл ажиллагаа хязгаарлагдмал байгааг удирдах газрууд анхааралдаа авах хэрэгтэй байна. Сүүлийн жил гаруй хугацааны үнийн өсөлтийг эс тооцвол инфляцийн түвшин тогтмол буурч нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх болсон нь хадгаламжийн хүүний түвшинг багасхад нөлөөлсөн байж болох талтай. Хэдий тийм ч 1997 оны 9-р сараас (2005 оны дунд үеийг эс тооцвол) эхлэн бодит хүүний түвшин эерэг түвшинд байгааг анхааралдаа авна уу (Зураг 12.).

#### 5.4. Хадгаламжийн хүү таны бодлоор

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Бага байна	3031	57.6%	3505	56.3%	-1.3%
Боломжийн байна	1451	27.6%	1825	29.3%	1.7%
Мэдэхгүй	777	14.8%	900	14.4%	-0.4%
Нийт	5259	100.0%	6230	100.0%	0.0%
Хариулаагүй	146	2.8%	171	2.7%	-0.1%
Нийт	5405		6401		

### 3.6. Зээл

Хүн бүрт зээлийн эрэлт хэрэгцээ ямар нэгэн хэмжээгээр байдаг. Гагцхүү тэр эрэлт хэрэгцээний эх үүсвэрийг (нийлүүлэлт) яаж олох, мөн тухайн эх үүсвэрийн өртөг (хүү) ямар түвшинд байгааг сайн тооцоолох хэрэгтэй болов уу. Өнөөгийн байдлаар инфляцийн түвшин багасч тогтворжин, түүнийг даган хадгаламжийн хүү буурч байгаа хэдий ч зээлийн хүү дорвитой буурахгүй байгаа нь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг хязгаарлах улмаар эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

#### 6.1. Танд зээлийн хэрэгцээ байдаг уу

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	4464	83.5%	5255	82.6%	-0.9%
Үгүй	721	13.5%	923	14.5%	1.0%
Мэдэхгүй	159	3.0%	186	2.9%	-0.1%
Нийт	5344	100.0%	6364	100.0%	0.0%
Хариулаагүй	61	1.1%	37	0.6%	-0.5%
Нийт	5405		6401		

Зээлийн хэрэгцээ танд байдаг уу гэсэн асуултанд 82.6 хувь нь тийм, 14.5 хувь нь үгүй гэж хариулсан байна (6.1.). Харин 2.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Зээлийн хэрэгцээ байдаг гэж хариулсан хүмүүсийн хувь өнгөрсөн оныхоос 0.9 нэгжээр буурсан бол хэрэгцээ байдаггүй гэсэн хариултынх 1.0 нэгжээр өссөн байна. Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн иргэдийн тоо бага зэрэг буурсан ч дийлэнхи буюу 82.6 хувь нь урьдын адил зээл өндөр эрэлттэй байна.

#### 6.2. Танд банк санхүүгийн байгууллагаас олгож буй зээл хүртээмжтэй байдаг уу

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	2229	42.1%	2598	42.8%	0.7%
Үгүй	2035	38.5%	2278	37.5%	-1.0%
Мэдэхгүй	1026	19.4%	1191	19.6%	0.2%
Нийт	5290	100.0%	6067	100.0%	0.0%
Хариулаагүй	115	2.1%	334	5.2%	3.1%
Нийт	5405		6401		

Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнхид (82.6 хувь) зээлийн хэрэгцээ байдаг бөгөөд харин хүртээмж нь зөвхөн 42.8 хувьд нь л ногддог байна. 37.5 хувьд нь зээлийн хүртээмж байдаггүй бөгөөд 19.6 хувь нь зээлийн талаар ойлголт муутай гэж хариулжээ (6.2.). Өнгөрсөн онтой харьцуулахад зээлийн хүртээмж бага зэрэг буюу 0.7 нэгжээр өсчээ.


Зээлийн эрэлт өндөр, хүртээмж буюу нийлүүлэлт бага байгаа энэ үед банк санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж судалгаанд оролцсон иргэдийн 37.9 хувь, хүндрэлтэй гэж 49.3 хувь, мэдэхгүй гэж 12.8 хувь нь үзжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад хүндрэлгүй гэсэн хариултын хувь 0.4 нэгжээр буурч, хүндрэлтэй гэсэн хариулт 2.8 нэгжээр өссөн байна. Мэдэхгүй гэсэн хариулт хувь 2.3 нэгжээр буурчээ (6.3). Эндээс харахад зээл авдаг (хүртээмжтэй) иргэдийн хувьд хүндрэл байдаггүй бөгөөд авч үзээгүй, авдаггүй эсвэл ойлголт байхгүй (зээлийн эрэлт хэдий байгаа ч) иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг байна.

#### 6.3. Таны бодлоор банк санхүүгийн байгууллагаас зээл авахад


	2005	2006	Өөрчлөлт
--	------	------	----------

	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Хүндрэлгүй	2044	38.3%	2390	37.9%	-0.4%
Хүндрэлтэй	2479	46.5%	3107	49.3%	2.8%
Мэдэхгүй	807	15.1%	806	12.8%	-2.3%
Нийт	5330	100.0%	6303	100.0%	0.0%
Хариулаагүй	75	1.4%	98	1.5%	0.1%
Нийт	5405		6401		

Зураг 13. Зээл, тэрбум төгрөг



Зураг 14. Зээлийн хүү ба инфляци, жилээр



Инфляцийн түвшин буурч түүнийг даган хадгаламжийн хүү багасч байхад зээлийн хүү дорвитой буурч өгөхгүй байна гэж нэгэнтээ дурьдсан (Зураг 14). Харин одоо санал асуулгад оролцсон иргэд маань зээлийн хүүний талаар юу гэж бодож байгааг сонирхоё. 71.4 хувь нь зээлийн хүүг өндөр байна гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос 1.8 нэгжээр нэмэгдсэн, 20.1 хувь нь боломжийн гэсэн нь 0.3 хувиар буурчээ. Харин 8.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (6.4.). Энд нэг зүйлийг онцлон хэлэхэд банкууд зээл олгохдоо зээлийн зориулалт, олгож буй салбар, өөрийн эх үүсвэр, зээлийн хугацаа болон харилцагчдын санхүүгийн байдлыг харгалзан хүүг жилийн 6-аас 36 хүртэлх хувиар тогтоож байна. Судалгаанд оролцсон иргэдийн хэд нь банкнаас зээл авдаг, зээл авдаггүйг мэдэх боломжгүй. Магадгүй зарим нь өөрийн санхүүгийн нөхцөл байдлаас хамааран өндөр хүүгээр, зарим нь бага хүүгээр авдаг байх. Хэдий тийм ч 71.4 хувь нь одоогийн зээлийн хүүг өндөр гэж үзэж байгаа нь зээлийн хүүг салбарын хэмжээгээр буулгах дохио болж буйг харуулж байна.

Зээлийн хүүг салбарын хэмжээгээр бууруулах тал дээр Монголбанкны удирдлагын зүгээс нилээд арга хэмжээ авч хэрэгжүүлээд байна. Үүнд: банкуудын удирдлагуудтай хэд хэдэн удаа уулзалт зохион байгуулж зээлийн хүүг яаж багасгах тал дээр санал бодлоо солилцсон, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран төслийн хүрээнд ажлын байр шинээр бий болгох, ХАА-г хөгжүүлэх болон орон сууцны зориулалттай урт болон дунд хугацааны бага хүүтэй зээлийг банкуудаар дамжуулан олгох ажлыг зохион байгуулж байгаа, санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнийг (ялангуяа зээлийн талаар) бий болгох ажил зэрэг болно. Мөн УИХ дээр зээлийн хүүг бууруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

#### 6.4. Таны бодлоор зээлийн хүү

	2005	2006	Өөрчлөлт
--	------	------	----------

	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Өндөр	3689	69.6%	4477	71.4%	1.8%
Боломжийн	1080	20.4%	1260	20.1%	-0.3%
Мэдэхгүй	533	10.1%	530	8.5%	-1.6%
Нийт	5302	100.0%	6267	100.0%	0.0%
Хариулаагүй	103	1.9%	134	2.1%	0.2%
Нийт	5405		6401		

### 3.7. Бичил санхүүгийн талаар

Манай улсад сүүлийн жилүүдэд бичил санхүүгийн үйл ажиллагаа улам өргөжин тэлж байна. Бичил санхүүгийн үйл ажиллагааг зөвхөн банкууд биш банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод болон бусад байгууллагууд эрхэлж байна. Бичил санхүүгийн үндэсний чуулган 2004 оны 11-р сард болсны зэрэгцээ түүний дэд салбарын судалгааг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хийсэн тул энд дэлгэрэнгүй тайлбар хийхийг зорьсонгүй зөвхөн иргэдийн зүгээс ямар санаа бодолтой байгааг тусган харууллаа. Бичил зээлийн талаар болон манай улсад хэрхэн хөгжиж буйг “Бичил зээл ба бизнес үндэсний чуулган”, 1994 он, “Монгол дахь бичил санхүүгийн дэд салбарын судалгаа” 2004 он зэрэг товхимлуудтай танилцаж сайн ойлголт авч болно.

Та бичил санхүүгийн талаар ойлголттой юу гэсэн асуултанд судалгаанд оролцсон иргэдийн 64.8 хувь нь тийм, 21.6 хувь үгүй, 13.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (7.1.). Эндээс харахад бичил санхүүгийн үйл ажиллагаа манай оронд нилээд дэлгэрсэн иргэдийн төлөөллийн дийлэнх хувь нь ойлголттой байна.

#### 7.1. Та бичил санхүүгийн талаар ойлголттой юу

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	3595	67.3%	4083	64.8%	-2.5%
Үгүй	952	17.8%	1361	21.6%	3.8%
Мэдэхгүй	794	14.9%	857	13.6%	-1.3%
Нийт	5341	100.0%	6301	100.0%	0.0%
Хариулаагүй	64	1.2%	100	1.6%	0.4%
Нийт	5405		6401		

Бичил санхүүгийн талаар иргэдийн дийлэнх нь ойлголттой байгаа бол тэдний оршин суугаа газар энэхүү шинэ хэлбэрийн санхүүжилт нь хэр хөгжиж байгааг сонирхоё. Асуултанд хариулсан иргэдийн 24.2 хувь нь сайн хөгжсөн, 44.1 хувь нь дунд зэрэг хөгжсөн, 12.0 хувь нь огт хөгжөөгүй, 19.8 хувь нь мэдэхгүй гэжээ (7.2.). Энэ хариултаас харахад судалгаанд оролцсон иргэдийн 68.3 хувь нь өөрсдийн оршин сууж байгаа газарт бичил санхүүгийн үйл ажиллагаа явагдаж байгааг дурьдсан нь дээрх асуултын (7.1.) хариултыг давхар нотлон харуулж байна.

#### 7.2. Таны оршин сууж байгаа газарт бичил санхүү хэр зэрэг хөгжсөн бэ

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	



Сайн	1289	24.0%	1525	24.2%	0.2%
Дунд зэрэг	2295	42.6%	2777	44.1%	1.5%
Огт хөгжөөгүй	688	12.8%	753	12.0%	-0.8%
Мэдэхгүй	1110	20.6%	1245	19.8%	-0.8%
Нийт	5382	100.0%	6300	100.0%	0.0%
Хариулаагүй	23	0.4%	101	1.6%	1.2%
Нийт	5405		6401		

Иргэдийн 70.0 орчим хувь нь бичил санхүүгийн талаар ойлголттой байдгийн зэрэгцээ тэдний оршин суугаа нийт газрын мөн тийм орчим хувьд үйл ажиллагаа нь явагдаж байгаа нөхцөлд яг хувь хүн өөрт нь бичил зээл авах боломж байгаа эсэхийг тодруулбал, 57.1 хувьд нь боломж бий, 24.1 хувьд нь байхгүй гэж хариулсан байна (7.3.). Харин 18.8 хувь нь мэдэхгүй гэжээ. Бичил зээлийн хүртээмж банкуудын зээлийн хүртээмжээс их байгаа нь тодорхой байна.

### 7.3. Танд бичил зээл авах боломж бий юу

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	3124	59.1%	3556	57.1%	-2.0%
Үгүй	1216	23.0%	1501	24.1%	1.1%
Мэдэхгүй	942	17.8%	1168	18.8%	1.0%
Нийт	5282	100.0%	6226	100.0%	0.0%
Хариулаагүй	123	2.3%	175	2.7%	0.4%
Нийт	5405		6401		

Судалгаанд хамрагдсан иргэдийн 60.0 орчим хувь нь бичил зээл авах боломжтой гэж дээр хариулсныг санаж байгаа байх. Харин одоо түүгээр юу хийдэг буюу ямар бизнес эрхэлдэгийг нь тодруулъяа.

### 7.4. Хэрвээ бичил зээл авч ашигладаг бол ямар үйл ажиллагаа (бизнес) эрхэлдэг вэ

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Газар тариалан	343	6.1%	465	7.5%	1.4%
Хүнсний ногоо	380	6.8%	464	7.5%	0.7%
Мал аж ахуй	471	8.4%	541	8.7%	0.3%
Худалдаа наймаа	1669	29.8%	1885	30.5%	0.7%
Жижиг дунд үйлдвэрлэл	661	11.8%	686	11.1%	-0.7%
Аялал жуулчлал	222	4.0%	173	2.8%	-1.2%
Зочид буудал	108	1.9%	83	1.3%	-0.6%
Гуанз	448	8.0%	468	7.6%	-0.4%
Бусад	1297	23.2%	1419	22.9%	-0.3%
Нийт	5599	100.0%	6184	100.0%	0.0%
Хариулаагүй	-194	-3.5%	217	3.4%	6.9%
Нийт	5405		6401		

Хамгийн их буюу 30.5 хувь нь худалдаа наймаа хийдэг, 11.1 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг, 8.7 хувь нь мал аж ахуйдаа зориулдаг, 7.6 хувь гуанз буюу үйлчилгээ явуулдаг, 7.5 хувь хүнсний ногоо тарьдаг, 7.5 хувь нь газар тариалан эрхэлдэг, 2.8 хувь нь аялал жуулчлалын бизнест зориулдаг, 1.3 хувь нь зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг байна. Харин 22.9 хувь нь бусад үйл ажиллагаанд зориулдаг гэж хариулсан байна (7.4.).

Иргэд маань бичил зээл авч олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэгийг дээр дурьдсан. Харин тэдэнд үйл ажиллагаагаа явуулахад нь хэдий хэмжээний мөнгө хэрэг болдогийг лавлахад 37.8 хувь нь 1.5-2.0 сая төгрөг, 14.9 хувь нь 1.0-1.5 сая төгрөг, 21.2 хувь нь 500 мянгаас 1.0 сая төгрөг, 14.1 хувь нь 250000-500000 төгрөг, 7.5 хувь нь 100000-250000 төгрөг, 4.5 хувь 100000 мянгаас доош төгрөг гэж хариулжээ (7.5.). 2.0 саяас дээш дүнг хариултанд оруулаагүй учир түүнээс дээш эх үүсвэрийн хэрэгцээ байгааг үгүйсгэхгүй. Хамгийн боломжит хэмжээ нь 1.5-2.0 сая байгааг доорхи хүснэгтээс харж болно.

**7.5. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ**

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
100000 доош төгрөг	263	5.4%	254	4.5%	-0.9%
100000-250000 төгрөг	365	7.5%	420	7.5%	0.0%
250000-500000 төгрөг	748	15.4%	794	14.1%	-1.3%
500000-1 сая төгрөг	1047	21.6%	1191	21.2%	-0.4%
1-1.5 сая төгрөг	712	14.7%	836	14.9%	0.2%
1.5-2 сая төгрөг	1715	35.4%	2127	37.8%	2.4%
Нийт	4850	100.0%	5622	100.0%	0.0%
Хариулаагүй	555	11.4%	779	12.2%	0.8%
Нийт	5405		6401		

Бичил зээлийн боломжит мөнгөний хэмжээнийх нь хувьд ийм байдаг байж. Харин хугацааг нь сонирхвол, санал асуулгад хамрагдсан иргэдийн 61.2 хувь нь 9 сараас 1 жил хүртэл, 16.9 хувь нь 6 сараас 9 сар хүртэл, 13.8 хувь нь 3 сараас 6 сар хүртэл, 8.1 хувь нь 3 сар хүртэлх хугацаа шаардлагатай гэжээ (7.6.). Үүнээс үзэхэд бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хамгийн боломжит хугацаа нь 1 жил орчим буюу түүнээс дээш байна.

**7.6. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар хугацаа шаардагдах вэ**

	2005		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
3 сар хүртэлх	375	7.7%	455	8.1%	0.4%
3-6 сар	712	14.6%	781	13.8%	-0.8%
6-9 сар	824	16.9%	955	16.9%	0.0%
9 сараас 1 жил	2967	60.8%	3456	61.2%	0.4%
Нийт	4878	100.0%	5647	100.0%	0.0%
Хариулаагүй	527	10.8%	754	11.8%	1.0%
Нийт	5405		6401		

Эцэст нь бичил зээл авахад ямар ямар бэрхшээлүүд тулгардгийг сонирхоё. Асуултанд хариулсан иргэдийн 48.5 хувь зээлийн хүү өндөр байна, 15.2 хувь нь зээлийн хэмжээ бага байна, 18.7 хувь нь зээлийн хугацаа хангалтгүй байна, 11.2 хувь нь зээл авах боломж байхгүй байна, 6.4 хувь бусад гэсэн хариултыг өгчээ (7.7.). Эндээс дүгнэж үзэхэд хүүний түвшин өндөр байгаа нь тэдний үйл ажиллагаанд саад болж байгаа нь илэрхий байна. Энэ талаар зээлийн хэсэгт дурьдсан тул дахин давтахаас зайлсхийв.

**7.7. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар бэрхшээл байна вэ**

	2005	2006	Өөрчлөлт

	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Зээлийн хүү өндөр	2800	57.8%	3558	48.5%	-9.3%
Зээлийн хэмжээ бага	506	10.5%	1113	15.2%	4.7%
Зээлийн хугацаа хангалтгүй	652	13.5%	1374	18.7%	5.2%
Зээл авах боломжгүй	506	10.5%	819	11.2%	0.7%
Бусад	377	7.8%	468	6.4%	-1.4%
Нийт	4841	100.0%	7332	100.0%	0.0%
Хариулаагүй	564	11.7%	-931	-14.5%	-26.2%
Нийт	5405		6401		

### 3.8. Мөнгөн тэмдэгтийн тухай

Монголбанк гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийн зохистой харьцааг барих, иргэдийн эрэлт хэрэгцээг судлах зорилгоор мөнгөн тэмдэгттэй холбоотой доорхи асуултуудад иргэдээс санал асуулга авсан юм. Танд 1-т болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ гардаг уу гэсэн асуултанд иргэдийн 66.0 хувь нь үгүй, 25.7 хувь нь тийм гэж хариулсан бол 8.2 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Санал асуулгад оролцсон иргэдийн гуравны хоёр нь хэрэгцээ байдаггүй гэсэн нь уг дэвсгэртүүдийн эдийн засаг дахь мөнгөний эргэлтэнд гүйцэтгэх үүрэг эрс багассаныг илтгэж байна.

#### 8.1. Танд 1-т болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ гардаг уу?

	2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	
Тийм	1590	25.7%	
Үгүй	4082	66.0%	
Мэдэхгүй	509	8.2%	
Нийт	6181	100.0%	
Хариулаагүй	220	3.4%	
Нийт	6401		

Цаасан дэвсгэртийн амьдралын хугацаа богино байдаг тул эдийн засгийн мөнгөний эргэлтэд амьдралын урт хугацаатай зоосон мөнгө оруулах нь олон талын ач холбогдолтой байдаг. Иргэдээс 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд 56.7 хувь нь үгүй, 30.6 хувь нь тийм гэж хариулсан байна. Харин 12.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Иргэдийн талаас илүү хувь нь зоосон мөнгөний хэрэгцээ байдаггүй гэсэн нь зоосон мөнгө гүйлгээнд гаргасан тохиолдолд зоосон мөнгөний ач холбогдлыг олон нийтэд сайн ойлгуулах, сурталчлахын чухлыг харуулж байна. Мөн зоосон мөнгөний эрэлт бий болж байж зоосон мөнгөний хэрэгцээ гарах нь ойлгомжтой тул зоос ашигладаг автомат машиныг өргөнөөр ашигладаг болох нь зүйтэй болов уу. Энд анхаарах зүйл бол гүйлгээнд гаргах зоосон мөнгө нь чанарын өндөр түвшинд хийгдсэн, зоосон мөнгөний номиналтай ижил цаасан дэвсгэрт гүйлгээнд гаргахгүй байх нь зүйтэй болов уу. Урьд гаргасан зоосон мөнгөний номинал гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийн номиналтай ижил байсан тул амжилт олоогүй гэдгийг анхаарвал зохино.

#### 8.2. 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу?

	2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	

Тийм			1924	30.6%	
Үгүй			3569	56.7%	
Мэдэхгүй			799	12.7%	
Нийт			6292	100.0%	
Хариулаагүй			109	1.7%	
Нийт			6401		

Манай улсын эдийн засаг тэлж өргөжихийн хэрээр том дүнтэй мөнгөн дэвсгэртийн хэрэгцээ нэмэгдэх нь дамжиггүй. Иймд Монголбанкнаас хорин мянган төгрөгийн дүнтэй дэвсгэртийг удахгүй гүйлгээнд гаргах гэж байгаа билээ. Цаашид үүнээс илүү том дүнтэй мөнгөн дэвсгэртийн хэрэгцээ иргэдэд байгаа эсэхийг асуухад 51.6 хувь нь үгүй, 36.5 хувь нь тийм гэж хариулжээ. Харин 11.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Эндээс одоохондоо хорин мянган төгрөгөөс илүү дүнтэй мөнгөн дэвсгэрт гүйлгээнд гаргах шаардлага байхгүй гэж дүгнэж болохоор байна. Иймд хорин мянгатын шаардлага тодорхой хэмжээгээр бүрдэж эхэлж байна.

### 8.3. Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ танд байгаа юу?

			2006		Өөрчлөлт
			Хүний тоо	Хувь	
Тийм			2306	36.5%	
Үгүй			3259	51.6%	
Мэдэхгүй			747	11.8%	
Нийт			6312	100.0%	
Хариулаагүй			89	1.4%	
Нийт			6401		

Мөнгөн дэвсгэртүүд нь тухайн улсыг илэрхийлэх нэг хэрэгсэл болдог билээ. Ихэнх орнууд өөрийн улсын төлөө хамгийн их зүйл хийж бүтээсэн хүний зураг хөрөг тавидаг, Монголбанк ч энэ жишгийн дагуу мөнгөн дэвсгэртүүд дээрээ Их Монгол Улсыг үүсгэн байгуулагч Эзэн Хаан Чингис, 1921 оны Ардын хувьсгалыг санаачлагчдын нэг Д.Сүхбаатарын хөргийг тавьсан байгаа. Иймд мөнгөн дэвсгэртүүдийн хийц дизайн ард түмэнд таалагдаж буй эсэх нь анхаарал татсан асуултуудын нэг билээ. Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртүүдийн хийц дизайн таалагддаг уу гэсэн асуултанд санал асуулгад оролцогч иргэдийн 74.7 хувь нь тийм, 14.9 хувь нь үгүй, 10.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Санал асуулгад оролцсон иргэдийн бараг дөрөвны гурав нь гүйлгээнд байгаа төгрөгийн хийц дизайн таалагддаг гэсэн нь манай улсын мөнгөн дэвсгэртүүдийн хийц боломжийн түвшинд байгааг харуулж байна.

### 8.4. Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртүүдийн хийц дизайн таалагддаг уу?

			2006		Өөрчлөлт
			Хүний тоо	Хувь	
Тийм			4705	74.7%	
Үгүй			937	14.9%	
Мэдэхгүй			660	10.5%	
Нийт			6302	100.0%	
Хариулаагүй			99	1.5%	
Нийт			6401		

Бага дүнтэй мөнгөн дэвсгэрт эдийн засагт хангалттай хэмжээгээр гүйж байх нь чухал ач холбогдолтой билээ. Бага дүнтэй мөнгөн дэвсгэрт ховордох нь хариулт мөнгө байхгүйн улмаас арилжааг багасгах, бараа, үйлчилгээ үзүүлэгч нь үнийг нэмж том дэвсгэртийн хэмжээнд аваачиж тавих сөрөг үр дагавартай байдаг. Ингээд таны 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддаг уу гэсэн асуултанд

иргэдийн 72.4 хувь нь тийм, 21.1 хувь нь үгүй, харин 6.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Дээрх хариултаас харахад дийлэнх иргэдийн бага дүнтэй мөнгөн дэвсгэртийн хэрэгцээ хангагддаг болох нь харагдаж байна.

**8.5. Таны 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддаг уу?**

	2002		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм			4564	72.4%	
Үгүй			1329	21.1%	
Мэдэхгүй			407	6.5%	
Нийт			6300	100.0%	
Хариулаагүй			101	1.6%	
Нийт			6401		

Мөнгөн дэвсгэртүүдийн амьдралын хугацаа богино байдаг гэж дээр дурдсан. Дэвсгэртүүдийг чанарын өндөр түвшинд хийж амьдралын хугацааг уртасгах нь мөнгөн дэвсгэрт хэвлүүлэх зардал хэмнэх, эдэлгээний явцад урагдаж устах аюулаас сэргийлэх ач холбогдолтой. Иргэдээс гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай юу гэж асуухад 45.9 хувь нь тийм, 42.1 хувь нь үгүй, харин 12.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Эндээс харахад дэвсгэртүүдийн эдэлгээ даах чадварыг цаашид анхааран судалж үзэн боломжтой бол дэвсгэртүүдийн чанарыг дээшлүүлэх нь зүйтэй болов уу.

**8.6. Та гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг үү?**

	2002		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм			2902	45.9%	
Үгүй			2658	42.1%	
Мэдэхгүй			759	12.0%	
Нийт			6319	100.0%	
Хариулаагүй			82	1.3%	
Нийт			6401		

Аливаа улсын мөнгөн дэвсгэрт нарийн нууцлалтай хийгддэг. Манай улсын мөнгөн тэмдэгт ч олон улсын жишгийн дагуу нууцлалын өндөр түвшинд хийгдэж байгаа билээ. Харин сүүлийн үед хуурамч мөнгөн дэвсгэрт мэр сэр илэрсэн нь иргэд маань мөнгөн дэвсгэртийн нууцлалын тухай мэдээллийг авч судалж үзээгүй, анхаарал сэрэмж сул байгаагаас шалтгаалсан байна. Иргэд хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг уу гэсэн асуултанд 25.4 хувь нь тийм, 60.5 хувь нь үгүй, 14.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Иймд цаашид мөнгөн тэмдэгтийн нууцлалын талаар иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчлах шаардлага урган гарч ирж байна.

**8.7. Та хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг уу?**

	2002		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм			1598	25.4%	

Үгүй			3804	60.5%	
Мэдэхгүй			890	14.1%	
Нийт			6292	100.0%	
Хариулаагүй			109	1.7%	
Нийт			6401		

Мэдээжийн хэрэг мөнгөн дэвсгэртүүдийн амьдралын хугацаа иргэд мөнгөн дэвсгэртийг хэрхэн хадгалж, эдэлж хэрэглэж байгаагаас шууд хамаарна. Иргэдийн дийлэнх олон буюу 86.0 хувь нь мөнгөн дэвсгэртийг түрийвчиндээ хийж цэвэрхэн авч явдаг бол 10.4 хувь нь тэгдэггүй байна. Мөн энэ асуултанд 3.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Манай улсын дийлэнх иргэд мөнгөн тэмдэгттэй соёлтой боловсон харьцаж хэрэглэдэг гэж хариулсан боловч мөнгөн тэмдэгтийн амьдралын хугацаа богино байна. Цаашид мөнгөн тэмдэгтийн амьдралын хугацааг уртасгах зорилгоор нийт иргэдийг түрийвч хэрэглэдэг болгох, мөнгөн тэмдэгттэй соёлтой, хүндэтгэлтэй харьцаж байх шаардлага урган гарч байна.

#### 8.8. Та мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг уу?

	2002		2006		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм			5440	86.0%	
Үгүй			655	10.4%	
Мэдэхгүй			230	3.6%	
Нийт			6325	100.0%	
Хариулаагүй			76	1.2%	
Нийт			6401		

#### 4. Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлын (санал асуулга) хүрээнд зах зээлийн системд шилжин орсноос хойш өнөөг хүртэл (2006 он) Монгол улсын эдийн засгийн байдал, нийгмийн хурцадсан асуудлууд, татварын тогтолцоо болон ачаалал, банк санхүүгийн салбарын хөгжил үүнээс хадгаламж, зээл, бичил санхүүгийн талаар төв суурин газар болон хөдөө орон нутгийн иргэд маань ямар санал бодолтой байгааг нэгтгэн дүгнэж бодит байдалтай (тоон үзүүлэлтүүдтэй) харьцуулан дүн шинжилгээ хийлээ. Түүний зэрэгцээ өнгөрсөн оны судалгаа дээр тулгуурлан иргэдийн санал бодол хэр өөрчлөгдсөнийг харьцуулан дүгнэсэн. Судалгааны ажил нь нийгэм, эдийн засгийн олон чухал асуудлуудыг агуулсан учраас дэлгэрэнгүй тайлбар хийхэд их цаг хугацаа, бусад олон зүйл шаардагдах тул аль болох товчхон оновчтой тайлбар хийхийг зорьлоо. Судалгааны ажлын асуулт бүрээр тодорхой хэмжээний тайлбар дүгнэлтүүдийг хийсний зэрэгцээ хавсралт болгонд зохих хэмжээний дүгнэлтүүдийг тусгасан учир энэхүү төгсгөлийн хэсэгт дээр ангилсан дэд бүлэг тус бүрээр товчхон дүгнэж цаашид авах арга хэмжээний талаар дурьдсан болно.

*Эдийн засгийн өсөлт тогтворгүй, үр өгөөж нь иргэдэд тэгш бус хуваарилагдаж байна ...*

Иргэдийн дийлэнх нь эдийн засгийн байдал хэвэндээ эсвэл муудсан гэж хариулсан байна. Гэтэл ҮСГ-ын мэдээгээр ДНБ-ний сүүлийн хоёр жилийн өсөлт нийтдээ 16.9 хувьтай байгаа. Энэхүү эдийн засгийн өсөлт иргэдэд төдийлөн

мэдрэгдээгүй нь хачирхалтай. Иймд шинээр бий болсон нийгмийн баялаг хэтэрхий тэгш бус хуваарилагддаг гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Энэ нь манай улсын эдийн засгийн өсөлтийг экспортын гол түүхий эд болох алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлт бий болгож байгаа, эдгээр түүхий эдийг олборлох салбарт гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд олноор үйл ажиллагаа явуулдаг, ногдол ашгаа гадагшаа нутаг руугаа шилжүүлдэг байж болох талтай ч улсын төсөвт тодорхой хэмжээний татварын орлого бий болж баялгийн хуваарилалтийг зөв зохистой түвшинд барих боломж байна. Нөгөө талаар орлогын хуваарилалт тэгш бус байгаа нь нийгэмд эмх замбараагүй байдал бий болгох эрсдэлтэй. Иймд Засгийн газар нийгмийн баялгийг дахин хуваарилах асуудалд нухацтай хандах нь чухал болов уу. Шинээр бий болсон баялгийг дахин хуваарилахад нийгмийн халамж, тэтгэмжээр дамжуулахаасаа илүү эдийн засгийн бусад салбарт ажлын байр бий болгон, улмаар бусад салбарт баялаг бүтээх нөхцлийг бүрдүүлж ажиллах нь үр ашигтай гэдгийг дурьдах нь илүүц бизээ.

2005 онд ДНБ-ний өсөлт 6.2 хувьтай гарсан нь 2004 оныхоос даруй 4.5 нэгжээр бага, 2003 оныхоос 0.6 нэгжээр их байна. Эдгээр тоо баримт нь эдийн засгийн өсөлт тогтворгүй байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч 6.2 хувь гэдэг чамлахааргүй өндөр өсөлт бөгөөд хэрвээ энэхүү өсөлтийг тогтвортой хадгалж чадах юм бол 11.2 жилийн дараа манай эдийн засаг хоёр дахин нэмэгдэх боломжтой. Манай улсын экспортын гол түүхий эд болсон зэс, алтны дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэл манай эдийн засгийн өсөлтийг тодорхойлсон хэвээр байна. Хэдийгээр олон жилийн турш эдийн засгийг түүхий эдээс хамаарах хамаарлыг бууруулах, баялаг бий болгох замаар хөгжүүлнэ гэж ярьж бичдэг ч бодит байдал дээр манай улсын эдийн засгийн бүтэц бараг хэвээрээ хадгалагдан үлджээ. Иймд эдийн засгийн өсөлтийг баялаг бий болгох замаар хөгжүүлэх, түүхий эдийн үнийн өөрчлөлтийн эрсдлээс хамгаалах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нөгөө талаар нэгэнт алт, зэс зэрэг эрдэс баялаг нөхөн сэргээгдэхгүй учир байгалийн баялаг шавхагдсаны дараа яах вэ гэдгээ одооноос бодож төлөвлөн эдийн засгаа удирдах шаардлага гарч ирж байна. Бидний дараа дараагийн үеийнхэн манай улсын байгалийн баялгаас адилхан тэгш хүртэх эрхтэй учраас байгалийн баялгаас орж ирж байгаа хөрөнгөнөөс нөөцийн санг цаашид байгуулах нь зүйтэй болов уу. ОХУ, Кувейт, Бахрейн зэрэг улсууд нөөцийн сан байгуулан, цаашид байгалийн баялгаа дуусвал эдийн засгаа хөгжүүлэх стратегийн бодлоготой байдаг байна.

Иргэдийн дийлэнх нь зээлийн хүүг бууруулж, татварын ачааллыг багасгаснаар үндэсний үйлдвэрлэлээ сэргээж улмаар эдийн засгийн өсөлтийг хангаж чадна гэж үзжээ. Монголбанкны зүгээс зээлийн хүүг бууруулах талаар шат дараалсан арга хэмжээ авсаар байна. Банкуудын дүрмийн санг нэмж найман тэрбум төгрөгт хүргэсэн байгаа. Манай банкууд хэмжээний хувьд томорч байж өргөжилтийн үр өгөөжөөр зардлаа бууруулах боломж бий. Цаашилбал, Монголбанк заавал байлгах нөөцийн хувь хэмжээ, заавал байлгах нөөцийн дундаж үлдэгдэлд ТБҮЦ-ны хамгийн бага хүүгээр хүү төлөх зэрэг асуудлыг эргэн харж болох юм. Ер нь Төв банкууд мөнгөний бодлогын шууд арга хэрэгслээс татгалзаж байгаа ч шаардлагатай гэж үзвэл банкуудад харилцах дансны үлдэгдэлд хүү төлдгийг хуулийн хүрээнд хориглох арга хэмжээ авч болох юм. Учир нь банкуудын хооронд өрсөлдөөн ширүүсэх тусам харилцагчаа татахын тулд харилцахын үлдэгдэлд хүү төлж эхэлсэн нь банкуудын зардлыг өсгөж зээлийн хүүгээ бууруулах орон зайг хумьж байна. Мөн хадгаламжийн үлдэгдэлд төлөх хүүгийн дээд хэмжээг тогтоон өгч банкуудыг үйлчилгээний чанараар өрсөлдүүлэх, улмаар зээлийн хүүгээ бууруулах боломж олгох шаардлага байж мэднэ. Мэдээж хэрэг эдгээр арга

хэмжээнүүд нь захиргаадалтын арга хэмжээнүүд бөгөөд хэрэв үнэхээр зах зээлийн гажуудал (market failure) байгаа бол Төв банк эдгээр арга хэрэгслийг судалж үзэхэд илүүдэхгүй гэж бодож байна. Нөгөө талаас банкууд зээлдэгч нарын эрсдэлийн үнэлгээг зөв хийх, зардлын менежментээ мэргэжлийн өндөр түвшинд хийж өрсөлдөх шаардлага байна. Ялангуяа манай банкууд маш олон салбартай бөгөөд эдгээр салбаруудын үр ашиг хэр байдаг, оптимал байх хэмжээнээсээ илүү их байгаа сэтгэгдэл төрөхөөр байна. Хамгийн гол нь Төв банк, банкуудтайгаа харилцан ойлголцож хамтран ажиллавал татан төвлөрүүлсэн хөрөнгө хурдтай нэмэгдэж байгаа нөхцөлд ойрын ирээдүйд зээлийн хүү буурах нь дамжиггүй. Мөн Засгийн газар татварын хувь хэмжээг ирэх оны эхнээс бууруулах алхам хийсэн нь үндэсний үйлдвэрлэлд маш том дэмжлэг болно.

Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар эдийн засгийн өсөлтийг хангана гэж үзэж буй иргэдийн тоо өссөөр байна. Дээр баялаг бий болгох замаар хөгжих нь чухал ач холбогдолтойг дурьдсан ч эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн явцад уул уурхайн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг онцгой чухал юм. Иймд Засгийн газраас тус салбарын хөгжлийн талаар хуулийн орчинг боловсронгуй болгох, газрын сэргээлтний ажлыг зохих түвшинд хийх, нутгийн иргэдтэй хамтран ажиллах шаардлага урган гарч ирж байна. Бусад салбарын хувьд иргэдийн өгөх ач холбогдол буурсан ч ХАА, аялал жуулчлалын салбаруудад иргэд өндөр ач холбогдол өгсөөр байна. Боловсруулах салбарын үйлдвэрлэл Хятад улс Дэлхийн Худалдааны Байгууллагад элссэнээр Хятад улсын хөрөнгө оруулалттай зарим үйлдвэр үйл ажиллагаагаа зогсоох, үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээг хумих зэргээс шалтгаалан 2005 онд 24.1 хувиар буурсан нь энэ салбар эдийн засгийг түргэн хөгжүүлнэ гэсэн иргэдийн хариултад нөлөөлсөн байх. Гэсэн хэдий ч 2006 он гарсаар Европын холбоо манай улсад экспортын хөнгөлөлт үзүүлэхээр болсон нь тус салбар дахин сэргэх хандлагатай болж байна. Аливаа улс өөрийн эх орны байгалийн баялгийг хорогдуулахгүйгээр, байгаль орчиндоо хохирол учруулахгүйгээр эдийн засгаа хөгжүүлэхийг чухалчилдаг. Энэ стратегийг манай улс ч даган хөгжих нь зүйтэй болов уу. Ажиллах хүчээ мэргэшүүлэх, чадварыг нь дээшлүүлэх, орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, хамгийн гол нь баялгийг нэмэгдүүлэх (value added) нь нэн тэргүүний ач холбогдолтой юм. Харамсалтай нь эдгээр арга хэмжээг олон дахин давтдаг боловч ажил хэрэг болгодоггүй, иргэдийн чихний дасал болжээ. Иймд бодлого боловсруулагч нар дөнгөж өсөж өндийж байгаа салбаруудаа (infant industry) бодлогоор дэмжих, импортын тарифийг харилцан уялдаатай тогтоох арга хэмжээ авах шаардлагатай байна. Уг арга хэмжээг хэрэгжүүлэх нь бэрхшээлтэй боловч Дэлхийн худалдааны байгууллагатай харилцан тохирч, хохирч байгаа салбарын бараа бүтээгдэхүүний тарифийг хангалттай хэмжээнд өндөрсгөх боломжтой юм. Манай хоёр хөрш улс эдийн засгийн салбаруудаа хөл дээр нь босгож, бусад улс орнуудын компаниудтай өрсөлдөх чадвартай болсны дараа Дэлхийн худалдааны байгууллагад элсч байгааг анхаарах хэрэгтэй юм.

Иргэдийн ерээд хувь нь өргөн хэрэглээний барааны үнэ өссөн гэж хариулжээ. Аливаа эдийн засагт үнийн өсөлт бага хэмжээнд байх нь ашигтай билээ. Манай улсын инфляцийн түвшин сүүлийн жилүүдэд нэг оронтой тоонд байгаа нь Монголбанкны үйл ажиллагааг дүгнэх нэг үзүүлэлт болов уу. Мэдээжийн хэрэг үнэ бага зэргээр өсч байгаа учир иргэдийн дийлэнх үнэ өсч байна гэсэн байна. Харин өрхийн амьжиргааны түвшин хэвэндээ, доошилсон гэсэн иргэдийн хариулт дийлэнх байгаа нь дээр өгүүлсэн нийгмийн баялгийн тэгш бус хуваарилалт, эдийн засгийн өсөлт эдийн засгийн нийт салбарыг хамарч чадахгүй байгаатай холбоотой.



### *Ядуурал, ажилгүйдэл ихэссээр байна ...*

Хэдийгээр нийгмийн тулгамдсан асуултуудын хариулт өнгөрсөн оныхоос бага зэрэг сайжирсан ч иргэдийн дийлэнх буюу дөрөвны гурав нь ядуурал, ажилгүйдэл ихэссэн гэж хариулсан нь манай эдийн засагт байгаа гол шийдвэрлэх асуудлын нэг болов уу. Тодорхойлолт ёсоороо ядуу хүн гэж ажилгүй хүнийг хэлдэг учир дээрх хоёр хариулт бараг ижил гарсан байна. Манай улс ажиллах хүч гадаадад тогтмол тодорхой хэмжээгээр гаргаж байгаа, дотооддоо олон улсын байгууллагатай хамтран ажлын байр нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлж байгаа мөн төр засгаас ч олон төрлийн арга хэмжээ авч байгаа хэдий боловч ажилгүйчүүдийн тоо дорвитой буурахгүй харин ч сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Тэгэхээр ажлын байр бий болгож өргөн олныг хамруулах ажил хийгдэж байгаа ч үр дүн нь бага байна. Ажлын байр байхад ч иргэд хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байгаа дүр зураг харагдаж байна. Ерөнхийдөө манай иргэд уйгагүй ажил хөдөлмөр эрхлэж баялаг бий болгож байж үр шимийг нь амсаж, амьжиргааны түвшин дээшлэнэ гэдэг ойлголт, ухамсар сайн суугаагүй, бүх зүйлийг төрөөс нэхсэн, шаардсан, ганц удаагийн аз үзэх мөрийтэй тоглоомоор тоглох, нэг л өдөр бүх юм сайхан болчих мэт сэтгэлгээнээс салаагүй байна. Ер нь 1990 онд Монгол улс төрийг намаас салгах, эдийн засгийг хувийн хэвшил авч явах түүхэн сонголт хийснийг хүн бүр мартсан мэт сэтгэгдэл төрж байна. Иймд иргэдийн сэтгэлгээг өөрчлөх, хөдөлмөр эрхлэх сонирхлыг бий болгох талаар сурталчилгааны ажил хийх шаардлагатай байна. Мэдээжийн хэрэг төр засгийн зүгээс шаардлагатай бүхнийг ажил идэвхтэй хайж байгаа иргэдэд зориулж хийх нь зүйтэй. Ялангуяа хувиараа хөдөлмөр эрхлэх орчныг нь бүрдүүлж өгөх, түүнийгээ сурталчлан нийгмийг хамруулах нь өнөөгийн тулгамдсан чухал асуудал хэвээр байна. Энд төр, иргэдийн маань аль алийнх нь оролцоо чухал бөгөөд хамтарч ажилгүйдлийг бууруулах тал дээр ажиллавал үр дүн өндөр байх болов уу.

Ядуурал, ажилгүйдэл газар авсны нөгөө нэг шалтгаан бол манай улсын эдийн засгийн өсөлт тогтворгүй байгаа, нийгмийн баялгийн хуваарилалт хэт тэгш бус байгаатай холбоотой. Иймд нийгмийн баялгийг тэгш хуваарилах тал дээр Засгийн газар зохицуулалт хийх шаардлага гарч байна. Мөн ажилгүйчүүдийн тоог бууруулж, ядуурлын түвшинг багасгах арга хэмжээг цаг алдалгүй авах нь чухал юм. Манай улсын хувьд ОУВС-тай хамтран ажиллаж эхлээд 16 жил болсон, мөн дээр дурьдсанчлан иргэдэд хувиараа хөдөлмөр эрхлэх орчин болон боломжийг бүрдүүлж өгвөл зөвхөн ядуурал буурахаас гадна ажилгүйчүүдийн эгнээнд байгаа хүмүүсийн тоо ч цөөрнө. Үүнийг дагаад өрхийн орлого ч нэмэгдэнэ.

Газрыг хувьчлах нь газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, дор хаяж иргэд жижиг аж ахуй эрхлэхэд шаардлагатай зээлийн барьцаанд тавих өмчтэй болох давуу талтай. Мөн улсын мэдэлд байгаа газрын менежмент хувь хүмүүст шилжсэнээр газартай холбоотой хүнд суртал, хээл хахууль, маргаантай асуудлуудад цэг тавих давуу талуудтай. Харин хувьчлалыг ямар арга замаар хэрхэн явуулах, газрын байршил, үржил шимийг хэрхэн тооцож үнэлэх болон бусад олон асуудлуудыг шийдсэний дараа хувьчлах нь зүйтэй болов уу.

### *Татварын түвшин өндөр, ачаалал нь их хэвээр л байна ...*

Одоо мөрдөж байгаа татварын хуулиар татварын хувь хэмжээ 100.0 сая төгрөгөөс доошхи орлоготой аж ахуйн нэгж 15 хувь, түүнээс дээш орлоготой аж ахуйн нэгж 40 хувь байгаа. Манай улсад ихэнх аж ахуйн нэгж 15 хувийн татвар төлж байхад үйлчилж буй татварын хувь хэмжээ (effective tax rate) 30.5 хувь байгаа

нь хуульд заасан хувь (statutory tax rate)-аас өндөр, татварын дарамт байгааг илтгэж байна. Иргэдийн 70 гаруй хувь нь татварын ерөнхий түвшин өндөр, татварын ачаалал нэмэгдсэн гэж хариулсан нь бодит байдалтай тохирч байна. Иймээс Засгийн газраас татварын тухай багц хуулинд нэмэлт, өөрчлөлт хийх цаг болсныг мэдрэн ирэх оноос мөрдөх татварын багц хуулийг УИХ-аас батлуулсан байна. Ирэх оны нэг сарын нэгнээс эхлэн татварын хувь хэмжээг 5.0 тэрбумаас дээш орлоготой аж ахуйн нэгж 30 хувь, түүнээс доош орлоготой аж ахуйн нэгж 10 хувь байхаар татварын хуулинд зааж өглөө. Мөн хүн амын орлогын татварыг 10 хувь байхаар зааж өгсөн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд өссөн татварын дарамтыг бууруулахад чиглэгдсэн том алхам боллоо. Харин бусад татварын хувь хэмжээг өсгөхгүй байх нь чухал болов уу.

Манай улсын татварын ачаалал 2000 оноос хойш өсч 30 орчим хувьд хадгалагдсаар байна. Бусад орнуудтай харьцуулахад энэ нь тийм өндөр үзүүлэлт биш боловч хуульд заасан хэмжээнээс өндөр байна. Энэ нь Засгийн газрын хуримтлагдсан өр өндөр, яаралтай хүлээгдэж буй санхүүжилт их байсантай холбоотой болов уу. Гэвч сүүлийн жилүүдэд Засгийн газар дотоод өрийн ихэнх хэсгийг барагдуулсан, алт, зэсийн үнийн өсөлтөөс шалтгаалан татварын орлого өссөн зэрэг нь төсөвт зэрэгээр нөлөөлж татварын хувь хэмжээг бууруулах алхам хийх боломжтой боллоо. Үүнээс гадна Засгийн газарт татварын баазаа өргөжүүлэх, татварын нэг хувь хэмжээтэй болох гээд шийдэх асуудлууд байна. Татварын хоёр шатлалтай байх нь аж ахуйн нэгжийн томорч өсөх сонирхлыг бууруулж, олон жижиг аж ахуйн нэгжид хуваагдах зэрэг эдийн засгийн хувьд үр ашиггүй, зардал өндөртэй үйл ажиллагааг дэвэргэж байна. Иймд цаашид татварын нэг шатлалтай болох, оновчтой татварын хувь хэмжээг тогтоох тал дээр судалгаа шинжилгээний ажлыг нухацтай сайн хийх нь чухал байна. Нөгөө талаас компаниудын нийгмийн хариуцлага (corporate social responsibility)-ыг ойлгуулан үйл ажиллагаанд нь хэвшүүлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлдэг соёлд сургах шаардлага байна.

*Банкны салбарын үйл ажиллагаа сайжирч, түүнд итгэх иргэдийн итгэл дээшилсээр л ...*

Иргэдийн ихэнх нь банкуудын үйл ажиллагаа найдвартай, тооны хувьд боломжийн, банкинд итгэх итгэл нэмэгдсэн, өөрсдийн үйл ажиллагааг сурталчлан, үйлчилгээгээ хувь хүнд хүргэж хэвийн үйлчилж байна гэж үзжээ. Мөн мөнгөний хэрэгцээ гарвал ихэвчлэн банкаар үйлчлүүлдэг, гуравны нэг нь бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл ашигладаг байна. Харин ихэнх иргэд банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэггүй, хадгаламж зээлийн хоршооны гишүүн бус, үйл ажиллагааных нь талаар ойлголтгүй, эргэлзсэн байдалтай байна.

Банкуудад итгэх итгэл нэмэгдсэн нь иргэдийн банкууд дахь хадгаламжийн хэмжээний өсөлтөөр харагдах болов уу. Өнгөрсөн онд төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлт 26.3 нэгжээр, гадаад валютын хадгаламж 7.3 нэгжээр тус тус нэмэгджээ. Мөн банкуудын нийт актив 42.9 хувь, нийт зээлийн хэмжээ 41.8 хувь, өөрийн хөрөнгө 23.9 хувиар өсчээ. Энэ бүхний үр дүнд санхүүгийн зуучлал гүнзгийрч, банкны салбар эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулж байна. Банк санхүүгийн хөгжлийн талаар Монголбанкны жилийн тайланд дэлгэрэнгүй нийтэлсэн учир уншигч та тэндээс мэдээлэл авах бүрэн боломжтой.

Хадгаламж зээлийн хоршоотой холбоотой иргэдийг хохироосон хэрэг хэд хэд гарсан нь санхүүгийн салбарт сөргөөр нөлөөллөө. Энд иргэд хуулиа сайн

судлах, зах зээлийн эдийн засагтай нийгэмд аливаа арилжаа, гэрээний эрсдэлийг уг гэрээнд оролцогч талууд хүлээдэг гэдгийг ойлгох хэрэгтэй юм. Төрийн зүгээс хууль зүйн орчныг нь боловсронгуй болгох, иргэдийг залилсан санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа этгээдүүдийг цаг алдалгүй илрүүлж, үйл ажиллагааг нь зогсоож иргэдэд мэдээлэх шаардлагатай байна. Мөн манай улсад гарч буй энэ төрлийн хэргүүд хойд хөршид гараад тэндээ оршин тогтнох орон зайгүй болсныхоо дараа Монголд орж ирдгийг анхаарвал зохино. Мөн манай иргэдийн хялбар аргаар их хэмжээний ашиг олох гэсэн сэтгэлгээн дээр нь тоглож байхыг үгүйсгэхгүй.

Иргэдийн санал бодлоор манай улсын эдийн засагт дотоодын эх үүсвэрээс гадна гадаадын хөрөнгө оруулалттай банкууд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзжээ. Энэ нь эдийн засагт орох хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэн, улмаар банк санхүүгийн салбарын өрсөлдөөнийг бий болгож, үйл ажиллагааг нь улам боловсронгуй болгох сайн талтай юм.

*Ихэнх иргэдэд хадгалуулах мөнгө байхгүй, ... мөнгөтэй нь бэлнээр мөн төгрөгөөр байлгахыг л тэмүүлсээр ...*

Манай улсын иргэдийн бодит орлого бага учир ихэнхэд нь хэмнэх мөнгө гардаггүй байна. Хэмнэх мөнгөтэй буюу хэмнэх мөнгө байсан тохиолдолд банкинд хадгалуулах эсвэл худалдаа наймаа хийж эргэлдүүлэх болно гэж иргэдийн ихэнх нь урьд онуудын адил хариулсан байна. Иргэдийн дийлэнх нь мөнгөө бэлнээр байлгах сонирхолтой байгаа иргэдийн бодит орлого бага учир ихэнх нь өдрийн амь зуулгын хэдэн төгрөгийг бэлнээр авч явдаг, татварын бодлого болон тогтолцооны буруу үйл ажиллагаанаас шалтгаалан татвараас зайлсхийхийн тулд мөнгөө бэлнээр байлгадагтай холбоотой байж болох юм. Мөн нэмж хэлэхэд санхүүгийн зах зээлийн хөгжил дорой тул түүнд хөрөнгөө байршуулах боломжоор тун хомс байдаг нь ажиллагдаж байна. Харин банкинд мөнгөө хадгалуулахдаа төгрөгийг илүүд үзэж байгаа нь төгрөгийн ханшны уналт харьцангуй багасч тогтворжсон, төгрөгийн хадгаламжийн хүү өндөр, төгрөгийн бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл нэвтэрч эхэлсэн, хөдөө орон нутагт төгрөгийн үйлчилгээ зонхилж байгаатай холбоотой болов уу. Хадгаламжийн бодит хүү сүүлийн жилүүдэд эерэг түвшинд байгаа хэдий ч энэ жилийн санал асуулгаар иргэдийн ихэнх нь хадгаламжийн хүүг бага байна гэж хариулжээ.

*Зээлийн эрэлт их, хүү нь өндөр хэвээр л ...*

Иргэдийн дийлэнхэд зээлийн хэрэгцээ их, хүртээмж нь дунд зэрэг, банк санхүүгийн байгууллагаас зээл авахад хүндрэлтэй, мөн зээлийн хүүгийн хэмжээ өндөр байдаг байна. Сүүлийн жилүүдэд банк санхүүгийн салбар өргөжин тэлэхийн зэрэгцээ зээлийн хэмжээ, тоо, төрөл нэмэгдсэн хэдий ч иргэдийн хувьд эрэлт нь урьдын адил өндөр хэвээр байна. Харин банк санхүүгийн байгууллагуудаас олгож буй зээлийн хүү өндөр байгаа нь ихэнх иргэдийн зээл авах боломжийг нь хааж байна. Зээлийн хүү буурсан тохиолдолд зээл авах хүсэлтэй иргэдийн тоо өндөр хэвээр байна. Банкуудад зээлийн эх үүсвэр хангалттай байгаа боловч зээл олгоход барьцаа хөрөнгө, бизнес төлөвлөгөө зэрэг эргээд олгосон газарт учруулж болзошгүй эрсдэлээс сэрэмжилсэн олон зүйл шаардагдана. Зээлийн хүүг бууруулах, иргэдийн орлогыг хэрхэн нэмэгдүүлж болох талаар дээр дурьдсан учир энд давтсангүй.

*Бичил санхүү иргэдийн амьжиргаанд тусалсаар байна ...*

Бичил санхүүгийн үйл ажиллагаа хүн амын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах олон талын ач холбогдолтой билээ. Санал асуулгад оролцсон иргэдийн дийлэнх нь бичил санхүү гэж юу байдгийг мэддэг, оршин суугаа газар нь тодорхой хэмжээгээр бичил санхүү хөгжсөн, бичил зээл авах боломжтой байдаг нь сайшаалтай. Иргэдийн ихэнх нь бичил зээлээ худалдаа наймаа хийх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхэд зориулалдаг байна. Олонхи иргэд 1.5 саяаас 2 сая хүртэлх төгрөгийн зээл хүсдэг бол 250 мянгаас 1.5 сая төгрөгийн зээл хүссэн иргэд ч байна. Хугацааны хувьд урт байх тусмаа иргэдэд ашигтай байдаг байна. Хүн амын ядуурал ихтэй улсууд бичил санхүүгийн үйл ажиллагааг дэлгэрүүлэн амжилтанд хүрсэн байдаг нь олон учир цаашид бичил санхүүгийн үйл ажиллагааг улам дэлгэрүүлж, бичил зээлийн хэмжээ болон хугацааг бага боловч нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүүг нь тодорхой хэмжээгээр бууруулж өгвөл ядуурлаас гарах, ажилгүйдлийг тоог багасгах, эдийн засгийн өсөлтийг хангах төр засгийн бодлогод дорвитой хувь нэмэр оруулах болно.

*Зоосон мөнгөний хэрэгцээ бага, хорин мянган төгрөгөөс илүү дүнтэй мөнгөн дэвсгэрт гүйлгээнд гаргах шаардлага байхгүй ...*

Иргэдийн талаас илүү хувь нь зоосон мөнгөний хэрэгцээ байдаггүй гэсэн нь зоосон мөнгө гүйлгээнд гаргах тохиолдолд зоосон мөнгөний ач холбогдлыг олон нийтэд сайн ойлгуулах, сурталчлахын чухлыг харуулж байна. Мөн зоосон мөнгөний эрэлт бий болж байж зоосон мөнгөний хэрэгцээ гарах нь ойлгомжтой тул зоос ашигладаг автомат машиныг өргөнөөр ашигладаг болох нь зүйтэй болов уу. Одоохондоо хорин мянган төгрөгөөс илүү дүнтэй мөнгөн дэвсгэрт гүйлгээнд гаргах шаардлага байхгүй гэж иргэдийн ихэнх үзэж байна. Харин бага дүнтэй мөнгөн дэвсгэрт эдийн засагт хангалттай хэмжээгээр гүйж байгаа нь иргэдийн санал асуулгаас харагдаж байна. Мөнгөн дэвсгэртийн нууцлалын хувьд ихэнх иргэд маань мөнгөн дэвсгэртийн нууцлалын тухай мэдээллийг авч чаддаггүй байна. Иймд цаашид мөнгөн тэмдэгтийн нууцлалын талаар иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчлах шаардлага урган гарч ирж байна. Мөн мөнгөн дэвсгэртүүдийн амьдралын хугацаа иргэд мөнгөн дэвсгэртийг хэрхэн хадгалж, эдэлж хэрэглэж байгаагаас шууд хамаарна. Дийлэнх иргэд мөнгөн тэмдэгттэй соёлтой боловсон харьцаж хэрэглэдэг гэсэн боловч мөнгөн тэмдэгтийн амьдралын хугацаа богино байна. Цаашид мөнгөн тэмдэгтийн амьдралын хугацааг уртасгах зорилгоор нийт иргэдийг түрийвч хэрэглэдэг, мөнгөн тэмдэгттэй соёлтой, хүндэтгэлтэй харьцаж занших шаардлага урган гарч байна.

Энэ судалгааны ажил нь хэдий маш товч боловч их өргөн хүрээг хамарснаараа ач холбогдолтой боллоо. Үүний зэрэгцээ Хавсралт I-V-д иргэдийг харьяалал, хүйс, нас, боловсрол, ажил эрхлэлтийн байдлаар ангилан, бүлэг тус бүрээр нь тайлбар, дүгнэлт хийсэн нь та бүхний сонирхолыг илүүд татна гэдэгт найдаж байна. Дараа дараагийн судалгааны ажлуудаа (санал асуулга) тухайн үеийн тулгамдсан асуудал тус бүрээр нь тусад нь хийж та бүхний сонорт хүргэнэ. Эцэст нь судалгааны ажилд идэвхтэй оролцсон МУИС-ын Социологийн тэнхим, Монголбанкны МБСГ-ын хамт олонд талархсанаа илэрхийлье.

**МОНГОЛБАНК**

## I. ХАРЪЯАЛАЛ

Нийгэм эдийн засаг болон банк, санхүүгийн салбарын талаар явуулсан санал асуулгад иргэдийн хариулах хандлага нь газар зүй болон эдийн засгийн онцлог шинж чанараас хамаарч харилцан өөр байж болох юм. Аймгуудын эдийн засгийн хөгжил, ДНБ-д эзлэх хувийн жин, хүн амын суурьшил болон бусад хүчин зүйлээс хамаарч 18 аймаг болон Улаанбаатар хотын оршин суугчдын дунд асуулга явуулж нийт 6401 иргэдийг хамруулав. Санал асуулгад иргэдийн хариулсан байдлыг аймаг тус бүрээр авч үзье.

## I.1. Улаанбаатар хот

2005 оны эцсийн байдлаар Улаанбаатар хотын өрхийн тоо 215.7 мянга, хүн ам 965.3 мянгад хүрчээ. Судалгаанд хотоос 1205 иргэн оролцсоны 55.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 21.2 хувь нь 25 нас хүртэлх, 23.5 хувь нь 25-34 насны, 22.7 хувь нь 35-44 насны, 20.0 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 10.0 хувь нь бүрэн бус дунд, 30.9 хувь нь бүрэн дунд, 13.2 хувь нь тусгай дунд, 45.9 хувь нь дээд боловсролтой хүмүүс болно. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 22.2 хувь нь улсын байгууллага, 20.5 хувь нь хувийн байгууллагад ажилладаг бөгөөд 20.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 25.7 хувь нь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 25-34 насны, дээд боловсролтой, ажилгүй хүмүүс байна. Судалгаанд оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

I.1.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд

- Эдийн засгийн байдлыг иргэдийн олонх буюу 37.4 хувь нь муудаж байна гэж дүгнэсэн нь 2005 оны (цаашид өмнөх гэх) санал асуулгын дүнгээс 2.3 нэгжээр буурчээ. Харин хэвэндээ гэж 30.9 хувь, сайжирсан гэж 23.7 хувь нь хариулсан байна. Сайжирсан гэж хариулсан хүмүүсийн хувийн жин 1.4 нэгжээр өсчээ.
- Иргэдийн 21.8 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 30.2 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 15.1 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 22.3 хувь нь зээлийн хүүг бууруулах, 9.3 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэй гэсэн бодолтой хүмүүс хамгийн их байна. Харин өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад татварыг бууруулах гэсэн санал 3 нэгжээр буурч, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих болон бизнесменүүдээ урамшуулах гэсэн санал 1.7 болон 1.5 нэгжээр өсчээ.
- Иргэдийн 30.7 хувь нь уул уурхай, 20.9 хувь нь хөдөө аж ахуй, 14.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 18.5 хувь нь аялал жуулчлал, 6.5 хувь нь банк санхүү, 7.5 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулсан байна. Нэг жилийн хугацаанд уул уурхайд өгсөн санал 10.4 нэгжээр өссөн бол бусад салбаруудыг сонгосон нь 1.4-3.6 нэгжээр буурчээ.
- Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 90.6 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс 2.6 нэгжээр буурсан үнэлэлт юм. Харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 1.7 хувь нь өгсөн бол

тогтворжиж байна гэж 5.8 хувь нь хариулжээ. Тогтворжиж байна гэсэн хариултын хувийн жин 1.3 нэгжээр нэмэгджээ.

### 1.1.2 Нийгмийн тулгамдсан асуудал

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 17.7 хувь нь дээшилж байна, 33.1 хувь нь доошилж байна, 47 хувь нь хэвэндээ байна гэж хариулсан бөгөөд доошилж байна гэсэн хариултын хувийн жин 4.8 нэгжээр буурч, дээшилж байна буюу хэвэндээ гэсэн хариултынх 0.4 нэгж болон 3.7 нэгжээр тус бүр өсчээ.
- Хүн амын ядуурлыг иргэдийн 77.7 хувь нь нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өндөр хувиар үнэлсэн байна. Ядуурал буурсан гэсэн хариултыг 7.3 хувь нь өгсөн бол хэвэндээ гэж 11.5 хувь нь хариулжээ. 2005-2006 онд хүн амын ядуурал нэмэгдэж байна гэсэн хариултын эзлэх хувь 3 нэгжээр буурч, хэвэндээ гэсэн хариултынх 2.6 нэгжээр өсчээ.
- Иргэдийн дийлэнх буюу 76.1 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 7.7 хувь нь буурсан, 12 хувь нь хэвэндээ, 4.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Өмнөх онтой харьцуулбал ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзэх нь 5.1 нэгжээр буурчээ.
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 62.1 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 24.1 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 13.8 хувь нь өгчээ. Газар хувьчлалыг дэмжиж байгаа хүмүүсийн хувийн жин 8 нэгжээр буурч, дэмжихгүй хүмүүсийнх 5.7 нэгжээр өсчээ.

### 1.1.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 69.4 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад 3 нэгжээр багасчээ. Харин боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 17.4 хувь нь өгсөн нь 2005 оныхтой харьцуулбал 3.8 нэгжээр их бөгөөд 13.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 62.3 хувь нь өгсөн бол 16.5 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачаалал буурсан гэж иргэдийн 4.4 хувь, мэдэхгүй гэж 16.8 хувь нь хариулжээ. Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 3.8 нэгжээр буурч, буурсан гэсэн хариултынх 2.4 нэгжээр нэмэгджээ.
- Иргэдийн дийлэнх буюу 71.2 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 7.6 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 21.2 хувь хариулсан байна. Нэг жилийн хугацаанд татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын хувийн жин 2.5 нэгжээр өсч мэдэхгүй гэсэн хариултын эзлэх хувь 2.6 нэгжээр буурчээ.

### 1.1.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 47.5 хувь нь олон, 5 хувь нь цөөн, 41.1 хувь нь боломжийн, 6.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Олон байна гэсэн хариултын хувийн жин 4.1 нэгжээр буурч, боломжийн гэсэн хариултынх 7.6 нэгжээр өсчээ.
- Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн 35 хувь нь найдвартай гэж дүгнэсэн байна. Эргэлзээтэй гэсэн хариултыг иргэдийн 43.7 хувь нь өгсөн бол 13 хувь нь найдваргүй гэж хариулжээ. Өмнөх судалгааны

дүнтэй харьцуулахад найдвартай гэсэн хариултын хувийн жин 8.4 нэгжээр өсч, эргэлзээтэй гэсэн хариултынх 4.5 нэгжээр буурчээ.

- Иргэдийн 30 хувь нь банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн, 18.8 хувь нь буурсан, 39.3 хувь нь хэвэндээ, 11.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэсэн хариулт өөрчлөгдөөгүй боловч буурсан болон хэвэндээ гэсэн хариултын эзлэх хувь 2.9 болон 5.9 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултынх 9.2 нэгжээр буурчээ.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 60.8 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 22.3 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 16.9 хувь нь хариулсан байна. Нэг жилийн хугацаанд банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултын хувийн жин 1.3 буурсан бол чадахгүй байна гэсэн нь 3.4 нэгжээр нэмэгджээ.
- Иргэдийн тал хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн хариултыг иргэдийн 33.4 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 16.3 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариултын эзлэх хувь 6.9 нэгжээр өссөн бол мэдэхгүй гэсэн хариултынх тэр хэмжээгээр багасчээ.
- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 33.9 хувь нь банк, 4.3 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 4.1 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 24.1 хувь нь ломбард, 27 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Хүмүүс банкинд хандах нь 8.8 нэгжээр өссөн бол банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоонд хувь хүнд хандах бага зэрэг буурчээ.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 26.4 хувь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 71.2 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 2.4 хувь нь өгсөн байна. Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултын хувийн жин 6.5 нэгжээр буурч, үйлчлүүлдэггүй гэсэн хариултынх 9.3 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултынх 2.7 нэгжээр буурчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 45.2 хувь, ойлголтгүй иргэд 40.4 хувь байгаа бол мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 14.4 хувь нь өгчээ. Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголтгүй гэсэн хариултын хувийн жин 5.3 нэгжээр өссөн бол ойлголттой болон мэдэхгүй гэсэн хариултауд тэр хэмжээгээр буурчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 10.4 хувь нь хариулсан бол үгүй гэсэн хариултыг 85.9 хувь нь өгсөн байна. 2005 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал гишүүн мөн гэсэн хариултын эзлэх хувь 3.4 нэгжээр буурсан бол биш гэснийх нь мөн ижил хэмжээгээр өсчээ.
- Иргэдийн 19.5 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн бол 35.9 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 44.5 хувь нь өгсөн байна. Иргэдийн хадгаламж зээлийн хоршоог дэмжих нь 10.6 нэгжээр буурч, дэмжихгүй байгаа нь 22.4 нэгжээр өссөн бол мэдэхгүй гэсэн нь 11.9 нэгжээр буурчээ.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 43.4 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 23.7 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 32.9 хувь

нь өгсөн байна. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж дүгнэсэн иргэдийн эзлэх хувь 5.8 нэгжээр буурч, эсрэг хариултынх 6.9 нэгжээр өсчээ.

- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 32.2 хувь нь хариулсан бол 64 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 3.8 хувь нь хариулсан байна. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг иргэдийн хувийн жин 8.7 нэгжээр өсч, хэрэглэдэггүй гэсэн хариултынх 6.9 нэгжээр буурчээ.

#### 1.1.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 31.8 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 10 хувь нь бусдад зээлдүүлдэг, 20.9 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 2.1 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 2.1 хувь нь хувьцаа худалдаж авдаг гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад хуримтлуулсан мөнгөө банк санхүүгийн байгууллагад хадгалуулах нь 8.2 нэгж, худалдаа наймаа хийх нь 0.4 нэгж, хувьцаа авах нь 0.3 нэгжээр тус тус өсч, харин худалдаа наймаа хийж эргэлдүүлэх нь 4.6 нэгж, үнэт цаасанд байршуулах нь 0.4 нэгжээр буурсан байна.
- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 69.9 хувь нь хариулсан бол 11.8 хувь нь бэлэн бус, 4.1 хувь нь үнэт цаас, 4.7 хувь нь хувьцаанд мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Хоёр жилийн хугацаанд мөнгөө бэлнээр байлгах явдал 2.2 нэгжээр өсч, хувьцаанд хөрөнгө оруулах нь 1.8 нэгжээр өссөн бол бусад хэлбэрээр байлгах нь 4.8 нэгжээр буурчээ.
- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 80.5 хувь нь төгрөгөөр, 14.8 хувь нь америк доллараар, 4.7 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Мөнгөө төгрөгөөр хадгалдаг гэсэн хариултын хувийн жин 2.5 нэгжээр багасч, америк доллараар хадгалдаг гэсэн хариултынх 3.7 нэгжээр нэмэгджээ.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 53.4 хувь нь бага гэж үзсэн байхад 27.7 хувь нь боломжийн байна гэж хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 18.9 хувь нь өгчээ. Тус асуудлаар өгсөн бага гэсэн хариултын хувийн жин нэг жилийн хугацаанд 3.5 нэгжээр өссөн бол боломжийн гэснийх нь 3.3 нэгжээр буурсан байна.

#### 1.1.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 75.9 хувь нь өгсөн бол 20.3 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Зээлийн хэрэгцээтэй гэсэн хариултын хувийн жин 4.8 нэгжээр буурч, хэрэгцээгүй гэсэн хариултынх мөн ижил хэмжээгээр өсчээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 23.1 хувь нь үзсэн байхад 50.2 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 26.6 хувь нь өгчээ. Зээл хүртээмжтэй гэсэн хариултын эзлэх хувь 3.6 нэгжээр буурч, хүртээмжгүй гэсэн хариултынх 4.3 нэгжээр өсчээ.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 21.5 хувь нь хариулсан бол 57.1 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариулт өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 21.4 хувь нь өгсөн байна. Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэсэн хариултын



хувийн жин 2.7 нэгжээр буурч, хүндрэлтэй гэсэн хариултынх мөн ижил хэмжээгээр өсчээ.

- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 66.9 хувь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшин боломжийн гэж иргэдийн 18.8 хувь нь хариулсан байна. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос бараг өөрчлөгдөөгүй байна.

#### 1.1.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 59.2 хувь, ойлголтгүй гэж 25 хувь, харин мэдэхгүй гэж 15.8 хувь нь хариулжээ. Бичил санхүүгийн талаар ойлголттой гэх хариултын хувийн жин 4.5 нэгжээр багассан бол ойлголтгүй болон мэдэхгүй гэсэн хариултынх 2.9, 1.6 нэгжүүдээр өсчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 17.4 хувь нь сайн, 40.3 хувь нь дунд зэрэг, 14.9 хувь нь огт хөгжөөгүй, 27.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Огт хөгжөөгүй гэсэн хариултын хувийн жин 4.7 нэгжээр буурсан бол сайн болон дунд зэрэг хөгжсөн гэснийх тус бүр 2.1 нэгжээр өсчээ.
- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 47.2 хувь, боломжгүй гэж 28.4 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 24.4 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 24.4 хувь нь худалдаа наймаа, 15.2 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 11.7 хувь нь үйлчилгээ, 7.8 хувь нь хүнсний ногоо, 6.8 хувь нь газар тариалан, 4.6 хувь нь аялал жуулчлал, 3.9 хувь нь мал аж ахуй, 2.6 хувь нь зочид буудал, үлдсэн 22.8 хувь нь бусад төрлийн бизнес эрхэлдэг гэж хариулсан байна. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй байна.
- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн 42.5 хувь нь 1.5-2 сая төгрөг гэж хариулжээ. Харин иргэдийн 18.5 хувь нь 500000-1000000 төгрөг, 15.1 хувь нь 1 сая-1.5 сая төгрөг, 14.3 хувь нь 250000-500000 төгрөг, 6.4 хувь нь 100000-250000 төгрөг гэсэн хариулт өгсөн байна. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос бараг өөрчлөгдөөгүй байна.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн талаас илүү буюу 53 хувь нь үзсэн байна. Харин иргэдийн 19.8 хувь нь 6-9 сар, 16.5 хувь нь 3-6 сар, 10.7 хувь нь 3 сар хүртэлх гэсэн хариулт өгчээ. Өмнөх судалгаатай харьцуулахад 9 сараас 1 жил хүртэл хугацаа гэсэн хариултын эзлэх хувь 6.7 нэгжээр буурсан бол бусад хариултууд 1.4-3 нэгжээр өсчээ.
- Бизнес эрхэлхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 38.7 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 14.4 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 20 хувь, зээл авах боломжгүй гэж 17.8 хувь нь дүгнэсэн байна. Өмнөх оны судалгаатай харьцуулахад зээлийн хүү өндөр гэсэн хариултын хувийн жин 9.7 нэгжээр буурсан бол зээлийн хэмжээ бага, зээл авах боломжгүй, зээлийн хугацаа хангалтгүй гэсэн хариултуудын эзлэх хувь 4.8, 2.2, 4 нэгжээр тус тус өсчээ.

#### 1.1.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 25.5 хувь, байхгүй гэж 67.6 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 6.9 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 34.2 хувь тийм, 52.7 хувь нь үгүй, 13.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 34.6 хувь, байхгүй гэж 54 хувь, мэдэхгүй гэж 11.4 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 72.6, таалагддаггүй гэж 17 хувь, мэдэхгүй гэж 1.4 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 75.6 хувь нь тийм, 18.1 хувь нь үгүй, 6.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 44.6 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 43.8 хувь нь чанаргүй, 11.6 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.
- Санал асуулгад оролцогчдын 20.2 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 64.3 хувь нь чаддаггүй, 15.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн ихэнх нь буюу 86 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 10.5 хувь нь үгүй, 3.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

## **1.2. Булган аймаг**

2005 оны эцсийн байдлаар Булган аймгийн өрхийн тоо 15.0 мянга, хүн ам 59.9 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 258 иргэн оролцсоны 66.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 15.6 хувь нь 25 нас хүртэлх, 29.3 хувь нь 25-34 насны, 28.9 хувь нь 35-44 насны, 17.6 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 11.1 хувь нь бүрэн бус дунд, 26.9 хувь нь бүрэн дунд, 20.2 хувь нь тусгай дунд, 41.9 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 38.6 хувь нь улсын байгууллага буюу 21.7 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 23.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 7.5 хувь нь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 25-34 насны, дээд боловсролтой, улсын байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.2.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 22.7 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 (цаашид өмнөх гэх) оны санал асуулгатай ижил үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 32.7 хувь нь муудсан гэж хариулсан нь 3.7 нэгжээр өссөн үзүүлэлт бол иргэдийн 35.5 хувь нь хэвэндээ гэсэн нь 4.6 нэгжээр буурсан үнэлэлт юм.
- Иргэдийн 24.9 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 29.4 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 8.8 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 27.6 хувь нь зээлийн хүүг бууруулах, 7.9 хувь нь бизнесменүүдэд урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх

гэсэн хариулт өгсөн байна. Нэг жилийн хугацаанд зээлийн хүүг бууруулах, бизнесменүүдээ урамшуулах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих нь зүйтэй гэсэн бодол нэмэгдэж, татвар бууруулах, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг хангах нөхцөл төдийлөн биш гэж үзэх болжээ.,

- Иргэдийн 26.7 хувь нь уул уурхай, 21.1 хувь нь хөдөө аж ахуй, 16.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 16.4 хувь нь аялал жуулчлал, 8.7 хувь нь банк санхүү, 9.2 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. 2005-2006 онд уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбарыг чухал гэж үзэх нь нэмэгдэж аялал жуулчлал, хөдөө аж ахуй, банк санхүүгийн салбарын ач холбогдлыг багасгасан байна.
- **Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 93 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс 1.7 нэгжээр өссөн үнэлэлт юм. Харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 0.8 хувь нь өгсөн бол тогтворжиж байна гэж 4.7 хувь нь хариулжээ. Тогтворжиж байна гэсэн хариултын хувийн жин 2.4 нэгжээр буурч, буурч байна гэсэн хариултынх 0.4 нэгжээр нэмэгджээ.**

### **1.2.2 Нийгмийн тулгамдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 22.4 хувь нь дээшилж байна, 32.5 хувь нь доошилж байна, 44.7 хувь нь хэвэндээ байна гэж хариулжээ. Өмнөх санал асуулгатай харьцуулахад дээшилж байна гэсэн хариултын хувийн жин 7.4 нэгжээр өссөн бол доошилж байна, хэвэндээ гэсэн хариултынх 1.4, 6.5 нэгжээр тус тус буурсан байна.
- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 81.6 хувь нь нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өмнөх санал асуулгын дүнгээс 1.8 нэгжээр өсчээ. Ядуурал буурсан гэсэн хариултыг маш цөөхөн буюу 5.1 хувь нь өгсөн бол ядуурал хэвэндээ гэж 11.7 хувь нь хариулжээ.
- **Иргэдийн дийлэнх буюу 77.3 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 6.6 хувь нь буурсан, 12.9 хувь нь хэвэндээ, 3.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Ажилгүйчүүдийн тоо өссөн гэсэн хариултын хувийн жин 7.2 нэгжээр буурч, буурсан болон хэвэндээ гэсэн хариултынх 4.2, 2.6 нэгжээр тус тус өсчээ.**
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 54.1 хувь, дэмжихгүй байна гэж 31.3 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 14.6 хувь нь өгчээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн газар хувьчлалыг дэмжсэн хариулт 14.5 нэгжээр буурсан бол дэмжихгүй байгаа болон мэдэхгүй гэсэн хариултын нийлбэр нь 14.5 нэгжээр өсчээ.

### **1.2.3 Татварын талаар**

- Татварын ерөнхий түвшинг өндөр байна гэж иргэдийн 74.6 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад хэвэндээ байна. Харин боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 15.6 хувь нь өгсөн бол 9.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 67.7 хувь нь өгсөн бол 18.1 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 2.4 хувь нь буурсан, 11.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 0.83 нэгжээр буурч, буурч байна гэсэн хариултынх 1.2 нэгжээр өсчээ.

- Иргэдийн дийлэнх буюу 70.5 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 9.2 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 20.3 хувь нь хариулсан байна. Татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын эзлэх хувь 0.9 нэгжээр өсч, бага гэсэн хариултынх 3.6 нэгжээр нэмэгджээ.

#### 1.2.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 33.1 хувь нь олон, 8.7 хувь нь цөөн, 52.8 хувь нь боломжийн, 5.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. 2005-2006 онд банкуудын тоо олон гэсэн хариултын хувийн жин 2 нэгжээр буурч, боломжийн гэсэн хариултынх 4.2 нэгжээр нэмэгджээ.
- Өмнөх санал асуулгын дүнтэй харицуулахад банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг найдвартай гэж дүгнэсэн нь 9.8 нэгжээр өсч 58.4 хувьд хүрсэн байна. Харин найдвар муутай гэж 1.2 хувь, мэдэхгүй гэж 6.7 хувь нь хариулсан бөгөөд өмнөх асуулгын дүнгээс буурсан байна. Харин эргэлзээтэй гэсэн дүгнэлтийг 33. хувь өгсөн нь өмнөх санал асуулгын үзүүлэлтээс 6.6 нэгжээр бага байна.
- Иргэдийн 55.9 хувь нь банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн, 4.7 хувь нь буурсан, 34 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 6.3 нэгжээр өсч, буурсан болон хэвэндээ гэсэн хариултынх 2.9, 2.8 нэгжээр тус тус багасчээ.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 73 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 16.3 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 10.7 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултын хувийн жин 3.1 нэгжээр өсч, эсрэг хариултынх 2.3 нэгжээр буурчээ.
- Иргэдийн 71.1 хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн хариултыг иргэдийн 21.5 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 7.4 хувь нь хариулсан байна. 2005-2006 онд банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариултын эзлэх хувь 7.2 нэгжээр өссөн бол эсрэг хариултынх 7.5 нэгжээр буурчээ.
- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн ихэнх нь буюу 64.7 хувь нь банк, 3.7 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 0.6 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 11.1 хувь нь ломбард, 15.5 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Өмнөх асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн банкинд хандах нь үлэмж хэмжээгээр буюу 231.3 хувиар нэмэгдэж ББСБ, ХЗХ, Ломбард, хувь хүнээр үйлчлүүлэх нь 7.4, 12.2, 3.2, болон 1.5 хувиар тус тус багассан байна.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 25.1 хувь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 71.8 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 3.1 хувь нь өгсөн байна. Нэг жилийн хугацаанд банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг иргэдийн эзлэх хувь 7.4 нэгжээр буурч эсрэг хариултынх нь 6.7 нэгжээр өсчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 34.1 хувийг эзэлж байгаа бол ойлголтгүй иргэд 47.7 хувь, мэдэхгүй нь 18.2 хувийг эзэлж байна. ХЗХ-ны талаар ойлголттой гэсэн хариултын эзлэх хувь 11.3 нэгжээр буурч эсрэг хариултынх нь 20.4 нэгжээр өсчээ.

- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 6.6 хувь хариулсан бол үгүй гэсэн хариултыг иргэдийн ихэнх нь буюу 91.1 хувь нь өгсөн байна. Харин мэдэхгүй гэж 2.3 хувь нь хариулжээ. Өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал гишүүн мөн гэсэн хариултын хувийн жин 1 нэгжээр буурч гишүүн биш гэсэн хариултынх 21.4 нэгжээр өсч, мэдэхгүй гэснийх нь 20.4 нэгжээр буурчээ.
- Иргэдийн 12.5 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн бол 36.2 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 51.4 хувь нь өгсөн байна. ХЗХ-ий үйл ажиллагааг дэмжсэн хариултын хувийн жин 13.1 нэгжээр буурч, дэмжээгүй нь 31 хувиар нэмэгдсэн бол мэдэхгүй гэснийх 17.8 нэгжээр багасчээ.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 41.7 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 21.3 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 37 хувь нь өгсөн байна. Нэг жилийн хугацаанд гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэсэн хариултын хувийн жин 12.8 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултынх 16 нэгжээр буурчээ.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 42.4 хувь нь хариулсан бол 53.7 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 3.9 хувь нь хариулсан байна. Хоёр судалгааны дүнг харьцуулж үзэхэд бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг хүмүүсийн хувийн жин 25.3 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хүмүүсийнх 25 нэгжээр буурчээ.

#### 1.2.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 39.5 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 1.9 хувь нь бусдад зээлдүүлдэг, 28.3 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 0.4 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 1.6 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 28.3 хувь нь бусад хэлбэрээр хэрэглэдэг гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд банк, санхүүгийн байгууллагад хадгалуулах, худалдаа наймаа хийх зэрэг нь нэмэгдэж, бусдад зээлдүүлэх хэлбэрээр хуримтлуулсан мөнгөө зарцуулах нь багасчээ.
- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 67.8 хувь нь хариулсан бол 17.6 хувь нь бэлэн бус, 4.1 хувь нь үнэт цаас, 4.5 хувь нь хувьцаа, 10.6 хувь нь бусад хэлбэрүүдээр мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулдаг гэсэн хариултын хувийн жин 27.8 нэгжээр өсч, бэлэн бус, үнэт цаас, хувьцаа болон бусад хэлбэрээр мөнгөө байршуулдаг гэсэн хариултынх 2.1, 9.6, 8.8, 7.3 нэгжээр тус тус буурчээ.
- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 92.8 хувь нь төгрөгөөр, 4.3 хувь нь америк доллараар, 3 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад мөнгөө төгрөгөөр хадгалах явдал ихэсч, бусад мөнгөний нэгжийг дорд үздэг болжээ.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 59.1 хувь нь бага байна гэж үзсэн байхад иргэдийн 29 хувь нь хүүний түвшин боломжийн байна гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 11.9 хувь нь өгчээ. Бага байна гэсэн хариултын хувийн жин 5.2 нэгжээр багасч, боломжийн гэсэн хариултынх 4.1 нэгжээр өсчээ.

### 1.2.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 89.1 хувь нь өгсөн бол 9.7 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 1.2 хувь нь өгчээ. Нэг жилийн хугацаанд зээлийн хэрэгцээ 14 нэгжээр өсч, хэрэгцээгүй гэж хариулсан хүмүүсийн хувийн жин 9.6 нэгжээр багасчээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 51.6 хувь нь үзсэн байхад 35 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 13.5 хувь нь өгчээ. Зээл хүртээмжтэй гэсэн хариултын хувийн жин 3 нэгжээр багасч, эсрэг хариултынх нь 3.5 нэгжээр өсчээ.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 50.2 хувь нь хариулсан бол 40.4 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариултыг өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 9.4 хувь нь өгсөн байна. Хүндрэлгүй гэсэн хариултын эзлэх хувь 4.3 нэгжээр өсч, хүндрэлтэй гэсэн хариултынх 6.3 нэгжээр өсчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултын эзлэх хувь 10.6 нэгжээр буурчээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 74.6 хувь нь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшинг боломжийн гэж иргэдийн 21.7 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 3.8 хувь нь өгчээ. Нэг жилийн хугацаанд зээлийн хүүний түвшин өндөр байна гэсэн хариултын эзлэх хувь 14.7 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултынх мөн ижил хувиар буурчээ.

### 1.2.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 62 хувь нь хариулсан бол 23.1 хувь ойлголтгүй гэж хариулжээ. Харин мэдэхгүй гэж 14.9 хувь нь хариулжээ. Өмнөх оныхтой харьцуулбал ойлголттой гэсэн хариултын эзлэх хувь 3.3 нэгжээр буурсан бол эсрэг хариултынх 12.6 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултынх 9.3 нэгжээр буурчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 29.3 хувь нь сайн, 41.3 хувь нь дунд зэрэг, 10.3 хувь нь огт хөгжөөгүй, 19 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Бичил санхүү сайн хөгжсөн, дунд зэрэг, огт хөгжөөгүй гэсэн хариултаудын хувийн жин 6.3, 2, 4.7 нэгжээр нэмэгдсэн бол мэдэхгүй гэснийх 13.1 нэгжээр буурчээ.
- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 58.3 хувь, боломжгүй гэж 22.9 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 18.8 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал боломжтой гэсэн хариултын эзлэх хувь 5.7 нэгжээр буурч, эсрэг хариултынх нь 7.2 нэгжээр өсчээ.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 37.1 хувь худалдаа наймаа, 10.8 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 8.3 хувь нь хүнсний ногоо, 7.5 хувь нь мал аж ахуй, 7.1 хувь нь үйлчилгээ, 7.1 хувь нь газар тариалан, 1.3 хувь нь аялал жуулчлал гэж хариулсан байна. Харин дийлэнх буюу 20.8 хувь нь бусад гэсэн хариулт өгчээ. Газар тариалан, хүнсний ногоо, мал аж ахуй, худалдаа наймаа гэсэн хариултын хувийн жин 2.4, 2.4, 4.4, 20.3 нэгжээр тус тус нэмэгдсэн бол боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлал, болон бусад гэсэн хариултынх 4.7, 10.8, 1.8 болон 12.8 нэгжээр тус тус буурчээ.
- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн 17.8 хувь нь хариулаагүй байна. Харин хариулсан

иргэдийн 19.8 хувь нь 500000-1000000 төгрөг, 39.2 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг, 14.6 хувь нь 250000-500000 төгрөг, 14.2 хувь нь 1 сая-1.5 сая төгрөг, 7.1 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ. Хоёр оны судалгааг харьцуулбал 100000-аас бага мөнгө шаардлагатай болон 1-1.5 сая, 1.5-2 сая гэсэн хариултын хувийн жин 1.9, 2.8, 14.2 нэгжээр тус тус өссөн бол бусад хариултынх 3.2-10.1 хувиар буурчээ.

- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 67 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 10.7 хувь нь 6-9 сар, 7.9 хувь нь 3 сар хүртэлх, 14.4 хувь нь 3-6 сар гэсэн хариулт өгчээ. Өмнөх онтой харьцуулбал 3 сар хүртлэх болон 6-9 сар гэсэн хариултын хувийн жин 1.7 болон 4.2 нэгжээр буурсан бол 3-6 сар гэснийх 5.8 нэгжээр өсчээ.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 49.3 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 18.1 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 20.5 хувь нь хариулсан байна. Үүнийг өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал зээлийн хүү өндөр, зээл авах боломжгүй гэсэн хариултын хувийн жин 4.1, 3.6 нэгжээр тус тус буурсан бол зээлийн хэмжээ бага, зээлийн хугацаа хангалтгүй гэснийх 4.3, 7.3 нэгжээр тус тус өссөн байна.

#### 1.2.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 34.7 хувь, байхгүй гэж 55.6 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 9.6 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 28.7 хувь тийм, 56.6 хувь нь үгүй, 14.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 37.2 хувь, байхгүй гэж 52.2 хувь, мэдэхгүй гэж 10.7 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 81.8, таалагддаггүй гэж 10.7 хувь, мэдэхгүй гэж 7.5 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 76.9 хувь нь тийм, 15.1 хувь нь үгүй, 8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 51.4 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 35.3 хувь нь чанаргүй, 13.3 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.
- Санал асуулгад оролцогчдын 27.7 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 55 хувь нь чаддаггүй, 17.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн ихэнх нь буюу 89.4 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 7.8 хувь нь үгүй, 2.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

#### 1.3. Хөвсгөл аймаг

2005 оны эцсийн байдлаар Хөвсгөл аймгийн өрхийн тоо 29.7 мянга, хүн ам 121.7 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 290 иргэн оролцсоны 61.5 хувь нь

эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар, нийт оролцогчдын 13.5 хувь нь 25 нас хүртэлх, 34 хувь нь 25-34 насны, 27.1 хувь нь 35-44 насны, 17.7 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 13.6 хувь нь бүрэн бус дунд, 31.7 хувь нь бүрэн дунд, 16.7 хувь нь тусгай дунд, 38 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 21.3 хувь нь улсын байгууллага, 32.1 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 30 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 11.5 хувь нь ажилгүй иргэд байна. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 25-34 насны, дээд боловсролтой, хувийн байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.3.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 31.8 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 оны санал асуулгын дүнгээс 5.9 нэгжээр өссөн үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 23.5 хувь нь муудсан гэж хариулсан бол иргэдийн 38.1 хувь нь хэвэндээ гэсэн үнэлэлт өгчээ.
- Иргэдийн 24.6 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 26.9 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 8.9 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 29.6 хувь нь зээлийн хүүг бууруулах, 8.7 хувь нь бизнесменүүдэд урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Хоёр судалгааны дүнг харьцуулахад зээлийн хүүг бууруулж, бизнесмэнүүдэд урамшуулал үзүүлэх нь эдийн засгийн өсөлтийг хангана гэж үзэх нь олширчээ.
- Иргэдийн 24.4 хувь нь уул уурхай, 25.9 хувь нь хөдөө аж ахуй, 10.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 22.0 хувь нь аялал жуулчлал, 10.5 хувь нь банк санхүү, 5.1 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. Өнгөрсөн жилийн хугацаанд уул уурхайн салбарыг чухалчилсан хариултын хувийн жин 3.8 нэгжээр, худалдаа үйлчилгээний салбарыг чухалчилсан хариултын хувийн жин 1.8 нэгжээр тус тус өссөн байна. Харин хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлал, банк санхүүгийн салбарыг эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж үзэгсэдийн хувь тус бүр нь 0.2, 1.8, 1.4, 1.8 нэгжээр буурсан байна.
- **Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 93.1 хувь хариулсан нь 2005 оны санал асуулгын дүнгээс төдийлөн өөрчлөгдсөнгүй. Харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 1.0 хувь нь өгсөн бол тогтворжиж байна гэж 4.5 хувь нь хариулжээ.**

### **1.3.2 Нийгмийн түлгэмдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 22.9 хувь нь дээшилж байна, 18.8 хувь нь доошилж байна, 55.6 хувь нь хэвэндээ байна хэмээн хариулжээ. 2005 оны санал асуулгын дүнтэй харьцуулахад дээшилж байна гэсэн хариулт өсч доошилж байна гэсэн хариулт нь буурсан байна.
- Иргэдийн 75.4 хувь нь хүн амын ядуурлыг нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өмнөх санал асуулгын дүнгээс 7.5 нэгжээр буурчээ. Ядуурал буурсан гэсэн хариултыг 8.3 хувь нь өгсөн бол ядуурал хэвэндээ гэж 11.8 хувь нь, мэдэхгүй гэж 4.5 хувь нь хариулжээ.
- **Иргэдийн дийлэнх буюу 74.2 хувь нь ажилгүйчүүдийн тоог өссөн гэж үзсэн бол 5.9 хувь нь буурсан, 15.0 хувь нь хэвэндээ, 4.9 хувь нь мэдэхгүй гэж**



хариулсан байна. Ажилгүйчүүдийн тоо өссөн гэсэн хариултын хувийн жин 8.2 нэгжээр буурч, буурсан гэсэн хариултынх 2.5 нэгжээр өсчээ. Мөн хэвэндээ хэмээн хариулсан байдал нь 3.5 нэгжээр, мэдэхгүй гэж хариулсан байдал нь 2.2 нэгжээр тус тус өссөн байна.

- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 55.1 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 31.2 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 13.7 хувь нь өгчээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн газар хувьчлалыг дэмжсэн хариулт 0.4 нэгжээр буурсан байна.

### 1.3.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 76.3 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс 2.2 нэгжээр буурсан байна. Харин боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 15.0 хувь нь өгсөн бол 8.7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 65.7 хувь нь өгсөн бол 19.9 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачаалал буурсан гэж иргэдийн 2.8 хувь, мэдэхгүй гэж 11.5 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 оны судалгааны дүнд мэдэгдэхүйц өөрчлөлт оруулсангүй.
- Иргэдийн дийлэнх буюу 61.7 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 10.8 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 27.5 хувь нь хариулсан байна. 2005-2006 онд татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын хувийн жин 10.1 нэгжээр буурч, бага гэсэн хариултынх 3.3 нэгжээр, мэдэхгүй гэсэн хариултынх 6.8 нэгжээр тус тус өсчээ.

### 1.3.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 32.2 хувь нь олон, 6.6 хувь нь цөөн, 56.1 хувь нь боломжийн, 5.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Өнгөрсөн жилийн хугацаанд банкуудын тоо олон байна гэсэн хариултын хувийн жин 3.3 нэгжээр өсч, харин цөөн байна гэсэн хариулт 4.1 нэгжээр буурчээ.
- Өмнөх санал асуулгын дүнтэй харицуулахад иргэдийн банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг найдвартай гэж дүгнэсэн нь 10 нэгжээр өсч 58.0 хувьд хүрсэн байна. Харин найдвар муутай гэж 4.5 хувь, мэдэхгүй гэж 9.4 хувь хариулжээ. Харин эргэлзээтэй гэсэн дүгнэлтийг 28.1 хувь өгсөн нь өмнөх санал асуулгын дүнгээс 11.1 нэгжээр буурсан байна.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 48.8 хувь нь нэмэгдсэн, 6.9 хувь нь буурсан, 33.9 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл буурсан гэсэн хариултынх 1.9 нэгжээр багасчээ.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 69.9 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 15.9 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 14.2 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадахгүй байна гэсэн хариултын хувийн жин 5.1 нэгжээр буурч, мэдэхгүй гэсэн хариултынх 5 нэгжээр өсчээ.
- Иргэдийн 68.4 хувь нь банк, санхүүгийн байгууллагуудыг хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн

хариултыг иргэдийн 24.7 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 6.9 хувь нь хариулсан байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал хувь хүнд хүрч хэвийн үйлчилж байна гэсэн хариулт 11.3 нэгжээр өсч, хүнд сурталтай чирэгдэлтэй байна гэсэн хариулт 10.4 нэгжээр буурчээ.

- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 63.9 хувь нь банк, 3.0 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 3.9 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 8.7 хувь нь ломбард, 16.0 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Өмнөх судалгаатай харьцаалбал банкинд хандана гэсэн хүмүүсийн хувийн жин 10.1 хувиар өсч, хадгаламж зээлийн хоршоо болон хувь хүн, бусад эх сурвалжид хандах хүмүүсийн эзлэх хувь тус бүр 1.5 болон 5.7, 1.75 нэгжээр буурсан байна.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 33.5 хувь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 63.4 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 3.2 хувь нь өгсөн байна. Өмнөх судалгаатай харьцуулбал банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх нь багасчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 39.9 хувь байгаа бол ойлголтгүй иргэд 40.6 хувь байна. Харин мэдэхгүй гэж иргэдийн 19.6 хувь нь хариулжээ. Энэ нь өмнөх судалгааны дүнгээс ойлголттой иргэд 9.7 нэгжээр буурч, ойлголтгүй иргэд 6.6 нэгжээр, мэдэхгүй иргэд 3.3 нэгжээр нэмэгдсэнийг харуулж байна.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 10.1 хувь хариулсан бол үгүй гэсэн хариултыг 87.1 хувь нь өгсөн байна. Харин мэдэхгүй гэж 2.8 хувь нь хариулжээ.
- Иргэдийн 22.5 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн бол 18.0 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 59.5 хувь нь өгсөн байна. Эндээс үзвэл зөв буюу хуулийн дагуу гэж үздэг иргэдийн хувь 10.4 нэгжээр буурч, буруу буюу хууль бус гэж үздэг иргэд 8.6 нэгжээр өсч, мэдэхгүй иргэд 1.9 нэгжээр нэмэгдсэн байна.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 42.4 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 21.9 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 35.8 хувь нь өгсөн байна. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэсэн хариултын хувийн жин 2 нэгжээр өсч, эсрэг хариултынх нь 5.8 нэгжээр буурч, мэдэхгүй гэсэн хариулт өгсөн иргэд 4 нэгжээр өсчээ.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 25.7 хувь нь хариулсан бол 68.3 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариултыг өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 6.0 хувь нь хариулсан байна. Өнгөрсөн жилийн хугацаанд бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэсэн хариултын эзлэх хувь 8 нэгжээр өсч, харин хэрэглэдэггүй гэсэн хариултын тоо 7.1 нэгжээр буурчээ.

### 1.3.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 32.2 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 5.5 хувь нь бусдад зээлдүүлдэг, 31.9 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 0.7 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 2.3 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 27.4 хувь нь бусад гэж хариулжээ. 2005-2006 онд хуримтлуулсан мөнгөө банк, санхүүгийн байгууллагад хадгалуулах, худалдаа наймаа хийж эргэлдүүлэх нь харгалзан

2.9 болон 4.7 нэгжээр нэмэгдэж, бусдад зээлдүүлэх болон бусад арга хэрэгсэл нь харгалзан 1.9, 5.8 нэгжээр буурчээ.

- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 65.9 хувь нь хариулсан бол 14.9 хувь нь бэлэн бусаар, 3.4 хувь нь үнэт цаасаар, 3.0 хувь нь хувьцаагаар мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Өнгөрсөн жилийн хугацаанд мөнгөө бэлэн бус хэлбэрээр байршуулах нь багасч, бусад хэлбэрийг сонгох нь нэмэгджээ.
- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 89.9 хувь нь төгрөгөөр, 6.9 хувь нь ам.доллараар, 3.2 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Мөнгөө төгрөгөөр хадгалдаг гэсэн хариултын хувийн жин 4.8 нэгжээр буурч, Америк доллараар хадгалдаг гэсэн хариултын хувийн жин 3.9 нэгжээр өсчээ.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 53.2 хувь нь бага байна гэж үзсэн байхад иргэдийн 32.0 хувь нь хүүний түвшин боломжийн байна гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 14.8 хувь нь өгчээ. Хадгаламжийн хүүний түвшин бага гэсэн хариултын хувийн жин 16.4 нэгжээр буурч, боломжийн гэсэн хариултынх 10.2 нэгжээр, мэдэхгүй гэсэн хариултынх 6.2 нэгжээр өсчээ.

#### 1.3.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 83.9 хувь нь өгсөн бол 12.6 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 3.5 хувь нь өгчээ. Өнгөрсөн жилийн хугацаанд зээлийн хэрэгцээгүй гэсэн хариултын хувийн жин 2.0 нэгжээр нэмэгдэж, хэрэгцээтэй гэсэн хариултын хувийн жин 2.9 нэгжээр буурч мэдэхгүй гэсэн хариултын хувийн жин 1.5 нэгжээр тус тус нэмэгджээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 48.0 хувь нь үзсэн байхад 27.4 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 24.6 хувь өгчээ. 2005-2006 онд зээл хүртээмжтэй гэсэн хариулт 10.8 нэгжээр өсч, хүртээмжгүй гэсэн хариултын хувийн жин 18.7 нэгжээр буурч, мэдэхгүй гэх иргэд 7.9 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 39.7 хувь нь хариулсан бол 47.7 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариултыг өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 12.5 хувь нь өгсөн байна. Хоёр судалгааны дүнг харьцуулахад банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэсэн хариултын хувийн жин 1.9 нэгжээр өсч, хүндрэлтэй гэсэн хариултынх 3.5 нэгжээр буурчээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 71.9 хувь нь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшин боломжийн гэж иргэдийн 20.4 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 7.7 хувь нь өгчээ. Зээлийн хүүний түвшин өндөр байна гэж үзэх нь буурч, харин боломжийн гэсэн хариултын эзлэх хувь 4.8 нэгжээр нэмэгджээ.

#### 1.3.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 63.2 хувь нь хариулсан бол 19.4 хувь нь ойлголтгүй гэж хариулжээ. Харин мэдэхгүй гэж 17.4 хувь нь хариулжээ. Эндээс үзвэл өмнөх жилийн судалгааны дүнгээс ойлголттой иргэд 11.0 нэгжээр буурч, ойлголтгүй иргэд 7.5 нэгжээр нэмэгдэж, мэдэхгүй иргэд 3.5 нэгжээр нэмэгдсэн байна.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 30.8 хувь нь сайн, 43.6 хувь нь дунд зэрэг, 5.9 хувь нь огт

хөгжөөгүй, 19.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Өмнөх судалгаатай харьцуулбал дунд зэрэг хөгжсөн ба огт хөгжөөгүй гэсэн хариултууд харгалзан 2.0, 3.2 нэгжээр буурч, мэдэхгүй гэсэн хариулт 4.5 нэгжээр нэмэгдсэн байна.

- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 57.3 хувь, боломжгүй гэж 23.8 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 18.9 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал бичил зээл авах боломжтой иргэд 8.9 нэгжээр буурч, боломжгүй иргэд 7.4 нэгжээр, мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн иргэд 1.5 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 41.3 хувь нь худалдаа наймаа, 10.2 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 2.7 хувь нь аялал жуулчлал, 2.7 хувь нь үйлчилгээ, 7.2 хувь нь хүнсний ногоо, 5.8 хувь нь газар тариалан, 9.6 хувь нь мал аж ахуй гэж хариулсан байна. Өмнөх оныхтой харьцуулбал газар тариалан 1.9 нэгжээр, худалдаа наймаа 12.3 нэгжээртус тус өссөн байна. Харин жижиг дунд үйлдвэрлэл 2.9 нэгжээр, үйлчилгээ 6.2 нэгжээр, бусад 6.9 нэгжээр тус тус буурсан байна.
- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 37.3 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг гэж хариулжээ. Харин иргэдийн 21.8 хувь нь 500000-1000000 төгрөг, 15.9 хувь нь 1 сая-1.5 сая төгрөг, 11.8 хувь нь 250000-500000 төгрөг, 8.9 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 73.7 хувь хариулсан байна. Харин иргэдийн 10.7 хувь нь 6-9 сар, 9.3 хувь нь 3-6 сар гэсэн хариултыг өгчээ.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 52.7 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 16.0 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 15.2 хувь нь хариулсан байна.

### 1.3.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 29.0 хувь, байхгүй гэж 60.1 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 10.8 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 28.3 хувь тийм, 55.5 хувь нь үгүй, 16.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 35.9 хувь, байхгүй гэж 50.3 хувь, мэдэхгүй гэж 13.8 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 72.1, таалагддаггүй гэж 14.5 хувь, мэдэхгүй гэж 13.4 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 69.7 хувь нь тийм, 24.0 хувь нь үгүй, 6.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 43.1 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 43.1 хувь нь чанаргүй, 13.8 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.
- Санал асуулгад оролцогчдын 31.0 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 52.8 хувь нь чаддаггүй, 16.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

- Иргэдийн ихэнх нь буюу 86.8 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 9.4 хувь нь үгүй, 3.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

#### **I.4. Говь-Алтай аймаг**

2005 оны эцсийн байдлаар, Говь-Алтай аймгийн өрхийн тоо 15.5 мянга, хүн ам 60.4 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 301 иргэн оролцсоны 53.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 21.3 хувь нь 25 нас хүртэлх, 29.6 хувь нь 25-34 насны, 23.9 хувь нь 35-44 насны, 17.3 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 8.7 хувь нь бүрэн бус дунд, 19.1 хувь нь бүрэн дунд, 15.4 хувь нь тусгай дунд, 56.9 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 44.4 хувь нь улсын байгууллага, 21.5 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 16.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 9.8 хувь нь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 25-34 насны, дээд боловсролтой, улсын байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

##### **1.4.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 35.2 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 оны санал асуулгын дүнгээс 9.7 нэгжээр өссөн үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 23.5 хувь нь муудсан, 33.4 хувь нь хэвэндээ гэж үнэлсэн нь өмнөх оныхоос тус бүр 4.6, 5.8 нэгжээр буурчээ.
- Иргэдийн 19.7 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 28.5 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 14.2 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 27.6 хувь нь зээлийн хүүг бууруулах, 8.3 хувь нь бизнесменүүдэд урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Нэг жилийн хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангахын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, зээлийн хүүг бууруулах, бизнесменүүдэд урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй гэсэн бодол олширчээ.
- Иргэдийн 28.4 хувь нь уул уурхай, 25.5 хувь нь хөдөө аж ахуй, 12.0 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 15.7 хувь нь аялал жуулчлал, 8.3 хувь нь банк санхүү, 7.9 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. Тус асуултын хариултанд нэг жилийн хугацаанд уул уурхай гэсэн хариултын эзлэх хувь 6.9 нэгжээр өсч, бусад хариултуудын хувьд онцын өөрчлөлт гараагүй байна.
- Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 87.0 хувь нь хариулсан бол буурч байна гэсэн хариултыг иргэдийн 4.7 хувь нь өгч тогтворжиж байна гэж 6.5 хувь нь хариулжээ. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос бараг өөрчлөгдөөгүй байна.

##### **1.4.2 Нийгмийн түлгэмдсэн асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 23.2 хувь нь дээшилж байна, 20.2 хувь нь доошилж байна, 55.2 хувь нь хэвэндээ байна хэмээн хариулжээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад хэвэндээ гэсэн хариулт 7 нэгжээр өсч муудсан гэсэн хариулт нь 9.3 нэгжээр буурсан байна.

- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 68.8 хувь нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өмнөх санал асуулгын дүнгээс 7.9 нэгжээр багасчээ. Ядуурал буурсан гэсэн хариултыг маш цөөхөн буюу 9.4 хувь нь өгсөн бол ядуурал хэвэндээ гэж 17.8 хувь нь хариулжээ.
- Иргэдийн дийлэнх буюу 66.6 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 7.8 хувь нь буурсан, 18.2 хувь нь хэвэндээ, 7.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. 2005-2006 онд ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзэх нь багасчээ.
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 51.9 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 33.3 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 14.8 хувь нь өгчээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн газар хувьчлалыг дэмжсэн болон дэмжээгүй хариулт тус бүр 2.4, 3.0 нэгжээр буурсан бол мэдэхгүй гэсэн хариултын эзлэх хувь 5.4 нэгжээр өссөн байна.

#### 1.4.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 61.8 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс 11.0 нэгжээр багасчээ. Харин боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 23.6 хувь өгсөн бол 14.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 51.4 хувь нь өгсөн бол 27.4 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 7.1 хувь нь буурсан, 14.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулж үзэхэд татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 11.5 нэгжээр буурсан бол бусад хариултын хувьд бага зэрэг өсчээ.
- Иргэдийн дийлэнх буюу 70.0 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 12.3 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 17.7 хувь нь хариулсан байна. Татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын эзлэх хувь 3.9 нэгжээр өсч, харин бага болон мэдэхгүй гэсэн хариултынх 1.4, 2.5 нэгжээр тус тус буурчээ.

#### 1.4.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 23.3 хувь нь олон, 14.0 хувь нь цөөн, 58.7 хувь нь боломжийн, 4.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулж үзэхэд банкуудын тоо олон гэсэн хариултын хувийн жин 11.2 нэгжээр буурч, цөөн болон боломжийн гэсэн хариултынх 3.9, 9.1 нэгжээр тус тус өсчээ.
- Өмнөх санал асуулгын дүнтэй харицуулахад иргэдийн банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг найдвартай гэж дүгнэсэн нь 4.4 нэгжээр өсч 56.4 хувьд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, найдвар муутай гэж 7.0 хувь, мэдэхгүй гэж 4.7 хувь хариулсан нь өмнөх асуулгын дүнгээс буурав. Харин эргэлзээтэй гэсэн дүгнэлтийг 31.9 хувь өгсөн нь өмнөх санал асуулгын үзүүлэлтээс 2.5 нэгжээр бага байна.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 50.3 хувь нь нэмэгдсэн, 6.7 хувь нь буурсан, 36.3 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос бараг өөрчлөгдөөгүй байна.

- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 64.6 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 25.6 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 9.8 хувь нь хариулсан байна. 2005-2006 онд банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултын эзлэх хувь 6.3 нэгжээр буурч, эсрэг хариултынх нь 9.1 нэгжээр өсчээ.
- Иргэдийн 54.2 хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн хариултыг иргэдийн 38.8 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 7.0 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариултын хувийн жин 11.2 нэгжээр буурч, эсрэг хариултынх нь мөн ижил хэмжээгээр өсчээ.
- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 58.2 хувь нь банк, 4.4 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 2.5 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 7.5 хувь нь ломбард, 20.8 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд банк, хадгаламж зээлийн хоршоо, хувь хүнд хандах хүмүүс ялимгүй багассан байна.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 24.5 хувь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 70.1 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 5.4 хувь нь өгсөн байна. 2005-2006 онд банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх нь эрс багасчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 40.5 хувьтай байгаа бол ойлголтгүй иргэд 35.8 хувьтай байна. Харин мэдэхгүй гэж иргэдийн 23.6 хувь нь хариулжээ. ХЗХ-ны талаар ойлголттой гэсэн хариултын эзлэх хувь 6.2 нэгжээр буурчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 7.0 хувь нь хариулсан бол үгүй гэсэн хариултыг 87.9 хувь нь өгсөн байна. Харин мэдэхгүй гэж 5.0 хувь нь хариулжээ. ХЗХ-ны гишүүн гэсэн хариултын хувийн жин 5.7 нэгжээр буурчээ.
- Иргэдийн 20.7 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн бол 26.9 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 52.4 хувь нь өгсөн байна. Зөв буюу хуулийн дагуу гэсэн хариултын эзлэх хувь 12.5 нэгжээр буурчээ.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 48.6 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 21.6 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 29.7 хувь нь өгсөн байна. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 33.0 хувь нь хариулсан бол 61.0 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 6.0 хувь нь хариулсан байна. Нэг жилийн хугацаанд бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэсэн хариултын эзлэх хувь 12.9 нэгжээр өсч, хэрэглэдэггүй гэсэн хариултынх нь 9.6 нэгжээр буурчээ.

#### 1.4.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 31.6 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 14.1 хувь нь бусдад

зээлдүүлдэг, 23.0 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 3.8 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 1.3 хувь нь хувьцаа худалдаж авдаг гэж хариулжээ. Хуримтлуулсан бусдад зээлдүүлэх, үнэт цаасанд байршуулах нь нэг жилийн хугацаанд нэмэгджээ.

- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 63.0 хувь нь хариулсан бол 16.9 хувь нь бэлэн бусаар, 5.2 хувь нь үнэт цаасаар, 4.9 хувь нь хувьцаагаар мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад бараг өөрчлөлт гараагүй байна.
- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 87.0 хувь нь төгрөгөөр, 7.2 хувь нь ам.доллараар, 5.8 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Нэг жилийн хугацаанд мөнгөө төгрөгөөр хадгалах нь буурч, бусад мөнгөний нэгжийг илүүд үзэх болжээ.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 57.9 хувь нь бага байна гэж үзсэн байхад 29.3 хувь нь хүүний түвшин боломжийн байна гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 12.8 хувь нь өгчээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад хадгаламжийн хүү бага гэсэн хариултын эзлэх хувь 5.6 нэгжээр буурч, боломжийн гэснийх 6.2 нэгжээр өссөн байна.

#### 1.4.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээтэй гэсэн хариултыг иргэдийн 79.0 хувь нь өгсөн бол 18.0 хувь нь зээлийн хэрэгцээ байхгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 3.0 хувь нь өгчээ. Зээлийн хэрэгцээтэй гэсэн хариултын хувийн жин 2.9 нэгжээр буурч, хэрэгцээгүй гэсэн хариултынх 2.1 нэгжээр өсчээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 50.4 хувь нь үзсэн байхад 33.0 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 16.7 хувь нь өгчээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад зээл хүртээмжтэй гэсэн хариултын эзлэх хувь 5.8 нэгжээр өсч, хүртээмжгүй гэсэн хариултынх 8.0 нэгжээр багасчээ.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 41.7 хувь нь хариулсан бол 49.7 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариулт өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 8.7 хувь нь өгсөн байна. Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэсэн хариултын хувийн жин 2.3 нэгжээр багасч, хүндрэлтэй гэсэн хариултынх 3.9 нэгжээр өсчээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 67.6 хувь нь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшин боломжийн гэж иргэдийн 25.3 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 7.1 хувь нь өгчээ. Зээлийн хүүний түвшин өндөр гэсэн хариултын хувийн жин 3.3 нэгжээр буурч, боломжийн гэсэн хариултынх 3.8 нэгжээр өсчээ.

#### 1.4.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 68.4 хувь нь хариулсан бол 19.5 хувь ойлголтгүй гэж хариулжээ. Харин мэдэхгүй гэж 12.1 хувь нь хариулжээ. Ойлголттой гэсэн хариултын хувийн жин 4.5 нэгжээр буурсан бол эсрэг хариултынх 3.1 нэгжээр өсчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 19.5 хувь нь сайн, 46.8 хувь нь дунд зэрэг, 18.2 хувь нь огт хөгжөөгүй, 15.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Сайн хөгжсөн болон



хөгжөөгүй гэсэн хариултын хувийн жин 1.8, 4.8 нэгжээр тус тус буурсан бол огт хөгжөөгүй гэснийх 7.7 нэгжээр өсчээ.

- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 61.7 хувь, боломжгүй гэж 21.4 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 16.6 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Өмнөх оныхтой харьцуулбал бичил зээл авах боломжтой гэсэн хариултын хувийн жин 3 нэгжээр буурч, боломжгүй гэснийх 2 нэгжээр өсчээ.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 34.2 хувь нь худалдаа наймаа, 9.7 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 5.0 хувь нь аялал жуулчлал, 5.0 хувь нь үйлчилгээ, 4.0 хувь нь хүнсний ногоо, 7.2 хувь нь газар тариалан, 11.9 хувь нь мал аж ахуй, 22.7 хувь нь бусад төрлийн гэж хариулсан байна. Үүнийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал газар тариалан, худалдаа наймаа, аялал жуулчлал гэсэн хариултууд бага зэрэг нэмэгдэж бусад нь багасчээ.
- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 40.9 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг гэж хариулжээ. Харин иргэдийн 22.9 хувь нь 500000-1000000 төгрөг, 14.3 хувь нь 1 сая-1.5 сая төгрөг, 13.6 хувь нь 250000-500000 төгрөг, 5.0 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ. 1.5-2 сая гэсэн хариултын хувийн жин 6.7 нэгжээр өсч бусад хариултынх төдийлөн анхаарал татахуйц өсөөгүй байна.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 53.7 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 19.5 хувь нь 6-9 сар, 17.6 хувь нь 3-6 сар гэсэн хариултыг өгчээ. 3-6 сар гэсэн хариултын хувийн жин 4.2 нэгжээр буурсан бол 6-9 сар гэснийх 3.1 нэгжээр өсчээ.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 51.0 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 17.6 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 17.0 хувь нь хариулсан байна. Өмнөх оны судалгаатай харьцуулбал зээлийн хүү өндөр гэсэн хариултын хувийн жин 9.5 нэгжээр буурсан бол зээлийн хэмжээ бага, хугацаа хангалтгүй гэсэн хариултынх 4.1, 9.5 нэгжээр тус тус өссөн байна.

#### 1.4.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 31.6 хувь, байхгүй гэж 60.2 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 8.2 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 38.5 хувь тийм, 46.5 хувь нь үгүй, 15.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 36.9 хувь, байхгүй гэж 50.0 хувь, мэдэхгүй гэж 13.1 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 79.3, таалагддаггүй гэж 11.9 хувь, мэдэхгүй гэж 8.8 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 70.7 хувь нь тийм, 21.3 хувь нь үгүй, 8.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 45.8 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 39.2 хувь нь чанаргүй, 15.0 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.

- Санал асуулгад оролцогчдын 25.0 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 62.7 хувь нь чаддаггүй, 12.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн ихэнх нь буюу 81.7 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 12.3 хувь нь үгүй, 6.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

## **1.5. Завхан аймаг**

2005 оны эцсийн байдлаар Завхан аймгийн өрхийн тоо 19.9 мянга, хүн ам 80.1 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 270 иргэн оролцсоны 60.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 16.0 хувь нь 25 нас хүртэлх, 30.9 хувь нь 25-34 насны, 29.4 хувь нь 35-44 насны, 19.3 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 13.4 хувь нь бүрэн бус дунд, 27.5 хувь нь бүрэн дунд, 18.2 хувь нь тусгай дунд, 40.9 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 42.8 хувь нь улсын байгууллага, 20.4 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 20.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 11.2 нь хувь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 25-34 насны, дээд боловсролтой, улсын байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.5.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 28.4 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 оны санал асуулгын дүнгээс 9.1 нэгжээр өссөн үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 25.4 хувь нь муудсан гэж хариулсан бол иргэдийн 37.7 хувь нь хэвэндээ гэсэн үнэлэлт өгчээ.
- Иргэдийн 35.2 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 31.1 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 8.5 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 26.2 хувь нь зээлийн хүүг бууруулах, 7.2 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Хоёр судалгааны дүнг харьцуулж үзэхэд татварын ачааллыг багасгах гэсэн хариултын хувийн жин 2.4 нэгжээр өсч, бусад хариултуудынх ялимгүй багассан байна.
- Иргэдийн 26.0 хувь нь уул уурхай, 28.8 хувь нь хөдөө аж ахуй, 10.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 15.1 хувь нь аялал жуулчлал, 8.9 хувь нь банк санхүү, 8.2 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд эдийн засгийг хөгжүүлэхэд уул уурхай, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний салбар чухал гэсэн хариултууд нэмэгдэж, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлал, банк санхүү гэсэн хариултууд багасчээ.
- **Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 94.4 хувь хариулсан нь 2005 оны санал асуулгын дүнгээс 2.6 нэгжээр өссөн үнэлэлт юм. Харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 1.1 хувь нь өгсөн бол тогтворжиж байна гэж 3.0 хувь нь хариулжээ.**

### **1.5.2 Нийгмийн тулгамдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 11.9 хувь нь дээшилж байна, 27.2 хувь нь доошилж байна, 57.1 хувь

нь хэвэндээ байна хэмээн хариулжээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад доошилсон гэсэн хариулт нь 7.0 нэгжээр буурсан байна.

- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 77.6 хувь нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өмнөх санал асуулгын дүнгээс 3.7 нэгжээр буурчээ. Ядуурал буурсан болон хэвэндээ гэсэн хариултыг маш цөөхөн буюу тус бүр 6.0, 14.2 хувь нь өгсөн байна.
- Иргэдийн дийлэнх буюу 77.4 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 6.7 хувь нь буурсан, 11.9 хувь нь хэвэндээ, 4.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Нэг жилийн хугацаанд ажилгүйчүүдийн тоо өссөн гэсэн хариулт 3.3 нэгжээр буурчээ.
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 41.7 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 43.2 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 15.0 хувь нь өгчээ. Газар хувьчлалыг дэмжсэн хариултын хувийн жин 16.2 нэгжээр буурч, эсрэг хариултынх 13.5 нэгжээр өсчээ.

### 1.5.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 72.6 хувь хариулсан бол боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 15.6 хувь нь өгч, 11.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 69.9 хувь нь өгсөн бол 17.5 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 1.9 хувь нь буурсан, 10.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 4.5 нэгжээр өсч, хэвэндээ гэсэн хариултынх 6.3 нэгжээр буурчээ.
- Иргэдийн дийлэнх буюу 64.3 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 13.2 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 22.6 хувь нь хариулсан байна. Татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын эзлэх хувь 2.6 нэгжээр буурч, бага гэсэн хариултынх 5.0 нэгжээр өсчээ.

### 1.5.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 35.9 хувь нь олон, 7.0 хувь нь цөөн, 52.2 хувь нь боломжийн, 4.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Банкуудын тоо олон гэсэн хариултын эзлэх хувь 3.4 нэгжээр өсч, цөөн гэсэн хариултынх 2.2 нэгжээр буурчээ.
- Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн 45.9 хувь нь найдвартай гэж дүгнэсэн байна. Эргэлзээтэй гэсэн хариултыг иргэдийн 40.0 хувь нь өгсөн бол 7.4 хувь нь найдваргүй гэж хариулжээ. Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа найдвартай гэсэн дүгнэлтийн хувийн жин 8.3 нэгжээр буурч, эргэлзээтэй гэсэн хариултын хувийн жин 4.2 нэгжээр өсчээ.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 38.1 хувь нь нэмэгдсэн, 12.7 хувь нь буурсан, 41.8 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэсэн хариултын эзлэх хувь 10.4 нэгжээр буурч, буурсан болон хэвэндээ гэсэн хариултынх 6.8, 4.4 нэгжээр тус тус өсчээ.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 59.9 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 21.6 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж

иргэдийн 18.6 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултын хувийн жин 5.2 нэгжээр буурч, мэдэхгүй гэсэн хариултынх 6.0 нэгжээр өсчээ.

- Иргэдийн 50.9 хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн хариултыг иргэдийн 42.0 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 7.1 хувь нь хариулсан байна. Нэг жилийн хугацаанд банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариултын хувийн жин 17.6 нэгжээр буурсан бол эсрэг хариултынх мөн ижил хэмжээгээр нэмэгджээ.
- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 58.5 хувь нь банк, 3.4 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 9.8 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 8.6 хувь нь ломбард, 16.9 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд банк, хувь хүнд хандах иргэдийн тоо бага зэрэг өсч, банк бус санхүүгийн байгууллага болон ломбардад хандах нь ялимгүй багасчээ.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 39.2 хувь нь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж 57.0 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг 3.8 хувь нь өгсөн байна. Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултын эзлэх хувь 4.0 нэгжээр буурч, эсрэг хариултынх 3.6 нэгжээр өсчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 51.7 хувь байгаа нь 2005 оныхтой харьцуулбал 6.8 нэгжээр багассан бол ойлголтгүй иргэд 33.7 хувь буюу 10.2 нэгжээр өссөн байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 14.6 хувь нь өгчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 23.3 хувь нь хариулсан нь 2005 оныхоос 2.5 нэгжээр буурсан үзүүлэлт бол үгүй гэсэн хариултыг 75.2 хувь нь өгсөн нь 3.9 нэгжээр өссөн дүн юм.
- Иргэдийн 33.5 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн бол 16.0 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 50.6 хувь нь өгсөн байна. Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг дэмжсэн хариултын хувийн жин 12.4 нэгжээр буурсан бол эсрэг хариултынх мөн ижил хэмжээгээр өсчээ.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 36.0 хувь нь хариулсан нь өмнөх оныхоос 12.7 нэгжээр буурсан үзүүлэлт бол ач холбогдолгүй гэж иргэдийн 29.9 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 34.1 хувь нь өгсөн байна.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 20.7 хувь нь хариулсан бол 72.6 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 6.8 хувь нь хариулсан байна. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэсэн хариултын хувийн жин 3.7 нэгжээр өсчээ.

#### 1.5.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 35.9 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 2.9 хувь нь бусдад зээлдүүлдэг, 28.6 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 0.4 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 3.3 хувь нь хувьцаа худалдаж авдаг гэж хариулжээ. Хуримтлуулсан мөнгөө банк, санхүүгийн байгууллагад

хадгалуулах, хувьцаа худалдаж авах нь нэмэгдэж, харин бусдад зээлдүүлэх, худалдаа наймаа хийх нь багасчээ.

- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 69.1 хувь нь хариулсан бол 10.6 хувь нь бэлэн бусаар, 3.0 хувь нь үнэт цаасаар, 5.3 хувь нь хувьцаагаар мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулдаг гэсэн хариултын хувийн жин 5.4 нэгжээр өсч бэлэн бусаар байршуулдаг гэсэн хариултынх 9.2 нэгжээр буурчээ.
- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 92.6 хувь нь төгрөгөөр, 3.5 хувь нь америк доллараар, 3.9 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 58.2 хувь нь бага байна гэж үзсэн байхад иргэдийн 28.1 хувь нь хүүний түвшин боломжийн байна гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 13.7 хувь нь өгчээ. Хадгаламжийн хүүний түвшин бага гэсэн хариултын эзлэх хувь 2.6 нэгжээр буурч, боломжийн гэсэн дүгнэлтийн эзлэх хувь 1.6 нэгжээр өсчээ.

#### 1.5.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 85.4 хувь нь өгсөн бол 12.3 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултын хувийн жин 2.9 нэгжээр буурч, эсрэг хариултынх нь 3.3 нэгжээр өсчээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 41.9 хувь нь үзсэн байхад 36.0 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 22.1 хувь нь өгчээ. Нэг жилийн хугацаанд зээл хүртээмжтэй гэсэн хариултын эзлэх хувь 13.4 нэгжээр буурч, хүртээмжгүй гэсэн хариултынх 8.9 нэгжээр өсчээ.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 34.9 хувь нь хариулсан бол 53.2 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариултыг өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 11.9 хувь нь өгсөн байна. Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэсэн хариултын хувийн жин 20.7 нэгжээр буурч, хүндрэлтэй гэсэн хариултынх мөн ижил хэмжээгээр өсчээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 75.1 хувь нь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшинг боломжийн гэж иргэдийн 17.4 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 7.5 хувь нь өгчээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад зээлийн хүү өндөр байна гэсэн хариултын хувийн жин 7.7 нэгжээр нэмэгдэж, боломжийн гэсэн хариултынх 9.6 нэгжээр багасчээ.

#### 1.5.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 66.3 хувь нь хариулсан бол 20.2 хувь нь ойлголтгүй гэж хариулжээ. Харин мэдэхгүй гэж 13.5 хувь нь хариулжээ. Бичил санхүүгийн талаар ойлголттой гэсэн хариултын хувийн жин 10.3 нэгжээр буурч эсрэг хариултынх мөн ижил хэмжээгээр өсчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 16.0 хувь нь сайн, 48.9 хувь нь дунд зэрэг, 13.4 хувь нь огт хөгжөөгүй, 21.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Бичил санхүү сайн хөгжсөн гэсэн хариултын эзлэх хувь 6.9 нэгжээр буурсан бол огт хөгжөөгүй гэсэн хариултынх 5.3 нэгжээр өсчээ.

- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 56.2 хувь, боломжгүй гэж 21.1 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 22.6 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ. Бичил зээл авах боломжтой иргэдийн хувийн жин 11.1 нэгжээр буурсан бол боломжгүй болон мэдэхгүй гэсэн иргэдийнх 2.2, 8.8 нэгжээр тус тус өсчээ.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 32.7 хувь нь худалдаа наймаа, 8.0 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 1.2 хувь нь аялал жуулчлал, 9.2 хувь нь үйлчилгээ, 7.2 хувь нь хүнсний ногоо, 6.4 хувь нь газар тариалан, 9.6 хувь нь мал аж ахуй гэж хариулсан байна. Худалдаа наймаа, үйлчилгээний салбарыг сонгосон хариулт өсчээ.
- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн 8.9 хувь нь хариулт өгөөгүй байна. Харин хариулсан иргэдийн 15.9 хувь нь 500000-1000000 төгрөг, 40.2 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг, 14.6 хувь нь 250000-500000 төгрөг, 15.4 хувь нь 1 сая- 1.5 сая төгрөг, 8.5 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ. Үйл ажиллагаа явуулахад 500000-1 сая төгрөг хэрэгтэй гэсэн хариултын хувийн жин 7.0 нэгжээр буурч, 1.5-2 сая төгрөг гэсэн хариултынх 10.6 нэгжээр өсчээ.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 66.3 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 12.6 хувь нь 6-9 сар, 8.1 хувь нь 3 сар хүртэлх, 13.0 хувь нь 3-6 сар гэсэн хариулт өгчээ. Зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэсэн хариултын хувийн жин 10.2 нэгжээр өсч, бусад хариултынх буурчээ.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 56.9 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 14.9 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 16.7 хувь нь хариулсан байна. Өмнөх онтой харьцуулбал зээлийн хүү өндөр гэсэн хариултын хувийн жин 3.9 нэгжээр буурч, зээлийн хэмжээ бага гэсэн хариултынх 4.5 нэгжээр өсчээ.

#### 1.5.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 22.0 хувь, байхгүй гэж 69.1 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 8.9 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 31.3 хувь тийм, 51.4 хувь нь үгүй, 17.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 45.4 хувь, байхгүй гэж 37.7 хувь, мэдэхгүй гэж 16.9 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 80.8, таалагддаггүй гэж 8.7 хувь, мэдэхгүй гэж 10.6 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 75.7 хувь нь тийм, 20.5 хувь нь үгүй, 3.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 59.5 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 27.9 хувь нь чанаргүй, 12.6 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.

- Санал асуулгад оролцогчдын 18.9 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 66.4 хувь нь чаддаггүй, 14.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн ихэнх нь буюу 90.8 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 6.9 хувь нь үгүй, 2.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

## **I.6. Хэнтий аймаг**

2005 оны эцсийн байдлаар Хэнтий аймгийн өрхийн тоо 17.9 мянга, хүн ам 70.8 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 293 иргэн оролцсоны 71.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 16.2 хувь нь 25 нас хүртэлх, 39.5 хувь нь 25-34 насны, 25.4 хувь нь 35-44 насны, 14.1 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 14.1 хувь нь бүрэн бус дунд, 31.7 хувь нь бүрэн дунд, 14.8 хувь нь тусгай дунд, 39.3 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд, нийт оролцогчдын 40.8 хувь нь улсын байгууллага болон 25.1 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 18.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 11.8 хувь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 25-34 насны, дээд боловсролтой, улсын байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.6.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 31.4 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 (цаашид өмнөх гэх) оны санал асуулгын дүнгээс 2.3 нэгжээр буурсан үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 22.3 хувь нь муудсан гэж хариулсан бол иргэдийн 32.5 хувь нь хэвэндээ гэсэн үнэлэлт өгчээ.
- Иргэдийн 18.6 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 32.6 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 9.9 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 30.7 хувь нь зээлийн хүүг бууруулах, 7.6 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Хоёр судалгааны дүнг харьцуулж үзэхэд эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах хэрэгтэй гэсэн хариултын хувийн жин 6 нэгжээр буурч, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих гэсэн хариултынх 5.6 нэгжээр өссөчээ.
- Иргэдийн 28.7 хувь нь уул уурхай, 25.2 хувь нь хөдөө аж ахуй, 12.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 13.4 хувь нь аялал жуулчлал, 10.4 хувь нь банк санхүү, 8.7 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд уул уурхай, банк санхүү зэрэг салбарыг чухал гэж үзэх нь нэмэгджээ.
- Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 93.9 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын үзүүлэлтээс 7.2 нэгжээр өссөн үнэлэлт юм. Харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 1.0 хувь нь өгсөн бол тогтворжиж байна гэж 3.4 хувь нь хариулжээ.

### **1.6.2 Нийгмийн тулгамдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 20.5 хувь нь дээшилж байна, 19.8 хувь нь доошилж байна, 58.0 хувь нь хэвэндээ байна хэмээн хариулжээ. Өмнөх санал асуулгын дүнтэй

харьцуулахад иргэдийн дээшилж байна болон хэвэндээ гэсэн хариулт 2.4, 3.9 нэгжээр өссөн байна.

- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 75.9 хувь нь нэмэгдсэн гэж дүгнэсэн бөгөөд энэ нь өмнөх санал асуулгын үзүүлэлтээс 2.3 нэгжээр өсчээ. Ядуурал буурсан гэсэн хариултыг 4.8 хувь нь өгсөн бол хэвэндээ гэж 15.5 хувь нь хариулжээ.
- Иргэдийн дийлэнх буюу 80.3 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 6.2 хувь нь буурсан, 9.7 хувь нь хэвэндээ, 3.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Нэг жилийн хугацаанд ажилгүйчүүдийн тоо өссөн гэсэн хариултын хувийн жин 3.0 нэгжээр өсч, хэвэндээ гэсэн хариултынх 3.9 нэгжээр буурчээ.
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 52.8 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 35.2 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 12.2 хувь нь өгчээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн газар хувьчлалыг дэмжсэн хариулт 3.2 нэгжээр багассан байна.

### 1.6.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 72.3 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын үзүүлэлтээс 2.5 нэгжээр багасчээ. Харин боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 13.4 хувь нь өгсөн бол 14.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 55.7 хувь нь өгсөн бол 20.8 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 3.5 хувь нь буурсан, 20.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 9.7 нэгжээр буурч, мэдэхгүй гэсэн хариултынх 7.2 нэгжээр өсчээ.
- Иргэдийн дийлэнх буюу 61.3 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 12.2 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 26.5 хувь нь хариулсан байна. Нэг жилийн хугацаанд татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын хувийн жин 3.9 нэгжээр буурч, мэдэхгүй гэсэн хариултынх 5.2 нэгжээр өсчээ.

### 1.6.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 28.4 хувь нь олон, 4.8 хувь нь цөөн, 56.5 хувь нь боломжийн, 10.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад банкуудын тоо боломжийн гэсэн хариултын хувийн жин 8.7 нэгжээр өсч, олон буюу цөөн гэсэн хариултынх 5.8, 8.1 нэгжээр тус бүр буурчээ.
- Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн 59.6 хувь нь найдвартай гэж дүгнэсэн байна. Эргэлзээтэй гэсэн хариултыг иргэдийн 30.5 хувь нь өгсөн бол 3.8 хувь нь найдваргүй гэж хариулжээ. Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эргэлзээтэй гэсэн хариултын хувийн жин 5.7 нэгжээр буурч, найдвартай гэсэн хариултынх 13.1 нэгжээр өсчээ.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 46.6 хувь нь нэмэгдсэн, 5.9 хувь нь буурсан, 39.0 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл буурсан гэсэн хариултын эзлэх хувь 4.2 нэгжээр буурч, хэвэндээ гэсэн хариултынх 5.7 нэгжээр өсчээ.



- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 64.7 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 20.9 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 14.4 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултын хувийн жин 2.7 нэгжээр өсч, сурталчилж чадахгүй байна гэсэн хариултынх мөн ижил хэмжээгээр буурчээ.
- Иргэдийн 61.2 хувь нь банк, санхүүгийн байгууллагуудыг хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн хариултыг иргэдийн 28.0 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 10.7 хувь нь хариулсан байна. Нэг жилийн хугацаанд банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг дэмжсэн хариултын эзлэх хувь 3.1 нэгжээр өсч, эсрэг хариултынх мөн ижил хэмжээгээр буурчээ.
- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 52.6 хувь нь банк, 2.9 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 1.5 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 16.7 хувь нь ломбард, 24.0 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Өмнөх асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн банкинд хандах нь 2.8 нэгжээр өсч, бусад санхүүгийн байгууллагад хандах нь багассан байна.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 29.7 хувь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 66.1 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 4.2 хувь нь өгсөн байна. Нэг жилийн хугацаанд банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултын хувийн жин 11.1 нэгжээр буурч, үйлчлүүлдэггүй гэсэн хариултынх 12.0 нэгжээр өсчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголтой иргэд 34.0 хувь байгаа бол ойлголтугүй иргэд 42.6 хувь байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 23.4 хувь нь өгчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 5.5 хувь нь хариулсан нь өмнөх оныхоос 8.6 нэгжээр буурсан үзүүлэлт бол үгүй гэсэн хариултыг 92.7 хувь нь өгсөн байна.
- Иргэдийн 19.4 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн нь өмнөх оныхоос 5.9 нэгжээр буурсан үзүүлэлт бол 20.5 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 60.1 хувь нь өгсөн байна.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 37.1 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 19.6 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 43.4 хувь нь өгсөн байна. Хоёр судалгааны дүнг харьцуулахад гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэсэн хариултын хувийн жин 10.9 нэгжээр буурч, мэдэхгүй гэсэн хариултынх нь 11.3 нэгжээр өсчээ.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 22.7 хувь нь хариулсан бол 71.0 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 6.3 хувь нь хариулсан байна. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэсэн хариултын эзлэх хувь 6.3 нэгжээр өсч, хэрэглэдэггүй гэсэн хариултынх 4.1 нэгжээр багасчээ.

#### 1.6.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 31.9 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 4.0 хувь нь бусдад

зээлдүүлдэг, 26.8 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 0.7 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 1.8 хувь нь хувьцаа худалдаж авдаг гэж хариулжээ. 2005-2006 онд хуримтлуулсан мөнгөө худалдаа наймаа хийж эргэлдүүлэх нь нэмэгдсэн байна.

- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 66.9 хувь нь хариулсан бол 15.7 хувь нь бэлэн бусаар, 3.6 хувь нь үнэт цаасаар, 2.5 хувь нь хувьцаанд мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд тус асуултын хариултын хувийн жин их хэмжээгээр өөрчлөгдөөгүй байна.
- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 94.6 хувь нь төгрөгөөр, 2.7 хувь нь америк доллараар, 2.7 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Мөнгөө төгрөгөөр хадгалдаг гэсэн хариултын эзлэх хувь 5.8 нэгжээр өсчээ.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 62.1 хувь нь бага байна гэж үзсэн байхад иргэдийн 22.1 хувь нь хүүний түвшинг боломжийн байна гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 15.8 хувь нь өгчээ. Нэг жилийн хугацаанд хадгаламжийн хүү бага байна гэсэн хариултын эзлэх хувь 2.2 нэгжээр өсч, боломжийн байна гэснийх 3.6 нэгжээр буурчээ.

#### 1.6.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 86.5 хувь нь өгсөн бол 10.8 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Хоёр судалгааны дүнг харьцуулахад зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултын хувийн жин 4.0 нэгжээр буурч, эсрэг хариултынх нь 2.0 нэгжээр өсчээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 42.9 хувь нь үзсэн байхад 40.4 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 16.7 хувь нь өгчээ. Зээл хүртээмжтэй гэсэн хариултын эзлэх хувь 5.2 нэгжээр өсч, хүртээмжгүй гэсэн хариултынх 8.9 нэгжээр буурчээ.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 39.7 хувь нь хариулсан бол 47.3 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариултыг өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 13.0 хувь нь өгсөн байна. Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлтэй гэсэн хариултын хувийн жин 5.4 нэгжээр буурч, хүндрэлгүй гэсэн хариултынх 6.1 нэгжээр нэмэгджээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 75.0 хувь нь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшин боломжийн гэж иргэдийн 15.6 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 9.4 хувь нь өгчээ. Нэг жилийн хугацаанд зээлийн хүүний түвшин өндөр гэсэн хариултын эзлэх хувь 6.6 нэгжээр өсч, эсрэг хариултынх нь 5.0 нэгжээр буурчээ.

#### 1.6.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 64.6 хувь нь хариулсан бол 19.3 хувь нь ойлголтгүй гэж хариулжээ. Харин мэдэхгүй гэж 16.1 хувь нь хариулжээ. Бичил санхүүгийн талаар ойлголттой гэсэн хариултын хувийн жин 4.7 нэгжээр өсч эсрэг хариултынх 5.8 нэгжээр буурчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 28.0 хувь нь сайн, 41.3 хувь нь дунд зэрэг, 8.7 хувь нь огт хөгжөөгүй, 22.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Бичил санхүү сайн хөгжсөн гэсэн хариултын эзлэх хувь 7.2 нэгжээр өссөн бол дунд зэрэг хөгжсөн гэсэн хариултынх 5.3 нэгжээр буурчээ.

- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 57.0 хувь, боломжгүй гэж 27.2 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 15.8 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ. Нэг жилийн хугацаанд тус асуултын хариултын хувийн жин их хэмжээгээр өөрчлөгдөөгүй байна.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 30.0 хувь нь худалдаа наймаа, 8.1 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 1.9 хувь нь аялал жуулчлал, 7.7 хувь нь үйлчилгээ, 5.0 хувь нь хүнсний ногоо, 5.8 хувь нь газар тариалан, 8.1 хувь нь мал аж ахуй гэж хариулсан байна. Өмнөх онтой харьцуулбал үйлчилгээний салбарыг сонгосон хариулт бага зэрэг өсчээ.
- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн 12.3 хувь нь хариулт өгөөгүй байна. Харин хариулсан иргэдийн 24.1 хувь нь 500000-1000000 төгрөг, 32.3 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг, 16.0 хувь нь 250000-500000 төгрөг, 16.3 хувь нь 1 сая- 1.5 сая төгрөг, 5.8 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ. Үйл ажиллагаа явуулахад 100000-250000 төгрөг хэрэгтэй гэсэн хариултын хувийн жин 6.2 нэгжээр буурч, 1.5-2 сая төгрөг гэсэн хариултынх 8.8 нэгжээр өсчээ.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 61.8 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 13.5 хувь нь 6-9 сар, 9.3 хувь нь 3 сар хүртэлх, 15.4 хувь нь 3-6 сар гэсэн хариулт өгчээ. Зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэсэн хариултын хувийн жин 7.7 нэгжээр өсч, бусад хариултынх нь буурчээ.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 42.2 хувь нь зээлийн хүү өндөр, 18.2 хувь нь зээл авах боломжгүй гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 16.0 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 16.3 хувь нь хариулсан байна. Өмнөх онтой харьцуулбал зээлийн хүү өндөр гэсэн хариултын хувийн жин 19.0 нэгжээр буурч, зээлийн хэмжээ бага, зээл авах боломжгүй болон зээлийн хугацаа хангалтгүй гэсэн хариултынх 3.0, 6.3, 7.2 нэгжээр тус тус өсчээ.

#### 1.6.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 17.7 хувь, байхгүй гэж 72.0 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 10.3 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 19.2 хувь тийм, 65.2 хувь нь үгүй, 15.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 29.1 хувь, байхгүй гэж 55.4 хувь, мэдэхгүй гэж 15.4 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 80.5, таалагддаггүй гэж 8.7 хувь, мэдэхгүй гэж 10.8 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 76.2 хувь нь тийм, 16.4 хувь нь үгүй, 7.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 50.2 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 38.6 хувь нь чанаргүй, 11.2 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.

- Санал асуулгад оролцогчдын 23.4 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 62.1 хувь нь чаддаггүй, 14.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн ихэнх нь буюу 87.4 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 9.5 хувь нь үгүй, 3.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

## **1.7. Дорноговь аймаг**

2005 оны эцсийн байдлаар Дорноговь аймгийн өрхийн тоо 14.0 мянга, хүн ам 53.3 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 299 иргэн оролцсоны 66.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 12.1 хувь нь 25 нас хүртэлх, 35.4 хувь нь 25-34 насны, 27.6 хувь нь 35-44 насны, 15.8 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 9.4 хувь нь бүрэн бус дунд, 23.6 хувь нь бүрэн дунд, 17.2 хувь нь тусгай дунд, 49.8 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд, нийт оролцогчдын 26.2 хувь нь улсын байгууллага болон 31.9 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 20.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 17.4 хувь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 25-34 насны, дээд боловсролтой, хувийн байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.7.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 25.3 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 (цаашид өмнөх гэх) оны санал асуулгын дүнгээс 5.6 нэгжээр буурсан үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 25.3 хувь нь муудсан гэж хариулсан бол иргэдийн 40.3 хувь нь хэвэндээ гэсэн үнэлэлт өгчээ.
- Иргэдийн 28.6 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 29.7 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 9.3 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 23.4 хувь нь зээлийн хүүг бууруулах, 7.1 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Нэг жилийн хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварыг багасгах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, бизнесменүүдээ урамшуулах гэж үзэх нь нэмэгдэж, харин зээлийн хүүг бууруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн бодол багасчээ.
- Иргэдийн 28.0 хувь нь уул уурхай, 20.6 хувь нь хөдөө аж ахуй, 14.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 16.2 хувь нь аялал жуулчлал, 9.5 хувь нь банк санхүү, 8.0 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. 2005-2006 онд уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбарыг чухал гэж үзэх нь нэмэгджээ.
- **Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 91.3 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын үзүүлэлтээс 4.7 нэгжээр өссөн үнэлэлт юм. Харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 1.0 хувь нь өгсөн бол тогтворжиж байна гэж 5.7 хувь нь хариулжээ.**

### **1.7.2 Нийгмийн тулгамдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 19.1 хувь нь дээшилж байна, 22.4 хувь нь доошилж байна, 57.2 хувь нь хэвэндээ байна гэж хариулжээ. Өмнөх санал асуулгын дүнтэй

харьцуулахад иргэдийн дээшилж байна болон хэвэндээ гэсэн хариулт 2.6, 4.9 нэгжээр тус тус өсч, доошил байна гэсэн хариулт 6.3 нэгжээр буурчээ.

- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 73.9 хувь нь нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өмнөх санал асуулгын үзүүлэлтээс 1.2 нэгжээр буурчээ. Ядуурал буурсан гэсэн хариултыг 4.7 хувь нь өгсөн бол хэвэндээ гэж 16.4 хувь нь хариулжээ.
- **Иргэдийн дийлэнх буюу 75.3 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 6.4 хувь нь буурсан, 10.9 хувь нь хэвэндээ, 8.0 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Хоёр судалгааны дүнг харьцуулахад өөрчлөлт гараагүй байна.**
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 62.4 хувь, дэмжихгүй байна гэж 28.2 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 9.4 хувь нь өгчээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад газар хувьчлалыг дэмжсэн иргэдийн хариулт 1.3 нэгжээр өссөн байна.

### 1.7.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 80.2 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс 8.3 нэгжээр нэмэгджээ. Харин боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 10.4 хувь нь өгсөн бол 9.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 68.1 хувь нь өгсөн бол 19.8 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 0.7 хувь нь буурсан, 11.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултын эзлэх хувь 5.3 нэгжээр өсчээ.
- Иргэдийн дийлэнх буюу 68.0 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 10.8 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 21.2 хувь нь хариулсан байна. Татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын хувийн жин 10.1 нэгжээр өсчээ.

### 1.7.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 40.1 хувь нь олон, 3.4 хувь нь цөөн, 53.4 хувь нь боломжийн, 3.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд банкуудын тоо олон гэсэн хариултын хувийн жин 9.2 нэгжээр өсч, харин бусад хариултынх нх буурчээ.
- Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн 55.9 хувь нь найдвартай гэж дүгнэсэн байна. Эргэлзээтэй гэсэн хариултыг иргэдийн 32.5 хувь нь өгсөн бол 4.4 хувь нь найдваргүй гэж хариулжээ. Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа найдвартай гэсэн дүгнэлтийн эзлэх хувь 2.8 нэгжээр өсч, эргэлзээтэй болон мэдэхгүй гэсэн хариултынх 1.3, 2 нэгжээр тус тус буурчээ.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 48.5 хувь нь нэмэгдсэн, 8.4 хувь нь буурсан, 37.7 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл буурсан гэсэн хариултын хувийн жин 3.1 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултынх 3.9 нэгжээр буурчээ.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 75.1 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 13.1 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж

иргэдийн 11.8 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултын хувийн жин 6.2 нэгжээр өсч, бусад хариултууд тус бүр 3.1 нэгжээр буурчээ.

- Иргэдийн 64.3 хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн хариултыг иргэдийн 25.6 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 10.1 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариултын эзлэх хувь 4.4 нэгжээр буурч, эсрэг хариултынх нь мөн ижил хэмжээгээр өсчээ.
- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 53.0 хувь нь банк, 3.1 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 3.7 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 14.7 хувь нь ломбард, 18.7 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Өмнөх асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн банкинд хандах нь 4.9 нэгжээр өсч бусад хариултуудын хувийн жин буурсан байна.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 20.5 хувь нь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 77.1 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 2.4 хувь нь өгсөн байна. Нэг жилийн хугацаанд банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултын хувийн жин 23.4 нэгжээр багасчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 38.6 хувь байгаа нь өмнөх оноос 5.5 нэгжээр буурсан үзүүлэлт бол ойлголтгүй иргэд 45.3 хувь байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 16.1 хувь нь өгчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 9.8 хувь нь хариулсан бол үгүй гэсэн хариултыг 88.5 хувь нь өгсөн байна.
- Иргэдийн 18.3 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн нь өмнөх оныхоос 14.8 нэгжээр буурсан үзүүлэлт бол 32.5 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 49.2 хувь нь өгсөн байна.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 40.1 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 27.7 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариулт иргэдийн 32.2 хувь өгсөн байна. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэсэн хариултын хувийн жин 6.4 нэгжээр буурч, ач холбогдолгүй гэснийх 11.2 нэгжээр өсчээ.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 43.9 хувь нь хариулсан бол 52.7 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 3.4 хувь нь хариулсан байна. Нэг жилийн хугацаанд бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэсэн хариултын хувийн жин 16.6 нэгжээр нэмэгджээ.

#### 1.7.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 34.4 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 6.7 хувь нь бусдад зээлдүүлдэг, 26.6 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 1.1 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 2.1 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 29.1 хувь нь бусад хэлбэрээр байршуулдаг гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд хуримтлуулсан мөнгөө банк, санхүүгийн байгууллагад хадгалуулах, худалдаа наймаанд эргэлдүүлэх нь нэмэгджээ.
- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 63.5 хувь нь хариулсан бол 17.4 хувь нь бэлэн бусаар, 3.9 хувь нь үнэт

цаасаар, 3.9 хувь нь хувьцаагаар мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд тус асуултын хариултын хувийн жиг бараг өөрчлөгдөөгүй байна.

- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 90.4 хувь нь төгрөгөөр, 8.4 хувь нь америк доллараар, 1.1 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Мөнгөө төгрөгөөр хадгалдаг гэсэн хариултын хувийн жин өөрчлөгдөөгүй боловч америк доллараар хадгалдаг гэсэн хариултынх 3.8 нэгжээр өсчээ.

#### 1.7.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 87.8 хувь нь өгсөн бол 10.5 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Нэг жилийн хугацаанд зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултын хувийн жин 3.4 нэгжээр өсчээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 43.5 хувь нь үзсэн байхад 39.1 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 17.4 хувь нь өгчээ. Нэг жилийн хугацаанд зээл хүртээмжгүй гэсэн хариултын эзлэх хувь 7.0 нэгжээр багасчээ.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 40.7 хувь нь хариулсан бол 51.4 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариулт өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 7.9 хувь нь өгсөн байна. Хоёр судалгааны дүнг харьцуулахад банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэсэн хариултын хувь 7.1 нэгжээр багасч, хүндрэлтэй гэсэн хариултынх 14.6 нэгжээр өсчээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 74.2 хувь нь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшин боломжийн гэж иргэдийн 20.3 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 5.4 хувь нь өгчээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад зээлийн хүүний түвшин өндөр гэсэн хариултын хувийн жин 7.2 нэгжээр өсч, боломжийн болон мэдэхгүй гэсэн хариултынх нь тус бүр 3.6 нэгжээр буурчээ.

#### 1.7.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 62.2 хувь нь хариулсан бол 21.0 хувь нь ойлголтгүй гэж хариулжээ. Харин мэдэхгүй гэж 16.8 хувь нь хариулжээ. Бичил санхүүгийн талаар ойлголттой гэсэн хариултын хувийн жин 6.0 нэгжээр буурчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 25.3 хувь нь сайн, 37.4 хувь нь дунд зэрэг, 13.8 хувь нь огт хөгжөөгүй, 23.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Бичил санхүү дунд зэрэг хөгжсөн гэсэн хариултын эзлэх хувь 10.1 нэгжээр буурсан бол огт хөгжөөгүй гэсэн хариултынх 5.1 нэгжээр өсчээ.
- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 54.6 хувь хариулсан нь өмнөх оныхоос 5.0 нэгжээр буурсан үзүүлэлт бол боломжгүй гэж 22.5 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 22.9 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 33.2 хувь нь худалдаа наймаа, 11.3 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 1.1 хувь нь аялал жуулчлал, 7.5 хувь нь үйлчилгээ, 5.3 хувь нь хүнсний ногоо, 3.8 хувь нь газар тариалан, 6.0 хувь нь мал аж ахуй гэж хариулсан байна. Өмнөх онтой харьцуулбал дээрх асуултанд хариулсан байдал их хэмжээгээр өөрчлөгдөөгүй байна.

- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн 16.7 хувь нь хариулт өгөөгүй байна. Харин хариулсан иргэдийн 23.3 хувь нь 500000-1000000 төгрөг, 36.5 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг, 17.7 хувь нь 250000-500000 төгрөг, 12.9 хувь нь 1 сая- 1.5 сая төгрөг, 6.8 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ. Үйл ажиллагаа явуулахад 1 сая- 1.5 сая төгрөг хэрэгтэй гэсэн хариултын хувийн жин 9.4 нэгжээр өсчээ.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 64.5 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 21.1 хувь нь 6-9 сар, 6.0 хувь нь 3 сар хүртэлх, 8.4 хувь нь 3-6 сар гэсэн хариулт өгчээ. Зээл авч үйл ажиллагаа явуулахад 6-9 сар хүртэлх хугацаа шаардлагатай гэсэн хариултын хувийн жин 8.8 нэгжээр өсч, 3-6 сар гэсэн хариултынх нь 8.1 нэгжээр буурчээ.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 48.2 хувь нь зээлийн хүү өндөр, 9.5 хувь нь зээл авах боломжгүй гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 14.9 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 23.5 хувь нь хариулсан байна. Өмнөх онтой харьцуулбал зээлийн хүү өндөр гэсэн хариултын хувийн жин 14.6 нэгжээр буурч, зээлийн хэмжээ бага, зээл авах боломжгүй болон зээлийн хугацаа хангалтгүй гэсэн хариултынх 3.8, 4.3, 11.2 нэгжээр тус тус өсчээ.

#### 1.7.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 23.0 хувь, байхгүй гэж 72.1 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 4.9 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 26.1 хувь тийм, 65.1 хувь нь үгүй, 8.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 31.9 хувь, байхгүй гэж 55.0 хувь, мэдэхгүй гэж 13.1 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 75.0, таалагддаггүй гэж 12.8 хувь, мэдэхгүй гэж 12.2 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 75.2 хувь нь тийм, 21.8 хувь нь үгүй, 3.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 45.8 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 41.1 хувь нь чанаргүй, 13.0 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.
- Санал асуулгад оролцогчдын 24.1 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 58.0 хувь нь чаддаггүй, 18.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн ихэнх нь буюу 86.1 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 11.6 хувь нь үгүй, 2.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

#### 1.8. Баян-Өлгий аймаг

2005 оны эцсийн байдлаар Баян-Өлгий аймгийн өрхийн тоо 21.3 мянга, хүн ам 100.0 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 281 иргэн оролцсоны 34.1



хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 14.1 хувь нь 25 нас хүртэлх, 22.8 хувь нь 25-34 насны, 29.0 хувь нь 35-44 насны, 23.2 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 11.6 хувь нь бүрэн бус дунд, 15.9 хувь нь бүрэн дунд, 17.3 хувь нь тусгай дунд, 55.2 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 33.1 хувь нь улсын байгууллага болон 27.8 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 15.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 17.8 хувь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эрэгтэй, 35-44 насны, дээд боловсролтой, улсын байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.8.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 27.8 хувь нь хариулжээ. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 26.4 хувь нь муудсан гэж хариулсан бол иргэдийн 39.7 хувь нь хэвэндээ гэсэн үнэлэлт өгчээ. Эдийн засаг сайжирч байна болон мэдэхгүй гэсэн хариултын хувийн жин өмнөх онтой харьцуулбал 0.9, 1.4 нэгжээр тус бүр буурч, муудаж байна, хэвэндээ гэсэн хариултуудын эзлэх хувь 1.4 болон 0.9 нэгжээр өсчээ.
- Иргэдийн 24.7 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 24.2 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 16.7 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 21.5 хувь нь зээлийн хүүг бууруулах, 10.9 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал татварыг бууруулах гэсэн хариултын хувийн жин 1.4 нэгжээр өссөн бол гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих гэсэн саналынх 1.9 нэгжээр буурчээ.
- Иргэдийн 28.9 хувь нь уул уурхай, 21.5 хувь нь хөдөө аж ахуй, 9.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 15.8 хувь нь аялал жуулчлал, 12.6 хувь нь банк санхүү, 10.6 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд уул уурхай, аялал жуулчлалд өгсөн санал 11.1 болон 1.2 нэгжээр өссөн бол бусад салбаруудыг сонгосон нь 0.7-4 нэгжээр буурчээ.
- **Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 85.7 хувь нь хариулсан бол буурч байна гэсэн хариултыг иргэдийн 5 хувь нь өгчээ. Тогтворжиж байна гэж 5.7 хувь нь хариулсан байна. Өргөн хэрэглээний барааны үнэ өсч байна гэсэн санал 2.3 нэгжээр буурсан бол буурч байна гэсэн нь 3.2 нэгжээр өсчээ.**

### **1.8.2 Нийгмийн тулгамдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 18.1 хувь нь дээшилж байна, 21 хувь нь доошилж байна, 59.4 хувь нь хэвэндээ байна гэж хариулсныг өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал дээшилж байна болон хэвэндээ гэсэн саналууд 2.6, 4 нэгжээр өссөн бол доошилж байна гэсэн нь 8.9 нэгжээр буурчээ.
- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 82.5 хувь нь нэмэгдсэн гэж дүгнэсэн байна. Ядуурал буурсан гэсэн хариултыг 2.5 хувь нь өгсөн бол хэвэндээ гэж 12.9 хувь нь хариулжээ. Ядуурал нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 3.8 нэгжээр өсч, буурсан болон хэвэндээ гэснийх 2.6 болон 2.1 нэгжүүдээр буурчээ.

- Иргэдийн дийлэнх буюу 85 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 5 хувь нь буурсан, 7.1 хувь нь хэвэндээ, 2.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Ажилгүйдэл нэмэгдсэн гэсэн хариултын эзлэх хувь 2.2 нэгжээр багассан бол буурсан гэснийх мөн ижил хэмжээгээр өсчээ.
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 54.8 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 29.4 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 15.8 хувь нь өгчээ. Газар хувьчлалыг дэмжсэн хариулт 2.7 нэгжээр буурсан бол дэмжээгүй нь 2.3 нэгжээр өсчээ.

### 1.8.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 72 хувь нь хариулсан байна. Харин боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 19.4 хувь нь өгсөн бол 8.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Татварыг өндөр гэсэн хариулт 9.5 нэгжээр өссөн бол боломжийн гэсэн нь мөн ижил хэмжээгээр буурчээ.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 70.1 хувь нь өгсөн бол 19.4 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 2.9 хувь нь буурсан, 7.6 хувь нь мэдэхгүй хэмээн хариулжээ. Татварын ачаалал нэмэгдэж байна болон мэдэхгүй гэсэн хариултын эзлэх хувь 8.1 болон 2.4 нэгжээр өссөн бол хэвэндээ байна гэсэн нь 10.5 нэгжээр буурчээ.
- Иргэдийн дийлэнх буюу 63.3 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 19.4 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 17.3 хувь нь хариулсан байна. Татвараас зайлсхийх нь нийтлэг гэсэн хариултын эзлэх хувь 12.1 хувиар өссөн бол бага байна болон мэдэхгүй гэснийх нийлээд 12 нэгжээр буурчээ.

### 1.8.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 50.2 хувь нь олон, 3.9 хувь нь цөөн, 43.4 хувь нь боломжийн, 2.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд банкуудын тоог олон гэсэн нь 12.4 нэгжээр өссөн бол цөөн гэсэн нь мөн тэр хэмжээгээр буурчээ.
- Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн 50.9 хувь нь найдвартай гэж дүгнэсэн байна. Эргэлзээтэй гэсэн хариултыг иргэдийн 31.7 хувь нь өгсөн бол 12.5 хувь нь найдваргүй гэж хариулжээ. Өнгөрсөн онтой харьцуулбал найдвартай гэсэн хариулт 6.9 нэгжээр өссөн бол эргэлзээтэй гэсэн нь 10.1 нэгжээр буурчээ.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 37.9 хувь нь нэмэгдсэн, 10.7 хувь нь буурсан, 46.1 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл хэвэндээ гэсэн хариултын хувийн жин 3.4 нэгжээр нэмэгдэж мэдэхгүй гэснийх 4.5 нэгжээр буурсан бол бусад хариултууд бараг өөрчлөгдөөгүй байна.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 67.7 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 22.6 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 9.7 хувь нь хариулсан байна. Өмнөх онтой харьцуулбал сурталчилж чадаж байна гэсэн хариултын эзлэх хувь 7.5 нэгжээр өссөн бол чадахгүй болон мэдэхгүй гэснийх 4.4 болон 3.1 нэгжээр буурчээ.
- Иргэдийн 58.8 хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилдэг, 33.2 хувь нь тэдний үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй гэсэн

бол 7.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Үүнийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал банк санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилдэг, мэдэхгүй гэсэн хариулт 2.5 болон 1.8 нэгжээр буурсан бол хүнд сурталтай, чирэгдэлтэй гэсэн нь 4.2 нэгжээр өсчээ.

- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 59.4 хувь нь банк, 5.1 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 13.4 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 3.9 хувь нь ломбард, 14.3 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Банк, хадгаламж зээлийн хоршоо, ломбардад хандах иргэдийн тоо 3.1, 3.9, 2.4 нэгжээр нэмэгдсэн бол хувь хүн гэсэн нь 8.8 нэгжээр буурчээ. Харин бусад сонголтуудын хувьд тодийлөн өөрчлөлт гараагүй байна.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 34.4 хувь нь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 61.6 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 4 хувь нь өгсөн байна. Банк санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг болон мэдэхгүй гэсэн хариултуудын хувийн жин 3.1 болон 2.3 нэгжээр буурсан бол үйлчлүүлдэггүй гэснийх 5.4 нэгжээр нэмэгджээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 59.4 хувь байгаа бол ойлголтгүй иргэд 25 хувь байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 15.6 хувь нь өгчээ. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос бараг өөрчлөгдөөгүй байна.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 17.5 хувь нь хариулсан бол үгүй гэсэн хариултыг 79.6 хувь нь өгсөн байна. ХЗХ-ын гишүүн гэсэн хариулт 5 нэгжээр нэмэгдэж эсрэг хариулт нь 2.8 нэгжээр буурчээ.
- Иргэдийн 36.6 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн бол 26.1 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 37.3 хувь нь өгсөн байна. Зөв болон мэдэхгүй гэсэн хариултын эзлэх хувь 4.5 болон 11.2 хувиар буурсан бол буруу гэсэн хариулт 15.7 нэгжээр өсчээ.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 54.7 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 21.4 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 23.9 хувь нь өгсөн байна. Ач холбогдолтой гэсэн хариултын эзлэх хувь 7.7 нэгжээр буурсан бол ач холбогдолгүй болон мэдэхгүй гэсэн хариултын нийлбэр нь 7.8 нэгжээр өсчээ.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 22.5 хувь нь хариулсан бол 72.1 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 5.4 хувь нь хариулсан байна. Карт хэрэглэдэг гэсэн хариултын хувийн жин 10.7 нэгжээр өссөн бол үгүй болон мэдэхгүй гэсэн хариултын нийлбэр нь мөн 10.7 нэгжээр буурчээ.

#### 1.8.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 40.3 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 4.9 хувь нь бусдад зээлдүүлдэг, 32.5 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 2.6 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 2.6 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 17 хувь нь бусад хэлбэрээр ашигладаг гэж хариулжээ. Банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг гэсэн хариулт 7.8 нэгжээр өссөн бол худалдаа наймаа хийдэг болон бусад гэсэн хариултууд 3.9 болон 7.5 нэгжээр буурчээ.
- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 64.7 хувь нь хариулсан бол 14.9 хувь нь бэлэн бусаар, 4.8 хувь нь үнэт цаасаар, 3.5 хувь нь хувьцаагаар мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж

хариулжээ. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос бараг өөрчлөгдөөгүй байна.

- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 87.2 хувь нь төгрөгөөр, 8.8 хувь нь ам.доллараар, 4 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Төгрөгөөр хадгалдаг гэсэн хариултын хувийн жин 3.3 нэгжээр буурсан бол ам. доллараар гэсэн нь 2.3 нэгжээр өсчээ.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 62.2 хувь нь бага байна гэж үзсэн байхад иргэдийн 27.6 хувь нь хүүний түвшин боломжийн байна гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 10.2 хувь нь өгчээ. Хадгаламжийн хүү бага гэсэн хариултын эзлэх хувь 2 нэгжээр өссөн бол мэдэхгүй гэсэн хариултынх 1.8 нэгжээр буурчээ.

#### 1.8.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 76.3 хувь нь өгсөн бол 18.7 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Зээлийн хэрэгцээтэй гэсэн хариултын эзлэх хувь 2.8 нэгжээр өссөн бол хэрэггүй гэснийх 3.4 нэгжээр буурчээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 53.9 хувь нь үзсэн байхад 29.7 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 16.4 хувь өгчээ. Зээл хүртээмжтэй гэсэн хариултын эзлэх хувь 7.5 нэгжээр нэмэгдсэн бол хүртээмжгүй болон мэдэхгүй гэсэн хариултуудын нийлбэр нь мөн 7.5 нэгжээр буурчээ.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 48.4 хувь нь хариулсан бол 41.2 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариулт өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 10.4 хувь өгсөн байна. Зээл авахад хүндрэлгүй гэсэн хариултын хувийн жин 9.3 нэгжээр өссөн бол хүндрэлтэй болон мэдэхгүй гэсний нийлбэр нь мөн 9.3 нэгжээр буурчээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 72.9 хувь нь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшин боломжийн гэж иргэдийн 20.5 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 6.6 хувь нь өгчээ. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос бараг өөрчлөгдөөгүй байна.

#### 1.8.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 72.9 хувь нь хариулсан бол 15.4 хувь нь ойлголтгүй гэж хариулжээ. Харин мэдэхгүй гэж 11.8 хувь нь хариулжээ. Ойлголттой гэсэн хариултын эзлэх хувь 4.4 нэгжээр өссөн бол мэдэхгүй гэсэн хариултынх мөн ижил хэмжээгээр буурчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 30.7 хувь нь сайн, 48.6 хувь нь дунд зэрэг, 11.4 хувь нь огт хөгжөөгүй, 9.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Бичил санхүү сайн болон дунд зэрэг хөгжсөн гэсэн хариултын хувийн жин 3.1, 10.1 нэгжээр өссөн бол огт хөгжөөгүй болон мэдэхгүй гэсэн хариултынх 9.3, 3.8 нэгжээр тус тус буурчээ.
- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 60.9 хувь, боломжгүй гэж 26.9 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 12.2 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Боломжтой болон боломжгүй гэсэн хариултын хувийн жин 2.2, 1.2 нэгжээр тус тус өссөн бол мэдэхгүй гэсэн хариултынх мөн 3.3 нэгжээр буурчээ.

- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 31.7 хувь нь худалдаа наймаа, 10.1 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 4.8 аялал жуулчлал, 6.2 хувь нь үйлчилгээ, 8.1 хувь нь хүнсний ногоо, 9 хувь нь газар тариалан, 14.6 хувь нь мал аж ахуй гэж хариулсан байна. Газар тариалан, хүнсний ногоо, аялал жуулчлал гэсэн хариултуудын хувийн жин 3.5, 2.9, 2.5 нэгжээр тус тус өссөн бол худалдаа наймаа, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ гэсэн хариултууд 2.9, 4.4, 1.9 нэгжээр тус тус буурчээ.
- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн 2.1 хувь нь хариулт өгөөгүй байна. Харин хариулсан иргэдийн 20.7 хувь нь 500000-1000000 төгрөг, 38.2 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг, 13.5 хувь нь 250000-500000 төгрөг, 12 хувь нь 1 сая- 1.5 сая төгрөг, 9.8 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ. Өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 100000 төгрөгөөс доош болон 1-1.5 сая гэсэн хариултуудын эзлэх хувь 4.6, 4.9 нэгжээр тус тус буурсан бол 100000-250000 болон 500000-1 сая гэсэн хариултууд 5.4, 4.2 нэгжээр тус тус өсчээ.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 57.9 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 17.2 хувь нь 6-9 сар, 7.7 хувь нь 3 сар хүртэлх, 17.2 хувь нь 3-6 сар гэсэн хариулт өгчээ. 3-6 сар болон 6-9 сар гэсэн хариултын эзлэх хувь 3.4, 2.3 нэгжээр тус тус өссөн бол 9 сараас 1 жил гэсэн хариултынх 4 нэгжээр буурчээ.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 56.7 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 15.9 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 13.9 хувь нь хариулсан байна. Зээлийн хүү өндөр гэсэн хариултын эзлэх хувь 3.3 нэгжээр буурсан бол зээлийн хэмжээ бага, хугацаа хангалтгүй гэсэн хариултынх 3.5, 2.3 нэгжээр тус тус өсчээ.

#### 1.8.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 26.9 хувь, байхгүй гэж 64.9 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 8.2 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 33.8 хувь тийм, 56 хувь нь үгүй, 10.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 39.9 хувь, байхгүй гэж 50.5 хувь, мэдэхгүй гэж 9.6 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 69.4, таалагддаггүй гэж 21.4 хувь, мэдэхгүй гэж 9.3 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 54.6 хувь нь тийм, 34.3 хувь нь үгүй, 11.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 41.9 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 45.5 хувь нь чанаргүй, 12.5 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.
- Санал асуулгад оролцогчдын 37.7 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 49.1 хувь нь чаддаггүй, 13.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

- Иргэдийн ихэнх нь буюу 81.8 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 13.2 хувь нь үгүй, 5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

## **1.9. Сүхбаатар аймаг**

2005 оны эцсийн байдлаар Сүхбаатар аймгийн өрхийн тоо 13.3 мянга, хүн ам 56.0 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 292 иргэн оролцсоны 69.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 19.7 хувь нь 25 нас хүртэлх, 32.1 хувь нь 25-34 насны, 27.2 хувь нь 35-44 насны, 15.2 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 13.4 хувь нь бүрэн бус дунд, 27.6 хувь нь бүрэн дунд, 17.6 хувь нь тусгай дунд, 41.4 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 33.5 хувь нь улсын байгууллага болон 21.1 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 24.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 14.1 хувь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 25-34 насны, дээд боловсролтой, улсын байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.9.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 28.4 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 (цаашид өмнөх гэх) оны санал асуулгын дүнгээс 1.7 нэгжээр өссөн үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 17.9 хувь нь муудсан гэж хариулсан бол иргэдийн 46.3 хувь нь хэвэндээ гэсэн үнэлэлт өгчээ.
- Иргэдийн 27.2 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 28.3 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 10.0 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 23.9 хувь нь зээлийн хүүг бууруулах, 10.4 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. 2005-2006 онд эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, бизнесменүүдээ дэмжих хэрэгтэй гэж үзэх нь олширчээ.
- Иргэдийн 34.7 хувь нь уул уурхай, 20.7 хувь нь хөдөө аж ахуй, 10.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 11.7 хувь нь аялал жуулчлал, 10.6 хувь нь банк санхүү, 10.3 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд уул уурхай, банк санхүү, худалдаа үйлчилгээ зэрэг салбарыг чухалчлах явдал нэмэгдсэн байна.
- **Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 91.1 хувь, харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 1.4 хувь нь өгсөн бол тогтворжиж байна гэж 5.8 хувь нь хариулжээ. Өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал хариулсан байдалд өөрчлөлт гараагүй байна.**

### **1.9.2 Нийгмийн тулгамдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 19.4 хувь нь дээшилж байна, 19.4 хувь нь доошилж байна, 59.7 хувь нь хэвэндээ байна хэмээн хариулжээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн дээшилж байна гэсэн хариулт 2.6 нэгжээр өссөн байна.
- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 70.6 хувь нь нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өмнөх санал асуулгын үзүүлэлтээс 8.1 нэгжээр буурчээ. Ядуурал

буурсан гэсэн хариултыг 10.0 хувь нь өгсөн бол хэвэндээ гэж 14.9 хувь нь хариулжээ.

- Иргэдийн дийлэнх буюу 72.8 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 9.7 хувь нь буурсан, 13.1 хувь нь хэвэндээ, 4.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Нэг жилийн хугацаанд ажилгүйчүүдийн тоо өссөн гэсэн хариултын хувийн жин 10.6 нэгжээр багасчээ.
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 47.9 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 39.8 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 12.3 хувь нь өгчээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад газар хувьчлалыг дэмжсэн иргэдийн хариулт 9.4 нэгжээр буурсан байна.

### 1.9.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 80.0 хувь, боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 11.4 хувь нь өгсөн бол 8.6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Өмнөх онтой харьцуулбал хариулсан байдалд өөрчлөлт бараг гараагүй байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 69.0 хувь нь өгсөн бол 16.9 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 2.5 хувь нь буурсан, 11.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 5.1 нэгжээр буурчээ.
- Иргэдийн дийлэнх буюу 60.6 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 14.3 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 25.1 хувь хариулсан байна. Хоёр судалгааны дүнг харьцуулахад татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын хувийн жин өөрчлөгдөөгүй боловч бага гэсэн хариултын хувь 3.6 нэгжээр өсч мэдэхгүй гэсэн хариулт 4.9 нэгжээр багасчээ.

### 1.9.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 36.2 хувь нь олон, 5.5 хувь нь цөөн, 55.5 хувь нь боломжийн, 2.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Банкуудын тоо олон байна гэсэн хариултын эзлэх хувь 3.1 нэгжээр буурч, боломжийн гэсэн хариултынх 9.0 нэгжээр өсчээ.
- Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн 53.1 хувь нь найдвартай гэж дүгнэсэн байна. Эргэлзээтэй гэсэн хариултыг иргэдийн 37.2 хувь нь өгсөн бол 4.5 хувь нь найдваргүй гэж хариулжээ. Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эргэлзээтэй гэсэн дүгнэлтийн хувийн жин 3.6 нэгжээр нэмэгджээ.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 45.1 хувь нь нэмэгдсэн, 9.0 хувь нь буурсан, 37.2 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Өмнөх онтой харьцуулбал хариулсан байдалд өөрчлөлт бараг гараагүй байна.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 60.1 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 31.3 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 8.7 хувь нь хариулсан байна. 2005-2006 онд банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултын хувь 3.0 нэгжээр өсчээ.
- Иргэдийн 56.3 хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн

хариултыг иргэдийн 36.1 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 7.6 хувь нь хариулсан байна. Хоёр судалгааны дүнг харьцуулахад банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариултын хувийн жин 2.6 нэгжээр буурч, харин эсрэг хариултынх нь мөн ижил хэмжээгээр өсчээ.

- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 58.7 хувь нь банк, 3.2 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 3.5 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 10.3 хувь нь ломбард, 21.8 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Өмнөх асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн банкинд хандах нь хэвээр байгаа бол банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоонд хандах нь багасчээ.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 35.3 хувь нь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 61.9 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 2.8 хувь нь өгсөн байна. Нэг жилийн хугацаанд банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултын хувийн жин 7.5 нэгжээр буурчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 39.7 хувь байгаа нь өмнөх оноос 2.2 нэгжээр буурсан үзүүлэлт бол ойлголтгүй иргэд 41.1 хувь байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 19.2 хувь нь өгчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 6.9 хувь нь хариулсан нь өмнөх оноос 5.4 нэгжээр буурсан үзүүлэлт бол үгүй гэсэн хариултыг 91.0 хувь нь өгсөн байна.
- Иргэдийн 22.5 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн нь өмнөх оноос 6.6 нэгжээр буурсан үзүүлэлт бол 21.8 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 55.8 хувь нь өгсөн байна.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 45.4 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 20.4 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 34.2 хувь нь өгсөн байна. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэсэн хариултын эзлэх хувь 6.1 нэгжээр өсч, харин мэдэхгүй гэсэн хариултынх 6.4 нэгжээр буурчээ.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 20.3 хувь нь хариулсан бол 76.2 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 3.4 хувь нь хариулсан байна. Нэг жилийн хугацаанд бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэсэн хариултын хувийн жин 5.3 нэгжээр өссөн байна.

#### 1.9.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 31.4 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 2.4 хувь нь бусдад зээлдүүлдэг, 36.8 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 0.7 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 26.4 хувь нь бусад хэлбэрээр эргэлдүүлдэг гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд хуримтлуулсан мөнгөө банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг гэсэн хариултын хувь 3.9 нэгжээр нэмэгдэж, худалдаа наймаанд эргэлдүүлдэг гэсэн хариултынх 7.4 нэгжээр буурчээ.
- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 70.4 хувь нь хариулсан бол 14.3 хувь нь бэлэн бусаар, 3.5 хувь нь үнэт цаасаар, 1.4 хувь нь хувьцаагаар мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Хоёр судалгааны хариултын хувьд онцын өөрчлөлт гараагүй байна.



- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 93.5 хувь нь төгрөгөөр, 1.1 хувь нь ам.доллараар, 5.5 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Мөнгөө төгрөгөөр хадгалдаг гэсэн хариултын эзлэх хувь 2.4 нэгжээр өсчээ.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 62.8 хувь нь бага байна гэж үзсэн байхад иргэдийн 24.8 хувь нь хүүний түвшин боломжийн байна гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 12.4 хувь нь өгчээ. Хадгаламжийн хүүний түвшин бага байна гэсэн хариултын хувийн жин 1.8 нэгжээр багасч, боломжийн гэсэн хариултынх мөн ижил хэмжээгээр өсчээ.

#### 1.9.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 83.8 хувь нь өгсөн бол 13.7 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултын эзлэх хувь 3.9 нэгжээр буурч, харин хэрэгцээ байдаггүй гэсэн хариултынх 3.5 нэгжээр өсчээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 54.5 хувь нь үзсэн байхад 25.9 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 19.5 хувь нь өгчээ. Нэг жилийн хугацаанд зээл хүртээмжтэй гэсэн хариултын хувийн жин 2.6 нэгжээр өсч, хүртээмжгүй гэсэн хариултынх 7.9 нэгжээр багасчээ.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 48.9 хувь нь хариулсан бол 40.0 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариулт өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 11.1 хувь өгсөн байна. Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэсэн хариултын хувь 6.5 нэгжээр нэмэгджээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 78.2 хувь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшин боломжийн гэж иргэдийн 16.9 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 4.9 хувь нь өгчээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад зээлийн хүүний түвшин өндөр гэсэн хариултын хувь 3.4 нэгжээр өсч, боломжийн гэсэн хариултынх 2.3 нэгжээр буурчээ.

#### 1.9.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 60.5 хувь нь хариулсан бол 26.0 хувь нь ойлголтгүй гэж хариулжээ. Харин мэдэхгүй гэж 13.5 хувь нь хариулжээ. Ойлголтгүй гэсэн хариултын эзлэх хувь 7.7 нэгжээр өссөн бол мэдэхгүй гэсэн хариултынх мөн ижил хэмжээгээр буурчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 15.8 хувь нь сайн, 51.1 хувь нь дунд зэрэг, 13.7 хувь нь огт хөгжөөгүй, 19.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Бичил санхүү сайн болон огт хөгжөөгүй гэсэн хариултын хувийн жин 2.5, 2.9 нэгжээр тус тус буурсан бол дунд зэрэг гэсэн хариултынх 5.2 нэгжээр өсчээ.
- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 58.5 хувь, боломжгүй гэж 22.2 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 19.3 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Тус асуудлаар өгсөн хариултын хувийн жин өмнөх оныхоос бараг өөрчлөгдөөгүй байна.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 41.9 хувь нь худалдаа наймаа, 13.3 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 0.8 аялал жуулчлал, 6.5 хувь нь үйлчилгээ, 3.2 хувь нь хүнсний ногоо, 3.2 хувь нь газар тариалан, 6.9 хувь нь

мал аж ахуй гэж хариулсан байна. Газар тариалан, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, зочид буудал гэсэн хариултуудын хувийн жин өсч, хүнсний ногоо, худалдаа наймаа, аялал жуулчлал хариултууд буурчээ.

- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн 16.4 хувь нь хариулт өгөөгүй байна. Харин хариулсан иргэдийн 24.2 хувь нь 500000-1000000 төгрөг, 29.9 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг, 13.9 хувь нь 250000-500000 төгрөг, 19.7 хувь нь 1 сая- 1.5 сая төгрөг, 7.8 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ. Өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 250000-500000 төгрөг гэсэн хариултын хувийн жин 4.9 нэгжээр буурсан бол 1-1.5 сая гэсэн хариултынх 5.1 нэгжээр өсчээ.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 58.3 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 20.5 хувь нь 6-9 сар, 7.1 хувь нь 3 сар хүртэлх, 14.2 хувь нь 3-6 сар гэсэн хариулт өгчээ. 3-6 сар гэсэн хариултын эзлэх хувь 8.2 нэгжээр буурсан бол 9 сараас 1 жил гэсэн хариултынх 8.3 нэгжээр өсчээ.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 61.4 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 11.3 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 15.7 хувь нь хариулсан байна. Зээлийн хүү өндөр гэсэн хариултын эзлэх хувь 9.5 нэгжээр буурсан бол зээлийн хэмжээ бага, хугацаа хангалтгүй гэсэн хариултынх 4.3, 5.8 нэгжээр тус тус өсчээ.

#### 1.9.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 22.1 хувь, байхгүй гэж 69.5 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 8.5 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 30.8 хувь тийм, 60.1 хувь нь үгүй, 9.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 34.3 хувь, байхгүй гэж 58.4 хувь, мэдэхгүй гэж 7.3 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 76.5, таалагддаггүй гэж 13.7 хувь, мэдэхгүй гэж 9.8 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 73.3 хувь нь тийм, 19.6 хувь нь үгүй, 7.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 43.9 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 46.3 хувь нь чанаргүй, 9.8 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.
- Санал асуулгад оролцогчдын 16.8 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 71.2 хувь нь чаддаггүй, 11.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн ихэнх нь буюу 89.6 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 9.7 хувь нь үгүй, 0.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

#### 1.10. Өвөрхангай аймаг

2005 оны эцсийн байдлаар Өвөрхангай аймгийн өрхийн тоо 28.8 мянга, хүн ам 113.8 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 295 иргэн оролцсоны 56.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 13.4 хувь нь 25 нас хүртэлх, 30.3 хувь нь 25-34 насны, 31.7 хувь нь 35-44 насны, 16.9 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 13.1 хувь нь бүрэн бус дунд, 27.7 хувь нь бүрэн дунд, 20.8 хувь нь тусгай дунд, 38.4 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 29.2 хувь нь улсын байгууллага болон 30.2 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 25.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 10.4 хувь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 35-44 насны, дээд боловсролтой, хувийн байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.10.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 23.3 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 (цаашид өмнөх гэх) оны санал асуулгын дүнгээс 2.7 нэгжээр буурсан үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 24.7 хувь нь муудсан гэж хариулсан бол иргэдийн 44.4 хувь нь хэвэндээ гэсэн үнэлэлт өгчээ.
- Иргэдийн 25.2 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 26.5 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 9.6 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 27.8 хувь нь зээлийн хүүг бууруулах, 9.4 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Нэг жилийн хугацаанд татварыг бууруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нь зүйтэй гэсэн санал 4.3, 2.8 нэгжээр тус тус буурсан бол зээлийн хүүг бууруулах гэсэн санал 7.4 нэгжээр өсчээ.
- Иргэдийн 25.5 хувь нь уул уурхай, 21.7 хувь нь хөдөө аж ахуй, 12.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 19.8 хувь нь аялал жуулчлал, 9.3 хувь нь банк санхүү, 8.8 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад уул уурхайн салбарыг чухалчилсан санал 1.6 нэгжээр өссөн байхад боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлал гэсэн санал 1.6, 3.6 нэгжээр тус тус буурсан байна.
- **Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 87.4 хувь нь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс бараг өөрчлөгдөөгүй үнэлэлт юм. Харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 3.1 хувь нь өгсөн бол тогтворжиж байна гэж 7.5 хувь нь хариулжээ.**

### **1.10.2 Нийгмийн тулгамдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 18.2 хувь нь дээшилж байна, 29.8 хувь нь доошилж байна, 49.7 хувь нь хэвэндээ байна гэж хариулжээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн дээшилж байна гэсэн хариулт 1.7 нэгжээр өссөн байна.
- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 76.8 хувь нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өмнөх санал асуулгын дүнгээс 2.6 нэгжээр буурчээ. Ядуурал буурсан гэсэн хариултыг 8.0 хувь нь өгсөн бол хэвэндээ гэж 11.8 хувь нь хариулжээ. Өмнөх санал асуулгын дүнгээс ядуурал буурсан болох хэвэндээ гэсэн хариулт 2.3, 2.8 нэгжээр тус тус өсчээ.

- Иргэдийн дийлэнх буюу 80.2 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 4.4 хувь нь буурсан, 12.3 хувь нь хэвэндээ, 3.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Үүнийг өмнөх оны судалгаатай харьцуулахад өөрчлөлт гараагүй байна.
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 52.9 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 32.5 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 14.5 хувь нь өгчээ. Өмнөх санал асуулгын үзүүлэлттэй харьцуулахад газар хувьчлалыг дэмжсэн иргэдийн хариулт 5.5 нэгжээр багассан байна.

### 1.10.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 75.9 хувь хариулсан бол боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 12.4 хувь нь өгсөн бол 11.7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Үүнийг өмнөх оны судалгаатай харьцуулахад мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 63.6 хувь нь өгсөн бол 20.6 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 2.4 хувь нь буурсан, 13.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариулт 11.8 нэгжээр багасч, хэвэндээ гэсэн хариулт 8.1 нэгжээр өсчээ.
- Иргэдийн дийлэнх буюу 67.6 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 10.5 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 22.0 хувь нь хариулсан байна. Татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын хувийн жин өөрчлөгдөөгүй бол, бага гэсэн хариултынх 2.8 нэгжээр өсчээ.

### 1.10.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 38.1 хувь нь олон, 5.8 хувь нь цөөн, 52.4 хувь нь боломжийн, 3.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Үүнийг 2005 оны байдалтай харьцуулбал үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог цөөн гэж үзэгсэд 3.4 нэгжээр нэмэгдсэн байхад боломжийн гэж үзсэн иргэдийн хувийн жин 1.6 нэгжээр буурсан байна.
- Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн 55.3 хувь нь найдвартай гэж дүгнэсэн байна. Эргэлзээтэй гэсэн хариултыг иргэдийн 33.0 хувь нь өгсөн бол 4.1 хувь нь найдваргүй гэж хариулжээ. Найдвартай гэж хариулсан иргэдийн хувийн жин 9.2 нэгжээр өсч, эргэлзээтэй болон мэдэхгүй гэж хариулсан иргэдийнх тус бүр 4.8, 5.3 нэгжээр буурчээ.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 45.8 хувь нь нэмэгдсэн, 4.4 хувь нь буурсан, 38.6 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэсэн иргэдийн хувийн жин 1.7 нэгжээр буурчээ.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 62.4 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 23.7 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 13.9 хувь нь хариулсан байна. Сурталчилж чадаж байна гэсэн хариулт 1.8 нэгжээр буурч, чадахгүй байна гэсэн хариулт 3.6 нэгжээр өссөн байна.
- Иргэдийн 57.4 хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн

хариултыг иргэдийн 35.3 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 7.3 хувь нь хариулсан байна. Үүнийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад хэвийн үйлчилж байна гэж үзсэн иргэдийн хариултын хувийн жин 5.2 нэгжээр буурсан байхад чирэгдэлтэй байна гэсэн хариултынх 10.8 нэгжээр өссөн байна.

- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 56.8 хувь нь банк, 5.5 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 8.6 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 10.1 хувь нь ломбард, 14.7 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Өмнөх асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн банк, хувь хүнд хандах нь тус бүр 4.1, 2.3 нэгжээр буурсан бол хадгаламж зээлийн хоршоо, ломбардад хандах нь 4.4, 2.1 нэгжээр тус тус өссөн байна.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 39.8 хувь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 57.8 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 2.4 хувь нь өгсөн байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал үйлчлүүлдэг гэсэн хариултын хувийн жин 4.0 нэгжээр буурч, эсрэг хариултынх нь мөн ижил хэмжээгээр өсчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 43.2 хувь байгаа бол ойлголтгүй иргэд 37.0 хувь байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 19.9 хувь нь өгчээ. Үүнийг өмнөх оны судалгаатай харьцуулахад мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 15.8 хувь нь хариулсан өмнөх оныхоос 7.6 нэгжээр өссөн үзүүлэлт бол үгүй гэсэн хариултыг 81.5 хувь нь өгсөн байна.
- Иргэдийн 25.9 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн бол 22.4 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 51.7 хувь нь өгсөн байна. Өмнөх онтой харьцуулбал буруу буюу хууль бус гэсэн хариултын хувийн жин 14.3 нэгжээр өсчээ.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 47.2 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 19.9 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 32.9 хувь нь өгсөн байна. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэсэн хариултын хувийн жин 3.3 нэгжээр нэмэгджээ.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 25.0 хувь нь хариулсан бол 68.8 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 6.3 хувь нь хариулсан байна. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж хариулсан иргэдийн хувийн жин 8.4 нэгжээр нэмэгджээ.

#### 1.10.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 28.1 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 5.0 хувь нь бусдад зээлдүүлдэг, 31.8 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 2.0 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 29.8 хувь нь бусад хэлбэрээр эргэлдүүлдэг гэж хариулжээ. Банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг гэсэн хариултын эзлэх хувь 5.1 нэгжээр өсч, бусад хариултууд төдийлөн өөрчлөгдөөгүй байна.
- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 59.0 хувь нь хариулсан бол 15.6 хувь нь бэлэн бус, 3.1 хувь нь үнэт цаас, 5.9 хувь нь хувьцаагаар мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг

илүүд үздэг гэсэн хариултын хувийн жин 4.6 нэгжээр буурч, бэлэн бус хэлбэрийг сонгох нь ихэссэн байна.

- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 84.2 хувь нь төгрөгөөр, 8.6 хувь нь америк доллараар, 7.1 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Хоёр судалгааны дүнгээс үзэхэд төгрөгөөр хадгалах 6.7 нэгжээр багассан бол ам. доллар болон бусад валютаар хадгалах нь 3.2, 3.5 нэгжээр тус тус нэмэгджээ.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 55.3 хувь нь бага байна гэж үзсэн байхад иргэдийн 31.2 хувь нь хүүний түвшин боломжийн байна гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 13.5 хувь нь өгчээ. Хадгаламжийн хүүний түвшин боломжийн гэсэн хариултын хувийн жин 2.5 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултынх 2.7 нэгжээр багасчээ.

#### 1.10.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 87.2 хувь нь өгсөн бол 11.0 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Үүнийг өмнөх оны судалгаатай харьцуулахад өөрчлөлт гараагүй байна.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 53.2 хувь нь үзсэн байхад 29.6 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 17.2 хувь нь өгчээ. 2005-2006 онд зээл хүртээмжтэй гэсэн хариултын хувийн жин 1.5 нэгжээр нэмэгдэж, мэдэхгүй гэсэн хариултынх нь 1.8 нэгжээр багасчээ.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 48.3 хувь нь хариулсан бол 43.1 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариулт өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 8.6 хувь нь өгсөн байна. Зээл авахад хүндрэлгүй гэсэн хариултын хувийн жин 6.8 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултынх 6.3 нэгжээр буурчээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 71.7 хувь нь өндөр гэж хариулжээ. Харин зээлийн хүүний түвшин боломжийн гэж иргэдийн 22.7 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 5.6 хувь нь өгчээ. Зээлийн хүүний түвшин өндөр гэсэн хариултын хувийн жин 3.5 нэгжээр нэмэгдэж, мэдэхгүй гэсэн хариултынх 4.2 нэгжээр буурсан байна.

#### 1.10.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 70.1 хувь нь хариулсан бол 18.3 хувь нь ойлголтгүй гэж хариулжээ. Ойлголттой гэсэн хариултын эзлэх хувь 5.9 нэгжээр өссөн бол мэдэхгүй гэсэн хариултынх 6.9 нэгжээр буурчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 27.9 хувь нь сайн, 46.7 хувь нь дунд зэрэг, 9.8 хувь нь огт хөгжөөгүй, 15.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Бичил санхүү сайн хөгжсөн болон мэдэхгүй гэсэн хариултуудын хувийн жин 6.0, 3.5 нэгжээр тус тус буурсан бол дунд зэрэг болон огт хөгжөөгүй гэсэн хариултынх тус бүр 6.7, 2.9 нэгжээр өсчээ.
- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 63.5 хувь, боломжгүй гэж 19.5 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 17.0 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Бичил зээл авах боломжтой гэсэн хариулын хувийн жин 3.4 нэгжээр өссөн бол мэдэхгүй гэсэн хариултынх 3.2 нэгжээр буурчээ.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 27.9 хувь нь худалдаа наймаа, 11.5 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 4.5 хувь нь аялал жуулчлал, 10.8 хувь нь үйлчилгээ, 6.3 хувь нь хүнсний ногоо, 4.1 хувь нь газар тариалан,

7.4 хувь нь мал аж ахуй гэж хариулсан байна. Хүнсний ногоо, мал аж ахуй, аялал жуулчлал гэсэн хариултуудын хувийн жин өсч, худалдаа наймаа, жижиг дунд үйлдвэрлэл гэсэн хариултууд буурчээ.

- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн 10.8 хувь нь хариулт өгөөгүй байна. Харин хариулсан иргэдийн 22.4 хувь нь 500000-1000000 төгрөг, 33.5 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг, 14.1 хувь нь 250000-500000 төгрөг, 17.1 хувь нь 1 сая- 1.5 сая төгрөг, 8.0 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ. Өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 250000-500000 төгрөг, 500000-1 сая төгрөг гэсэн хариултуудын хувийн жин тус бүр 3.6, 5.8 нэгжээр буурсан бол 1-1.5 сая, 1.5-2 сая гэсэн хариултуудынх 4.8, 3.5 нэгжээр тус тус өсчээ.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 62.3 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 16.0 хувь нь 6-9 сар, 8.2 хувь нь 3 сар хүртэлх, 13.4 хувь нь 3-6 сар гэсэн хариулт өгчээ. Өмнөх жилтэй харьцуулбал хариулсан байдалд өөрчлөлт гараагүй байна.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 50.0 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 19.0 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 16.1 хувь нь хариулсан байна. Зээлийн хүү өндөр гэсэн хариултын эзлэх хувь 11.4 нэгжээр буурсан бол зээлийн хэмжээ бага, хугацаа хангалтгүй гэсэн хариултынх 8.7, 4.0 нэгжээр тус тус өсчээ.

#### 1.10.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 22.1 хувь, байхгүй гэж 69.5 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 8.5 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 32.9 хувь тийм, 57.9 хувь нь үгүй, 9.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 36.9 хувь, байхгүй гэж 48.6 хувь, мэдэхгүй гэж 14.5 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 72.4, таалагддаггүй гэж 15.9 хувь, мэдэхгүй гэж 11.7 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 70.5 хувь нь тийм, 23.1 хувь нь үгүй, 6.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 41.7 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 49.5 хувь нь чанаргүй, 8.8 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.
- Санал асуулгад оролцогчдын 31.2 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 52.6 хувь нь чаддаггүй, 16.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн ихэнх нь буюу 86.7 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 7.0 хувь нь үгүй, 6.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

#### I.11. Орхон аймаг

2005 оны эцсийн байдлаар Орхон аймгийн өрхийн тоо 20.9 мянга, хүн ам 79.0 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 264 иргэн оролцсоны 63.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 16.0 хувь нь 25 нас хүртэлх, 35.0 хувь нь 25-34 насны, 24.7 хувь нь 35-44 насны, 18.3 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 12.2 хувь нь бүрэн бус дунд, 22.8 хувь нь бүрэн дунд, 13.3 хувь нь тусгай дунд, 51.7 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 34.5 хувь нь улсын байгууллага буюу 32.9 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 14.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 9.7 хувь нь ажилгүй иргэд байна. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 25-34 насны, дээд боловсролтой, улсын байгууллагад ажилладаг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.11.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 30.7 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 (цаашид өмнөх гэх) оны санал асуулгын дүнгээс 5.5 нэгжээр өссөн үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 29.5 хувь нь муудсан гэж хариулсан бол иргэдийн 32.6 хувь нь хэвэндээ гэсэн үнэлэлт өгчээ.
- Иргэдийн 28.4 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 26.3 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 12.5 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 23.3 хувь нь зээлийн хүүг бууруулах, 7.2 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Эдийн засгийн өсөлтийг хангахын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нь зүйтэй гэж үзэх нь нэг жилийн хугацаанд нэмэгдсэн байна.
- Иргэдийн 38.5 хувь нь уул уурхай, 20.4 хувь нь хөдөө аж ахуй, 11.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 13.5 хувь нь аялал жуулчлал, 8.4 хувь нь банк санхүү, 6.4 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад уул уурхайг чухал гэсэн хариулт нэмэгдэж, бусад салбарыг сонгосон хариулт багасчээ.
- **Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 84.0 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс 9.2 нэгжээр буурсан үнэлэлт юм. Харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 8.4 хувь нь өгсөн бол тогтворжиж байна гэж 4.2 хувь нь хариулжээ.**

### **1.11.2 Нийгмийн тулгамдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 23.8 хувь нь дээшилж байна, 26.2 хувь нь доошилж байна, 46.4 хувь нь хэвэндээ байна гэж хариулжээ. Өмнөх санал асуулгын үзүүлэлттэй харьцуулахад иргэдийн дээшилж байна гэсэн хариулт 6.8 нэгжээр нэмэгдсэн байна.
- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 72.0 хувь нь нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өмнөх санал асуулгын дүнгээс 9.0 нэгжээр буурчээ. Ядуурал буурсан гэсэн хариултыг 12.2 хувь нь өгсөн бол хэвэндээ гэж 12.2 хувь нь хариулжээ.
- **Иргэдийн дийлэнх буюу 74.4 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 11.4 хувь нь буурсан, 9.1 хувь нь хэвэндээ, 5.1 хувь нь мэдэхгүй гэж**



хариулсан байна. Нэг жилийн хугацаанд ажилгүйчүүдийн тоо өссөн гэсэн хариултын хувийн жин 8.3 нэгжээр буурчээ.

- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 58.2 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 28.7 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 13.1 хувь нь өгчээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн газар хувьчлалыг дэмжсэн хариулт 15.3 нэгжээр багассан байна.

#### 1.11.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 69.0 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс 19.2 нэгжээр буурчээ. Харин боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 19.4 хувь нь өгсөн бол 11.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 61.8 хувь нь өгсөн бол 16.3 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 10.0 хувь нь буурсан, 12.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 16.0 нэгжээр буурч, буурч байна буюу хэвэндээ гэсэн хариултынх 8.3 болон 2.7 нэгжээр тус тус өсчээ.
- Иргэдийн дийлэнх буюу 67.3 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 15.7 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 16.9 хувь нь хариулсан байна. Татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын хувийн жин 12.6 нэгжээр буурчээ.

#### 1.11.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 42.9 хувь нь олон, 13.1 хувь нь цөөн, 38.5 хувь нь боломжийн, 5.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулахад банкуудын тоо олон буюу цөөн байна гэсэн хариултын хувийн жин 5.4 нэгж болон 9.7 нэгжээр тус тус өсч, боломжийн гэсэн хариултынх 19.5 нэгжээр багасчээ.
- Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн 55.1 хувь нь найдвартай гэж дүгнэсэн байна. Эргэлзээтэй гэсэн хариултыг иргэдийн 27.6 хувь нь өгсөн бол 12.6 хувь нь найдваргүй гэж хариулжээ. Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа найдвартай гэсэн хариултын хувь 5.4 нэгжээр багасч, найдваргүй гэсэн хариултынх 8.6 нэгжээр өсчээ.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 42.3 хувь нь нэмэгдсэн, 14.2 хувь нь буурсан, 34.8 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэсэн хариултын эзлэх хувь 15.6 нэгжээр буурсан байна.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 61.8 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 27.6 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 10.6 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултын хувь 15.5 нэгжээр буурсан бол чадахгүй байна гэсэн хариултынх 12.7 нэгжээр өсчээ.
- Иргэдийн 58.3 хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн хариултыг иргэдийн 34.1 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 7.5 хувь нь

хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариултын эзлэх хувь 10.0 нэгжээр багассан бол эсрэг хариултынх 7.3 нэгжээр өссөн байна.

- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 49.7 хувь нь банк, 5.5 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 9.8 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 14.6 хувь нь ломбард, 16.5 хувь нь хувь хүн гэж хариулжээ. Мөнгөний хэрэгцээ гарахад банкинд хандана гэсэн хариултын хувийн жин 2.9 нэгжээр буурчээ.
- Банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултыг иргэдийн 34.5 хувь өгсөн бол, үйлчлүүлдэггүй гэж иргэдийн 60.9 хувь нь хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 4.6 хувь нь өгсөн байна. Нэг жилийн хугацаанд банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг гэсэн хариултын хувийн жин 7.7 нэгжээр багассан байна.
- Хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой иргэд 46.6 хувь байгаа нь өмнөх оноос 10.8 нэгжээр буурсан үзүүлэлт бол ойлголтгүй иргэд 38.6 хувь байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 14.8 хувь нь өгчээ.
- Хадгаламж зээлийн хоршооны гишүүн гэж иргэдийн 14.8 хувь нь хариулсан бол үгүй гэсэн хариултыг 81.4 хувь нь өгсөн байна. Хоёр судалгааны дүнд ялгаа ажиглагдахгүй байна.
- Иргэдийн 22.1 хувь нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа зөв буюу хуулийн дагуу гэж үзсэн нь өмнөх оноос 13.7 нэгжээр буурсан үзүүлэлт бол 40.8 хувь нь буруу буюу хууль бус гэж дүгнэжээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 37.0 хувь нь өгсөн байна.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж иргэдийн 39.8 хувь нь хариулсан бол ач холбогдолгүй гэж иргэдийн 33.3 хувь нь үзжээ. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 26.9 хувь нь өгсөн байна. Хоёр судалгааны дүнгээс үзэхэд гадаадын банк санхүүгийн байгууллагыг дэмжсэн хариултын хувийн жин 12.6 нэгжээр буурсан бол эсрэг хариултынх 10.0 нэгжээр өсчээ.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэж иргэдийн 46.7 хувь нь хариулсан бол 47.1 хувь нь хэрэглэдэггүй гэсэн хариулт өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 6.1 хувь нь хариулсан байна. Нэг жилийн хугацаанд бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг гэсэн хариултын хувийн жин 4.0 нэгжээр буурсан байна.

#### 1.11.5 Хадгаламж, хуримтлал

- Хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 43.6 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 13.8 хувь нь бусдад зээлдүүлдэг, 18.9 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 1.5 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 1.1 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 21.1 хувь нь бусад хэлбэрээр эргэлдүүлдэг гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд хуримтлуулсан мөнгөө банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг болон бусдад зээлдүүлдэг гэсэн хариултын хувь тус бүр 5.1, 9.3 нэгжээр нэмэгджээ. Харин худалдаа наймаа хийдэг гэсэн хариултын хувийн жин 3.5 нэгжээр буурчээ.
- Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэж иргэдийн дийлэнх буюу 63.1 хувь нь хариулсан бол бусад иргэдийн 17.2 хувь нь бэлэн бусаар, 4.9 хувь нь үнэт цаасаар, 3.0 хувь нь хувьцаагаар мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэж хариулжээ. Мөнгөө бэлэн хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг гэсэн хариултын эзлэх хувь 1.9 нэгжээр ихэсч, бэлэн бусаар байршуулах нь 3.5 нэгжээр буурчээ.

- Мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд иргэдийн 79.3 хувь нь төгрөгөөр, 14.0 хувь нь америк доллараар, 6.6 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулсан байна. Хоёр судалгааны дүнг харьцуулбал мөнгөө төгрөгөөр хадгалдаг гэсэн хариултын хувийн жин 9.3 нэгжээр багасч, ам. доллараар хадгалах нь 5.2 нэгжээр нэмэгджээ.
- Хадгаламжийн хүүний түвшинг иргэдийн 57.5 хувь нь бага байна гэж үзсэн байхад иргэдийн 29.9 хувь нь хүүний түвшин боломжийн байна гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 12.6 хувь нь өгчээ. Нэг жилийн хугацаанд хадгаламжийн хүүний түвшин бага гэсэн хариултын хувийн жин 2.7 нэгжээр буурчээ.

#### 1.11.6 Зээлийн талаар

- Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултыг иргэдийн 79.1 хувь нь өгсөн бол 16.3 хувь нь зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан байна. Зээлийн хэрэгцээ байдаг гэсэн хариултын эзлэх хувь 9.1 нэгжээр багасчээ.
- Зээл хүртээмжтэй гэж иргэдийн 36.9 хувь нь үзсэн байхад 44.4 хувь нь зээл хүртээмжгүй гэж хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 18.7 хувь нь өгчээ. Зээл хүртээмжтэй гэсэн хариултын хувийн жин 13.4 нэгжээр буурсан байна.
- Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж иргэдийн 29.3 хувь нь хариулсан бол 56.0 хувь нь зээл авахад хүндрэлтэй гэсэн хариулт өгчээ. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 14.7 хувь нь өгсөн байна. Нэг жилийн хугацаанд банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэсэн хариултын хувийн жин 12.4 нэгжээр буурчээ.
- Зээлийн хүүний түвшинг иргэдийн дийлэнх буюу 57.5 хувь нь өндөр гэж хариулжээ. Энэ нь өмнөх судалгааны дүнгээс 9.2 нэгжээр бага байна. Харин зээлийн хүүний түвшин боломжийн гэж иргэдийн 30.1 хувь нь хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 12.4 хувь нь өгчээ.

#### 1.11.7 Бичил санхүүгийн талаар

- Бичил санхүүгийн талаар ойлголттой гэж иргэдийн 63.5 хувь нь хариулсан бол 25.4 хувь нь ойлголтгүй гэж хариулжээ. Өмнөх онтой харьцуулбал бичил санхүүгийн талаар ойлголттой гэсэн хариултын эзлэх хувь 14.1 нэгжээр буурчээ.
- Таны оршин суугаа газар бичил санхүү хэрхэн хөгжсөн бэ гэсэн асуултанд иргэдийн 30.2 хувь нь сайн, 43.4 хувь нь дунд зэрэг, 14.7 хувь нь огт хөгжөөгүй, 11.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Бичил санхүү сайн хөгжсөн гэсэн хариултуудын хувийн жин 9.3 нэгжээр буурсан бол огт хөгжөөгүй гэсэн хариултынх 10.0 нэгжээр өсчээ.
- Бичил зээл авах боломжтой гэж иргэдийн 57.9 хувь, боломжгүй гэж 27.8 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 14.3 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Бичил зээл авах боломжтой гэсэн хариулын хувийн жин 9.0 нэгжээр буурсан бол боломжгүй гэсэн хариултынх 6.9 нэгжээр өсчээ.
- Ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд иргэдийн 27.6 хувь нь худалдаа наймаа, 10.7 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 2.7 хувь нь аялал жуулчлал, 9.3 хувь нь үйлчилгээ, 7.6 хувь нь хүнсний ногоо, 7.6 хувь нь газар тариалан, 9.3 хувь нь мал аж ахуй гэж хариулсан байна. Хүнсний ногоо, мал аж ахуй, аялал жуулчлал, зочид буудал гэсэн хариултуудын хувийн жин өсч, худалдаа наймаа, үйлчилгээ гэсэн хариултууд буурчээ.

- Үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд иргэдийн 16.7 хувь нь хариулт өгөөгүй байна. Харин хариулсан иргэдийн 16.4 хувь нь 500000-1000000 төгрөг, 46.4 хувь нь 1.5 сая-2 сая төгрөг, 10.0 хувь нь 250000-500000 төгрөг, 15.5 хувь нь 1 сая- 1.5 сая төгрөг, 4.5 хувь нь 100000-250000 төгрөг гэж хариулжээ. Өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 100000-250000, 250000-500000 төгрөг гэсэн хариултууд багассан бол 1-1.5 сая, 1.5-2 сая гэсэн хариултуудынх ялимгүй өсчээ.
- Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9 сараас-1 жил хүртэлх хугацаа шаардлагатай гэж иргэдийн 61.0 хувь нь хариулсан байна. Харин иргэдийн 16.5 хувь нь 6-9 сар, 11.0 хувь нь 3 сар хүртэлх, 11.5 хувь нь 3-6 сар гэсэн хариулт өгчээ. Өмнөх жилтэй харьцуулбал 6-9 сарын сонгох нь 3.9 нэгжээр өссөн бол 9 сараас- 1 жил хүртэл гэсэн хариултыг сонгох нь 9.1 нэгжээр буурчээ.
- Бизнес эрхлэхэд банк, санхүүгийн байгууллагаас ямар хүндрэл учруулж байна гэсэн асуултанд иргэдийн дийлэнх буюу 48.8 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулжээ. Мөн зээлийн хэмжээ бага гэж 14.3 хувь, зээлийн хугацаа хангалтгүй гэж 22.9 хувь нь хариулсан байна. Зээлийн хүү өндөр гэсэн хариултын эзлэх хувь 10.8 нэгжээр буурсан бол бусад хариултуудынх ялимгүй өсчээ.

#### 1.11.8 Мөнгөн тэмдэгтийн талаар

- Бага нэрлэсэн үнэтэй буюу 1-т, 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байна гэж иргэдийн 21.8 хувь, байхгүй гэж 61.3 хувь нь санал өгсөн бол мэдэхгүй гэж 16.9 хувь нь хэлжээ.
- 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд иргэдийн 32.2 хувь тийм, 50.8 хувь нь үгүй, 17.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 44.2 хувь, байхгүй гэж 42.3 хувь, мэдэхгүй гэж 13.5 хувь нь илэрхийлжээ.
- Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж иргэдийн 70.7, таалагддаггүй гэж 17.4 хувь, мэдэхгүй гэж 12.0 хувь нь хариулжээ.
- 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу гэсэн асуултанд иргэдийн 75.0 хувь нь тийм, 20.8 хувь нь үгүй, 4.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн 47.1 хувь нь гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг бол 42.5 хувь нь чанаргүй, 10.4 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.
- Санал асуулгад оролцогчдын 30.1 хувь нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг гэсэн бол, 59.1 хувь нь чаддаггүй, 10.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Иргэдийн ихэнх нь буюу 84.6 хувь нь мөнгөө түрийвчинд хийж цэвэрхэн авч явдаг гэсэн бол 10.4 хувь нь үгүй, 5.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

#### 1.12. Ховд аймаг

2005 оны эцсийн байдлаар Ховд аймгийн өрхийн тоо 19.4 мянга, хүн ам 87.9 мянгад хүрсэн байна. Санал асуулгад тус аймгаас 296 иргэн оролцсоны 55.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны ангиллаар авч үзвэл нийт оролцогчдын 9.2 хувь нь 25

нас хүртэлх, 28.7 хувь нь 25-34 насны, 37.5 хувь нь 35-44 насны, 18.1 хувь нь 45-54 насны иргэд байв. Санал асуулгад оролцогчдын 11.3 хувь нь бүрэн бус дунд, 24.7 хувь нь бүрэн дунд, 20.3 хувь нь тусгай дунд, 43.6 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Ажил эрхлэлтийн хувьд нийт оролцогчдын 29.8 хувь нь улсын байгууллага болон 20.3 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 34.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 12.2 хувь нь ажилгүй иргэд байлаа. Тус санал асуулгад илүү хамрагдсан нь эмэгтэй, 35-44 насны, дээд боловсролтой, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн дараах байдлаар танилцуулъя.

### **1.12.1 Эдийн засгийн ерөнхий асуудлууд**

- Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж санал асуулгад оролцсон иргэдийн 22.7 хувь нь хариулжээ. Энэ нь 2005 (цаашид өмнөх гэх) оны санал асуулгын дүнгээс 3.5 нэгжээр буурсан үнэлэлт юм. Өнөөгийн эдийн засгийн байдлыг иргэдийн 33.2 хувь нь муудсан гэж хариулсан бол иргэдийн 33.9 хувь нь хэвэндээ гэсэн үнэлэлт өгчээ.
- Иргэдийн 23.6 хувь нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын ачааллыг багасгах, 23.9 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 11.3 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 28.0 хувь нь зээлийн хүүг бууруулах, 12.4 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэсэн хариулт өгсөн байна. Нэг жилийн хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварыг бууруулах, бизнесменүүдээ урамшуулах хэрэгтэй гэсэн бодол олширчээ.
- Иргэдийн 29.6 хувь нь уул уурхай, 25.3 хувь нь хөдөө аж ахуй, 12.0 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 14.4 хувь нь аялал жуулчлал, 9.7 хувь нь банк санхүү, 6.9 хувь нь худалдаа үйлчилгээг Монгол улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх салбар гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд уул уурхайд өгсөн санал 5.3 нэгжээр өсч, боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг чухалчлах нь 3.1 нэгжээр буурчээ.
- **Өргөн хэрэглээний барааны үнийн түвшин өсч байна гэж иргэдийн 90.9 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс өөрчлөгдөөгүй байна. Харин буурч байна гэсэн хариултыг иргэдийн 0.3 хувь нь өгсөн бол тогтворжиж байна гэж 7.4 хувь нь хариулжээ.**

### **1.12.2 Нийгмийн тулгамдсан асуудал**

- Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд иргэдийн 16.3 хувь нь дээшилж байна, 31.6 хувь нь доошилж байна, 50.7 хувь нь хэвэндээ байна гэж хариулжээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад хэвэндээ байна гэсэн хариулт 4.4 нэгжээр өссөн байна.
- Хүн амын ядуурлыг иргэдийн дийлэнх буюу 78.7 хувь нь нэмэгдсэн гэж дүгнэсэн нь өмнөх санал асуулгын үзүүлэлтээс 3.6 нэгжээр өсчээ. Ядуурал буурсан гэсэн хариултыг 5.7 хувь нь өгсөн бол хэвэндээ гэж 11.8 хувь нь хариулжээ.
- **Иргэдийн дийлэнх буюу 80.7 хувь нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн бол 4.7 хувь нь буурсан, 9.8 хувь нь хэвэндээ, 4.7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.**
- Газар хувьчлалыг дэмжиж байна гэж иргэдийн 59.1 хувь, дэмжихгүй байна гэж иргэдийн 29.4 хувь нь хариулсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг иргэдийн 11.5 хувь нь өгчээ. Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад

иргэдийн газар хувьчлалыг дэмжсэн хариулт 10.1 нэгжээр багассан бол дэмжихгүй байгаа нь 8.6 нэгжээр нэмэгдсэн байна.

### 1.12.3 Татварын талаар

- Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж иргэдийн 75.7 хувь хариулсан нь өмнөх санал асуулгын дүнгээс 4.1 нэгжээр нэмэгджээ. Харин боломжийн гэсэн дүгнэлтийг иргэдийн 15.2 хувь нь өгсөн бол 9.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Татварын ачаалал нэмэгдсэн гэсэн хариултыг иргэдийн 66.6 хувь нь өгсөн бол 20.3 хувь нь татварын ачаалал хэвэндээ гэж хариулсан байна. Харин татварын ачааллыг иргэдийн 2.7 хувь нь буурсан, 10.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Хоёр судалгааны дүнг харьцуулж үзэхэд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.
- Иргэдийн дийлэнх буюу 71.7 хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж хариулсан байна. Харин татвараас зайлсхийх явдал бага гэсэн хариултыг иргэдийн 9.2 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 19.8 хувь нь хариулсан байна. Татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариултын эзлэх хувь 3.1 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултынх 3.7 нэгжээр буурчээ.

### 1.12.4 Банк, санхүүгийн салбарын талаар

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн 38.3 хувь нь олон, 5.4 хувь нь цөөн, 49.8 хувь нь боломжийн, 6.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Нэг жилийн хугацаанд банкуудын тоо олон байна гэсэн хариултын хувийн жин 5.1 нэгжээр буурч, харин боломжийн байна гэсэн хариултынх 4.4 нэгжээр өсчээ.
- Өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулахад иргэдийн банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг найдваргүй гэж дүгнэсэн нь 2.5 нэгжээр буурч найдвартай гэсэн нь хэвэндээ буюу 48.3 хувьтай байна. Харин эргэлзээтэй гэсэн хариултын хувийн жин 5.0 нэгжээр өсч 42.2 хувьд хүрсэн бол мэдэхгүй гэж 4.1 хувь нь хариулсан байна.
- Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг иргэдийн 44.6 хувь нь нэмэгдсэн, 9.1 хувь нь буурсан, 36.8 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэсэн хариултын хувийн жин 6.4 нэгжээр буурч, хэвэндээ гэсэн хариултынх 5.8 нэгжээр өсчээ.
- Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж иргэдийн 61.0 хувь нь хариулсан байна. Харин сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг иргэдийн 25.4 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 13.6 хувь нь хариулсан байна. 2005-2006 онд банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултын эзлэх хувь 6.6 нэгжээр буурч, эсрэг хариултынх нь 3.2 нэгжээр өсчээ.
- Иргэдийн 52.2 хувь нь банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж хариулсан байна. Харин банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн хариултыг иргэдийн 41.4 хувь нь өгчээ. Мэдэхгүй гэж иргэдийн 6.4 хувь нь хариулсан байна. Банк, санхүүгийн байгууллагууд хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариултын хувийн жин 7.2 нэгжээр багасч, эсрэг хариултынх нь 8.4 нэгжээр өсчээ.
- Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултанд иргэдийн 60.7 хувь нь банк, 2.3 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 1.2 хувь нь

Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг найдваргүй, мэдэхгүй гэсэн хариултуудын хувьд хүйсийн ялгаа их ажиглагдахгүй байгаа бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 7 орчим хувь нь (2005 оноос эмэгтэйчүүдийн хувьд бага хэмжээгээр өссөн) найдваргүй, мөн 7 орчим хувь нь (2005 оноос аль алиных нь хувьд бага хэмжээгээр буурсан) мэдэхгүй гэж хариулсан байна. Харин найдвартай гэсэн хариултыг эрэгтэйчүүдийн 54.1 хувь нь (2005 оноос 9.5 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 48.6 хувь нь (2005 оноос 3.5 нэгжээр өссөн) сонгосон байна. Мөн эргэлзээтэй гэсэн хариултыг эрэгтэйчүүдийн 31.1 хувь нь (2005 оноос 6.6 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 38.0 хувь нь (2005 оноос 1.5 нэгжээр буурсан) сонгосон байна.

Хүснэгт II.4.3. Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл

		Нэмэгдсэн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
Эрэгтэй	2005	46.2	10	32.5	11.3
	2006	45.8	10.7	36.2	7.4
	<i>өөрчлөлт</i>	-0.4	0.7	3.7	-3.9
Эмэгтэй	2005	42.2	8.9	36.8	12.1
	2006	40.8	10.9	39.0	9.3
	<i>өөрчлөлт</i>	-1.4	2.0	2.2	-2.8

Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл буурсан гэсэн хариултын хувьд хүйсийн ялгаа бага байгаа бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 11 орчим хувь нь тус хариултыг сонгосон байна. Дээрх хариулт 2005 онтой харьцуулахад харгалзан 0.7, 2.0 нэгжээр тус тус өссөн байна. Банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэж судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 45.8 хувь нь (2005 оноос 0.4 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 40.8 хувь нь (2005 оноос 1.4 нэгжээр буурсан), хэвэндээ гэж эрэгтэйчүүдийн 36.2 хувь нь (2005 оноос 3.7 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 39.0 хувь нь (2005 оноос 2.2 нэгжээр буурсан) хариулжээ.

Хүснэгт II.4.4. Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж

		Сурталчилж чадаж байна	Сурталчилж чадахгүй байна	Мэдэхгүй
Эрэгтэй	2005	66.7	20.8	12.5
	2006	66.9	21.2	11.9
	<i>Өөрчлөлт</i>	0.2	0.4	-0.6
Эмэгтэй	2005	65.8	19.1	15.1
	2006	63.4	22.8	13.9
	<i>Өөрчлөлт</i>	-2.4	3.7	-1.2

Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг сурталчилж чадаж байна гэсэн хариултыг эрэгтэйчүүдийн 66.9 хувь (2005 оноос 0.2 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 63.4 хувь нь (2005 оноос 2.4 нэгжээр буурсан) сонгосон байна. Харин сурталчилж чадахгүй байна, мэдэхгүй гэсэн хариултуудын хувьд хүйсийн ялгаа хүчтэй ажиглагдахгүй байна.

Хүснэгт II.4.5. Банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ

		Хэвийн	Чирэгдэлтэй	Мэдэхгүй
Эрэгтэй	2005	57	29.8	13.1
	2006	58.7	31.5	9.8
	<i>Өөрчлөлт</i>	1.7	1.7	-3.3
Эмэгтэй	2005	59.6	28.6	11.8
	2006	56.5	33.4	10.1
	<i>Өөрчлөлт</i>	-3.1	4.8	-1.7

Банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хэвийн гэж эрэгтэйчүүдийн 58.7 хувь нь (2005 оноос 1.7 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 56.5 хувь нь (2005 оноос 3.1 нэгжээр буурсан), чирэгдэлтэй гэсэн хариултыг эрэгтэйчүүдийн 31.5 хувь нь (2005 оноос 1.7 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 33.4 хувь нь (2005 оноос 4.8 нэгжээр өссөн) тус тус сонгосон байна. Эндээс харахад банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээ 2005 онтой харьцуулахад эмэгтэйчүүдийн хувьд хүндрэл чирэгдэл нэлээд ихэсч, харин эрэгтэйчүүдийн хувьд багассан үр дүн харагдаж байна.

Хүснэгт II.4.6. Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ

		Банк	ББСБ	ХЗХ	Ломбард	Хувь хун	Бусад
Эрэгтэй	2005	44.5	6.2	6.9	15.2	21.3	6
	2006	63.8	5.9	5.2	15.7	24.7	6.5
	<i>Өөрчлөлт</i>	19.3	-0.3	-1.7	0.5	3.4	0.5
Эмэгтэй	2005	45.8	5.5	6.8	15.9	21.1	5
	2006	65.9	4.6	5.3	18.8	23.9	5.1
	<i>Өөрчлөлт</i>	20.1	-0.9	-1.5	2.9	2.8	0.1

Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ гэсэн асуултын хариултад хүйсийн байдал нөлөөлөөгүй байна. ББСБ, ХЗХ, Бусад гэж эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн 5-6 орчим хувь нь (2005 онтой харьцуулахад 0.3-1.7 нэгжээр буурсан) хариулсан байна. Харин банк гэж дийлэнх нь буюу эрэгтэйчүүдийн 63.8 хувь (2005 оноос 19.3 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 65.9 хувь нь (2005 оноос 20.1 нэгжээр өссөн), ломбард гэж эрэгтэйчүүдийн 15.7 хувь (2005 оноос 0.5 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 18.8 хувь нь (2005 оноос 2.9 нэгжээр өссөн) хариулсан байна.

Хүснэгт II.4.7. Та банк бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг үү

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	2005	37	58.9	4.1
	2006	29.1	67.2	3.6
	<i>Өөрчлөлт</i>	-7.9	8.3	-0.5
Эмэгтэй	2005	38.5	57.6	3.8
	2006	29.8	67.3	2.9
	<i>Өөрчлөлт</i>	-8.7	9.7	-0.9

Банк бус санхүүгийн байгууллагаар эрэгтэйчүүдийн 67.2 хувь нь (2005 оноос 8.3 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 67.3 хувь нь (2005 оноос 9.7 нэгжээр өссөн) үйлчлүүлдэггүй байна. Энэ асуултын хувьд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байгаа боловч ББСБ-аар үйлчлүүлэх нь эмэгтэйчүүдийн хувьд илүү ихээр багассан байна.

Хүснэгт II.4.8. Та хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой юу

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	2005	47.4	34.9	17.7
	2006	44.4	39.3	16.2
	<i>Өөрчлөлт</i>	-3.0	4.4	-1.5
Эмэгтэй	2005	37.1	57.2	5.7
	2006	39.6	42.5	17.9
	<i>Өөрчлөлт</i>	2.5	-14.7	12.2

Энэ асуултын хувьд хүйсийн багахан ялгаа нэлээд ажиглагдаж байна. Судалгаанд хамрагдсан эрчүүдийн 39.3 хувь нь (2005 оноос 4.4 нэгжээр өссөн) үгүй гэж хариулсан бол эмэгтэйчүүдийн 42.5 хувь нь (2005 оноос 14.7 нэгжээр буурсан) үгүй гэж хариулсан байна. Эмэгтэйчүүдийн ойлголтгүй гэсэн хариулт 14.7 нэгжээр буурсан нь мэдэхгүй гэсэн хариултыг 12.2 нэгжээр өсгөж, ойлголттой гэсэн хариултыг 2.5 нэгжээр өсгөсөн байна.

Хүснэгт II.4.9. Та хадгаламж зээлийн хоршооны гишүүн үү

		Тийм	Үгүй	Мэдэхгүй

Эрэгтэй	2005	12.8	82.1	5.1
	2006	10.1	86.3	3.5
	<i>Өөрчлөлт</i>	-2.7	4.2	-1.6
Эмэгтэй	2005	12.3	82.6	5
	2006	9.8	87.5	2.7
	<i>Өөрчлөлт</i>	-2.5	4.9	-2.3

ХЗХоршооны гишүүн мөн эсэхийг сонирхсон асуултад хүйсийн ялгаа ажиглагдахгүй байгаа бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 87 орчим хувь нь гишүүн биш гэсэн хариулт өгсөн бөгөөд 2005 онтой харьцуулахад 4-5 орчим нэгжээр өссөн байна.

Хүснэгт II.4.10. Та хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ

		Зөв, хуулийн дагуу	Буруу, хууль бус	Мэдэхгүй
Эрэгтэй	2005	34.2	13.3	52.5
	2006	23.5	32.0	44.5
	<i>Өөрчлөлт</i>	-10.7	18.7	-8.0
Эмэгтэй	2005	30.6	9.8	59.7
	2006	19.2	27.3	53.5
	<i>Өөрчлөлт</i>	-11.4	17.5	-6.2

Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг дүгнэж мэдэхгүй эрэгтэйчүүд 44.5 хувь (2005 оноос 8 нэгжээр буурсан), эмэгтэйчүүд 53.5 хувийг (2005 оноос 6.2 нэгжээр буурсан) эзэлж байна. Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг буюу зөв гэж эрэгтэйчүүдийн 23.5 хувь (2005 оноос 10.7 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 19.2 хувь нь (2005 оноос 11.4 нэгжээр буурсан) хариулжээ.

Хүснэгт II.4.11. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь

		Ач холбогдолтой	Ач холбогдолгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	2005	51.4	20.9	27.7
	2006	47.7	25.1	27.1
	<i>Өөрчлөлт</i>	-3.7	4.2	-0.6
Эмэгтэй	2005	42.7	19.2	38.1
	2006	39.4	23.1	37.5
	<i>Өөрчлөлт</i>	-3.3	3.9	-0.6

Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь гэсэн асуултад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ялгаатай хариулт өгсөн байна. Ач холбогдолтой гэж эрэгтэйчүүдийн 47.7 хувь (2005 оноос 3.7 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 39.4 хувь нь (2005 оноос 3.3 нэгжээр буурсан) үзжээ. Ач холбогдолгүй гэж эрэгтэйчүүдийн 25.1 хувь нь (2005 оноос 4.2 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 23.1 хувь нь (2005 оноос 3.9 нэгжээр өссөн) хариулсан байна. Харин эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс 10 орчим илүү хувиар мэдэхгүй гэж хариулсан байна. Гэвч мэдэхгүй гэсэн хариулт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь хувьд багассан байна.

Хүснэгт II.4.12. Та бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	2005	23	69.2	7.8
	2006	34.3	61.2	4.5
	<i>Өөрчлөлт</i>	11.3	-8.0	-3.3

Эмэгтэй	2005	20.2	71.5	8.3
	2006	29.3	65.7	5.0
	Өөрчлөлт	9.1	-5.8	-3.3

Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох карт хэрэглэдэггүй хүмүүс олонх бөгөөд эрэгтэйчүүдийн 61.2 хувь (2005 оноос 8 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 65.7 хувь (2005 оноос 5.8 нэгжээр буурсан) нь байна. Эндээс харвал эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүүтэйгээр бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болох картыг ашиглаж байна. Гэхдээ эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн картын хэрэглээ 2005 онтой харьцуулахад багагүй хэмжээгээр нэмэгдсэн байна.

## II. 5. Хадгаламж хуримтлал

Хүснэгт II.5.1. Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ

		Банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг	Бусад зээлдүүлдэг	Худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг	Үнэт цаасанд байршуулдаг	Хувьцаа худалдаж авдаг	Бусад байдлаар зарцуулдаг
Эрэгтэй	2005	27.2	8	28.9	1.4	1.3	33.2
	2006	35.9	7.9	30.1	2.2	2.5	30.8
	Өөрчлөлт	8.7	-0.1	1.2	0.8	1.2	-2.4
Эмэгтэй	2005	29.7	8	26.8	1.2	1.5	32.8
	2006	37.4	7.7	27.6	1.3	2.1	32.4
	Өөрчлөлт	7.7	-0.3	0.8	0.1	0.6	-0.4

Хуримтлуулсан мөнгөө банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг гэж судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 35.9 хувь (2005 оноос 8.7 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 37.4 (2005 оноос 7.7 нэгжээр өссөн) хувийг тус тус эзэлжээ. Эрэгтэйчүүдийн 30.8 хувь (2005 оноос 2.4 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 32.4 (2005 оноос 0.4 нэгжээр өссөн) хувь нь бусад байдлаар зарцуулдаг байна. Худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг гэсэн хариулт нь хүйсийн ялгаа харьцангуй ихтэй бөгөөд эрэгтэйчүүдийн 30.1 хувь (2005 оноос 1.2 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийнх 27.6 хувь (2005 оноос 0.8 нэгжээр өссөн) нь энэ хариултыг сонгосон байна.

Хүснэгт II.5.2. Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ

		Бэлэн мөнгөөр	Бэлэн бусаар	Үнэт цаасаар	Хувьцаагаар	Бусад
Эрэгтэй	2005	62	15.7	4.2	3.8	14.3
	2006	66.4	16.1	5.0	5.5	12.8
	Өөрчлөлт	4.4	0.4	0.8	1.7	-1.5
Эмэгтэй	2005	63.9	14.7	4.4	3.3	13.7
	2006	70.2	15.6	3.4	3.3	11.9
	Өөрчлөлт	6.3	0.9	-1.0	0.0	-1.8

Мөнгөө бэлэн бусаар, бусад гэсэн хэлбэрээр байршуулдаг иргэдийн хувьд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна. Харин бэлэн мөнгөөр, үнэт цаасаар болон хувьцаагаар байршуулахад хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Бэлэн мөнгөөр гэж судалгаанд оролцогч эрэгтэйчүүдийн 66.4 хувь (2005 оноос 4.4 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 70.2 хувь (2005 оноос 6.3 нэгжээр өссөн) нь хариулсан байна. Харин үнэт цаас болон хувьцаагаар гэж эрэгтэйчүүдийн 5.0 орчим хувь (2005 оноос 1 орчим нэгжээр

өссөн), эмэгтэйчүүдийн 3 орчим хувь (2005 оноос 1 орчим нэгжээр буурсан) нь хариулсан байна.

Хүснэгт II.5.3. Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ

		Төгрөг	Ам.доллар	Бусад валютаар
Эрэгтэй	2005	87.7	7.2	5.1
	2006	87.7	10.7	4.5
	<i>Өөрчлөлт</i>	0.0	3.5	-0.6
Эмэгтэй	2005	89.4	5.7	5
	2006	91.0	7.1	4.5
	<i>Өөрчлөлт</i>	1.6	1.4	-0.5

Мөнгөө байршуулах валютын сонголтын хувьд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хооронд бага зэргийн ялгаа ажиглагдаж байна. Төгрөгөөр эрэгтэйчүүдийн 87.7 хувь (2005 оноос өөрчлөгдөөгүй) нь, эмэгтэйчүүдийн 91.0 хувь (2005 оноос 1.6 нэгжээр өссөн) нь, ам.доллараар гэж эрэгтэйчүүдийн 10.7 хувь (2005 оноос 3.5 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 7.1 хувь (2005 оноос 1.4 нэгжээр өссөн) нь байршуулж байна. 2005 онтой харьцуулахад мөнгөө бусад валютаар байршуулах нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд багассан байна.

Хүснэгт II.5.4. Хадгаламжийн хүү таны бодлоор

		бага байна	боломжийн байна	мэдэхгүй
Эрэгтэй	2005	56.7	28.7	14.6
	2006	53.9	32.6	13.4
	<i>Өөрчлөлт</i>	-2.8	3.9	-1.2
Эмэгтэй	2005	58.4	26.7	14.9
	2006	58.0	26.9	15.1
	<i>Өөрчлөлт</i>	-0.4	0.2	0.2

Хадгаламжийн хүүний талаар өгсөн хариултууд хүйсийн байдлаас тодорхой хэмжээгээр хамаарч байна. Хадгаламжийн хүү бага байна гэж эрэгтэйчүүдийн 53.9 хувь (2005 оноос 2.8 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 58.0 хувь нь (2005 оноос 0.4 нэгжээр буурсан) хариулсан байхад боломжийн байна гэж эрэгтэйчүүдийн 32.6 хувь (2005 оноос 3.9 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 26.9 хувь нь (2005 оноос 0.2 нэгжээр буурсан) хариулсан байна. Мэдэхгүй гэсэн хариултын хувьд хүйсийн ялгаа их ажиглагдахгүй байна.

## II. 6. Зээлийн талаар

Хүснэгт II.6.1. Танд зээлийн хэрэгцээ байдаг уу

		тийм	үгүй	мэдэхгүй
Эрэгтэй	2005	83.1	13.8	3.1
	2006	81.6	15.2	3.3
	<i>Өөрчлөлт</i>	-1.5	1.4	0.2
Эмэгтэй	2005	83.9	13.2	2.8
	2006	83.4	14.1	2.5
	<i>Өөрчлөлт</i>	-0.5	0.9	-0.3

Энэ асуултын хариултанд хүйсийн ялгаа харьцангуй бага байна. Зээлийн хэрэгцээтэй гэж эрэгтэйчүүдийн 83.1 хувь (2005 оноос 1.5 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 83.4 хувь (2005 оноос 0.5 нэгжээр буурсан) нь, хэрэгцээгүй гэж



эрэгтэйчүүдийн 15.2 хувь (2005 оноос 1.4 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 14.1 хувь (2005 оноос 0.9 нэгжээр өссөн) нь хариулсан байна.

Хүснэгт II.6.2. Танд банк, санхүүгийн байгууллагуудаас олгож буй зээл хүртээмжтэй байдаг уу

		тийм	үгүй	мэдэхгүй
Эрэгтэй	2005	41.8	40	18.2
	2006	44.0	32.7	18.9
	<i>Өөрчлөлт</i>	2.2	-7.3	0.7
Эмэгтэй	2005	42.4	37.2	20.3
	2006	42.0	37.8	20.2
	<i>Өөрчлөлт</i>	-0.4	0.6	-0.1

Зээл хүртээмжтэй, мэдэхгүй гэсэн хариултуудын хувьд хүйсийн ялгаа харьцангуй бага байна. Харин хүртээмжгүй гэсэн хариултын хувьд хүйсийн ялгаа харьцангуй ажиглагдаж байна. Хүртээмжгүй гэж эрэгтэйчүүдийн 32.7 хувь (2005 оноос 7.3 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 37.8 хувь (2005 оноос 0.6 нэгжээр өссөн) нь хариулсан байна.

Хүснэгт II.6.3. Таны бодлоор банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад

		хүндрэлгүй	хүндрэлтэй	мэдэхгүй
Эрэгтэй	2005	40.4	45.2	14.4
	2006	39.8	47.8	12.4
	<i>Өөрчлөлт</i>	-0.6	2.6	-2.0
Эмэгтэй	2005	36.8	47.5	15.7
	2006	36.6	50.4	13.0
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	2.9	-2.7

Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлтэй эсэхийг асуухад бага боловч хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Хүндрэлтэй гэж эрэгтэйчүүдийн 47.8 хувь (2005 оноос 2.6 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 50.4 хувь (2005 оноос 2.9 нэгжээр өссөн), хүндрэлгүй гэж эрэгтэйчүүдийн 39.8 хувь (2005 оноос 0.6 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 36.6 хувь (2005 оноос 0.2 нэгжээр буурсан) нь хариулсан байна.

Хүснэгт II.6.4. Таны бодлоор зээлийн хүү

		өндөр	боломжийн	мэдэхгүй
Эрэгтэй	2005	70.3	20.3	9.4
	2006	71.0	20.5	8.5
	<i>Өөрчлөлт</i>	0.7	0.2	-0.9
Эмэгтэй	2005	69	20.4	10.6
	2006	71.6	19.9	8.5
	<i>Өөрчлөлт</i>	2.6	-0.5	-2.1

Зээлийн хүүгийн талаар хариулсан байдалд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна. Зээлийн хүү өндөр гэж эрэгтэйчүүдийн 71.0 хувь (2005 оноос 0.7 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 71.6 хувь (2005 оноос 2.6 нэгжээр өссөн) нь хариулсан бол боломжийн гэж эрэгтэйчүүдийн 20.5 хувь (2005 оноос 0.2 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 19.9 хувь (2005 оноос 0.5 нэгжээр буурсан) нь хариулсан байна.

## II. 7. Бичил санхүүгийн талаар

Хүснэгт II.7.1. Та бичил санхүүгийн талаар (бага хэмжээний зээл, цалингийн зээл, тэтгэврийн зээл, бага хэмжээний хөдлөх хөрөнгийн зээл) ойлголттой юу

		тийм	үгүй	мэдэхгүй
Эрэгтэй	2005	67.6	18.3	14
	2006	66.3	22.0	11.8
	<i>Өөрчлөлт</i>	-1.3	3.7	-2.2
Эмэгтэй	2005	67	17.4	15.5
	2006	63.8	21.4	14.8
	<i>Өөрчлөлт</i>	-3.2	4.0	-0.7

Бичил санхүүгийн талаар ойлголтой эсэхийг асуухад үгүй гэсэн хариултын хувьд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна. Ойлголтой гэж эрэгтэйчүүдийн 66.3 хувь (2005 оноос 1.3 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 63.8 хувь (2005 оноос 3.2 нэгжээр буурсан), мэдэхгүй гэж эрэгтэйчүүдийн 11.8 хувь (2005 оноос 2.2 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 14.8 хувь (2005 оноос 0.7 нэгжээр буурсан) нь хариулсан байна.

Хүснэгт II.7.2. Таны оршин сууж байгаа газарт бичил санхүүгийн үйл ажиллагаа хэр хөгжсөн бэ

		Сайн	Дунд зэрэг	Огт хөгжөөгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	2005	22.9	43	14.9	19.2
	2006	24.8	45.0	13.2	16.9
	<i>Өөрчлөлт</i>	1.9	2.0	-1.7	-2.3
Эмэгтэй	2005	24.8	42.4	11.2	21.7
	2006	23.9	43.3	11.0	21.8
	<i>Өөрчлөлт</i>	-0.9	0.9	-0.2	0.1

Таны оршин сууж байгаа газарт бичил санхүүгийн үйл ажиллагаа хэр хөгжсөн бэ гэсэн асуултын сайн хөгжсөн, дунд зэрэг хөгжсөн гэсэн хариултын хувьд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна. Сайн хөгжсөн гэж эрэгтэйчүүдийн 24.8 хувь (2005 оноос 1.9 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 23.9 хувь (2005 оноос 0.9 нэгжээр буурсан) нь хариулсан бол дунд зэрэг гэж эрэгтэйчүүдийн 45.0 хувь (2005 оноос 2.0 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 43.3 хувь (2005 оноос 0.9 нэгжээр өссөн) нь хариулсан байна. Харин огт хөгжөөгүй, мэдэхгүй гэсэн хариултуудад хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Огт хөгжөөгүй гэж эрэгтэйчүүдийн 13.2 хувь (2005 оноос 1.7 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 11.0 хувь (2005 оноос 0.2 нэгжээр буурсан) нь хариулсан бол мэдэхгүй гэж эрэгтэйчүүдийн 16.9 хувь (2005 оноос 2.3 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 21.8 хувь (2005 оноос 0.1 нэгжээр өссөн) нь хариулжээ.

Хүснэгт II.7.3. Бичил зээл авах боломж бий юу

		тийм	үгүй	мэдэхгүй
Эрэгтэй	2005	60.4	23.7	15.9
	2006	61.0	22.9	16.0
	<i>Өөрчлөлт</i>	0.6	-0.8	0.1
Эмэгтэй	2005	58.2	22.5	19.3
	2006	54.3	24.9	20.8
	<i>Өөрчлөлт</i>	-3.9	2.4	1.5

Бичил зээл авах боломжийн талаар иргэд хүйсээс хамааран бага зэрэг ялгаатай хариулт өгсөн байна. Тийм гэж эрэгтэйчүүдийн 61.0 хувь (2005 оноос 0.6 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 54.3 хувь (2005 оноос 3.9 нэгжээр буурсан) нь хариулсан бол үгүй гэж эрэгтэйчүүдийн 22.9 хувь (2005 оноос 0.8 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 24.8 хувь (2005 оноос 2.4 нэгжээр өссөн) нь хариулсан байна.

Хүснэгт II.7.4. Бичил зээл авсан бол ямар үйл ажиллагаа (бизнес) эрхэлдэг вэ

		Газар тариалан	Хүнсний ногоо	Мал аж ахуй	Худалдаа наймаа	Жижиг дунд үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Зочид буудал	Үйлчилгээ	Бусад
Эрэгтэй	2005	6.8	6.8	10.6	27.1	13.5	4.2	1.8	7.6	21.6
	2006	10.3	9.9	12.6	34.4	15.6	3.6	2.1	8.9	26.7
	<i>Өөрчлөлт</i>	3.5	3.1	2.0	7.3	2.1	-0.6	0.3	1.3	5.1
Эмэгтэй	2005	5.6	6.8	6.6	32.1	10.4	3.7	2.1	8.4	24.5
	2006	8.0	8.3	8.7	38.3	11.6	3.1	1.3	9.3	28.5
	<i>Өөрчлөлт</i>	2.4	1.5	2.1	6.2	1.2	-0.6	-0.8	0.9	4.0

Бичил зээл авсан бол ямар үйл ажиллагаа (бизнес) эрхэлдэг вэ гэсэн асуултын хүнсний ногоо, аялал жуулчлал, зочид буудал, үйлчилгээ, бусад гэсэн хариултуудын хувьд хүйсийн ялгаа их ажиглагдахгүй байна. Харин газар тариалан, мал аж ахуй, худалдаа наймаа, жижиг дунд үйлдвэрлэл гэсэн хариултуудын хувьд нэлээд хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Газар тариалан гэж эрэгтэйчүүдийн 10.3 хувь (2005 оноос 3.5 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 8.0 хувь (2005 оноос 2.4 нэгжээр өссөн) нь хариулсан бол мал аж ахуй гэж эрэгтэйчүүдийн 12.6 хувь (2005 оноос 2.0 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 8.7 хувь (2005 оноос 2.1 нэгжээр өссөн) нь хариулсан байна. Мөн худалдаа наймаа гэсэн хариултыг эрэгтэйчүүдийн 34.4 хувь (2005 оноос 7.3 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 38.3 хувь (2005 оноос 6.2 нэгжээр өссөн) нь сонгосон бол жижиг дунд үйлдвэрлэл гэсэн хариултыг эрэгтэйчүүдийн 15.6 хувь (2005 оноос 2.1 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 11.6 хувь (2005 оноос 1.2 нэгжээр өссөн) нь сонгосон байна.

Хүснэгт II.7.5. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ

		<100 мянга	100–250 мянга	250–500 мянга	0.5- 1 сая	1– 1,5 сая	1.5– 2 сая
Эрэгтэй	2005	5.9	7.5	13.4	19.7	14.7	38.8
	2006	4.4	7.4	13.1	18.8	14.5	41.8
	<i>Өөрчлөлт</i>	-1.5	-0.1	-0.3	-0.9	-0.2	3.0
Эмэгтэй	2005	5.1	7.6	17.1	23.1	14.7	32.6
	2006	4.6	7.4	15.0	23.0	15.1	34.9
	<i>Өөрчлөлт</i>	-0.5	-0.2	-2.1	-0.1	0.4	2.3

Бичил зээлийн хэмжээг тодорхойлсон иргэдийн хариултыг хүйсээр задалж үзвэл 0.5-1 сая, 1.5-2 сая гэсэн хариултуудын хувьд л хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Харин бусад хариултуудын хувьд хүйсийн ялгаа бараг ажиглагдахгүй байна. 0.5-1 сая гэж эрэгтэйчүүдийн 18.8 хувь (2005 оноос 0.9 нэгжээр буурсан), эмэгтэйчүүдийн 23.0 хувь (2005 оноос 0.1 нэгжээр буурсан) нь, 1.5-2 сая гэж эрэгтэйчүүдийн 41.8 хувь (2005 оноос 3.0 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 34.9 хувь (2005 оноос 2.3 нэгжээр өссөн) нь хариулсан байна. 0.5-1 сая гэсэн хариултын хувьд эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээсээ 4.2 хувиар илүү, харин 1.5-2 саяын хувьд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээсээ 6.9 хувиар илүү байна.

Хүснэгт II.7.6. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар хугацаа шаардагдах вэ

		3 сар хүртэл	3-6 сар	6-9 сар	9-12 сар
Эрэгтэй	2005	8.6	13.6	17	60.8
	2006	7.6	14.0	17.0	61.3
	<i>Өөрчлөлт</i>	-1.0	0.4	0.0	0.5

Эмэгтэй	2005	7	15.4	16.8	60.8
	2006	8.3	13.8	16.7	61.1
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.3</i>	<i>-1.6</i>	<i>-0.1</i>	<i>0.3</i>

Бичил зээлийн хугацааны хувьд 9-12 сарын хугацааг эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд санал нэгтгэйгээр буюу тус бүр 61 хувь (2005 оноос 0.3-0.5 нэгжээр өссөн) нь сонгожээ. Хугацаа богиносох тутам өгсөн хариултын хувийн жин буурсан бөгөөд санал өгсөн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хувийн жингийн хувьд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна.

Хүснэгт II.7.7. Бичил бизнесийн үйл ажиллагаа явуулахад банк, санхүүгийн байгууллагын зүгээс танд ямар хүндрэл учруулж байна вэ

		Зээлийн хүү өндөр	Зээлийн хэмжээ бага	Зээл авах боломжгүй	Зээлийн хугацаа	Бусад
Эрэгтэй	2005	56.1	10.9	10.5	15	7.5
	2006	63.2	20.5	14.1	26.3	8.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>7.1</i>	<i>9.6</i>	<i>3.6</i>	<i>11.3</i>	<i>0.9</i>
Эмэгтэй	2005	59.2	10.1	10.4	12.2	8
	2006	63.8	19.6	15.0	23.4	8.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>4.6</i>	<i>9.5</i>	<i>4.6</i>	<i>11.2</i>	<i>0.4</i>

Бичил бизнесийн үйл ажиллагаа явуулахад банк, санхүүгийн байгууллагын зүгээс учруулж буй хүндрэлийн хувьд ихэнх хариултуудын хувьд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна. Зөвхөн зээлийн хугацаа богино гэсэн хариултын хувьд бага зэргийн ялгаа байна. Тодруулбал, зээлийн хугацаа гэж эрэгтэйчүүдийн 26.3 хувь (2005 оноос 11.3 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 23.4 хувь (2005 оноос 11.2 нэгжээр өссөн) нь хариулсан байна. Харин хамгийн их хувийн жин эзэлдэг буюу нийтлэг тохиолддог хүндрэл нь зээлийн хүү өндөр байгаа явдал бөгөөд судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 63.2 хувь (2005 оноос 7.1 нэгжээр өссөн), эмэгтэйчүүдийн 63.8 хувь (2005 оноос 4.6 нэгжээр өссөн) нь энэ хариултыг сонгосон байна.

## V.8 Мөнгөн дэвсгэртийн талаар

Хүснэгт V.8.1 Танд 1-т болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байдаг уу?

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	26.3	66.2	7.4
Эмэгтэй	25.1	66.1	8.8

Танд 1-т болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байдаг уу? гэсэн асуултанд эрэгтэйчүүдийн 26.3 хувь нь, эмэгтэйчүүдийн 25.1 хувь нь тийм гэж хариулсан байна. Хариултуудын хувьд онцын хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна.

Хүснэгт V.8.2 Танд 50, 100, 200, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу?

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	33.2	55.1	11.8
Эмэгтэй	28.7	57.9	13.4

Танд 50, 100, 200, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу? гэсэн асуултанд иргэд хүйсийн хувьд бага зэрэг ялгаатай байдлаар хариулсан байна. Тодруулбал, эрэгтэйчүүдийн 33.2 хувь, эмэгтэйчүүдийн 28.7 хувь нь тийм гэж хариулсан байна. Харин үгүй гэж эрэгтэйчүүдийн 55.1 хувь, эмэгтэйчүүдийн 57.9 хувь нь хариулсан байна.

**Хүснэгт V.8.3 Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа юу?**

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	40.3	49.5	10.2
Эмэгтэй	33.8	53.1	13.1

Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа юу гэсэн асуултанд эрэгтэйчүүдийн 40.3 хувь, эмэгтэйчүүдийн 33.8 хувь нь тийм гэж хариулсан байна. Харин үгүй гэж эрэгтэйчүүдийн 49.5 хувь, эмэгтэйчүүдийн 53.1 хувь нь хариулсан байна.

**Хүснэгт V.8.4 Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэдэвэртний хийц дизайн таалагддаг уу?**

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	73.6	16.7	9.7
Эмэгтэй	75.6	13.5	10.9

Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртний хийц дизайн таалагддаг уу гэсэн асуултанд эрэгтэйчүүдийн 73.6 хувь, эмэгтэйчүүдийн 75.6 хувь нь тийм гэж хариулсан байна. Харин үгүй гэж эрэгтэйчүүдийн 16.7 хувь, эмэгтэйчүүдийн 13.5 хувь нь хариулсан байна.

**Хүснэгт V.8.5 Таны 10, 20, 50, 100-тын дэвсгэртний хэрэгцээ хангагддаг уу?**

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	72.5	21.1	6.5
Эмэгтэй	72.5	21.1	6.4

Таны 10, 20, 50, 100-тын дэвсгэртний хэрэгцээ хангагддаг уу гэсэн асуултанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 72.5 хувь нь тийм, эмэгтэйчүүдийн 21.1 хувь нь үгүй гэж хариулсан байна.

**Хүснэгт V.8.6 Та гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг үү?**

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	48.9	39.8	11.2
Эмэгтэй	43.8	43.7	12.5

Та гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг үү гэсэн асуултанд хүйсийн хувьд тодорхой хэмжээний ялгаатай байдлаар хариулсан байна. Эрэгтэйчүүдийн 48.9 хувь, эмэгтэйчүүдийн 43.8 хувь нь тийм гэж хариулсан байна. Харин үгүй гэж эрэгтэйчүүдийн 39.8 хувь, эмэгтэйчүүдийн 43.7 хувь нь хариулсан байна.

**Хүснэгт V.8.7 Та хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг уу?**

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	29.3	57.3	13.4
Эмэгтэй	22.6	62.8	14.6

Та хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг уу гэсэн асуултын хариултанд бага хэмжээний хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Эрэгтэйчүүдийн 29.3 хувь, эмэгтэйчүүдийн 22.6 хувь нь тийм гэж хариулсан

бол үгүй гэж эрэгтэйчүүдийн 57.3 хувь, эмэгтэйчүүдийн 62.8 хувь нь хариулсан байна.

**Хүснэгт V.8.8 Та мөнгөө түрийвчэнд хийж цэвэрхэн авч явдаг уу?**

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Эрэгтэй	83.3	12.3	4.4
Эмэгтэй	88.1	9	2.9

Та мөнгөө түрийвчэнд хийж цэвэрхэн авч явдаг уу гэсэн асуултын хариултанд бага хэмжээний хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Эрэгтэйчүүдийн 83.3 хувь, эмэгтэйчүүдийн 88.1 хувь нь тийм гэж хариулсан бол үгүй гэж эрэгтэйчүүдийн 12.3 хувь, эмэгтэйчүүдийн 9.0 хувь нь хариулсан байна.

**Дүгнэлт**

Өнөөгийн эдийн засгийн байдал сайжирч байна, хэвэндээ, муудаж байна гэсэн хариултауд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд ижил хувийн жин эзэлж байгаа бөгөөд ойролцоогоор тус бүрдээ 30 орчим хувь байна. Гэхдээ гэхдээ хүйсээс хамааралгүй хэвэндээ гэсэн хариулт бага зэрэг илүү байна. 2005 онтой харьцуулахад эрэгтэйчүүдийн хувьд сайжирч байна гэсэн хариулт, эмэгтэйчүүдийн хувьд хэвэндээ, муудаж байна гэсэн хариултауд тус тус бага хэмжээгээр өссөн байна. Эдийн засгийн өсөлтийг хангахын тулд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, зээлийн хүүг бууруулах, татварыг багасгах хэрэгтэй гэж, эдийн засгийг уул уурхайн салбар түргэн хөгжүүлнэ гэж нэгэн дуугаар иргэдийн дийлэнх нь хариулсан байна. Өргөн хэрэглээний барааны үнэ өссөн гэж иргэдийн 90 орчим хувь нь хариулсан боловч 2005 онтой харьцуулахад буурсан гэсэн хариулт бага хэмжээгээр өссөн байна.

Иргэд хүйсээс хамааралгүйгээр дийлэнх нь амьжиргааныхаа түвшинг сүүлийн жилүүдэд хэвэндээ гэж дүгнэж байгаа бөгөөд 2005 онтой харьцуулахад доошилсон гэсэн хариулт буурч, дээшилсэн гэсэн хариулт өссөн байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь ажилгүйдэл, ядуурал өссөн гэж 70 гаруй хувь нь дүгнэж байгаа боловч 2005 онтой харьцуулахад ажилгүйчүүд буурч, ядуурал өсөөгүй гэж хариулсан байна. Харин газар хувьчлалын асуудлыг иргэд хүйсээс хамааргүйгээр дийлэнх нь дэмжиж байгаа боловч 2005 онтой харьцуулахад нэлээд хэмжээгээр буурсан байна. Мөн газар хувьчлалыг эрэгтэйчүүд илүү ихээр дэмжиж байна.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дийлэнх нь татвар өндөр, татварын ачаалал сүүлийн жилүүдэд өссөн, татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж дүгнэж байгаа боловч 2005 онтой харьцуулахад татварын ачаалал буурсан гэсэн хариулт хүйсээс хамааралгүй, татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариулт эрэгтэйчүүдийн хувьд бага хэмжээгээр нэмэгдсэн үр дүн харагдаж байна.

Банк санхүүгийн байгууллагын тоог боломжийн гэсэн хариулт дийлэнх хувийг нь эзэлж байгаа боловч олон гэсэн хариулт ч нэлээд их хувьтай байна. 2005 онтой харьцуулахад банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа найдвартай гэсэн хариулт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд нэмэгдсэн бөгөөд эрэгтэйчүүд илүүтэйгээр найдвартай гэж хариулсан байна. Гэвч банк, санхүүгийн байгууллагад итгэх итгэл хоёр хүйсний аль алиных нь хувьд нэмэгдсэн болон хэвэндээ гэсэн хариултауд дийлэнх хувийг нь эзэлж байгаа боловч 2005 онтой харьцуулахад нэмэгдсэн гэсэн хариулт буурсан байна. Банк, санхүүгийн байгууллагуудыг өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна, үйл ажиллагаа хэвийн гэж хүйсээс хамаарахгүйгээр үзэж байгаа боловч 2005 онтой харьцуулахад чадахгүй

байна, үйл ажиллагаа чирэгдэлтэй гэсэн хариултууд хүйсээс хамаарахгүйгээр өссөн байна. Мөнгөний хэрэгцээ гарсан үед аль ч хүйсийн хувьд банкинд хандах нь дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд 2005 онтой харьцуулахад нэлээд хэмжээгээр нэмэгдэж, ХЗХ, ББСБ-д хандах нь багассан байна. ХЗХ-ны талаар эрэгтэйчүүдийн дийлэнх нь ойлголттой бол эмэгтэйчүүдийн дийлэнх нь ойлголтгүй байна. 2005 онтой харьцуулахад эрэгтэйчүүдийн хувьд түүний талаарх ойлголт буурсан бол эмэгтэйчүүдийн хувьд нэмэгдсэн байна. Гэвч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь хувьд гишүүн биш бөгөөд 2005 онтой харьцуулахад гишүүн байх нь багасч, ХЗХ-ны үйл ажиллагаа буруу хууль бус гэсэн дүгнэлт хүйсийн байдлаас хамааралгүйгээр нэмэгдсэн байна. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг оруулж ирэхийг эрэгтэйчүүд илүүтэйгээр ач холбогдолтой гэж үзэж байгаа боловч эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн аль алиных нь хувьд тус хариулт 2005 онтой харьцуулахад буурсан байна. Бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болох картыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 60 гаруй хувь нь хэрэглэдэггүй боловч 2005 оноос хүйсээс хамааралгүйгээр нэмэгдсэн байна. Эрэгтэйчүүдийн хувьд картын хэрэглээ эмэгтэйчүүдээсээ харьцангуй өндөр байна.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дийлэнх нь хуримтлуулсан мөнгөө банк санхүүгийн байгууллагад хадгалуулах, худалдаа, наймаа хийж эргэлдүүлэхэд нэлээдгүй хувийг нь зарцуулсаар байна. Иргэд мөнгөө бэлэн мөнгөөр, тэр тусмаа төгрөгөөр байршуулж байгаа бөгөөд ам.доллараар байршуулах нь эрэгтэйчүүдийн хувьд харьцангуй их байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дийлэнх нь хадгаламжийн хүүг бага гэж дүгнэж байгаа боловч 2005 онтой харьцуулахад энэ хандлага багасч боломжийн гэсэн хандлага хүйсээс хамааралгүйгээр нэмэгдсэн байна.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 80 гаруй хувьд нь зээлийн хэрэгцээ байгаа боловч 2005 онтой харьцуулахад зээлийн хэрэгцээ аль алиных нь хувьд багассан байна. Банк, санхүүгийн байгууллагуудаас олгож буй зээлийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 40 гаруй хувь нь хүртээмжтэй гэж хариулсан боловч хүртээмжгүй гэж 30 гаруй хувь нь хүртээмжгүй гэж хариулсан байна. 2005 онтой харьцуулахад зээлийн хүртээмж эрэгтэйчүүдийн хувьд нэмэгдсэн боловч эмэгтэйчүүдийн хувьд буурсан байна. Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахад ерөнхийдөө альч хүйсийн хувьд хүндрэлтэй боловч эмэгтэйчүүдийн хувьд илүү хүндрэлтэй байдаг бөгөөд 2005 онтой харьцуулахад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд хүндрэлтэй гэсэн хариулт улам бүр нэмэгдсэн байна. Аль ч хүйсийн хувьд зээлийн хүүг өндөр гэж дүгнэсэн бөгөөд 2005 оноос өндөр гэсэн хандлага нэмэгдсэн байна.

Бичил санхүүгийн талаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн 60 гаруй хувь нь ойлголттой, 40 гаруй хувь нь оршин суугаа газартай бичил санхүүгийн үйл ажиллагааг дунд зэрэг хөгжсөн гэж дүгнэсэн бол 2005 онтой харьцуулахад бичил санхүүгийн талаарх ойлголт, огт хөгжөөгүй гэсэн хариултууд буурсан байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь бичил зээл авах боломжтой боловч эрэгтэйчүүд нь илүү их боломжтой байна. 2005 онтой харьцуулахад бичил зээл авах боломж эрэгтэйчүүдийн хувьд бичил зээл авах боломж нэмэгдсэн бол эмэгтэйчүүдийн хувьд багассан байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд авсан зээлээрээ эрхлэх бизнесийн төрлүүдэд онцын ялгаа ажиглагдахгүй байгаа бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 30 гаруй хувь нь худалдаа наймааны бизнес эрхлэх сонирхолтой байна. Харин 0.5-1 сая, 1.5-2 сая төгрөгийн зээл нийгэмд илүү хэрэгцээтэй байгаа бөгөөд нийлээд нийт хариултын 60 орчим хувийг эзэлж байна. 2005 оноос аль хүйсийн хувьд 1.5-2 сая төгрөгийн зээлийн хэрэгцээ нэмэгдсэн байхад бусад хэмжээтэй зээлүүдийн хувьд багассан байна.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дийлэнх нь буюу 60 гаруй хувь нь зээлийн хугацааг 9-12 сар, бизнес явуулахад банк, санхүүгийн байгууллагаас учирч буй хүндрэлийг зээлийн хүү өндөр гэж хариулсан бөгөөд 2005 онтой харьцуулахад дээрх хариултууд аль ч хүйсийн хувьд өссөн байна.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дийлэнх нь 1, 5-тын дэвсгэрт, 50, 100, 200, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байхгүй гэж санал нэгтгэйгээр хариулсан байхад 20000-аас илүү дүнтэй дэвсгэртийн хэрэгцээ эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн олонхид нь байхгүй бөгөөд эмэгтэйчүүдийн хувьд дээрх дэвсгэртийн хэрэгцээ бүр ч бага байна. Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг, 10, 20, 50, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддаг, мөнгөө түрийвчэнд цэвэрхэн хийж авч явдаг гэж судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн 70-80 хувь нь хариулсан бөгөөд эдгээр асуултуудын хувьд хүйсийн ялгаа их ажиглагдахгүй байна. Харин гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эрэгтэйчүүдийн олонхи нь чанартай гэсэн бол эмэгтэйчүүдийн олонх нь чанаргүй гэж хариулсан байна. Хуурамч мөнгөн тэмдэгтийн талаарх мэдээллийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн олонх нь банкнаас авч чаддаггүй бөгөөд эмэгтэйчүүд илүүтэйгээр энэ хариултыг сонгосон байна.



### III. НАС

Нийгэм эдийн засаг болон банк, санхүүгийн салбарын талаар иргэдээс авсан санал асуулгад иргэдийн хариулах хандлага нь насны байдлаас хамааралтай байх магадлалтай. ҮСГ-ын статистикийн мэдээллээс үзэхэд 2005 онд Монгол улсын хүн ам 2 сая 562 мянга байсан бөгөөд үүний 55 хувь нь 25-аас доош насны, 17 хувь нь 25-34, 13 хувь нь 35-44, 7 хувь нь 45-54, 4 хувь нь 55-64 насны, 3.5 хувь нь 65-аас дээш насны иргэд байна. Манай санал асуулгад оролцсон 6312 хүнийг насны ангиллаар ялгаж үзэхэд 17 хувь нь 25-аас доош насны, 30 хувь нь 25-34, 27 хувь нь 35-44, 18 хувь нь 45-54, 6 хувь нь 55-64 насны, 2 хувь нь 65-аас дээш насны иргэд байна.

#### III.1. Эдийн засгийн ерөнхий асуудлууд

*Хүснэгт III.1.1. Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн байдал таны бодлоор*

Насны бүлэг		Сайжирсан	Муудсан	Хэвэндээ	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	29.7	24.9	33.5	11.9
	2006	28.7	24.9	34.3	12.2
	Өөрчлөлт	-1.0	0.0	0.8	0.3
25-34	2005	22.6	27.2	42.0	8.1
	2006	24.2	28.3	39.8	7.7
	Өөрчлөлт	1.6	1.1	-2.2	-0.4
35-44	2005	21.9	34.2	36.3	7.6
	2006	22.8	33.7	36.4	7.2
	Өөрчлөлт	0.9	-0.5	0.1	-0.4
45-54	2005	26.2	33.1	34.0	6.8
	2006	28.4	33.3	31.9	6.4
	Өөрчлөлт	2.2	0.2	-2.1	-0.4
55-64	2005	33.4	34.4	26.1	6.1
	2006	31.9	28.6	32.2	7.3
	Өөрчлөлт	-1.5	-5.8	6.1	1.2
65 дээш	2005	27.7	43.4	21.7	7.2
	2006	33.1	26.9	26.9	13.1
	Өөрчлөлт	5.4	-16.5	5.2	5.9
Бүгд	2005	25.1	30.3	36.2	8.3
	2006	26.0	30.0	35.8	8.2
	Өөрчлөлт	0.9	-0.3	-0.4	-0.1

Судалгаанд хамрагдсан иргэдийн 26 хувь нь Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан, 30 хувь нь муудсан, 35.8 хувь нь хэвээрээ байна гэж үзэж байгаа бол 8.2 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Үүнийг 2005 оны судалгааны дүнтэй харьцуулж харвал сайжирсан гэж хариулсан иргэдийн санал асуулгад оролцсон нийт хүмүүсийн тоонд эзлэх хувь 0.9 нэгжээр өсч, харин муудсан гэсэн хариулт 0.3 нэгжээр, хэвэндээ гэсэн нь 0.4 нэгжээр тус тус буурсан байна. Насны ангиллаар авч үзвэл, өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэсэн хариултыг судалгаанд оролцогчдын 2 хувь болох 65-аас дээш насны иргэдийн 33.1 хувь нь өгсөн нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Үүний дараагаар судалгааны 6 хувийг эзэлж байгаа 55-64 настнуудын (31.9%), судалгаанд оролцогчдын 17 болон 18 хувийг эзэлж буй 25-аас доош насныхны (28.7%), 45-54 насныхны (28.4%)

хариултууд орж байна. Харин судалгааны дийлэнх буюу 30 болон 27 хувийг эзэлж буй 25-34, 35-44 насныхны 22.8-24.2 хувь нь сайжирсан гэж үзэж байгаа нь хамгийн бага хувьтай хариулт байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал, 25-аас доош, 55-64 насныхны өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж хариулсан байдал буурсан бол бусад насны ангиллаарх иргэдийн хариулт нэмэгджээ.

Харин Монгол улсын эдийн засгийн байдал муудсан гэж судалгаанд идэвхтэй оролцсон 35-44 болон 45-54 насныхан илүү үзэж байна. Өмнөх судалгаанд 55-аас дээш насныхан илүүтэйгээр эдийн засгийн байдал муудсан гэж үзэж байсан бол энэ удаагийн судалгаагаар тэдний хариулт нэлээд өөрчлөгдөж, сайжирсан болон хэвэндээ гэсэн хариулт нь давамгайлах болжээ.

Эдийн засгийн байдлыг хэвэндээ гэж 54-өөс доош насныхны дийлэнх үзсэн хэвээр байна. Харин 25-аас доош, 65-аас дээш насныхны мэдэхгүй гэсэн хариулт бусад насны ангиллын хариултаас арай өндөр хувьтай байгаа бөгөөд 2005 оны судалгааны дүнгээс хувийн жин нь нэмэгдсэн байна.

**Хүснэгт III.1.2. Таны бодлоор эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?**

Насны бүлэг		Татварын ачааллыг багасгах	Гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих	Зээлийн хүүг бууруулах	Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих	Бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх	Бусад
		хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	23.1	11.7	24.1	31.1	7.3	2.7
	2006	21.7	12.6	21.9	33.3	7.7	2.8
	Өөрчлөлт	-1.4	0.9	-2.2	2.2	0.4	0.1
25-34	2005	25.6	11.9	24.5	29.3	7.3	1.4
	2006	25.6	11.2	26.5	27.2	8.2	1.3
	Өөрчлөлт	0.0	-0.7	2.0	-2.1	0.9	-0.1
35-44	2005	27.4	11.2	26.0	25.5	8.2	1.7
	2006	24.6	12.1	26.1	25.9	10.0	1.3
	Өөрчлөлт	-2.8	0.9	0.1	0.4	1.8	-0.4
45-54	2005	25.7	12.0	24.8	27.8	8.1	1.7
	2006	25.5	12.4	24.6	27.9	8.4	1.1
	Өөрчлөлт	-0.2	0.4	-0.2	0.1	0.3	-0.6
55-64	2005	22.8	14.0	23.8	29.5	8.0	1.9
	2006	25.8	12.6	22.7	28.0	9.7	1.1
	Өөрчлөлт	3.0	-1.4	-1.1	-1.5	1.7	-0.8
65 дээш	2005	28.0	11.3	20.7	29.3	8.0	2.7
	2006	18.8	15.2	22.7	32.8	7.8	2.7
	Өөрчлөлт	-9.2	3.9	2.0	3.5	-0.2	0.0
Бүгд	2005	25.5	11.8	24.8	28.3	7.8	1.8
	2006	24.6	12.1	25.0	28.1	8.8	1.5
	Өөрчлөлт	-0.9	0.3	0.2	-0.2	1.0	-0.3

Таны бодлоор эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай байна вэ гэсэн асуултанд иргэд нэгээс дээш санал өгсөн бөгөөд өмнөх судалгааны нэг адил бүх насныхан үндэсний үйлдвэрлэлээ дэмжих арга хэмжээг хамгийн чухал гэж үзжээ. Үүний дараагаар татварын ачааллыг багасгах, зээлийн хүүг бууруулах зэрэг арга хэмжээ орж байна. Гэхдээ татварын ачааллыг багасгах

гэсэн хариулт 55-64 наснаас бусад насныхны хувьд буурсан байна. Харин бизнесменүүдэд урамшуулалт, хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй гэж бүх насны ангилал дахь цөөнх үзэж байгаа ч 2005 оныхоос бага зэрэг нэмэгдэв. Ялангуяа, судалгаанд идэвхтэй оролцсон 25-44 насныхны хариулт 0.9-1.8 нэгжээр өсчээ.

**Хүснэгт III.1.3. Таны бодлоор ямар салбар манай улсын эдийн засгийг хөгжүүлэх вэ?**

Насны бүлэг		Уул уурхай	Хөдөө аж ахуй	Боловсруулах үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Банк санхүү	Худалдаа үйлчилгээ	Бусад
		хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	23.4	21.6	11.6	21.0	9.5	9.5	3.4
	2006	29.2	21.0	12.7	20.1	7.3	7.4	2.2
	Өөрчлөлт	5.8	-0.6	1.1	-0.9	-2.2	-2.1	-1.2
25-34	2005	23.4	26.8	14.1	17.9	8.7	7.3	1.8
	2006	30.1	23.4	11.8	17.0	8.4	7.5	1.7
	Өөрчлөлт	6.7	-3.4	-2.3	-0.9	-0.3	0.2	-0.1
35-44	2005	23.2	26.0	14.1	15.6	10.6	8.9	1.6
	2006	29.0	22.9	13.4	14.8	9.5	8.7	1.8
	Өөрчлөлт	5.8	-3.1	-0.7	-0.8	-1.1	-0.2	0.2
45-54	2005	24.1	23.5	14.0	17.2	11.3	8.2	1.6
	2006	30.5	22.1	13.4	15.7	9.4	7.5	1.4
	Өөрчлөлт	6.4	-1.4	-0.6	-1.5	-1.9	-0.7	-0.2
55-64	2005	24.1	25.0	14.0	15.7	10.5	8.7	2.1
	2006	29.6	23.2	13.7	15.0	8.5	8.2	1.8
	Өөрчлөлт	5.5	-1.8	-0.3	-0.7	-2.0	-0.5	-0.3
65 дээш	2005	24.6	29.7	21.0	11.6	2.9	5.1	5.1
	2006	28.9	28.5	14.6	11.5	6.3	7.1	3.2
	Өөрчлөлт	4.3	-1.2	-6.4	-0.1	3.4	2.0	-1.9
Бүгд	2005	23.5	24.9	13.7	17.5	9.9	8.4	2.1
	2006	29.7	22.7	12.9	16.4	8.7	7.8	1.8
	Өөрчлөлт	6.2	-2.2	-0.8	-1.1	-1.2	-0.6	-0.3

Таны бодлоор ямар салбар манай улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх вэ гэсэн асуултанд иргэд мөн нэгээс дээш санал өгсөн бөгөөд бүх насны иргэд уул уурхай, хөдөө аж ахуйн салбарыг манай улсын эдийн засгийг түргэн хөгжүүлнэ гэж үзсэн хэвээр байна. Гэхдээ өмнөх судалгаанаас уул уурхайн салбарыг сонгосон иргэд илүү нэмэгдэж, хөдөө аж ахуй болон бусад салбарыг сонгосон иргэдийн хувийн жин буурчээ. Үүний дараагаар аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг эдийн засгийг хөгжүүлэхэд чухал гэж үзэж байна. Харин банк, санхүү, худалдаа үйлчилгээний салбарыг бүх насны иргэдийн 6.3-9.5 хувь нь сонгосон нь хамгийн бага хувьтай хариулт болж байна.

**Хүснэгт III.1.4. Өргөн хэрэглээний барааны үнэ таны бодлоор?**

Насны бүлэг		Өсч байна	Буурч байна	Тогтворжиж байна	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	90.8	0.9	5.9	2.4
	2006	90.9	1.2	5.3	2.6
	Өөрчлөлт	0.1	0.3	-0.6	0.2
25-34	2005	90.8	1.2	6.1	2.0
	2006	91.3	1.4	5.5	1.9

	Өөрчлөлт	0.5	0.2	-0.6	-0.1
35-44	2005	90.9	2.0	5.9	1.3
	2006	90.1	2.2	6.0	1.7
	Өөрчлөлт	-0.8	0.2	0.1	0.4
45-54	2005	91.6	1.6	5.4	1.5
	2006	90.3	2.9	5.0	1.8
	Өөрчлөлт	-1.3	1.3	-0.4	0.3
55-64	2005	90.1	3.2	6.1	0.6
	2006	89.7	3.9	3.6	2.8
	Өөрчлөлт	-0.4	0.7	-2.5	2.2
65 дээш	2005	84.5	3.6	7.1	4.8
	2006	84.8	4.8	5.5	4.8
	Өөрчлөлт	0.3	1.2	-1.6	0.0
Бүгд	2005	90.8	1.6	5.9	1.7
	2006	90.5	2.1	5.4	2.0
	Өөрчлөлт	-0.3	0.5	-0.5	0.3

Өргөн хэрэглээний барааны үнэ өсч байна гэж нийт иргэдийн 90 гаруй, тогтвортой байна гэж 5 гаруй, буурч байна, мэдэхгүй гэж тус бүр 2 орчим хувь нь тус тус хариулжээ. Энэ хариултууд өмнөх судалгааны нэг адил насны ангиллаас үл хамааран бараг ялгаагүй байна. Харин 2005 оныхоос тогтвортой байна гэсэн хариулт бүх насны иргэдийн хувьд бага зэрэг буурч, буурч байна гэсэн хариулт бага зэрэг өссөн байна. 35-64 насныхны өсч байна гэсэн хариулт буурч, бусад насныхны тус хариулт өсчээ.

### III.2. Нийгмийн тулгамдсан асуудлууд

#### *Хүснэгт III.2.1. Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд?*

Насны бүлэг		Дээшилсэн	Доошилсон	Хэвэндээ	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	21.6	24.4	51.0	3.0
	2006	24.3	17.6	54.4	3.7
	Өөрчлөлт	2.7	-6.8	3.4	0.7
25-34	2005	16.3	26.6	55.4	1.6
	2006	22.0	20.7	55.1	2.1
	Өөрчлөлт	5.7	-5.9	-0.3	0.5
35-44	2005	13.8	35.9	48.3	2.0
	2006	17.4	30.7	50.9	1.1
	Өөрчлөлт	3.6	-5.2	2.6	-0.9
45-54	2005	15.4	39.2	43.8	1.6
	2006	16.7	34.5	47.2	1.6
	Өөрчлөлт	1.3	-4.7	3.4	0.0
55-64	2005	15.7	42.6	39.7	1.9
	2006	15.8	30.7	51.2	2.3
	Өөрчлөлт	0.1	-11.9	11.5	0.4
65 дээш	2005	17.9	39.3	38.1	4.8
	2006	11.0	39.0	47.9	2.1
	Өөрчлөлт	-6.9	-0.3	9.8	-2.7
Бүгд	2005	16.5	32.0	49.4	2.1
	2006	19.6	26.3	52.1	2.0
	Өөрчлөлт	3.1	-5.7	2.7	-0.1

Өөрийн өрхийн амьжиргааны түвшинг хэвэндээ байна гэж аль ч насныхны дийлэнх буюу 50-аас дээш хувь нь (45-54 насныхны 47.2%) үзэж байна. Харин дээшилсэн, доошилсон гэж үзэх байдал насны ангиллаасаа хамааран арай өөр өөр байна. Тухайлбал, насны ангилал өсөх тутам өрхийн амьжиргааны түвшингээ дээшилсэн гэж үзэх байдал 24.3-аас 11.0 хувь болон буурах хандлагатай байна. Харин доошилсон гэж үзэх байдал үүний эсрэг буюу насны ангилал өсөх тутам 17.6-39.0 хооронд өсөх хандлагатай байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад өрхийн амьжиргааны түвшингээ доошилсон гэж үзэж буй иргэдийн хувийн жин бүх насны ангилалд буурч, дээшилсэн болон хэвэндээ гэж үзсэн иргэдийн хувийн жин өссөн байна.

### *Хүснэгт III.2.2. Хүн амын ядуурал таны бодлоор?*

Насны бүлэг		Нэмэгдсэн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	76.3	5.9	12.2	5.7
	2006	71.0	8.0	15.6	5.3
	Өөрчлөлт	-5.3	2.1	3.4	-0.4
25-34	2005	79.0	5.3	12.7	2.9
	2006	78.5	5.7	13.0	2.8
	Өөрчлөлт	-0.5	0.4	0.3	-0.1
35-44	2005	81.4	6.7	9.3	2.5
	2006	77.9	7.1	12.1	2.9
	Өөрчлөлт	-3.5	0.4	2.8	0.4
45-54	2005	78.5	7.6	10.7	3.1
	2006	74.5	7.5	14.8	3.2
	Өөрчлөлт	-4.0	-0.1	4.1	0.1
55-64	2005	73.5	7.3	16.6	2.6
	2006	69.7	8.6	17.0	4.7
	Өөрчлөлт	-3.8	1.3	0.4	2.1
65 дээш	2005	62.7	7.2	22.9	7.2
	2006	63.4	9.7	22.1	4.8
	Өөрчлөлт	0.7	2.5	-0.8	-2.4
Бүгд	2005	78.5	6.3	11.8	3.4
	2006	75.5	7.0	14.0	3.5
	Өөрчлөлт	-3.0	0.7	2.2	0.1

Хүн амын ядуурал нэмэгдсэн гэж насны ангиллаас үл хамааран дийлэнх иргэд үзсэн хэвээр байна. Ялангуяа, судалгаанд идэвхтэй оролцсон 25-44 насны иргэдийн 77.9-78.5 хувь нь ийнхүү үзэж байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Гэхдээ өмнөх судалгаанаас 65-аас дээш насны ангиллаас бусад ангилалд нэмэгдсэн гэж үзсэн иргэдийн хувийн жин буурчээ. Хүн амын ядуурал хэвэндээ гэсэн хариулт үүний дараа орж байгаа бөгөөд 55-аас дээш насныхны өгсөн хариулт арай өндөр хувьтай байна. Буурсан гэсэн хариултыг мөн л 55-аас дээш насныхан бусад насны ангиллынхнаас түлхүү өгчээ. Хэвэндээ болон буурсан гэсэн харилтууд өмнөх судалгаатай харьцуулахад бараг бүх насны иргэдийн хувьд нэмэгджээ.

### *Хүснэгт III.2.3. Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор?*

Насны бүлэг		Өссөн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	76.6	7.4	10.4	5.6
	2006	71.4	8.7	13.6	6.3

	Өөрчлөлт	-5.2	1.3	3.2	0.7
25-34	2005	81.6	4.8	9.9	3.6
	2006	75.4	7.0	12.8	4.8
	Өөрчлөлт	-6.2	2.2	2.9	1.2
35-44	2005	83.4	4.6	8.4	3.5
	2006	80.2	6.8	9.9	3.1
	Өөрчлөлт	-3.2	2.2	1.5	-0.4
45-54	2005	82.6	3.7	10.9	2.7
	2006	77.1	6.8	12.6	3.4
	Өөрчлөлт	-5.5	3.1	1.7	0.7
55-64	2005	79.0	6.7	11.1	3.2
	2006	76.9	5.7	12.5	4.9
	Өөрчлөлт	-2.1	-1.0	1.4	1.7
65 дээш	2005	72.6	2.4	17.9	7.1
	2006	67.8	6.8	14.4	11.0
	Өөрчлөлт	-4.8	4.4	-3.5	3.9
Бүгд	2005	81.0	5.1	10.0	3.8
	2006	76.2	7.1	12.1	4.5
	Өөрчлөлт	-4.8	2.0	2.1	0.7

Аль ч насны ангиллын иргэдийн дийлэнх 2005 оны судалгаатай адил ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзсэн хэвээр байна. Ялангуяа, 35-44 насны иргэдийн 80.2 хувь ажилгүйдэл нэмэгдэж гэж үзэж байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад ажилгүйчүүдийн тоог нэмэгдсэн гэж үзэж буй хариултын хувийн жин бараг бүх насныхны хувьд буурч, буурсан болон хэвэндээ гэсэн харилтын хувийн жин нэмэгдсэн байна.

#### *Хүснэгт III.2.4. Газар хувьчлалыг?*

Насны бүлэг		Дэмжиж байна	Дэмжихгүй байна	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	62.3	25.0	12.7
	2006	54.2	29.9	15.9
	Өөрчлөлт	-8.1	4.9	3.2
25-34	2005	62.2	26.7	11.1
	2006	56.1	30.3	13.6
	Өөрчлөлт	-6.1	3.6	2.5
35-44	2005	63.8	25.0	11.2
	2006	56.1	30.4	13.5
	Өөрчлөлт	-7.7	5.4	2.3
45-54	2005	64.2	25.8	10.0
	2006	57.9	30.4	11.7
	Өөрчлөлт	-6.3	4.6	1.7
55-64	2005	72.6	15.5	11.9
	2006	61.2	25.3	13.5
	Өөрчлөлт	-11.4	9.8	1.6
65 дээш	2005	65.1	18.1	16.9
	2006	57.3	25.2	17.5
	Өөрчлөлт	-7.8	7.1	0.6
Бүгд	2005	63.6	25.0	11.4
	2006	56.4	29.9	13.7
	Өөрчлөлт	-7.2	4.9	2.3

Аль ч насны ангиллын иргэдийн дийлэнх (54.2-61.2) хувь өмнөх судалгаатай адил газар хувьчлалыг дэмжиж байгаа боловч тэдгээрийн хувийн жин 6.1-11.4 нэгжээр буурчээ. 55-64 насныхны 61.2 хувь нь газар хувьчлалыг дэмжиж байгаа нь хамгийн өндөр хувьтай хариулт байгаа бол 25-аас доош насныхан хамгийн бага хувьтай (54.2%) хариултыг өгчээ. Харин газар хувьчлалыг дэмжихгүй байна гэж 55-аас доош насныхны 30 орчим хувь хариулсан байхад 55-аас дээш насныхан үүнээс арай бага буюу тэдгээрийн 25 орчим хувь нь тус хариултыг өгсөн байна. Үүнийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал, 54-аас доош насныхны хувьд 3.6-5.4 нэгжээр, 55-аас дээш насныхны хувьд арай илүү буюу 7.1-9.8 нэгжээр тус тус өсчээ. Мэдэхгүй гэсэн хариултыг 65-аас дээш насныхан хамгийн их буюу 17.5 хувь нь хариулсан бол 45-54 насныхан хамгийн бага буюу 11.7 хувь нь өгчээ. Өмнөх судалгаанаас 65-аас дээш насныхны мэдэхгүй гэсэн хариулт 0.6 нэгжээр, 45-64 насныхны хариулт 1.6-1.7 нэгжээр, 44-өөс доош насныхны хариулт 2.3-3.2 нэгжээр тус тус нэмэгдэв.

### III.3. Татварын талаар

#### *Хүснэгт III.3.1. Татварын ерөнхий түвшин таны бодлоор?*

Насны бүлэг		Өндөр	Боломжийн	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	65.5	20.5	14.0
	2006	63.5	20.4	16.1
	Өөрчлөлт	-2.0	-0.1	2.1
25-34	2005	75.4	12.6	11.9
	2006	73.9	13.3	12.8
	Өөрчлөлт	-1.5	0.7	0.9
35-44	2005	78.3	12.5	9.2
	2006	76.6	13.5	9.9
	Өөрчлөлт	-1.7	1.0	0.7
45-54	2005	79.2	12.8	8.0
	2006	74.8	15.4	9.7
	Өөрчлөлт	-4.4	2.6	1.7
55-64	2005	73.7	15.8	10.4
	2006	77.0	13.7	9.3
	Өөрчлөлт	3.3	-2.1	-1.1
65 дээш	2005	67.5	15.7	16.9
	2006	64.1	18.6	17.2
	Өөрчлөлт	-3.4	2.9	0.3
Бүгд	2005	74.7	14.4	10.9
	2006	73.0	15.1	11.9
	Өөрчлөлт	-1.7	0.7	1.0

Татварын ерөнхий түвшин өндөр байна гэж аль ч насны ангиллын судалгаанд оролцогчдын дийлэнх үзсэн хэвээр байна. Ялангуяа, 25-64 насныхны 73.9-77.0 хувь нь өндөр гэж үзэж байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна. Гэхдээ өмнөх судалгаатай харьцуулахад 55-64 наснаас бусад насны иргэдийн татварын ерөнхий түвшин өндөр гэж үзэх байдал буурчээ. Харин боломжийн гэсэн хариултыг 25-аас доош болон 65-аас дээш насны иргэд хамгийн их (18.6-20.4) өгсөн бол бусад насны ангиллаарх иргэдийн хариулт харьцангуй ойролцоо буюу 13.3-15.4 хувьтай байв. Мэдэхгүй гэсэн хариултыг мөн л 25-аас доош болон 65-аас дээш насныхан хамгийн их (16.1-17.2) өгсөн бол түүний дараа 25-34 насныхны (12.8) хариулт орж байна. Дээрхээс бусад насныхны мэдэхгүй гэсэн хариулт харьцангуй ойролцоо буюу 9.3-9.9 хувьтай байна. 2005 оны судалгааны дүнтэй харьцуулахад 55-64 насныхны

татварын ерөнхий түвшин боломжийн болон мэдэхгүй гэсэн хариултууд 2.1 болон 1.1 нэгжээр буурсан бол бусад насны ангиллын иргэдийнх нэмэгдсэн байна.

*Хүснэгт III.3.2. Татварын ачаалал сүүлийн жилүүдэд?*

Насны бүлэг		Нэмэгдсэн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	62.9	3.2	16.7	17.2
	2006	58.0	4.5	16.9	20.6
	Өөрчлөлт	-4.9	1.3	0.2	3.4
25-34	2005	67.0	2.0	17.3	13.7
	2006	65.7	2.7	17.3	14.2
	Өөрчлөлт	-1.3	0.7	0.0	0.5
35-44	2005	71.4	1.8	18.1	8.8
	2006	67.2	3.4	17.8	11.6
	Өөрчлөлт	-4.2	1.6	-0.3	2.8
45-54	2005	71.2	2.2	19.0	7.6
	2006	65.6	4.3	20.8	9.4
	Өөрчлөлт	-5.6	2.1	1.8	1.8
55-64	2005	60.8	2.9	23.2	13.1
	2006	60.4	5.4	24.1	10.1
	Өөрчлөлт	-0.4	2.5	0.9	-3.0
65 дээш	2005	60.2	0.0	26.5	13.3
	2006	49.3	4.2	30.3	16.2
	Өөрчлөлт	-10.9	4.2	3.8	2.9
Бүгд	2005	67.7	2.2	18.2	11.9
	2006	64.1	3.7	18.7	13.5
	Өөрчлөлт	-3.6	1.5	0.5	1.6

Татварын ачаалал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн гэж аль ч насны судалгаанд оролцогчдын дийлэнх үзсэн хэвээр байгаа боловч хувийн жин нь бүх насны ангилалд буурчээ. Ялангуяа, 65-аас дээш насныхны хариулт хамгийн их буюу 10.9 нэгжээр багассан байна. Татварын ачаалал хэвэндээ байна гэсэн хариулт насны ангилал нэмэгдэх тутам 16.9-30.3 хүртэл өссөн байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг 25-аас доош насныхан (20.6) хамгийн их өгсөн байна. Буурсан гэж бүх насны иргэд харьцангуй бага хариулсан байна. Өмнөх судалгаатай харьцуулахад татварын ачаалал буурсан, хэвэндээ, мэдэхгүй гэсэн хариултуудын хувийн жин бүх насны иргэдийн хувьд нэмэгдэж, харин 35-44 насны иргэдийн хэвэндээ, 55-64 насны иргэдийн мэдэхгүй гэсэн хариултууд буурсан байна.

*Хүснэгт III.3.3. Татвараас зайлсхийх явдал таны бодлоор?*

Насны бүлэг		Нийтлэг	Бага	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	65.3	8.8	26.0
	2006	64.8	10.1	25.1
	Өөрчлөлт	-0.5	1.3	-0.9
25-34	2005	67.7	8.2	24.0
	2006	68.3	10.5	21.2
	Өөрчлөлт	0.6	2.3	-2.8
35-44	2005	66.6	10.4	23.0
	2006	67.6	11.0	21.4
	Өөрчлөлт	1.0	0.6	-1.6
45-54	2005	67.3	10.1	22.6



	2006	69.5	11.9	18.6
	Өөрчлөлт	2.2	1.8	-4.0
55-64	2005	61.5	14.1	24.4
	2006	71.7	10.0	18.4
	Өөрчлөлт	10.2	-4.1	-6.0
65 дээш	2005	67.5	6.0	26.5
	2006	75.0	2.8	22.2
	Өөрчлөлт	7.5	-3.2	-4.3
Бүгд	2005	66.5	9.5	23.9
	2006	68.1	10.6	21.3
	Өөрчлөлт	1.6	1.1	-2.6

Татвараас зайлсхийх явдал нийтлэг байна гэж санал асуулгад оролцсон бүх насны иргэдийн дийлэнх (64.8-75.0) хариулсан хэвээр байна. 2005 оны судалгааны дүнтэй харьцуулахад 25-аас доош насны иргэдийн хариулт 0.5 нэгжээр буурсан байхад бусад насны иргэдийн хариулт 0.6-10.2 нэгжээр нэмэгджээ. Ялангуяа, насны ангилал ахих тутам их хувиар өөрчлөгдсөн байна. Татвараас зайлсхийх явдлын талаар мэдэхгүй гэж нийт санал асуулгад оролцогчдын 21.3 хувь хариулснаас хамгийн их хувьтай хариултыг 25-аас доош насны иргэд, хамгийн бага хувьтай хариултыг 45-64 насны иргэд өгчээ. Өмнөх судалгааны дүнгээс мэдэхгүй гэсэн хариулт бүх насныхны хувьд, ялангуяа, 45-аас дээш насны иргэдийнх буурав. Харин татвараас зайлсхийх явдал бага гэж 65-аас дээш насны судалгаанд оролцогчдын 2.8 хувь хариулсан бол бусад насны иргэдийнх 10.0-11.9 хувьтай байна.

#### III.4. Банк санхүүгийн салбарын талаар

*Хүснэгт III.4.1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоо таны бодлоор?*

Насны бүлэг		Олон	Цөөн	Боломжийн	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	41.4	6.2	47.1	5.3
	2006	34.4	6.3	54.2	5.1
	Өөрчлөлт	-7.0	0.1	7.1	-0.2
25-34	2005	36.9	8.3	49.2	5.6
	2006	35.9	6.9	52.4	4.7
	Өөрчлөлт	-1.0	-1.4	3.2	-0.9
35-44	2005	40.6	8.7	43.0	7.6
	2006	39.5	7.0	48.6	4.9
	Өөрчлөлт	-1.1	-1.7	5.6	-2.7
45-54	2005	41.0	8.2	44.2	6.5
	2006	41.7	6.8	46.2	5.3
	Өөрчлөлт	0.7	-1.4	2.0	-1.2
55-64	2005	40.8	8.9	40.4	9.9
	2006	46.4	4.1	43.6	5.9
	Өөрчлөлт	5.6	-4.8	3.2	-4.0
65 дээш	2005	53.6	3.6	29.8	13.1
	2006	48.3	6.9	37.2	7.6
	Өөрчлөлт	-5.3	3.3	7.4	-5.5
Бүгд	2005	40.0	8.0	45.5	6.6
	2006	38.6	6.6	49.7	5.1
	Өөрчлөлт	-1.4	-1.4	4.2	-1.5

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоо боломжийн байна гэж судалгаанд хамрагдсан 65-аас дээш наснаас бусад иргэдийн дийлэнх өмнөх судалгааны нэг адил дүгнэсэн байна. Ялангуяа, 34-өөс доош насны иргэдийн 50-аас илүү хувь ийнхүү дүгнэжээ. Өмнөх судалгааны дүнгээс бүх насны иргэдийн хувьд энэ хариултын хувийн жин нь өсчээ. Мөн судалгаанд оролцсон иргэдийн багагүй (40) хувь үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог олон байна гэж үзсэн хэвээр байгаа бөгөөд насны ангилала нэмэгдэх тусам хувийн жин нь улам ихэсч байна. Харин цөөн болон мэдэхгүй гэж бүх насны иргэдийн харьцангуй цөөн хувь хариулсан байна.

*Хүснэгт III.4.2. Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа таны бодлоор?*

Насны бүлэг		Найдвартай	Найдваргүй	Эргэлзээтэй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	44.9	4.8	41.1	9.3
	2006	53.6	6.6	34.0	5.8
	Өөрчлөлт	8.7	1.8	-7.1	-3.5
25-34	2005	44.9	6.1	39.8	9.3
	2006	52.6	5.8	35.9	5.8
	Өөрчлөлт	7.7	-0.3	-3.9	-3.5
35-44	2005	45.5	6.6	37.6	10.3
	2006	50.8	7.3	35.1	6.8
	Өөрчлөлт	5.3	0.7	-2.5	-3.5
45-54	2005	46.4	6.7	38.0	8.9
	2006	47.9	9.5	34.9	7.7
	Өөрчлөлт	1.5	2.8	-3.1	-1.2
55-64	2005	43.2	11.7	31.4	13.7
	2006	47.9	11.5	31.8	8.9
	Өөрчлөлт	4.7	-0.2	0.4	-4.8
65 дээш	2005	24.1	9.6	44.6	21.7
	2006	37.9	9.0	42.8	10.3
	Өөрчлөлт	13.8	-0.6	-1.8	-11.4
Бүгд	2005	44.9	6.4	38.7	9.9
	2006	50.8	7.4	35.1	6.7
	Өөрчлөлт	5.9	1.0	-3.6	-3.2

Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа найдвартай гэж 65-аас дээш наснаас бусад иргэдийн дийлэнх өмнөх судалгаатай адил үзэж байгаа бөгөөд тэдгээрийн хувийн жин өмнөхөөсөө нэмэгдсэн байна. 65-аас дээш насныхны хувьд ч гэсэн тэдгээрийн дийлэнх нь эргэлзээтэй гэж үзэж байгаа боловч өмнөх судалгааны дүнгээс найдвартай гэж үзэж буй иргэдийн хувийн жин 13.8 нэгжээр өсчээ. Мөн нийт судалгаанд оролцогчдын 35 гаруй хувь нь банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг эргэлзээтэй гэж үзэж байгаа ч өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бүх насны ангиллын хувьд хувийн жин буурчээ. Ялангуяа, өмнөх судалгаанд өндөр хувийн санал эзэлж байсан 25-34, 45-54 насны ангиллуудын хувьд илүү хувиар буурсан байна. Харин найдваргүй гэж үзэж буй иргэдийн хувийн жин 25-аас доош, 35-54 насны ангиллын хувьд өсч, нийт иргэдийн 7.4 хувь болов. Өмнөх судалгаанд иргэдийн 10 орчим хувь нь банк санхүүгийн үйл ажиллагааны талаар мэдэхгүй гэж хариулж байсан бол энэ нь бүх насны ангилалд багасчээ.

*Хүснэгт III.4.3. Банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл?*

Насны бүлэг		Нэмэгдсэн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	45.2	8.1	33.7	13.0
	2006	47.4	10.0	34.4	8.3
	Өөрчлөлт	2.2	1.9	0.7	-4.7
25-34	2005	45.3	8.5	35.3	11.0
	2006	44.6	8.8	39.0	7.6
	Өөрчлөлт	-0.7	0.3	3.7	-3.4
35-44	2005	42.6	9.3	35.8	12.2
	2006	43.3	10.5	37.3	9.0
	Өөрчлөлт	0.7	1.2	1.5	-3.2
45-54	2005	45.0	10.1	35.4	9.5
	2006	38.4	14.3	38.5	8.8
	Өөрчлөлт	-6.6	4.2	3.1	-0.7
55-64	2005	40.8	14.6	29.3	15.3
	2006	37.2	12.7	39.8	10.3
	Өөрчлөлт	-3.6	-1.9	10.5	-5.0
65 дээш	2005	26.2	15.5	44.0	14.3
	2006	31.9	18.8	39.6	9.7
	Өөрчлөлт	5.7	3.3	-4.4	-4.6
Бүгд	2005	43.9	9.4	34.9	11.7
	2006	42.9	10.9	37.7	8.5
	Өөрчлөлт	-1.0	1.5	2.8	-3.2

Аль ч насны ангиллын хувьд санал асуулгад оролцогчдын дийлэнх банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэж өмнөх судалгаатай адил үзжээ. Мөн насны ангилал өсөх тутам тус хариулт 47.4-31.9 хооронд буурсан бөгөөд өмнөх судалгаанаас 45-54, 55-64 насныхны хариулт нэлээд багасчээ. Харин 25-аас доош, 35-44, 65-аас дээш насныхны уг хариулт нэмэгдсэн байна. Түүнчлэн судалгаанд оролцогчдын нэлээд (37.7) хувь нь банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл хэвэндээ гэж хариулснаас хамгийн бага хувьтай хариултыг 25-аас доош насны иргэд, хамгийн ихийг 55-аас дээш насныхан өгчээ. 2005 оны судалгааны дүнтэй харьцуулбал, 65-аас дээш насныхны хэвэндээ гэсэн хариулт 4.5 нэгжээр буурч, бусад насныхны уг хариулт, ялангуяа, 55-64 насныхны хариулт хамгийн их буюу 10.5 нэгжээр нэмэгдсэн байна. Мэдэхгүй гэсэн хариулт бүх насны иргэдийн хувьд буурч, 8.5 хувьд, буурсан гэсэн хариулт 55-64 наснаас бусад насны иргэдийн хувьд өсч, 10.9 хувьд тус тус хүрлээ.

#### *Хүснэгт III.4.4. Банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа?*

Насны бүлэг		Сурталчилж чадаж байна	Сурталчилж чадахгүй байна	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	70.1	15.7	14.2
	2006	69.7	18.1	12.2
	Өөрчлөлт	-0.4	2.4	-2.0
25-34	2005	68.7	17.9	13.4
	2006	67.7	21.2	11.1
	Өөрчлөлт	-1.0	3.3	-2.3
35-44	2005	63.7	22.2	14.1
	2006	62.7	22.9	14.4
	Өөрчлөлт	-1.0	0.7	0.3
45-54	2005	65.4	22.2	12.4
	2006	62.2	25.2	12.6

	Өөрчлөлт	-3.2	3.0	0.2
55-64	2005	56.5	24.6	18.8
	2006	59.4	23.5	17.1
	Өөрчлөлт	2.9	-1.1	-1.7
65 дээш	2005	57.3	22.0	20.7
	2006	51.4	27.8	20.8
	Өөрчлөлт	-5.9	5.8	0.1
Бүгд	2005	66.2	19.8	14.0
	2006	64.8	22.1	13.0
	Өөрчлөлт	-1.4	2.3	-1.0

Бүх насны иргэдийн дийлэнх (54.4-69.7%) банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэж өмнөх судалгааны нэг адил дүгнэжээ. Гэвч өмнөх судалгаатай харьцуулахад 55-64 наснаас бусад ангиллын хувьд буурсан үзүүлэлттэй байна. Сурталчилж чадахгүй байна гэж нийт иргэдийн 22.1 хувь үзэж байгаа ба 45-аас дээш насныхны тус хариултанд өгсөн хувь арай илүү байна. 2005 оны судалгаанаас 55-64 наснаас бусад бүх ангилалд тус хариултын хувийн жин өсчээ. Мэдэхгүй гэсэн хариултын хувийн жин 35-аас доош болон 55-64 насныхны хувьд 1.7-2.3 нэгжээр буурч, 13.0 хувь болсон байна.

#### *Хүснэгт III.4.5. Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ?*

Насны бүлэг		Хувь хүнд хүрч, хэвийн үйлчилж байна	Хүнд сурталтай	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	59.2	25.9	14.9
	2006	59.1	29.0	11.9
	Өөрчлөлт	-0.1	3.1	-3.0
25-34	2005	58.6	28.9	12.5
	2006	58.6	31.9	9.5
	Өөрчлөлт	0.0	3.0	-3.0
35-44	2005	58.2	30.5	11.4
	2006	58.6	32.3	9.1
	Өөрчлөлт	0.4	1.8	-2.3
45-54	2005	59.8	30.6	9.5
	2006	52.8	38.6	8.6
	Өөрчлөлт	-7.0	8.0	-0.9
55-64	2005	56.9	29.1	14.1
	2006	55.7	31.3	13.0
	Өөрчлөлт	-1.2	2.2	-1.1
65 дээш	2005	44.6	33.7	21.7
	2006	51.7	30.3	17.9
	Өөрчлөлт	7.1	-3.4	-3.8
Бүгд	2005	58.5	29.1	12.4
	2006	57.3	32.6	10.1
	Өөрчлөлт	-1.2	3.5	-2.3

Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хувь хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэж үзэж буй иргэд нийт санал асуулгад оролцогчдын 57.3 хувь, хүнд сурталтай гэж үзэгсэд 32.6 хувь байна. Насны ангиллын хувьд дээрх асуултанд хариулах байдал ерөнхийдөө ижил байгаа боловч 45-54, 65-аас дээш насныхны хувь хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариулт бусдаасаа арай бага байна.

2005 оны судалгааны дүнтэй харьцуулахад хүнд хүрч, хэвийн байна гэсэн хариулт 45-64 насны иргэдийн хувьд, мэдэхгүй гэсэн хариулт бүх насныхны хувьд тус тус буурч, хүнд сурталтай гэсэн хариулт 65-аас доош бүх насныхны хувьд нэмэгдсэн байна.

*Хүснэгт III.4.6. Мөнгөний хэрэгцээ гарвал та хаашаа хандах вэ?*

Насны бүлэг		Банк	ББСБ	ХЗХ	Ломбард	Хувь хүн	Бусад
		хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	34.7	6.2	6.5	19.3	26.2	7.1
	2006	42.9	4.0	3.8	18.4	24.5	6.3
	Өөрчлөлт	8.2	-2.2	-2.7	-0.9	-1.7	-0.8
25-34	2005	45.9	5.7	6.5	15.7	21.3	4.8
	2006	51.7	4.4	3.5	15.0	20.5	5.0
	Өөрчлөлт	5.8	-1.3	-3.0	-0.7	-0.8	0.2
35-44	2005	47.8	6.5	7.4	14.1	19.0	5.3
	2006	56.6	3.9	5.1	13.3	17.7	3.3
	Өөрчлөлт	8.8	-2.6	-2.3	-0.8	-1.3	-2.0
45-54	2005	50.7	5.0	6.7	14.0	19.0	4.7
	2006	58.6	5.2	4.8	12.0	16.9	2.5
	Өөрчлөлт	7.9	0.2	-1.9	-2.0	-2.1	-2.2
55-64	2005	49.2	5.0	7.9	14.0	18.5	5.3
	2006	54.3	3.5	5.3	10.9	19.0	7.0
	Өөрчлөлт	5.1	-1.5	-2.6	-3.1	0.5	1.7
65 дээш	2005	42.4	4.0	3.0	16.2	25.3	9.1
	2006	53.8	2.5	4.4	10.1	18.4	10.8
	Өөрчлөлт	11.4	-1.5	1.4	-6.1	-6.9	1.7
Бүгд	2005	45.2	5.8	6.8	15.6	21.2	5.4
	2006	52.9	4.2	4.3	14.3	19.7	4.6
	Өөрчлөлт	7.7	-1.6	-2.5	-1.3	-1.5	-0.8

Мөнгөний хэрэгцээ гарвал та хаашаа хандах вэ гэсэн асуултанд 25-аас доош наснаас бусад насны иргэдийн 50-аас дээш хувь нь банк гэж хариулсан бөгөөд бүх насныхны тус хариултын хувийн жин өмнөх судалгаанаас нэмэгдсэн байна. 35-54 насны иргэдийн 56.6-58.6 хувь банк гэж хариулсан нь хамгийн өндөр хувьтай санал байна. Үүний дараа хувь хүн, ломбард гэсэн хариултууд орж байгаа бөгөөд нийт иргэдийн саналын 19.7, 14.3 хувийг тус тус эзэлж байна. Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, бусад газарт хандана гэсэн хариулт хоорондоо ойролцоо буюу 4.2-4.6 хувийг эзэлж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад банкнаас бусад хариултуудын хувийн жин бараг бүх насны ангилалд буурчээ.

*Хүснэгт III.4.7. Та банк бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг үү?*

Насны бүлэг		Тийм	Үгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	37.4	59.1	3.5
	2006	30.8	66.6	2.7
	Өөрчлөлт	-6.6	7.5	-0.8
25-34	2005	36.3	60.2	3.5
	2006	26.7	70.5	2.8
	Өөрчлөлт	-9.6	10.3	-0.7
35-44	2005	38.7	57.9	3.4
	2006	32.2	64.3	3.5

	Өөрчлөлт	-6.5	6.4	0.1
45-54	2005	42.2	53.9	4.0
	2006	30.6	65.8	3.6
	Өөрчлөлт	-11.6	11.9	-0.4
55-64	2005	32.3	58.4	9.4
	2006	26.2	68.5	5.2
	Өөрчлөлт	-6.1	10.1	-4.2
65 дээш	2005	30.1	63.9	6.0
	2006	24.5	71.3	4.2
	Өөрчлөлт	-5.6	7.4	-1.8
Бүгд	2005	37.9	58.2	3.9
	2006	29.5	67.2	3.3
	Өөрчлөлт	-8.4	9.0	-0.6

Санал асуулгад оролцогчдын ихэнх буюу 67.2 хувь нь банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэггүй гэж хариулсан бол 29.5 хувь нь үйлчлүүлдэг гэж хариулсан байна. Дээрх асуултанд хариулах байдал нь насны ангиллын хувьд төстэй байгаа бөгөөд 2005 оны судалгааны дүнтэй харьцуулбал тийм гэсэн хариулт 8.4 нэгжээр буурч, үгүй гэсэн хариулт 9 нэгжээр өссөн байна.

*Хүснэгт III.4.8. Та хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой юу?*

Насны бүлэг		Тийм	Үгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	49.2	35.3	15.5
	2006	48.1	36.9	15.1
	Өөрчлөлт	-1.1	1.6	-0.4
25-34	2005	49.4	34.2	16.4
	2006	44.6	41.2	14.2
	Өөрчлөлт	-4.8	7.0	-2.2
35-44	2005	44.5	36.9	18.6
	2006	39.5	42.0	18.5
	Өөрчлөлт	-5.0	5.1	-0.1
45-54	2005	43.8	35.8	20.5
	2006	38.2	41.5	20.3
	Өөрчлөлт	-5.6	5.7	-0.2
55-64	2005	42.0	36.2	21.8
	2006	35.9	41.7	22.4
	Өөрчлөлт	-6.1	5.5	0.6
65 дээш	2005	29.8	34.5	35.7
	2006	26.6	52.4	21.0
	Өөрчлөлт	-3.2	17.9	-14.7
Бүгд	2005	46.3	35.5	18.1
	2006	41.7	41.0	17.2
	Өөрчлөлт	-4.6	5.5	-0.9

25-аас доош насныхны 48.1 хувь нь хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой гэж хариулсан нь хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд насны ангилал өсөх тутам буурсаар 55-64 насныхны хувьд 35.9 хувь, 65-аас дээш насныхны хувьд бүр 26.6 хувь болсон байна. Харин хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголтгүй гэж бүх насны ангиллын иргэдийн 36.9-52.4 хувь хариулжээ. Өмнөх судалгаагаар бүх насны иргэдийн дийлэнх нь хадгаламж зээлийн хоршоодын талаар ойлголттой байсан бол энэ удаагийн судалгаагаар ойлголттой

болон ойлголтгүй иргэдийн хувийн жин ойролцоо болсон байна. Гэхдээ насны ангиллаар нь авч үзвэл, залуу хүмүүсийн (35-аас доош настай) дийлэнх хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой, 35-аас дээш насныхны олонхи нь ойлголтгүй байна.

**Хүснэгт III.4.9. Та хадгаламж зээлийн хоршооны гишүүн мөн үү?**

Насны бүлэг		Тийм	Үгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	10.7	84.3	5.0
	2006	8.1	88.9	3.0
	Өөрчлөлт	-2.6	4.6	-2.0
25-34	2005	11.7	83.8	4.5
	2006	8.5	89.0	2.5
	Өөрчлөлт	-3.2	5.2	-2.0
35-44	2005	13.6	81.2	5.2
	2006	11.9	85.2	2.9
	Өөрчлөлт	-1.7	4.0	-2.3
45-54	2005	13.3	81.7	5.0
	2006	11.4	85.4	3.2
	Өөрчлөлт	-1.9	3.7	-1.8
55-64	2005	17.3	75.6	7.1
	2006	9.9	84.9	5.2
	Өөрчлөлт	-7.4	9.3	-1.9
65 дээш	2005	8.3	83.3	8.3
	2006	10.5	85.3	4.2
	Өөрчлөлт	2.2	2.0	-4.1
Бүгд	2005	12.6	82.4	5.1
	2006	10	87.0	3.0
	Өөрчлөлт	-2.6	4.6	-2.1

Бүх насны санал асуулгад оролцогчдын дийлэнх (84.9-89.0) хувь 2005 оныхтой адил хадгаламж зээлийн хоршооны гишүүн бус байна. Харин нийт санал асуулгад оролцогчдын 10.0 хувь нь хадгаламж зээлийн хоршооны гишүүн бөгөөд 35-аас дээш насныхны дунд 35-аас доош насныхныг бодвол гишүүнчлэл нь арай өндөр хувьтай байна. Өмнөх судалгаанаас гишүүн бус гэсэн хариулт бүх насны ангилалд өсч, гишүүн гэсэн хариулт 65-аас дээш наснаас бусад ангилалд буурчээ.

**Хүснэгт III.4.10. Та хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ?**

Насны бүлэг		Зөв буюу хуулийн дагуу	Буруу буюу хууль бус	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	35.4	10.6	54.0
	2006	23.9	27.5	48.7
	Өөрчлөлт	-11.5	16.9	-5.3
25-34	2005	32.3	11.9	55.8
	2006	21.5	27.1	51.4
	Өөрчлөлт	-10.8	15.2	-4.4
35-44	2005	31.7	10.1	58.2
	2006	22.1	27.8	50.1
	Өөрчлөлт	-9.6	17.7	-8.1

45-54	2005	31.9	11.5	56.6
	2006	18.9	32.3	48.8
	Өөрчлөлт	-13.0	20.8	-7.8
55-64	2005	25.2	14.2	60.6
	2006	14.9	40.2	44.9
	Өөрчлөлт	-10.3	26.0	-15.7
65 дээш	2005	27.7	18.1	54.2
	2006	13.4	38.7	47.9
	Өөрчлөлт	-14.3	20.6	-6.3
Бүгд	2005	32.2	11.3	56.5
	2006	21.0	29.3	49.7
	Өөрчлөлт	-11.2	18.0	-6.8

Ямар ч насны ангиллын санал асуулгад оролцогчдын дийлэнх 2005 оны судалгаатай адил хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг дүгнэж мэдэхгүй байна. Гэвч өмнөх судалгаанаас бүх насны ангилал дахь мэдэхгүй гэсэн хариултын хувийн жин буурчээ. Харин өмнөх судалгаагаар бүх насны иргэдийн 25.2-35.4 хувь нь зөв, хуулийн дагуу гэж дүгнэсэн нь буруу хууль бус (10.1-18.1) гэж дүгнэсэн иргэдээс олон байсан бол энэ байдал эсрэгээрээ өөрчлөгдөж, 29.3 хувь нь буруу, хууль бус, 21.0 хувь нь зөв, хуулийн дагуу гэж дүгнэх болжээ. Зөв хуулийн дагуу гэсэн хариултыг 45 наснаас доош насны иргэд арай илүү сонгосон бол, 45-аас дээш насны иргэд буруу, хууль бус гэж илүү шүүмжлэлтэй хандсан байна.

*Хүснэгт III.4.11. Гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь хэр ач холбогдолтой вэ?*

Насны бүлэг		Ач холбогдолтой	Ач холбогдолгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	43.5	23.4	33.1
	2006	42.1	27.1	30.9
	Өөрчлөлт	-1.4	3.7	-2.2
25-34	2005	47.6	19.4	33.0
	2006	42.7	24.0	33.2
	Өөрчлөлт	-4.9	4.6	0.2
35-44	2005	47.0	19.4	33.7
	2006	42.9	23.1	34.0
	Өөрчлөлт	-4.1	3.7	0.3
45-54	2005	47.1	17.7	35.2
	2006	44.7	23.4	31.9
	Өөрчлөлт	-2.4	5.7	-3.3
55-64	2005	48.2	21.2	30.5
	2006	38.5	24.3	37.2
	Өөрчлөлт	-9.7	3.1	6.7
65 дээш	2005	44.6	19.3	36.1
	2006	43.4	20.7	35.9
	Өөрчлөлт	-1.2	1.4	-0.2
Бүгд	2005	46.5	20.0	33.5
	2006	42.8	24.1	33.1
	Өөрчлөлт	-3.7	4.1	-0.4

Бүх насны иргэдийн дийлэнх (38.5-44.7) гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж үзсэн хэвээр байна. Гэвч насны ангилал тус бүрт уг саналын хувийн жин буурсан байна. 55-64 насны иргэдийн ач холбогдолтой гэж өгсөн санал бусад насны иргэдээс арай бага хувийн жинтэй



байна. Харин ач холбогдолгүй гэж нийт иргэдийн 20.7-27.1 хувь дүгнэж байгаа ба 2005 оныхоос хувийн жин бүх насны ангилалд өсчээ. Мөн мэдэхгүй гэж санал асуулгад оролцогчдын багагүй (30.9-37.2) хувь өмнөх судалгааны нэг адил хариулжээ.

**Хүснэгт III.4.12. Та бэлэн бус тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү?**

Насны бүлэг		Тийм	Үгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	26.2	67.1	6.7
	2006	33.1	62.3	4.6
	Өөрчлөлт	6.9	-4.8	-2.1
25-34	2005	25.9	67.1	7.0
	2006	39.3	57.1	3.6
	Өөрчлөлт	13.4	-10.0	-3.4
35-44	2005	18.2	73.5	8.3
	2006	27.8	67.2	5.0
	Өөрчлөлт	9.6	-6.3	-3.3
45-54	2005	16.8	75.4	7.8
	2006	28.5	65.9	5.5
	Өөрчлөлт	11.7	-9.5	-2.3
55-64	2005	14.4	71.8	13.8
	2006	19.1	73.9	7.0
	Өөрчлөлт	4.7	2.1	-6.8
65 дээш	2005	10.7	65.5	23.8
	2006	12.5	79.2	8.3
	Өөрчлөлт	1.8	13.7	-15.5
Бүгд	2005	21.4	70.5	8.1
	2006	31.5	63.7	4.8
	Өөрчлөлт	10.1	-6.8	-3.3

Санал асуулгын дүнгээс харахад, бэлэн бус тооцооны хэрэгсэл болох картны хэрэглээ бүх насны хүмүүсийн дунд 2005 оноос нэмэгдсэн ба ялангуяа, 25-54 насны иргэдийн хэрэглээ илүү өсчээ. 25-34 насны иргэдийн хэрэглээ бусад насныхнаас хамгийн их байгаа бөгөөд үүний дараагаар 25 хүртэл болон 35-54 насныхан орж байна. Мөн картын талаар мэдлэггүй байсан хүмүүсийн хувийн жин бүх насны ангилалд буурчээ.

**III.5. Хадгаламж, хуримтлал**

**Хүснэгт III.5.1. Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ?**

Насны бүлэг		Банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг	Бусад зээлдүүлдэг	Худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг	Үнэт цаасанд байршуулдаг	Хувьцаа худалдаж авдаг	Бусад
		хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	31.3	8.8	17.5	1.4	2.2	38.8
	2006	36.1	6.4	16.8	1.1	2.8	36.8
	Өөрчлөлт	4.8	-2.4	-0.7	-0.3	0.6	-2.0
25-34	2005	30.8	8.0	27.0	0.9	1.3	32.1

	2006	35.7	6.9	23.8	1.2	2.0	30.4
	Өөрчлөлт	4.9	-1.1	-3.2	0.3	0.7	-1.7
35-44	2005	27.7	7.5	33.5	1.1	1.1	29.0
	2006	31.1	8.3	33.2	1.5	1.6	24.3
	Өөрчлөлт	3.4	0.8	-0.3	0.4	0.5	-4.7
45-54	2005	25.3	8.6	32.6	1.4	1.4	30.6
	2006	32.2	6.8	30.5	2.8	2.3	25.4
	Өөрчлөлт	6.9	-1.8	-2.1	1.4	0.9	-5.2
55-64	2005	24.5	6.3	26.1	1.9	0.9	40.3
	2006	33.4	6.5	26.6	1.0	2.1	30.3
	Өөрчлөлт	8.9	0.2	0.5	-0.9	1.2	-10.0
65 дээш	2005	17.3	8.6	23.5	3.7	1.2	45.7
	2006	39.9	7.2	11.6	2.2	2.2	37.0
	Өөрчлөлт	22.6	-1.4	-11.9	-1.5	1.0	-8.7
Бүгд	2005	28.6	8.0	27.7	1.3	1.4	33.0
	2006	33.9	7.2	26.3	1.6	2.1	29.1
	Өөрчлөлт	5.3	-0.8	-1.4	0.3	0.7	-3.9

Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын 33.9 хувь нь банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 29.1 хувь нь бусад байдлаар зарцуулдаг, 26.3 хувь нь худалдаа наймаа хийж, эргүүлдэг, 7.2 хувь нь бусад зээлдүүлдэг, 2.1 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 1.6 хувь нь үнэт цаасанд байршуулдаг гэж тус тус харилусан байна. Насны ангиллаар авч үзвэл, 25-34 насны иргэдийн дийлэнх худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, мөн банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг гэж хариулсан байна. Харин бусад насны иргэдийн дийлэнх банк, санхүүгийн байгууллагад хадгалуулдаг гэжээ. Үүний дараагаар тэдний багагүй хэсэг худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг гэж хариулав. Мөн аль ч насны иргэдийн багагүй хувь бусад байдлаар мөнгөө зарцуулдаг гэсэн хариултыг сонгосон байна. Өмнөх судалгаатай харьцуулбал, бүх насны иргэдийн дунд банк, санхүүгийн байгууллагад хадгалуулах хандлага нэмэгджээ. Харин бусад зээлдүүлэх байдал санал асуулгад оролцогчдын 6.4-8.3 хувийг эзэлж байгаа бөгөөд 2005 оноос бага зэрэг буурав. Санал асуулгад оролцогчдын дөнгөж 3.7 хувь нь хуримтлуулсан мөнгөө үнэт цаасанд байршуулж эсвэл хувьцаа худалдаж авдаг гэж хариулсан ч өмнөх судалгааны дүнгээс бүх насны ангилалд бага зэрэг нэмэгдэв.

### *Хүснэгт III.5.2. Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ?*

Насны бүлэг		Бэлэн мөнгөөр	Бэлэн бус мөнгөний хэлбэрээр	Үнэт цаасаар	Хувьцаагаар	Бусад
		Хувь	хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	58.9	16.9	4.8	4.4	15.0
	2006	60.9	16.5	4.3	4.8	13.4
	Өөрчлөлт	2.0	-0.4	-0.5	0.4	-1.6
25-34	2005	61.7	17.4	4.2	2.7	14.0
	2006	65.3	16.6	3.2	3.0	11.9
	Өөрчлөлт	3.6	-0.8	-1.0	0.3	-2.1
35-44	2005	64.6	13.2	4.4	3.6	14.1
	2006	67.4	13.9	3.9	3.7	11.2
	Өөрчлөлт	2.8	0.7	-0.5	0.1	-2.9
45-54	2005	66.1	13.8	4.1	3.6	12.4
	2006	65.0	15.3	4.8	5.1	9.9
	Өөрчлөлт	-1.1	1.5	0.7	1.5	-2.5
55-64	2005	65.5	11.8	4.6	3.3	14.8

	2006	69.3	10.3	4.1	4.6	11.7
	Өөрчлөлт	3.8	-1.5	-0.5	1.3	-3.1
65 дээш	2005	71.1	6.6	2.6	5.3	14.5
	2006	68.2	7.8	2.3	7.0	14.7
	Өөрчлөлт	-2.9	1.2	-0.3	1.7	0.2
Бүгд	2005	63.0	15.1	4.3	3.5	14.0
	2006	65.3	15.1	3.9	4.0	11.7
	Өөрчлөлт	2.3	0.0	-0.4	0.5	-2.3

Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын дийлэнх 2005 оны судалгаатай адил насны ангиллаас үл хамааран бэлэн мөнгөөр гэж хариулсан байна. Өмнөх судалгаанаас 45-54, 65-аас дээш насныхны хариулт хувийн жингээрээ буурч, бусад насныхны хувьд өсчээ. Үүний дараа бэлэн бус мөнгөний хэлбэрийг сонгосноос 55-аас дээш насныхны хувийн жин арай доогуур байна. Нийт судалгаанд оролцогчдын 8 орчим хувь үнэт цаас, хувьцаагаар мөнгөө байршуулахыг илүүд үздэг гэжээ. Бэлэн бус мөнгөний хэлбэрээр болон үнэт цаас, хувьцаагаар гэсэн хариултууд өмнөх судалгааны дүнгээс өөрчлөлт бага байна.

### *Хүснэгт III.5.3. Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ?*

Насны бүлэг		Төгрөгөөр	Америк доллараар	Бусад мөнгөний нэгжээр
		хувь	хувь	хувь
25 доош	2005	85.8	7.6	6.6
	2006	84.4	8.4	7.2
	Өөрчлөлт	-1.4	0.8	0.6
25-34	2005	90.2	5.7	4.1
	2006	89.2	7.3	3.5
	Өөрчлөлт	-1.0	1.6	-0.6
35-44	2005	89.1	6.3	4.6
	2006	86.4	9.4	4.2
	Өөрчлөлт	-2.7	3.1	-0.4
45-54	2005	89.0	6.7	4.3
	2006	86.3	9.6	4.1
	Өөрчлөлт	-2.7	2.9	-0.2
55-64	2005	88.1	4.0	7.9
	2006	89.2	7.4	3.4
	Өөрчлөлт	1.1	3.4	-4.5
65 дээш	2005	84.7	6.9	8.3
	2006	89.7	6.0	4.3
	Өөрчлөлт	5.0	-0.9	-4.0
Бүгд	2005	88.6	6.3	5.0
	2006	87.1	8.4	4.4
	Өөрчлөлт	-1.5	2.1	-0.6

Аль ч насны ангиллын хувьд санал асуулгад оролцогчдын дийлэнх (84.4-89.7) хувь нь төгрөгөөр мөнгөө хадгалдаг гэж 2005 оны судалгааны нэг адил хариулсан байна. Гэхдээ өмнөх судалгаанаас 55-аас дээш насны иргэдийн тус хариулт нэмэгдэж, бусад насныхны хариулт буурсан байна. Харин америк доллараар иргэдийн 6.0-9.6 хувь нь хадгалдаг бөгөөд өмнөх судалгаатай харьцуулахад 65-аас дээш насныхны хувьд бага зэрэг буурч, бусад насныхны хувьд 0.8-3.4 нэгжээр өссөн байна. Бусад мөнгөний нэгжээр хадгалах байдал 25 дээш насны иргэдийн хувьд бага зэрэг буурч, нийт иргэдийн 4.4 хувийг эзэлж байна.

### Хүснэгт III.5.4. Хадгаламжийн хүү таны бодлоор?

Насны бүлэг		Бага байна	Боломжийн	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	49.1	31.8	19.1
	2006	46.6	35.5	17.9
	Өөрчлөлт	-2.5	3.7	-1.2
25-34	2005	59.4	28.1	12.5
	2006	56.7	31.8	11.6
	Өөрчлөлт	-2.7	3.7	-0.9
35-44	2005	59.3	26.9	13.8
	2006	60.0	25.8	14.3
	Өөрчлөлт	0.7	-1.1	0.5
45-54	2005	62.1	25.6	12.3
	2006	59.0	26.6	14.4
	Өөрчлөлт	-3.1	1.0	2.1
55-64	2005	58.4	20.6	20.9
	2006	57.3	26.1	16.7
	Өөрчлөлт	-1.1	5.5	-4.2
65 дээш	2005	46.8	25.3	27.8
	2006	56.9	19.0	24.1
	Өөрчлөлт	10.1	-6.3	-3.7
Бүгд	2005	57.6	27.6	14.8
	2006	56.3	29.3	14.4
	Өөрчлөлт	-1.3	1.7	-0.4

Хадгаламжийн хүүг бага байна гэж нийт санал асуулгад оролцсон бүх насны иргэдийн дийлэнх (46.6-60.0) хувь өмнөх судалгааны нэг адил үзжээ. Ялангуяа, 35-54 насны иргэдийн санал хамгийн өндөр хувьтай байлаа. Гэхдээ өмнөх судалгаатай харьцуулахад хувийн жин нь 65-аас доош бүх насныхны хувьд буурсан байна. Харин хадгаламжийн хүүг боломжийн гэж 35-аас доош насныхны 31.8-35.5 хувь үзэж байгаа нь тус хариултын хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол 65-аас дээш насныхны 19.0 хувь ингэж үзэж байгаа нь хамгийн бага хувийг эзэлж байна. 35-64 насны иргэдийн 25.8-26.6 хувь нь боломжийн гэж үзэж байна. Мэдэхгүй гэсэн хариултын хамгийн өндөр хувьтай хариултыг 65-аас дээш насныхан (24.1), хамгийн бага хувьтай хариултыг 25-34 насныхан (11.6) өгсөн байна. 2005 оны судалгаатай харьцуулахад боломжийн гэсэн хариулт 65-аас дээш наснаас бусад насны иргэдийн хувьд өсч, мэдэхгүй гэсэн хариулт 25-34, 65-аас дээш наснаас бусад насны иргэдийн хувьд буурсан байна.

### III.6. Зээлийн талаар

#### Хүснэгт III.6.1. Танд зээлийн хэрэгцээ байдаг уу?

Насны бүлэг		Тийм	Үгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	75.6	20.4	4.0
	2006	74.7	21.2	4.1
	Өөрчлөлт	-0.9	0.8	0.1
25-34	2005	85.1	11.9	3.0
	2006	84.6	13.1	2.3
	Өөрчлөлт	-0.5	1.2	-0.7
	2005	86.2	11.3	2.6

35-44	2006	84.9	12.0	3.1
	Өөрчлөлт	-1.3	0.7	0.5
45-54	2005	88.2	9.9	1.9
	2006	86.0	12.2	1.8
	Өөрчлөлт	-2.2	2.3	-0.1
55-64	2005	82.5	14.2	3.2
	2006	79.7	16.4	3.9
	Өөрчлөлт	-2.8	2.2	0.7
65 дээш	2005	58.0	33.3	8.6
	2006	69.2	25.9	4.9
	Өөрчлөлт	11.2	-7.4	-3.7
Бүгд	2005	83.5	13.5	3.0
	2006	82.6	14.5	2.9
	Өөрчлөлт	-0.9	1.0	-0.1

Зээлийн хэрэгцээ өмнөх судалгааны нэг адил бүх насны иргэдийн дунд өндөр байсаар л байна. Ялангуяа, 25-54 насны иргэд хамгийн их эрэлттэй гэж хариулжээ. Өмнөх судалгаатай харьцуулбал, ихэнх иргэдийн зээл хэрэгцээтэй гэсэн хариулт бага зэрэг буурсан байхад харьцангуй бага эрэлттэй байсан 65-аас дээш насныхны эрэлт нэлээд нэмэгдсэн байна.

*Хүснэгт III.6.2. Танд банк, санхүүгийн байгууллагуудаас олгож буй зээл хүртээмжтэй байдаг уу?*

Насны бүлэг		Тийм	Үгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	35.2	38.7	26.1
	2006	36.9	35.8	27.3
	Өөрчлөлт	1.7	-2.9	1.2
25-34	2005	45.2	36.2	18.6
	2006	43.5	37.8	18.6
	Өөрчлөлт	-1.7	1.6	0.0
35-44	2005	43.1	41.3	15.6
	2006	45.6	38.4	16.0
	Өөрчлөлт	2.5	-2.9	0.4
45-54	2005	44.7	38.6	16.6
	2006	45.2	38.0	16.7
	Өөрчлөлт	0.5	-0.6	0.1
55-64	2005	40.5	35.4	24.1
	2006	43.7	33.6	22.7
	Өөрчлөлт	3.2	-1.8	-1.4
65 дээш	2005	28.4	42.0	29.6
	2006	26.1	39.6	34.3
	Өөрчлөлт	-2.3	-2.4	4.7
Бүгд	2005	42.1	38.5	19.4
	2006	42.9	37.5	19.7
	Өөрчлөлт	0.8	-1.0	0.3

Танд банк, санхүүгийн байгууллагуудаас олгож буй зээл хүртээмжтэй байдаг уу гэсэн асуултанд бүх насны ангиллаарх санал асуулгад оролцогчдын дийлэнх тийм гэж хариулжээ. Үүнийг 2005 оны судалгаатай харьцуулахад 25-34 болон 65-аас дээш насныхны тус хариулт буурч, бусад насны иргэдийнх өссөн байна. Мөн банк санхүүгийн байгууллагуудаас олгож буй зээл хүртээмжгүй байдаг гэж бүх насны иргэдийн нэлээд (33.6-39.6) хувь үзсэн хэвээр байгаа боловч 25-34 наснаас бусад насны иргэдийн хувьд хувийн жин нь буурчээ. Харин мэдэхгүй гэсэн хариулт бүх

насны ангилалд өмнөх судалгааны дүнгээс харьцангуй бага өөрчлөгдсөн бөгөөд 25-аас доош болон 65-аас дээш насны иргэдийн дунд мэдэхгүй гэсэн хариулт өндөр хувийг эзэлж байна.

**Хүснэгт III.6.3. Таны бодлоор банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад?**

Насны бүлэг		Хүндрэлгүй	Хүндрэлтэй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	34.0	46.4	19.5
	2006	35.0	47.0	17.9
	Өөрчлөлт	1.0	0.6	-1.6
25-34	2005	38.0	47.6	14.4
	2006	37.5	51.4	11.1
	Өөрчлөлт	-0.5	3.8	-3.3
35-44	2005	39.1	47.5	13.4
	2006	39.5	49.2	11.2
	Өөрчлөлт	0.4	1.7	-2.2
45-54	2005	42.8	46.3	10.9
	2006	39.5	49.9	10.6
	Өөрчлөлт	-3.3	3.6	-0.3
55-64	2005	37.9	39.8	22.3
	2006	40.6	44.6	14.9
	Өөрчлөлт	2.7	4.8	-7.4
65 дээш	2005	35.4	37.8	26.8
	2006	27.9	45.7	26.4
	Өөрчлөлт	-7.5	7.9	-0.4
Бүгд	2005	38.3	46.5	15.1
	2006	38.0	49.3	12.8
	Өөрчлөлт	-0.3	2.8	-2.3

Бүх насны санал асуулгад оролцогчдын дийлэнх (44.6-51.4) банк санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлтэй гэж өмнөх судалгааны нэг адил үзсэн хэвээр байна. 2005 оны судалгаанаас бүх насны ангилалд хүндрэлтэй гэж үзсэн иргэдийн хувийн жин өсчээ. Харин санал асуулгад оролцсон иргэдийн 27.6-40.6 хувь хүндрэлгүй гэж хариулсан нь өмнөх судалгаатай харьцуулахад 25-34, 45-54, 65-аас дээш насныхны хувьд хувийн жин нь буурч, бусад насны иргэдийн хувьд бага зэрэг нэмэгдсэн байна. Мэдэхгүй гэсэн хариулт бүх насны иргэдийн хувьд буурч, дунджаар 12.8 хувьтай байна. Мэдэхгүй гэсэн хариултыг 25-аас доош болон 65-аас дээш насны иргэд хамгийн их өгчээ.

**Хүснэгт III.6.4. Таны бодлоор зээлийн хүү?**

Насны бүлэг		Өндөр байна	Боломжийн	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	64.6	21.0	14.4
	2006	63.7	24.4	11.9
	Өөрчлөлт	-0.9	3.4	-2.5
25-34	2005	69.6	22.2	8.2
	2006	72.2	20.7	7.1
	Өөрчлөлт	2.6	-1.5	-1.1
35-44	2005	69.6	21.8	8.7
	2006	72.7	19.1	8.2
	Өөрчлөлт	3.1	-2.7	-0.5

45-54	2005	75.0	16.9	8.1
	2006	75.0	18.5	6.4
	Өөрчлөлт	0.0	1.6	-1.7
55-64	2005	70.3	16.0	13.7
	2006	73.8	16.7	9.5
	Өөрчлөлт	3.5	0.7	-4.2
65 дээш	2005	67.1	9.8	23.2
	2006	70.0	15.7	14.3
	Өөрчлөлт	2.9	5.9	-8.9
Бүгд	2005	69.6	20.4	10.1
	2006	71.5	20.1	8.4
	Өөрчлөлт	1.9	-0.3	-1.7

Зээлийн хүүг санал асуулгад оролцогчдын дийлэнх (63.7-75) насны ангиллаас үл хамааран өндөр гэж өмнөх судалгааны нэг адил үзсэн хэвээр байна. Ялангуяа, 45-54 насныхны хувьд өндөр байна гэсэн хариулт хамгийн их хувьтай (75 хувь) байлаа. Харин боломжийн гэсэн хариултыг санал асуулгад оролцогчдын 20.1 хувь өгсөн ба хамгийн их хувьтай саналыг 20 хүртэлх насны иргэд, насны ангилал ихсэх тутам энэ хувь буурчээ. Мэдэхгүй гэж 25-аас доош, 65-аас дээш насныхан бусад насны иргэдээс арай илүү хувьтай хариулжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал, зээлийн хүү өндөр байна гэсэн хариулт 25-аас дээш насныхны хувьд нэмэгдэж, боломжийн гэсэн харилт 25-44 насныхны хувьд буурч, мэдэхгүй гэсэн хариулт нийт насныхны хувьд буурсан байна.

### III.7. Бичил санхүүгийн талаар

*Хүснэгт III.7.1. Та бичил санхүүгийн талаар (бага хэмжээний зээл, цалингийн зээл, тэтгэврийн зээл, бага хэмжээний хөдлөх хөрөнгийн зээл) ойлголттой юу?*

Насны бүлэг		Тийм	Үгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	59.9	22.7	17.4
	2006	58.8	26.0	15.3
	Өөрчлөлт	-1.1	3.3	-2.1
25-34	2005	71.6	15.9	12.5
	2006	68.5	20.5	11.0
	Өөрчлөлт	-3.1	4.6	-1.5
35-44	2005	66.5	18.3	15.2
	2006	64.1	20.9	15.0
	Өөрчлөлт	-2.4	2.6	-0.2
45-54	2005	70.6	15.8	13.6
	2006	66.5	20.4	13.2
	Өөрчлөлт	-4.1	4.6	-0.4
55-64	2005	67.0	14.7	18.3
	2006	65.5	19.2	15.3
	Өөрчлөлт	-1.5	4.5	-3.0
65 дээш	2005	54.2	21.7	24.1
	2006	57.3	26.6	16.1
	Өөрчлөлт	3.1	4.9	-8.0
Бүгд	2005	67.3	17.8	14.9
	2006	64.9	21.6	13.5
	Өөрчлөлт	-2.4	3.8	-1.4

Санал асуулгад оролцогчдын 65 хувь нь бичил санхүүгийн талаар ойлголттой, 21.6 хувь нь ойлголтгүй гэж хариулсан байна. Насны ангиллаар авч үзвэл 25-аас доош болон 65-аас дээш насныхан бусад насныхнаас арай бага ойлголттой байдаг байна. 2005 онтой харьцуулахад 65-аас доош бүх насны иргэдийн тийм гэсэн хариулт буурч, бүх насны иргэдийн үгүй гэсэн хариулт нэмэгджээ.

**Хүснэгт III.7.2. Таны оршин сууж байгаа газарт бичил санхүүгийн үйл ажиллагаа хэр хөгжсөн бэ?**

Насны бүлэг		Сайн	Дунд зэрэг	Огт хөгжөөгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	21.7	44.4	11.0	22.9
	2006	23.9	46.4	9.7	20.0
	Өөрчлөлт	2.2	2.0	-1.3	-2.9
25-34	2005	25.1	44.5	10.3	20.1
	2006	27.5	44.8	10.7	17.0
	Өөрчлөлт	2.4	0.3	0.4	-3.1
35-44	2005	24.5	40.7	14.7	20.2
	2006	23.2	43.8	12.3	20.6
	Өөрчлөлт	-1.3	3.1	-2.4	0.4
45-54	2005	25.5	42.3	13.6	18.6
	2006	22.1	44.2	13.4	20.3
	Өөрчлөлт	-3.4	1.9	-0.2	1.7
55-64	2005	19.4	38.7	19.0	22.9
	2006	22.6	39.1	16.0	22.3
	Өөрчлөлт	3.2	0.4	-3.0	-0.6
65 дээш	2005	20.5	38.6	15.7	25.3
	2006	15.9	33.8	18.6	31.7
	Өөрчлөлт	-4.6	-4.8	2.9	6.4
Бүгд	2005	24.0	42.6	12.8	20.6
	2006	24.2	44.1	12.0	19.7
	Өөрчлөлт	0.2	1.5	-0.8	-0.9

Бүх насны ангиллын иргэдийн дийлэнх өмнөх судалгааны нэг адил өөрийн оршин сууж байгаа газартаа бичил санхүүгийн үйл ажиллагаа дунд зэрэг хөгжсөн гэж дүгнэсэн байна. Тухайлбал, 55 хүртэлх насны иргэдийн тус хариулт харьцангуй өндөр байв. Үүний дараагаар сайн гэсэн хариулт 65-аас доош насны иргэдийн хувьд зонхилж байна. Харин 65-аас дээш насныхны хувьд мэдэхгүй гэсэн хариулт харьцангуй их буюу 31.7 хувьтай байв. Өмнөх судалгаатай харьцуулахад дунд зэрэг гэсэн хариулт 65-аас доош насныхны хувьд, сайн гэсэн хариулт 35-54 болон 65-аас дээш наснаас бусад насныхны хувьд тус тус өсч, мэдэхгүй болон огт хөгжөөгүй гэсэн хариулт 65-аас доош насны иргэдийн хувьд буурсан байна.

**Хүснэгт III.7.3. Танд бичил зээл авах боломж бий юу?**

Насны бүлэг		Тийм	Үгүй	Мэдэхгүй
		хувь	хувь	хувь
25 доош	2005	49.6	28.0	22.5
	2006	49.1	25.5	25.3
	Өөрчлөлт	-0.5	-2.5	2.8
25-34	2005	62.9	20.5	16.7



	2006	60.5	23.5	16.0
	Өөрчлөлт	-2.4	3.0	-0.7
35-44	2005	60.1	21.8	18.1
	2006	56.4	24.4	19.2
	Өөрчлөлт	-3.7	2.6	1.1
45-54	2005	64.1	22.1	13.8
	2006	61.7	21.8	16.6
	Өөрчлөлт	-2.4	-0.3	2.8
55-64	2005	58.4	23.0	18.7
	2006	57.8	24.7	17.5
	Өөрчлөлт	-0.6	1.7	-1.2
65 дээш	2005	36.6	41.5	22.0
	2006	43.6	34.3	22.1
	Өөрчлөлт	7.0	-7.2	0.1
Бүгд	2005	59.1	23.0	17.8
	2006	57.1	24.1	18.8
	Өөрчлөлт	-2.0	1.1	1.0

Танд бичил зээл авах боломж бий юу гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын дийлэнх буюу 57.1 хувь нь тийм, 24.1 хувь нь үгүй, 18.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. 25-аас доош болон 65-аас дээш насныхны хувьд бичил зээл авах боломж бусад насны иргэдээс арай бага байна. Өмнөх судалгаанд 65-аас дээш насны иргэдийн дийлэнх бичил зээл авах боломжгүй гэж хариулж байсан бол энэ удаагийн судалгаагаар тэдний дийлэнх боломжтой гэж хариулжээ. Харин бусад насны иргэдийн боломжтой гэсэн хариулт буурч, боломжгүй гэсэн хариулт 25-44, 55-64 насныхны хувьд өссөн байна.

**Хүснэгт III.7.4. Хэрвээ бичил зээл авч ашигладаг бол ямар үйл ажиллагаа (бизнес) эрхэлдэг вэ?**

Насны бүлэг		Газар гаригалан	Хүнсний ногоо	Мал аж ахуй	Худалдаа, наймаа	Жижиг, дунд үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Зочид буудал	Үйлчилгээ	Бусад
		хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	6.5	5.5	7.1	24.6	9.9	5.7	2.7	7.9	30.0
	2006	6.9	6.8	7.7	24.5	8.6	4.0	1.2	9.3	30.9
	Өөрчлөлт	0.4	1.3	0.6	-0.1	-1.3	-1.7	-1.5	1.4	0.9
25-34	2005	4.5	5.1	7.8	30.3	12.6	4.0	1.5	8.3	25.8
	2006	7.2	6.3	8.2	31.1	9.3	3	0.8	7.9	26.1
	Өөрчлөлт	2.7	1.2	0.4	0.8	-3.3	-1.0	-0.7	-0.4	0.3
35-44	2005	6.6	7.2	8.2	33.5	11.5	3.4	2.0	8.2	19.4
	2006	8	8.2	8.2	33.7	12.4	2.3	1.9	7.1	18.4
	Өөрчлөлт	1.4	1.0	0.0	0.2	0.9	-1.1	-0.1	-1.1	-1.0
45-54	2005	6.6	8.9	9.0	31.6	13.4	3.4	2.0	7.2	18.0
	2006	7.9	8.2	10.2	30.4	13.3	2.4	1.6	6.7	19.5
	Өөрчлөлт	1.3	-0.7	1.2	-1.2	-0.1	-1.0	-0.4	-0.5	1.5
55-64	2005	8.2	10.4	13.9	25.0	10.1	2.8	0.9	9.2	19.3
	2006	5.8	7.5	11.1	32.3	16.2	2.8	1.7	7	15.6
	Өөрчлөлт	-2.4	-2.9	-2.8	7.3	6.1	0.0	0.8	-2.2	-3.7
	2005	9.3	8.0	13.3	20.0	14.7	1.3	2.7	5.3	25.3

65 дээш	2006	13.4	16.1	11.6	22.3	7.1	18	0.9	3.6	23.2
	Өөрчлөлт	4.1	8.1	-1.7	2.3	-7.6	16.7	-1.8	-1.7	-2.1
Бүгд	2005	6.1	6.8	8.4	29.8	11.8	4.0	1.9	8.0	23.2
	2006	7.5	7.5	8.7	30.5	11.1	2.8	1.4	7.6	23
	Өөрчлөлт	1.4	0.7	0.3	0.7	-0.7	-1.2	-0.5	-0.4	-0.2

Хэрвээ бичил зээл авч ашигладаг бол ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын 30.5 хувь нь худалдаа наймаа, 11.1 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 8.7 хувь нь мал аж ахуй, 7.6 хувь нь үйлчилгээ, 7.5 хувь нь газар тариалан, 7.5 хувь нь хүнсний ногоо гэж тус тус хариулсан байна. Харин 2.8 хувь нь аялал жуулчлал, 1.4 хувь нь зочид буудал эрхэлдэг гэж хариулжээ. 65-аас дээш насныхны хувьд газар тариалан, хүнсний ногоо, мал аж ахуй, аялал жуулчлал гэсэн хариултыг харьцангуй их, 45-аас дээш насныхны хувьд мал аж ахуй, 45-аас 64 насныхны хувьд жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг гэсэн хариултыг түлхүү сонгожээ. 2005 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал газар тариалан гэсэн хариулт 1.4, хүнсний ногоо 0.7, худалдаа наймаа 0.7, мал аж ахуй 0.3 нэгжээр тус тус өсчээ. Харин аялал жуулчлал гэсэн хариулт 1.2, жижиг, дунд үйлдвэрлэл 0.7, зочид буудал 0.5, үйлчилгээ 0.4 нэгжээр тус тус буурсан байна.

**Хүснэгт III.7.5. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ?**

Насны бүлэг		100,000 доош төгрөг	100,000-250,000 төгрөг	250,000-500,000 төгрөг	500,000-1 сая төгрөг	1 сая- 1.5 сая төгрөг	1.5 сая- 2 сая төгрөг
		хувь	хувь	хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	7.0	8.9	17.0	21.9	15.2	30.0
	2006	5.3	10.1	14.7	22.4	12.3	35.2
	Өөрчлөлт	-1.7	1.2	-2.3	0.5	-2.9	5.2
25-34	2005	4.0	6.3	17.1	22.3	15.4	34.9
	2006	3.6	7.2	14.6	21.0	15.2	38.3
	Өөрчлөлт	-0.4	0.9	-2.5	-1.3	-0.2	3.4
35-44	2005	5.9	7.9	12.8	22.7	13.1	37.7
	2006	4.9	6.8	14.1	21.2	15.0	38.0
	Өөрчлөлт	-1.0	-1.1	1.3	-1.5	1.9	0.3
45-54	2005	4.8	5.8	14.4	19.6	15.0	40.4
	2006	4.1	5.4	12.0	21.6	15.5	41.4
	Өөрчлөлт	-0.7	-0.4	-2.4	2.0	0.5	1.0
55-64	2005	6.5	12.4	16.7	18.2	15.6	30.5
	2006	4.3	7.7	15.4	21.2	16.9	34.5
	Өөрчлөлт	-2.2	-4.7	-1.3	3.0	1.3	4.0
65 дээш	2005	7.1	10.0	17.1	20.0	15.7	30.0
	2006	8.2	14.5	18.2	10.9	15.5	32.7
	Өөрчлөлт	1.1	4.5	1.1	-9.1	-0.2	2.7
Бүгд	2005	5.4	7.5	15.4	21.6	14.7	35.4
	2006	4.5	7.5	14.2	21.2	14.8	37.9
	Өөрчлөлт	-0.9	0.0	-1.2	-0.4	0.1	2.5

Санал асуулгад оролцогчдын 38 хувь нь бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 1.5 – 2 сая төгрөг шаардлагатай, 22 хувь нь 500000-1 сая төгрөг, 14.2 болон 14.8 хувь нь 250000-500000 төгрөг буюу 1 – 1.5 сая төгрөг шаардлагатай гэж хариулсан байна. Хариулсан байдлыг насны ангиллаар үзэхэд 45-54 насныхан 1.5 – 2 сая төгрөг гэсэн хариултыг бусдаасаа илүү буюу 41.4 хувь нь сонгосон байна. Харин

25-аас доош болон 65-аас дээш насныхан 100000-аас доош, 100000-250000 төгрөг гэсэн хариултуудыг бусдаасаа илүү сонгожээ. 2005 оны судалгааны дүнтэй харьцуулбал, 1.5-2 сая төгрөг гэсэн хариулт бүх насны иргэдийн хувьд нэмэгдсэн байна.

**Хүснэгт III.7.6.** Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар хугацаа шаардагдах вэ?

Насны бүлэг		3 сар хүртэлх	3-6 сар	6-9 сар	9 сараас 1 жил хүртэлх
		хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	12.7	18.0	17.9	51.3
	2006	13.8	17.9	19.4	48.9
	Өөрчлөлт	1.1	-0.1	1.5	-2.4
25-34	2005	6.5	14.3	17.2	62.1
	2006	7.8	13.4	17.1	61.6
	Өөрчлөлт	1.3	-0.9	-0.1	-0.5
35-44	2005	7.1	14.4	15.8	62.7
	2006	6.1	14.1	15.8	64.0
	Өөрчлөлт	-1.0	-0.3	0.0	1.3
45-54	2005	5.5	12.6	16.9	65.0
	2006	6.0	10.0	16.5	67.4
	Өөрчлөлт	0.5	-2.6	-0.4	2.4
55-64	2005	7.2	13.0	15.9	63.9
	2006	7.1	13.9	16.0	63.0
	Өөрчлөлт	-0.1	0.9	0.1	-0.9
65 дээш	2005	5.6	9.9	21.1	63.4
	2006	9.7	17.7	14.2	58.4
	Өөрчлөлт	4.1	7.8	-6.9	-5.0
Бүгд	2005	7.7	14.6	16.9	60.8
	2006	8.1	13.9	16.9	61.1
	Өөрчлөлт	0.4	-0.7	0.0	0.3

Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар хугацаа шаардлагатай вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 61.1 хувь нь 9 сараас 1 жил хүртэл, 16.9 хувь нь 6-9 сар, 13.9 хувь нь 3-6 сар гэсэн хариултыг тус тус сонгожээ. Насны ангиллаар авч үзвэл, бүх насны иргэдийн дийлэнх 9 сараас 1 жил хүртэлх хугацааг бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад шаардлагатай гэж үзэж байгаа ба ялангуяа, 25-аас дээш бүх насныхны хувьд тус хариултын хувийн жин өндөр байна. 6-9 сарыг 65-аас доош бүх насны иргэд үүний дараа сонгосон бол 65-аас дээш насныхан 3-6 сарыг сонгожээ. Ерөнхийдөө хугацаа уртсах тусам аль ч насны ангилал дахь иргэдийн хувийн жин өссөн байна.

**Хүснэгт III.7.7.** Бичил бизнесийн үйл ажиллагаа явуулахад банк, санхүүгийн байгууллагын зүгээс танд ямар хүндрэл учруулж байна вэ?

2005		Зээлийн хүү өндөр	Зээлийн хэмжээ бага	Зээл авах боломж байхгүй	Зээлийн хугацаа хангалтгүй байна	Бусад
		хувь	хувь	хувь	хувь	хувь
25 доош	2005	54.6	8.9	11.8	14.2	10.4
	2006	46.6	12.1	11.5	18.4	11.5

	Өөрчлөлт	-8.0	3.2	-0.3	4.2	1.1
25-34	2005	56.7	9.8	10.0	14.8	8.7
	2006	48.5	14.9	10.7	19.8	6.1
	Өөрчлөлт	-8.2	5.1	0.7	5.0	-2.6
35-44	2005	59.6	11.3	9.4	12.8	7.0
	2006	51.1	16.0	11.4	16.8	4.7
	Өөрчлөлт	-8.5	4.8	2.0	4.0	-2.3
45-54	2005	60.1	12.0	10.6	12.3	5.0
	2006	46.9	16.6	11.5	20.3	4.6
	Өөрчлөлт	-13.2	4.6	0.9	8.0	-0.4
55-64	2005	58.8	11.1	12.2	11.1	6.8
	2006	49.4	16.9	9.2	17.5	7.0
	Өөрчлөлт	-9.4	5.8	-3.0	6.4	0.2
65 дээш	2005	60.8	6.8	12.2	12.2	8.1
	2006	39.6	16.2	16.2	21.4	6.5
	Өөрчлөлт	-21.2	9.4	4.0	9.2	-1.6
Бүгд	2005	57.8	10.5	10.5	13.5	7.8
	2006	48.5	15.2	11.2	18.8	6.4
	Өөрчлөлт	-9.3	4.7	0.7	5.3	-1.4

Бичил бизнесийн үйл ажиллагаа явуулахад банк, санхүүгийн байгууллагын зүгээс танд ямар хүндрэл учруулж байна вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын 48.5 хувь нь зээлийн хүү өндөр, 18.8 хувь нь зээлийн хугацаа хангалтгүй, 15.2 хувь нь зээлийн хэмжээ бага, 11.2 хувь нь зээл авах боломж байхгүй гэж тус тус хариулжээ. Насны ангиллаар авч үзвэл, зээлийн хүү өндөр гэсэн хариултыг 35-44 насныхан хамгийн их (51.1), 65-аас дээш насныхан хамгийн бага (39.6) өгчээ. Харин 55-64 насныхан зээлийн хэмжээ бага гэсэн хариултыг, 65-аас дээш насныхан зээл авах боломж байхгүй болон зээлийн хугацаа хангалтгүй байна гэсэн хариултыг, 25-аас доош насныхан мэдэхгүй гэсэн хариултыг бусдаасаа илүүтэйгээр сонгосон байна. 2005 оны судалгааны дүнтэй харьцуулбал зээлийн хүү өндөр гэсэн хариулт 9.3 нэгжээр буурч, зээлийн хугацаа хангалтгүй гэсэн хариулт 5.3 нэгжээр, зээлийн хэмжээ бага гэсэн хариулт 4.7 нэгжээр, зээл авах боломж байхгүй гэсэн хариулт 0.7 нэгжээр тус тус өсчээ.

### III. 8. Мөнгөн тэмдэгтийн талаар

*Хүснэгт III.8.1. Танд 1-т болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байдаг уу?*

2006	Тийм	Үгүй	Мэдэхгүй
	хувь	хувь	хувь
25 доош	26.8	63.5	9.7
25-34	23.6	68.6	7.9
35-44	25.8	66.3	7.9
45-54	27.1	64.9	8.0
55-64	25.1	66.7	8.3
65 дээш	35.9	57.7	6.3
Бүгд	25.7	66.1	8.2

Танд 1-т болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд бүх насны судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 57.5-68.6 хувь нь үгүй, 22.6-35.9 хувь нь тийм, 6.3-9.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. 65-аас дээш насны иргэд хэрэгцээ байдаг гэсэн хариултыг бусдаасаа илүү сонгосон бол хэрэгцээ байдаггүй гэсэн хариултыг 25-34 насныхан илүү өгчээ.

**Хүснэгт III.8.2.** Танд 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу?

2006	Тийм	Үгүй	Мэдэхгүй
	хувь	хувь	хувь
25 доош	38.7	48.4	12.9
25-34	27.4	60.5	12.1
35-44	28.8	58.4	12.7
45-54	30.4	56.4	13.2
55-64	32.6	55.0	12.4
65 дээш	29.9	55.6	14.6
Бүгд	30.6	56.8	12.6

Танд 50-т, 100-т, 200-т, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 56.8 хувь нь үгүй, 30.6 хувь нь тийм, 12.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Насны ангиллаар авч үзэхэд 25-аас доош насныхан дээрх мөнгөний хэрэгцээ арай илүү байдаг гэж хариулсан бол 25-34 насныхан хамгийн их хэрэгцээгүй гэж үзсэн байна.

**Хүснэгт III.8.3.** Танд удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа юу?

2006	Тийм	Үгүй	Мэдэхгүй
	хувь	хувь	хувь
25 доош	37.9	50.4	11.7
25-34	36.1	52.8	11.1
35-44	37.1	50.2	12.7
45-54	37.8	50.6	11.5
55-64	32.6	55.6	11.7
65 дээш	26.7	60.3	13.0
Бүгд	36.5	51.7	11.8

Санал асуулгад оролцогчдын 51.7 хувь нь удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байхгүй, 36.5 хувь нь байгаа, 11.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Насны ангиллаар авч үзэхэд 55-аас доош бүх насныхны хувьд ойролцоо хариулттай байна. Харин 55-аас дээш насны иргэдийн хэрэгцээгүй гэсэн хариулт бусдаасаа арай өндөр хувийн саналтай байна.

**Хүснэгт III.8.4.** Танд гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг уу?

2006	Тийм	Үгүй	Мэдэхгүй
	хувь	хувь	хувь
25 доош	76.1	14.6	9.4
25-34	76.3	13.8	9.9
35-44	74.2	15.1	10.8
45-54	73.6	15.5	10.9
55-64	71.3	15.8	12.9
65 дээш	70.8	16.7	12.5
Бүгд	74.8	14.8	10.5

Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж ямар ч насны санал асуулгад оролцогчдын дийлэнх буюу 70.8-76.1 хувь, таалагддаггүй гэж 13.8-16.7 хувь нь хариулсан байна. Ялангуяа, 34 хүртэлх насны иргэд таалагддаг гэж хамгийн их саналыг өгчээ. Харин мэдэхгүй гэж нийт санал асуулгад оролцогчдын 10.5 хувь хариулснаас 55-аас дээш насныхны хариулт арай өндөр хувьтай байв.

**Хүснэгт III.8.5.** Таны 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддаг уу?

2006	Тийм	Үгүй	Мэдэхгүй
	хувь	хувь	хувь
25 доош	76.4	17.1	6.5
25-34	73.3	20.8	5.9
35-44	71.6	21.6	6.8
45-54	68.6	24.1	7.3
55-64	72.1	23.2	4.7
65 дээш	72.2	20.8	6.9
Бүгд	72.4	21.1	6.4

Бүх насны санал асуулгад оролцогчдын дийлэнх (68.6-76.4) хувь нь өөрсдийн 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддаг гэж хариулсан бол 17.1-24.1 хувь нь хангагддаггүй, 4.7-7.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. 25-аас доош насныхны хангагддаг гэсэн хариулт, 45-54 насны иргэдийн үгүй гэсэн хариулт тус бүрийн хариултынхаа хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг 45-54 насныхан бусдаасаа арай илүү өгчээ.

**Хүснэгт III.8.6.** Та гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг үү?

2006	Тийм	Үгүй	Мэдэхгүй
	хувь	хувь	хувь
25 доош	44.3	42.3	13.4
25-34	43.0	45.1	11.9
35-44	47.7	40.7	11.5
45-54	48.7	40.4	11.0
55-64	47.0	41.2	11.8
65 дээш	50.0	36.1	13.9
Бүгд	45.9	42.2	11.9

Та гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг үү гэсэн асуултанд бүх насны санал асуулгад оролцогчдын 45.9 хувь тийм, 42.2 хувь үгүй, 11.9 хувь мэдэхгүй гэж тус тус хариулжээ. Насны ангиллаар авч үзвэл, 25-34 наснаас бусад иргэдийн хувьд гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанаргүй гэж үзсэн иргэд эдэлгээ даах чанаргүй гэж үзсэн иргэдээс олон байгаа бол 25-34 насныхны хувьд эсрэгээрээ байв. Мөн насны ангилал ахих тутам ийт гэсэн хариултын хувийн жин өсөх хандлагатай байна. Харин мэдэхгүй гэсэн хариултыг 25-аас доош болон 65-аас дээш насны иргэд арай илүү хувьтай хариултыг өгсөн бол бусад насны иргэдийн ойролцоо хувь уг хариултыг өгчээ.

**Хүснэгт III.8.7.** Та хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг уу?

2006	Тийм	Үгүй	Мэдэхгүй
------	------	------	----------

	хувь	хувь	хувь
25 доош	23.9	64.7	11.5
25-34	26.3	61.7	12.0
35-44	24.4	60.0	15.6
45-54	27.3	57.7	15.1
55-64	23.7	59.1	17.2
65 дээш	25.7	47.2	27.1
Бүгд	25.4	60.6	14.1

Бүх насны иргэдийн дийлэнх хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаггүй гэж хариулсан байна. Харин чаддаг гэсэн хариултыг иргэдийн 23.7-27.3 хувь өгчээ. Мэдэхгүй гэж нийт иргэдийн 14.1 хувь хариулснаас 65-аас дээш насныхны хариулт өндөр хувьтай байна.

### *Хүснэгт III.8.8. Та мөнгөө түрүүвчинд хийж, цэвэрхэн авч явдаг уу?*

2006	Тийм	Үгүй	Мэдэхгүй
	хувь	хувь	хувь
25 доош	84.8	11.1	4.1
25-34	85.7	10.4	3.9
35-44	87.1	9.6	3.3
45-54	86.6	10.3	3.1
55-64	84.6	10.2	5.2
65 дээш	84.0	13.9	2.1
Бүгд	86.0	10.4	3.7

Та мөнгөө түрүүвчинд хийж, цэвэрхэн авч явдаг уу гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын 86 хувь нь тийм, 10.4 хувь нь үгүй гэж хариулсан бол 3.7 хувь нь мэдэхгүй гэжээ. Дээрх асуултанд хариулсан байдал насны ангиллын хувьд бага ялгаатай боловч 25-аас доош болон 55-аас дээш насныхны хувьд мөнгөө түрүүвчинд хийж явдаг байдал арай бага байна.

### **ДҮГНЭЛТ**

Насны ангиллаар авч үзсэн судалгааны ихэнх асуултын хариулт ойролцоо, өөрөөр хэлбэл аль ч насны ангиллын хүмүүсийн ихэнх хариултын хувийн жин хоорондоо ижил төстэй байв. Мөн ихэнх хариултуудын ерөнхий хандлага өмнөх судалгаатай ижил байлаа.

Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдлыг судалгаанд идэвхтэй оролцсон 25-54 насны иргэдийн дийлэнх хэвэндээ болон муудсан гэж үзсэн хэвээр байна. Харин 25-аас доош, 55-аас дээш насны иргэдийн дийлэнх сайжирсан буюу хэвэндээ гэж үзэх болжээ. Ямар ч насны иргэдийн дийлэнх үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, зээлийн хүүг бууруулах, татварын ачааллыг багасгах арга хэмжээнүүдийг эдийн засгийн өсөлтийг хангахад чухал гэж өмнөх судалгаатай адил үзсэн хэвээр байна. Харин бизнесменүүдэд урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг сонгосон иргэд харьцангуй цөөн байв. Энэ нь дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжих, тэдний ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг иргэд хүсч байгааг илтгэж байгаагийн нэг илрэл юм. Аль ч насны ангиллын иргэд уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудыг эдийн засгийг хөгжүүлэхэд чухал гэж 2005 оны судалгаатай адил үзжээ. Харин банк санхүү, худалдаа үйлчилгээний салбарыг харьцангуй цөөнх сонгосон байв. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад

бүх насныхны уул уурхайн салбар гэсэн хариулт өсч, бусад салбарууд бага зэрэг буурсан байна.

Өргөн хэрэглээний барааны үнэ өсч байна гэж өмнөх судалгааны нэг адил бүх насны иргэдийн дийлэнх үзэж байна. Өөрийн өрхийн амьжиргааны түвшинг ямар ч насны иргэдийн ихэнх хувь нь хэвэндээ гэж үзсэн байна. 2005 оны судалгаатай харьцуулбал, өрхийн амьжиргааны түвшингээ доошилсон гэж үзэж буй иргэдийн хариулт буурч, дээшилсэн болон хэвэндээ гэж үзсэн иргэд нэмэгдсэн байна. Харин хүн амын ядуурал болон ажилгүйчүүдийн тоо нэмэгдсэн гэж ямар ч насны иргэдийн дийлэнх үзэж байгаа хэвээрээ байгаа хэдий ч өмнөх судалгааны дүнгээс бүх насны ангилалд хүн амын ядуурал нэмэгдэж, ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзэж буй иргэдийн хувийн жин буурч, энэ хэмжээгээр тэдний хэвэндээ, буурсан гэсэн хариултууд нэмэгдсэн байна. Бүх насны иргэдийн олонх урьдын адил газар хувьчлалыг дэмжиж байгаа боловч өмнөх судалгааны дүнгээс насны ангилал бүрт хувийн жин нь буурчээ.

Нийт иргэд (аль ч насны) татварын ерөнхий түвшинг өндөр, татварын ачаалал нэмэгдсэн, татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж үзсэн хэвээр байгаа ч татварын ерөнхий түвшин өндөр, татварын ачаалал нэмэгдсэн гэж үзсэн иргэдийн хувийн жин бүх насны ангилалд буурсан байна. Харин татвараас зайлсхийх явдал нийтлэг гэсэн хариулт 25-аас дээш бүх насны иргэдийн дунд нэмэгджээ.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог өмнөх судалгааны нэг адил боломжийн байна гэж судалгаанд хамрагдсан 65 хүртэлх насны бүх насны ангилал дахь иргэдийн дийлэнх үзэж байгаа бөгөөд 2005 оныхоос хувийн жин нь насны ангилал бүрт өсчээ. Түүнчлэн олон гэж хариулсан иргэдийн хувь нэлээд хувийг (38.6) эзэлж байгаа хэвээрээ байгаа ба насны ангилал ахих тусам нэмэгдэх хандлагатай байлаа. Бүх насны иргэдийн дийлэнх банк санхүүгийн үйл ажиллагааг найдвартай, тэдэнд итгэх итгэл нэмэгдсэн буюу хэвэндээ, тэдгээр нь өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна, тэдний үйлчилгээ хэвийн байна гэж үзсэн хэвээр байгаа төдийгүй тэдгээрийн үйл ажиллагааг найдвартай, үйлчилгээ нь хувь хүнд хүрч, хэвийн гэж үзэж байгаа байдал өмнөх судалгааны дүнгээс бүх насны ангилалд нэмэгдсэн байна. Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа нь эргэлзээтэй гэсэн хариулт ямар ч насны иргэдийн хувьд харьцангуй өндөр хэвээр байгаа хэдий ч өмнөх судалгаанаас бүх насны ангилалд багассан байна. Мөнгөний хэрэгцээ гарвал банкинд ханддаг гэж судалгаанд хамрагдсан бүх насны оролцогчдын дийлэнх хариулсан хэвээр байгаа төдийгүй өмнөх судалгаанаас насны ангилал бүрт нэмэгдсэн байна. Үүний дараагаар хувь хүн, ломбарданд хандана гэсэн хариулт аль ч насны ангилалд орж байгаа боловч хувь хүн, ломбард, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллага гэсэн хариултууд өмнөх судалгаанаас багассан байна. Нийт иргэдийн 30-аад хувь нь банк бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг гэсэн бөгөөд бүх насны иргэдийн хувьд энэ нь өмнөх судалгааны дүнгээс багассан байна. Хадгаламж зээлийн хоршоодын талаархи мэдлэг нийт иргэдийн дунд өмнөх судалгаанаас багассан харагдаж байгаа бөгөөд нийт санал асуулгад оролцсон бүх насны иргэдийн дийлэнх хувь нь хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголтгүй эсвэл мэдэхгүй гэж хариулжээ. Судалгаанд хамрагдагсадын 10 хувь нь ямар нэгэн хадгаламж зээлийн хоршооны гишүүн бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 65-аас доош бүх насныхны хувьд хувийн жин нь бага зэрэг буурсан байна. Тэдний үйл ажиллагааг бүх насны ангиллаарх ихэнх иргэд (49.7) дүгнэж чадахгүй байна. Гэвч зөв хуулийн дагуу гэсэн хариулт 11.2 нэгжээр буурч, буруу, хууль бус гэсэн хариулт 18 нэгжээр өссөн нь иргэд хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж байгааг



харуулж байна. Гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж бүх насны иргэдийн дийлэнх хувь үзсэн хэвээр байгаа боловч тэдгээрийн хувийн жин буурч, ач холбогдолгүй гэж үзсэн иргэдийнх өссөн байна. 2005 оныхоос бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгаа ч нийт иргэдийн дийлэнх бүх насны ангилалд хэрэглэдэггүй хэвээр байна. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг 25-34 насныхан хамгийн их хэрэглэдэг бөгөөд насны ангилал өсөх тусам хэрэглээ буурах хандлагатай байлаа.

Хуримтлуулсан мөнгөө банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, бусад байдлаар зарцуулдаг гэсэн хариултыг бүх насны ангилал дахь иргэд түлхүү сонгосон хэвээр байгаа бөгөөд өмнөх судалгаанаас банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг гэсэн хариулт бүх насны иргэдийн дунд өсч, бусад хариултууд буурсан байна. Бусдад зээлдүүлэх, хувьцаа худалдаж авах, үнэт цаасанд байршуулах явдал нийт иргэдийн дунд өмнөх судалгаатай адил бага байна. Мөнгөө бэлнээр үүн дотроо төгрөгөөр хадгалах сонирхол аль ч насны иргэдийн дунд өндөр хэвээр байгаа төдийгүй судалгаанд идэвхтэй оролцсон 45 хүртэлх насны иргэдийн бэлэн мөнгөөр байршуулахыг илүүд үздэг гэсэн хариултын хувийн жин өссөн байна. Харин энэ насны иргэдийн төгрөгөөр хадгалдаг гэсэн хариултын хувийн жин буурч, бусад валютаар, ялангуяа, америк доллараар гэсэн хариулт нэмэгджээ. Хадгаламжийн хүүг аль ч насны иргэдийн дийлэнх бага гэж үзсээр байгаа боловч хувийн жин нь өмнөх судалгаанаас буурч, тэдний боломжийн гэсэн хариултын хувь 35-44 наснаас бусад насныхны хувьд өссөн байна.

Бүх насны иргэдэд зээлийн хэрэгцээ өндөр хэвээр байгаа ба тэдний 42.9 хувь банк санхүүгийн байгууллагаас олгож буй зээлийг хүртээмжтэй гэж дүгнэдэг ч 37.5 хувь нь хүртээмжгүй гэж үзсэн байна. Гэвч банк, санхүүгийн байгууллагаас олгож буй зээл хүртээмжгүй гэсэн хариулт 25-34 наснаас бусад насны иргэдийн хувьд буурчээ. Мөн зээл авахад хүндрэлтэй, зээлийн хүү өндөр гэж үзэж байгаа хэвээр байна. 2005 оны судалгаанаас зээл авахад хүндрэлтэй гэж үзсэн иргэдийн хувийн жин бүх насны ангилалд өсч, зээлийн хүүг өндөр гэж үзсэн иргэдийн хувийн жин ихэнх насны ангилалд (45-54 насны иргэдийн хувьд өөрчлөгдөөгүй, 25-аас доош насны иргэдийн хувьд буурав) нэмэгдсэн байна.

Ихэнх иргэд бичил санхүүгийн талаар ойлголтой ба өөрийн оршин суугаа газрынхаа бичил санхүүгийн үйл ажиллагааг дунд зэрэг хөгжсөн гэж дүгнэжээ. Бүх насны иргэдийн олонхи бичил зээл авах боломжтой гэсэн хариулт өгсөн бөгөөд бичил зээл авдаг иргэдийн ихэнх худалдаа наймаанд зээлээ зарцуулсан хэвээр байна. Мөн 65-аас дээш насны иргэд газар тариалан, хүнсний ногоо, мал аж ахуй, аялал жуулчлал, 45-аас дээш насныхан мал аж ахуй, 45-64 насныхан жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг гэж хариулсан байна. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 1.5-2 сая гэж судалгаанд оролцсон бүх насны иргэдийн олонхи хариулсан бөгөөд энэ нь өмнөх судалгаанаас бүх ангилалд өсчээ. Мөн 250-500 мянга, 500 мянгаас 1 сая, 1-1.5 сая төгрөг шаардлагатай гэж үзэж буй иргэд бүх насны ангилалд хувийг эзэлж байна. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9-12 сар шаардагдах бөгөөд зээлийн хүү өндөр гэж бүх насны иргэдийн дийлэнх 2005 оныхтой адил үзсээр байна.

Бүх насны иргэдийн дийлэнх бага дэвсгэрт (1-т, 5-т)-үүд болон зоосон мөнгөний хэрэгцээгүй гэж хариулсан бөгөөд тэдний 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддаг гэжээ. Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ бүх насны иргэдийн дийлэнх хэрэгцээгүй гэж хариулсан байна. Мөн тэдний ихэнхэд нь гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн

хийц, дизайн талаалагддаг юм байна. Харин гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үзсэн иргэд олон байгаа ч чанаргүй гэж үзсэн иргэд цөөнгүй байлаа. Аль насны ангилал дахь иргэд харилцагч банкнаас хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ авч чаддаггүй гэж хариулжээ.

## IV. БОЛОВСРОЛ

Нийгэм эдийн засгийн болон банк, санхүүгийн салбарын талаархи иргэдийн санаа бодол боловсролоос хамааран ялгавартай байж болох талтай. Энэ ялгааг гарган харуулахын тулд санал асуулганд оролцогчдыг боловсролынх нь байдлаар ангилан, 2005 оны байдалтай харьцуулснаар авч үзлээ. Иргэдийн боловсролын хамрагдалт нь бүс нутаг, эсвэл нийгмийн бүлгүүдээр ихээхэн ялгаатай байдаг. Латин Америкийн орнуудын хийсэн судалгаанаас үзэхэд газрын хуваарилалтаас илүү боловсролын хамрагдалтын тэгш бус байдал нь нийгмийн тэгш бус байдлыг бий болгодог гол хүчин зүйл ажээ. Монгол улс 1989 ба 2000 оны хүн амын тооллогын хооронд боловсролтой хүмүүсийн эзлэх хувийн жин 0.2 хувиар, дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 0.6 хувиар өсч, бага болон бүрэн бус дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувийн жин буурчээ. Энэхүү өөрчлөлт нь шилжилтийн жилүүдэд бага, дунд боловсролын түвшинд сургууль завсардалт нэмэгдэж, дээд боловсрол эзэмших эрэлт хэрэгцээ өссөнтэй холбоотой. Манай судалгаанд оролцсон иргэдийн 45.8 хувийг дээд, 16.2 хувийг тусгай дунд, 26.0 хувийг бүрэн дунд, 12.0 хувийг бүрэн бус дунд боловсролтой иргэд эзэлж байна.

		Улсын байгууллагад	Хувийн байгууллагад	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	Ажилгүй	Бусад
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2006	22.1	19	20.9	29.9	8.1
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2006	18.7	22.3	25.9	23	10.1
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2006	29.6	20.4	30.4	14.4	5.2
<b>Дээд боловсролтой</b>	2006	39.3	33.2	14.5	7	6
<b>Бүгд</b>	2006	30.3	26.6	20.8	15.1	7.2

Санал асуулганд хамрагдсан иргэдийн 30.3 хувь нь улсын байгууллагад ажилладаг, 26.6 хувь нь хувийн байгууллагад, 20.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 15.1 хувь нь ажилгүй хүмүүс оролцож, өөрсдийн санал бодлоо өгчээ. Ялангуяа улсын байгууллагад ажилладаг дээд болон тусгай дунд боловсролтой иргэд, хувийн байгууллагад ажилладаг дээд боловсролтой иргэд, хувиараа хөдөлмөр эрхэлдэг тусгай дунд боловсролтой иргэд, бүрэн бус дунд боловсролтой ажилгүйчүүд хамгийн их судалгаанд хамрагдсан байна.

## IV.1. Эдийн засгийн ерөнхий асуудлууд

Хүснэгт IV.1.1. Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал таны бодлоор?

		Сайжирч	Муудаж	Хэвэндээ	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	24.6	30.8	32.9	11.6
	2006	22.5	32.1	34.8	10.6
	<i>Өөрчлөлт</i>	-2.1	1.3	1.9	-1
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	20.1	30.4	37.9	11.6
	2006	21.7	30.9	35.1	12.2
	<i>Өөрчлөлт</i>	1.6	0.5	-2.8	0.6

<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	24.9	34	34.5	6.7
	2006	24.9	32.1	35	8
	<i>Өөрчлөлт</i>	0	-1.9	0.5	1.3
<b>Дээд боловсролтой</b>	2005	29.7	28	37	5.4
	2006	29.8	28	36.9	5.3
	<i>Өөрчлөлт</i>	0.1	0	-0.1	-0.1
<b>Бүгд</b>	2005	25.1	30.3	36.2	8.3
	2006	26	29.9	35.9	8.2
	<i>Өөрчлөлт</i>	0.9	-0.4	-0.3	-0.1

Өнөөгийн эдийн засгийн байдал сайжирсан гэж бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 22.5 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 21.7 хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 24.9 хувь, дээд боловсролтой иргэдийн 29.8 хувь нь үзэж байгаа нь 2005 оныхоос бүрэн бус дунд боловсролтой иргэдийн хариулт 2.1 нэгжээр буурч, тусгай дунд боловсролтой иргэдийн хариулт өмнөх оны түвшинд байна. Харин бүрэн дунд боловсролтой иргэдийн хариулт 1.6 нэгжээр, дээд боловсролтой иргэд 0.1 нэгжээр тус тус өсчээ.

Харин тус асуултанд бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 32.1 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 30.9 хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 32.1 хувь, дээд боловсролтой иргэдийн 28.0 хувь нь муудсан гэж хариулсан нь 2005 оныхоос бүрэн бус дунд боловсролтой иргэдийн хариулт 1.3 нэгжээр, бүрэн дунд боловсролтой иргэдийнх 0.5 нэгжээр тус тус өсч, тусгай дунд боловсролтой иргэдийнх 1.9 нэгжээр буурч, дээд боловсролтой иргэдийн хариулт өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна.

Тус асуултанд хэвэндээ, мэдэхгүй гэж 2005, 2006 оны судалгаанд оролцогчид ангилал тус бүртээ ойролцоо хувиар хариулсан байна. Дээд боловсролтой иргэдийн 36.9 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 35.1 хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 35.0 хувь, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 34.8 хувь нь хэвэндээ гэж хариулжээ. Бүрэн дунд боловсролтой иргэдийн 12.6, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 10.6 хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 8.0 хувь, дээд боловсролтой иргэдийн 5.3 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал таны бодлоор гэсэн асуултанд оролцсон бүх шатны боловсролтой иргэдийн хариулт 2005 оныхоос сайжирсан гэсэн хариулт 0.9 нэгжээр өсч, бусад хариултауд нь 0.1-0.4 нэгжээр буурчээ.

Хүснэгт IV.1.2. Таны бодлоор эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай гэж вэ?

		Татварын ачааллыг багасгах	Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх	Зээлийн хүүг бууруулах	Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих	Бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх	Бусад
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	43.7	16.4	37.7	42	11.3	2.6
	2006	41.1	17.5	35.7	39.7	13.1	3.2
	<i>Өөрчлөлт</i>	-2.6	1.1	-2	-2.3	1.8	0.6
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	40.7	15.7	42.7	45.3	11.6	3.7
	2006	34.4	17.7	39.5	44.6	13.3	2.4

	<i>Өөрчлөлт</i>	-6.3	2	-3.2	-0.7	1.7	-1.3
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	44.8	20.2	44.9	50	14.6	2.7
	2006	41.5	19.2	43.9	46.4	16.5	2.5
	<i>Өөрчлөлт</i>	-3.3	-1	-1	-3.6	1.9	-0.2
<b>Дээд боловсролтой</b>	2005	46.7	26	43.7	53.8	15	3
	2006	45.8	23	44.7	51.2	15.3	2.6
	<i>Өөрчлөлт</i>	-0.9	-3	1	-2.6	0.3	-0.4
<b>Бүгд</b>	2005	44.1	20.5	42.9	49	13.4	3.1
	2006	41.6	20.3	42.1	47.3	14.7	2.6
	<i>Өөрчлөлт</i>	-2.5	-0.2	-0.8	-1.7	1.3	-0.5

Таны бодлоор эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай байна вэ гэсэн асуултанд иргэд нэгээс дээш санал өгсөн бөгөөд нийт санал асуулгад оролцогчдын 47.3 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 42.1 хувь нь зээлийн хүүг бууруулах, 41.6 хувь нь татварын ачааллыг багасгах, 20.3 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, 14.7 хувь нь бизнесменүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх гэж үзсэн байна. Бүх шатны боловсролтой иргэдийн Бизнесменүүдэд урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг сонгосон хариулт 2005 оныхоос өссөн байхад бусад арга хэмжээнүүдийнх буурсан байна. Ерөнхийдөө аль ч судалгаанд оролцсон ямар ч боловсролтой иргэдийн дийлэнх үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, татварын ачааллыг багасгах, зээлийн хүүг бууруулах арга хэмжээнүүдийг эдийн засгийн өсөлтийг хангахад чухал гэж үзжээ. Харин бизнесменүүдэд урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг сонгосон иргэд харьцангуй цөөн байлаа.

Хүснэгт IV.1.3. Таны бодлоор ямар салбар манай улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх вэ?

		Уул уурхай	Хөдөө аж ахуй	Хөнгөн үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Банк санхүү	Худалдаа үйлчилгээ	Бусад
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	32.7	40.1	18.9	19.5	16.1	13.9	4.1
	2006	45.9	36.0	17.3	18.1	14.8	14.0	4.0
	<i>Өөрчлөлт</i>	13.2	-4.1	-1.6	-1.4	-1.3	0.1	-0.1
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	37.4	42.7	20.6	25.8	16.6	15.3	4.8
	2006	44.2	35.3	18.5	24.2	14.1	13.6	3.1
	<i>Өөрчлөлт</i>	6.8	-7.4	-2.1	-1.6	-2.5	-1.7	-1.7
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	41.6	42.1	25.7	30.1	18.5	15.6	2.4
	2006	46.8	38.2	23.1	28.4	16.1	14.7	2.7
	<i>Өөрчлөлт</i>	5.2	-3.9	-2.6	-1.7	-2.4	-0.9	0.3
<b>Дээд боловсролтой</b>	2005	46.6	46.1	27.4	38.6	17.3	13.7	3.3
	2006	56.9	41.7	24.5	32.6	14.6	12.6	2.9
	<i>Өөрчлөлт</i>	10.3	-4.4	-2.9	-6.0	-2.7	-1.1	-0.4
<b>Бүгд</b>	2005	41.1	43.5	23.9	30.6	17.2	14.6	3.7
	2006	50.7	38.8	21.9	28.0	14.7	13.4	3.1
	<i>Өөрчлөлт</i>	9.6	-4.7	-2.0	-2.6	-2.5	-1.2	-0.6

Таны бодлоор ямар салбар манай улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх вэ гэсэн асуултанд иргэд мөн нэгээс дээш санал өгсөн бөгөөд бүх шатны боловсролтой иргэдийн 50.7 хувь, дээд боловсролтой иргэдийн 56.9 хувь, бүрэн бус, бүрэн дунд

болон тусгай дунд боловсролтой иргэдийн 40-өөс дээш хувь нь уул уурхай, мөн дээд боловсролтой иргэдийн 41.7 хувь, бүрэн бус, бүрэн дунд болон тусгай дунд боловсролтой иргэдийн 35-аас дээш хувь, нь хөдөө аж ахуй, дээд боловсролтой иргэдийн 32.6 хувь нь аялал жуулчлалын салбарыг тус тус сонгосон нь өндөр хувийг эзэлж байна. Харин бүх шатны боловсролтой иргэд банк санхүү, худалдаа үйлчилгээний салбаруудад харьцангуй бага санал өгсөн байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад уул уурхайн салбарыг чухал гэж үзсэн иргэд бүх шатанд (5.2-13.2 нэгжээр) нэмэгдэж, бусад салбарт өгсөн санал (0.1-7.4 нэгжээр) буурчээ.

Хүснэгт IV.1.4. Өргөн хэрэглээний барааны үнэ таны бодлоор

		өсч	буурч	тогтвортой	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	89.7	2.8	5.2	2.2
	2006	89.6	2.9	4.1	3.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.1</i>	<i>0.1</i>	<i>-1.1</i>	<i>1.2</i>
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	90.1	1.6	5.8	2.5
	2006	88.4	3.1	5.7	2.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.7</i>	<i>1.5</i>	<i>-0.1</i>	<i>0.3</i>
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	91.5	1.6	5.8	1.1
	2006	88.6	3.1	6.2	2.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>-2.9</i>	<i>1.5</i>	<i>0.4</i>	<i>0.9</i>
<b>Дээд боловсролтой</b>	2005	91.4	1.1	6.2	1.3
	2006	92.6	1.0	5.2	1.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.2</i>	<i>-0.1</i>	<i>-1.0</i>	<i>-0.1</i>
<b>Бүгд</b>	2005	90.8	1.6	5.9	1.7
	2006	90.5	2.1	5.4	2.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.3</i>	<i>0.5</i>	<i>-0.5</i>	<i>0.3</i>

Энэ удаагийн судалгааны дүн боловсролын аль ч ангиллаар авч үзсэн 2005 оныхтой ойролцоо байлаа. Тухайлбал, өргөн хэрэглээний барааны үнэ өсч байна гэж нийт иргэдийн 90 гаруй хувь хариулсан бол ердөө 5.4 хувь нь үнэ тогтвортой байна гэж үзжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бүх боловсролын шатлал дахь (дээд боловсролтой иргэдийг оролцуулахгүй) өсч байна гэсэн хариулт 0.1-2.9 нэгжээр, тогтвортой байна гэсэн хариулт 0.1-1.1 нэгжээр буурсан байхад буурч байна гэсэн хариулт 0.1-1.0 нэгжээр, мэдэхгүй гэсэн хариулт 0.3-1.2 нэгжээр тус тус өссөн байна.

## IV.2. Нийгмийн тулгамдсан асуудлууд

Хүснэгт IV.2.1. Танай өрхийн амьжиргааны түвшин

		Дээшилсэн	Доошилсон	Хэвэндээ	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	16.0	33.6	46.8	3.6
	2006	15.9	30.5	50.7	2.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.1</i>	<i>-3.1</i>	<i>3.9</i>	<i>-0.7</i>
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	15.0	32.6	49.4	2.9
	2006	17.1	25.9	54.5	2.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>2.1</i>	<i>-6.7</i>	<i>5.1</i>	<i>-0.4</i>
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	15.2	33.9	49.2	1.7
	2006	16.5	31.8	50.3	1.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.3</i>	<i>-2.1</i>	<i>1.1</i>	<i>-0.3</i>

<b>Дээд боловсролтой</b>	2005	18.7	29.8	50.5	1.0
	2006	22.9	23.6	51.8	1.7
	<i>Өөрчлөлт</i>	4.2	-6.2	1.3	0.7
<b>Бүгд</b>	2005	16.5	32.0	49.4	2.1
	2006	19.5	26.3	52.1	2.0
	<i>Өөрчлөлт</i>	3.0	-5.7	2.7	-0.1

Өөрийн өрхийн амьжиргааны түвшинг нийт иргэдийн 52.1 хувь нь хэвэндээ, 26.3 хувь нь доошилсон, 19.5 хувь нь дээшилсэн гэж үзэж байгаа нь 2005 оны судалгааны дүнгээс дээшилсэн болон хэвэндээ гэж үзэж буй иргэдийн хувийн жин 3.0, 2.7 нэгжээр тус бүр өссөн бол энэ хэмжээгээр (5.7 нэгжээр) доошилсон гэж үзэж буй иргэдийн хувийн жин буурчээ. Мэдэхгүй гэж хариулсан иргэдийн хариулт өмнөх оныхтой ойролцоо байна.

Иргэдийн боловсролын түвшин ахих тутам өөрийн өрхийн амьжиргааны түвшинг хэвэндээ гэж хариулах иргэдийн хувийн жин нэмэгдэх хандлагатай (50.3-54.5) байна. Тус асуултанд 2005 онд ямар ч боловсролтой иргэд ойролцоо буюу 46.8-50.5 хувьтай хариултыг өгч байжээ.

Доошилсон гэсэн хариултыг дээд боловсролтой иргэдийн 23.6 хувь, бусад иргэдийн 30 орчим хувь өгсөн нь 2005 оныхоос бүрэн бус дунд боловсролтой иргэдийн хариулт 3.1 нэгжээр, бүрэн дунд боловсролтой иргэдийнх 6.7 нэгжээр, тусгай дунд боловсролтой иргэдийнх 2.1 нэгжээр, дээд боловсролтой иргэдийнх 6.1 нэгжээр буурсан байна.

Дээшилсэн гэсэн хариултыг дээд боловсролтой иргэдийн 22.9 хувь, бусад боловсролтой иргэдийн 15-17 хувь өгсөн байна. Үүнийг 2005 оны байдалтай харьцуулбал дээд, бүрэн дунд, тусгай дунд боловсролтой иргэдийн хариулт 2.1-4.2 нэгжээр нэмэгдэж, бүрэн бус дунд боловсролтой иргэдийнх 0.1 нэгжээр буурсан байна.

Харин аль ч судалгаан дахь мэдэхгүй гэсэн хариулт бүх ангилалд харьцангуй бага хувийг эзэлж байна.

Хүснэгт IV.2.2. Хүн амын ядуурал таны бодлоор

		нэмэгдсэн	буурсан	хэвэндээ	мэдэхгүй
Бүрэн бус дунд боловсролтой	2005	72.4	9.7	13.0	4.9
	2006	73.3	7.3	14.2	5.2
	<i>Өөрчлөлт</i>	0.9	-2.4	1.2	0.3
Бүрэн дунд боловсролтой	2005	75.6	7.4	12.0	5.0
	2006	72.0	9.1	14.4	4.4
	<i>Өөрчлөлт</i>	-3.6	1.7	2.4	-0.6
Тусгай дунд боловсролтой	2005	80.8	5.5	10.8	2.9
	2006	74.0	6.6	15.4	4.1
	<i>Өөрчлөлт</i>	-6.8	1.1	4.6	1.2
Дээд боловсролтой	2005	81.6	4.7	11.7	2.0
	2006	78.5	5.8	13.4	2.3
	<i>Өөрчлөлт</i>	-3.1	1.1	1.7	0.3
Бүгд	2005	78.5	6.3	11.8	3.4
	2006	75.5	7.0	14.1	3.5

	<i>Өөрчлөлт</i>	<i>-3.0</i>	<i>0.7</i>	<i>2.3</i>	<i>0.1</i>
--	-----------------	-------------	------------	------------	------------

Хүн амын ядуурал таны бодлоор нэмэгдсэн үү гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 75.5 хувь нь нэмэгдсэн, 14.1 хувь нь хэвэндээ, 7.0 хувь нь буурсан гэж үзжээ. Энэ нь 2005 оны судалгаатай харьцуулахад нэмэгдсэн гэсэн хариулт 3.0 нэгжээр буурсан бол хэвэндээ, буурсан, мэдэхгүй гэсэн хариулт харилцан 2.3, 0.7, 0.1 нэгжээр өсчээ.

Бүх шатны боловсролтой иргэдийн 70 гаруй хувь нь хүн амын ядуурал нэмэгдсэн гэж үзэж байгаа нь хамгийн их хувийн жинг эзэлж байгаа хариулт болж байна. Энэ нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал бүрэн бус дунд боловсролтой иргэдийнх 0.9 нэгжээр нэмэгдэж, бусад ангиллын иргэдийнх 3.1-6.8 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

Хэвэндээ гэсэн хариулт боловсролын түвшин ахих тутам өсөх хандлагатай байгаа ба 2005 оныхоос тусгай дунд боловсролтой иргэдийн хувьд 4.6 нэгжээр, бусад шатны боловсролтой иргэдийн хувьд 1.2-2.4 нэгжээр тус тус өсч, тэдгээрийн 13.4-15.4 хувийн санал авсан байна.

Буурсан гэсэн хариултыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад боловсролын ангилал бүрт 1.1-1.7 нэгжээр өсч 5.8-9.7 хооронд байв. Харин бүрэн бус дунд боловсролтой иргэдийн хувьд 2.4 нэгжээр буурчээ.

Хүснэгт IV.2.3. Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор

		өссөн	буурсан	хэвэндээ	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	82.9	4.8	8.5	3.9
	2006	75.6	7.6	11.7	5.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-7.3</i>	<i>2.8</i>	<i>3.2</i>	<i>1.3</i>
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	81.1	6.1	8.2	4.6
	2006	76.1	7.7	11.7	4.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>-5.0</i>	<i>1.6</i>	<i>3.5</i>	<i>-0.1</i>
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	81.3	4.8	10.5	3.4
	2006	77.2	6.8	11.7	4.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.1</i>	<i>2.0</i>	<i>1.2</i>	<i>1.0</i>
<b>Дээд боловсролтой</b>	2005	80.2	4.6	11.7	3.4
	2006	76.1	6.8	12.7	4.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.1</i>	<i>2.2</i>	<i>1.0</i>	<i>0.9</i>
<b>Бүгд</b>	2005	81.0	5.1	10.0	3.8
	2006	76.2	7.1	12.2	4.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.8</i>	<i>2.0</i>	<i>2.2</i>	<i>0.7</i>

Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор гэсэн асуултанд аль ч боловсролын түвшин дэх иргэдийн дийлэнх буюу 76.2 хувь нь өссөн гэж хариулсан байхад 12.2 хувь нь хэвэндээ, 7 орчим хувь нь буурсан гэж хариулсан байна. Үүнийг 2005 оныхтой харьцуулвал өссөн гэсэн хариулт 4.1-7.3 нэгжээр буурч, бусад хариултууд 0.9-3.5 нэгжээр өсчээ.

Хүснэгт IV.2.4. Газар хувьчлалын талаархи таны бодол

	дэмжиж байна	дэмжихгүй байна	мэдэхгүй
--	--------------	-----------------	----------



<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	56.5	28.2	15.3
	2006	49.9	32.7	17.4
	<i>Өөрчлөлт</i>	-6.6	4.5	2.1
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	59.7	27.7	12.5
	2006	51.3	31.3	17.5
	<i>Өөрчлөлт</i>	-8.4	3.6	5.0
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	65.1	23.2	11.7
	2006	52.6	32.4	15.0
	<i>Өөрчлөлт</i>	-12.5	9.2	3.3
<b>Дээд боловсролтой</b>	2005	68.5	22.6	8.9
	2006	62.4	27.4	10.2
	<i>Өөрчлөлт</i>	-6.1	4.8	1.3
<b>Бүгд</b>	2005	63.6	25.0	11.4
	2006	56.4	29.8	13.7
	<i>Өөрчлөлт</i>	-7.2	4.8	2.3

Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 56.4 хувь нь газар хувьчлалыг дэмжиж байгаа бол 29.8 хувь дэмжихгүй байна. Энэ нь өмнөх судалгааны дүнгээс дэмжиж байгаа иргэдийн хувийн жин 7.2 нэгжээр багасаж, дэмжихгүй байгаа иргэдийн хувийн жин 4.8 нэгжээр нэмэгдсэн байна.

Газар хувьчлалыг дэмжиж байгаа иргэдийн хувийн жин боловсролын түвшин ахих тутам 49.9-62.4 болон нэмэгдэж байгаа бол дэмжихгүй байгаа нь үүний эсрэг буюу боловсролын түвшин ахих тутам 32.7-27.4 болон буурч байна.

Өмнөх судалгааны дүнгээс дэмжиж байна гэсэн хариулт дээд болон бүрэн бус дунд боловсролтой иргэдийнх 6.1-6.6 нэгжээр багассан бол бусад боловсролтой иргэдийнх арай илүү буюу 8.4-12.5 нэгжээр буурчээ. Дэмжихгүй байна гэсэн хариулт бүх шатны боловсролд нэмэгдсэн ба хамгийн их өөрчлөгдсөн нь 9.2 нэгжээр өссөн тусгай дунд боловсролтой иргэдийн хариулт байлаа.

Тус асуултанд мэдэхгүй гэж хариулсан байдал 2005 оныхоос өссөн ч бүрэн бус болон бүрэн дунд боловсролтой иргэдийн нэлээд хувь нь мэдэхгүй гэж хариулсан хэвээр байна.

#### IV. 3. Татварын талаар

##### Хүснэгт IV. 3. 1. Татварын ерөнхий түвшин таны бодлоор?

		өндөр	боломжийн	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	70.6	14.3	15.1
	2006	67.8	15.0	17.2
	<i>Өөрчлөлт</i>	-2.8	0.7	2.1
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	70.8	14.2	15.0
	2006	66.5	16.2	17.3
	<i>Өөрчлөлт</i>	-4.3	2.0	2.3
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	77.8	13.0	9.2
	2006	74.5	14.5	11.0
	<i>Өөрчлөлт</i>	-3.3	1.5	1.8
<b>Дээд боловсролтой</b>	2005	77.7	15.2	7.1
	2006	77.3	15.0	7.7

	<i>Өөрчлөлт</i>	-0.4	-0.2	0.6
	2005	74.7	14.4	10.9
<b>Бүгд</b>	2006	72.9	15.2	11.9
	<i>Өөрчлөлт</i>	-1.8	0.8	1.0

Нийт иргэд татварын ерөнхий түвшинг өндөр гэж үзсэн хэвээр байна. Ялангуяа, тусгай дунд болон дээд боловсролтой иргэд илүү татварын ерөнхий түвшинг өндөр буюу 70 гаруй хувьтай байна. Татварын ерөнхий түвшин өндөр гэсэн хариултыг өмнөх онтой харьцуулахад аль ч боловсролын шатанд багассан бөгөөд нийтдээ 1.8 нэгжээр буурсан байна.

Бүх шатны боловсролтой нийт иргэдийн 15 орчим хувийг татварын ерөнхий түвшинг боломжийн гэж үзсэн байна. Үүнийг 2005 оны судалгааны дүнтэй харьцуулахад 0.8 нэгжээр өсчээ.

Ерөнхийдөө аль ч боловсролын түвшинтэй иргэдийн татварын түвшинг өндөр гэж үзэх байдал өмнөх судалгаанаас дунджаар 1.8 нэгжээр буурч, энэ хэмжээгээр боломжийн, мэдэхгүй гэж бодох бодол өссөн байна. Харин мэдэхгүй гэсэн хариулт ямар ч боловсролын ангиллаар 2005 оны түвшиндээ ойролцоо байна.

Хүснэгт IV.3. 2. Татварын ачаалал сүүлийн жилүүдэд?

		нэмэгдсэн	буурсан	хэвэндээ	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	68.1	2.1	16.5	13.4
	2006	63.6	4.1	15.9	16.3
	<i>Өөрчлөлт</i>	-4.5	2.0	-0.6	2.9
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	68.1	2.2	15.3	14.3
	2006	59.8	3.4	17.6	19.1
	<i>Өөрчлөлт</i>	-8.3	1.2	2.3	4.8
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	69.2	2.6	18.0	10.2
	2006	63.4	4.4	19.6	12.5
	<i>Өөрчлөлт</i>	-5.8	1.8	1.6	2.3
<b>Дээд боловсролтой</b>	2005	66.2	2.1	21.3	10.4
	2006	67.1	3.4	19.7	9.7
	<i>Өөрчлөлт</i>	0.9	1.3	-1.6	-0.7
<b>Бүгд</b>	2005	67.7	2.2	18.2	11.9
	2006	64.2	3.7	18.7	13.4
	<i>Өөрчлөлт</i>	-3.5	1.5	0.5	1.5

Татварын ачаалал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн гэж бүрэн бус дунд болон тусгай дунд боловсролтой иргэдийн 63.5 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 59.8 хувь, дээд боловсролтой иргэдийн 67.1 хувь үзжээ. Үүнийг өмнөх судалгаатай харьцуулахад бүрэн бус дунд болон тусгай дунд боловсролтой иргэдийн хариулт 4.5-5.8 нэгжээр, бүрэн дунд боловсролтой иргэдийнх 8.3 нэгжээр буурсан бол дээд боловсролтой иргэдийнх 0.9 нэгжээр нэмэгдсэн байна. Ямарч боловсролтой иргэдийн 3-4 орчим хувь нь татварын ачаалал буурсан гэж үзэж байгаа бөгөөд энэ нь өмнөх судалгаанаас 1.2-2 нэгжээр өссөн байна. Хэвэндээ гэсэн хамгийн их (21.3 хувь) хариултыг дээд боловсролтой иргэд, хамгийн бага (15.3 хувь) хариултыг бүрэн дунд боловсролтой иргэд өгч байсан бол энэ удаагийн судалгаанд мөн дээд боловсролтой иргэд хамгийн их (19.7 хувь) хариултыг, бүрэн бус дунд боловсролтой иргэд хамгийн бага (15.9 хувь) хариултыг өгсөн байна.

Хүснэгт IV.3.3. Татвараас зайлсхийх явдал таны бодлоор?

		нийтлэг	бага	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	56.8	11.2	32.0
	2006	59.2	11.4	29.4
	<i>Өөрчлөлт</i>	2.4	0.2	-2.6
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	59.8	11.1	29.0
	2006	59.5	13.1	27.4
	<i>Өөрчлөлт</i>	-0.3	2.0	-1.6
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	68.5	9.4	22.0
	2006	63.7	12.4	23.9
	<i>Өөрчлөлт</i>	-4.8	3.0	1.9
<b>Дээд боловсролтой</b>	2005	74.2	7.8	18.1
	2006	76.8	8.4	14.8
	<i>Өөрчлөлт</i>	2.6	0.6	-3.3
<b>Бүгд</b>	2005	66.5	9.5	23.9
	2006	68.1	10.6	21.3
	<i>Өөрчлөлт</i>	1.6	1.1	-2.6

Татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж судалгаанд оролцогчдын олонхи үзсэн хэвээр байна. Бүрэн бус болон бүрэн дунд боловсролтой иргэдийн 60 орчим хувь нь татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж үзэж байгаа бол тэдгээрийн багагүй хувь (30 хувь орчим) мэдэхгүй гэж хариулсан байна. Харин тусгай дунд болон дээд боловсролтой иргэдийн 20 орчим хувь нь тус асуултанд мэдэхгүй, 70 гаруй хувь нь нийтлэг гэж хариулт өгсөн байна. Татвараас зайлсхийх явдал 2005 оныхоос нийтлэг болон бага гэж боддог иргэдийн хувийн жин бүх ангилалд өсч, мэдэхгүй гэж үзсэн иргэдийнх буурсан байна.

#### IV. 4. Банк, санхүүгийн байгууллагын талаар

Хүснэгт IV.4.1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банк, санхүүгийн байгууллагуудын тоо таны бодлоор?

		Олон	Цөөн	Боломжийн	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	33.0	9.4	45.1	12.5
	2006	40.0	7.5	43.6	8.9
	<i>Өөрчлөлт</i>	7.0	-1.9	-1.5	-3.6
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	39.9	7.2	45.3	7.6
	2006	36.0	7.5	48.9	7.5
	<i>Өөрчлөлт</i>	-3.9	0.3	3.6	-0.1
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	40.3	8.4	45.1	6.2
	2006	40.8	7.5	46.7	4.9
	<i>Өөрчлөлт</i>	0.5	-0.9	1.6	-1.3
<b>Дээд боловсролтой</b>	2005	42.2	7.8	46.1	3.9
	2006	38.8	5.6	52.8	2.8
	<i>Өөрчлөлт</i>	-3.4	-2.2	6.7	-1.1
<b>Бүгд</b>	2005	40.0	7.9	45.5	6.6
	2006	38.5	6.6	49.7	5.1
	<i>Өөрчлөлт</i>	-1.5	-1.3	4.2	-1.5

Бүх шатны боловсролын ангиллаар авч үзвэл иргэдийн 50 орчим хувь нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банк, санхүүгийн байгууллагын тоог боломжийн гэж дүгнэж байгаа ч олон гэж үзэж байгаа иргэд багагүй (40 орчим хувь) байна. Хоёр оны судалгааны дүнг харьцуулвал бүх шатны боловсролын иргэдийн боломжийн гэж хариулсан хариулт 4.2 нэгжээр нэмэгдэж, бусад хариултынх буурсан байна. Ялангуяа боломжийн гэсэн хамгийн их хариултыг буюу 52.8 хувийг дээд боловсролтой иргэд өгчээ.

Хүснэгт IV.4.2. Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа таны бодлоор?

		Найдвартай	Найдваргүй	Эргэлзээтэй	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	44.4	6.7	31.8	17.1
	2006	50.9	8.5	31.2	9.5
	<i>Өөрчлөлт</i>	6.5	1.8	-0.6	-7.6
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	42.0	6.7	39.5	11.8
	2006	47.7	7.7	36.2	8.3
	<i>Өөрчлөлт</i>	5.7	1.0	-3.3	-3.5
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	48.6	7.3	35.7	8.5
	2006	46.5	9.1	36.6	7.8
	<i>Өөрчлөлт</i>	-2.1	1.8	0.9	-0.7
<b>Дээд боловсролтой</b>	2005	45.3	5.7	42.2	6.8
	2006	54.1	6.3	35.0	4.6
	<i>Өөрчлөлт</i>	8.8	0.6	-7.2	-2.2
<b>Бүгд</b>	2005	44.9	6.4	38.7	9.9
	2006	50.8	7.4	35.1	6.7
	<i>Өөрчлөлт</i>	5.9	1.0	-3.6	-3.2

Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг найдвартай гэж аль ч түвшний боловсролтой иргэдийн дийлэнх буюу 46.5-54.1 хувь нь хариулсан бөгөөд энэ нь 2005 оныхоос тусгай дунд боловсролтой иргэдийнх 2.1 нэгжээр буурч, бусад боловсролын түвшинтэй иргэдийнх 5.7-8.8 нэгжээр илүү байна.

Эргэлзээтэй гэсэн хариулт багагүй хувийг эзэлж байгаа ба боловсролын түвшин ахих тутам 31.2-36.6 хооронд өсөх хандлагатай байна. Аль ч боловсролын ангиллаарх найдваргүй гэсэн хариулт харьцангуй бага хувийг эзэлж (6.3-9.1 хувь) байна. Бүх шатны боловсролын иргэдийн хариултыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад найдвартай 5.9 нэгжээр, найдваргүй 1.0 нэгжээр нэмэгдэж, эргэлзээтэй, мэдэхгүй гэсэн хариултууд 3.6, 3.2 нэгжээр буурав.

Хүснэгт IV.4.3. Банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл?

		Нэмэгдсэн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	38.3	8.1	36.2	17.5
	2006	39.7	11.7	36.3	12.3
	<i>Өөрчлөлт</i>	1.4	3.6	0.1	-5.2
<b>Бүрэн дунд</b>	2005	39.7	9.3	36.1	14.9

<b>боловсролтой</b>	2006	37.7	11.9	39.1	11.4
	<i>өөрчлөлт</i>	-2.0	2.6	3.0	-3.5
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	49.5	9.6	32.2	8.8
	2006	40.7	11.3	37.5	10.5
	<i>өөрчлөлт</i>	-8.8	1.7	5.3	1.7
<b>Дээд боловсролтой</b>	2005	46.2	9.8	35.1	8.9
	2006	47.5	9.9	37.3	5.2
	<i>өөрчлөлт</i>	1.3	0.1	2.2	-3.7
<b>Бүгд</b>	2005	43.9	9.4	34.9	11.7
	2006	42.9	10.9	37.7	8.5
	<i>өөрчлөлт</i>	-1.0	1.5	2.8	-3.2

Банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн буюу хэвэндээ гэсэн хариултыг нийт судалгаанд оролцогчид аль ч боловсролын ангилалд түлхүү өгсөн хэвээр байв. Гэвч банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэсэн хариулт өмнөх оныхоос 1.0 нэгжээр багасаж, буурсан гэж хариулт 1.5 нэгжээр нэмэгджээ. Харин банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл хэвэндээ гэсэн хамгийн ихээр өссөн хариултыг (5.3 нэгжээр нэмэгдсэн), мөн банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн гэсэн хамгийн ихээр багассан хариултыг (8.8 нэгжээр буурсан) тусгай дунд боловсролтой иргэд өгсөн байлаа.

Хүснэгт IV.4.4. Банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа?

		Сурталчилж чадаж байна	Сурталчилж чадахгүй байна	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	59.6	20.2	20.2
	2006	59.2	22.5	18.4
	<i>Өөрчлөлт</i>	-0.4	2.3	-1.8
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	63.6	20.3	16.1
	2006	62.7	22.1	15.1
	<i>Өөрчлөлт</i>	-0.9	1.8	-1.0
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	69.0	19.6	11.5
	2006	61.6	23.0	15.4
	<i>Өөрчлөлт</i>	-7.4	3.4	3.9
<b>Дээд боловсролтой</b>	2005	68.9	19.5	11.6
	2006	68.7	21.7	9.6
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	2.2	-2.0
<b>Бүгд</b>	2005	66.2	19.8	14.0
	2006	64.8	22.1	13.0
	<i>Өөрчлөлт</i>	-1.4	2.3	-1.0

Банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг сурталчилж чадаж байна гэж дээд боловсролтой иргэдийн 68.7 хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 61.6 хувь, бүрэн бус болон бүрэн дунд боловсролтой иргэдийн 59.2-62.7 хувь хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Үүнийг 2005 оны дүнтэй харьцуулахад бүх шатны боловсролын иргэдийн хариулт 0.4-7.4 нэгжээр буурсан байна.

Банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадахгүй байна гэсэн хариултыг өмнөх онтой харьцуулахад бүх шатандаа өссөн дүнтэй

байна. Харин ямар ч боловсролтой иргэдийн мэдэхгүй гэсэн дүгнэлт 2005 оноос бага зэрэг буурчээ.

Хүснэгт IV.4.5. Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ?

		Хэвийн	Чирэгдэлтэй	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	59.1	26.1	14.8
	2006	54.4	32.3	13.3
	<i>Өөрчлөлт</i>	-4.7	6.2	-1.5
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	55.0	29.8	15.1
	2006	54.8	32.4	12.9
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	2.6	-2.2
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	59.6	29.9	10.5
	2006	54.7	35.1	10.1
	<i>Өөрчлөлт</i>	-4.9	5.2	-0.4
<b>Дээд боловсролтой</b>	2005	60.5	29.2	10.4
	2006	60.5	32.0	7.6
	<i>Өөрчлөлт</i>	0.0	2.8	-2.8
<b>Бүгд</b>	2005	58.5	29.1	12.4
	2006	57.3	32.6	10.1
	<i>Өөрчлөлт</i>	-1.2	3.5	-2.3

Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хувь хүнд хүрч, хэвийн байна гэсэн хариулт нийт хариултын зонхилох хувийг эзэлж байна. Тухайлбал, дээд боловсролтой иргэдийн 60, тусгай дунд, бүрэн бус болон бүрэн дунд боловсролтой иргэдийн 55 орчим хувь нь тус хариултыг өгчээ. Үүнийг 2005 оны судалгаатай харьцуулахад дээд боловсролтой иргэдийн хариулт өөрчилөгдөөгүй, бусад хариултууд 0.2-4.9 нэгжээр буурчээ.

Харин нийт иргэдийн чирэгдэлтэй гэж хариулсан хариулт өмнөх судалгаанаас 3.5 нэгжээр өсч, тусгай дунд боловсролтой иргэдийн хариулт 35.1 хувьд, бусад боловсролтой иргэдийнх ойролцоогоор 32 хувьд хүрсэн байна. Нийт иргэдийн мэдэхгүй гэсэн хариулт өмнөх онохоос 2.3 нэгжээр буурч, 10.1 хувьд хүрэв.

Хүснэгт IV.4.6. Мөнгөний хэрэгцээ гарвал та хаашаа хандах вэ?

		Банк	ББСБ	ХЗХ	Ломбард	Хувь хүн	Бусад
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	57.5	7.1	9.5	20.6	26.3	8.0
	2006	61.1	5.7	5.2	16.4	20.2	6.5
	<i>Өөрчлөлт</i>	3.6	-1.4	-4.3	-4.2	-6.1	-1.5
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	53.7	7.1	7.1	24.8	29.3	7.7
	2006	59.6	5.3	3.9	21.7	23.6	5.3
	<i>Өөрчлөлт</i>	5.9	-1.8	-3.2	-3.1	-5.7	-2.4
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	68.0	7.1	8.2	18.7	25.1	5.7
	2006	67.8	5.0	6.2	17.6	21.2	5.4
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	-2.1	-2.0	-1.1	-3.9	-0.3
<b>Дээд боловсролтой</b>	2005	63.3	9.0	11.3	19.2	30.4	7.7
	2006	68.1	5.1	5.7	15.4	26.4	5.6

	<i>Өөрчлөлт</i>	4.8	-3.9	-5.6	-3.8	-4.0	-2.1
Бүгд	2005	60.7	7.8	9.2	20.9	28.4	7.3
	2006	65.0	5.2	5.3	17.5	24.1	5.6
	<i>Өөрчлөлт</i>	4.3	-2.6	-3.9	-3.4	-4.3	-1.7

Мөнгөний хэрэгцээ гарвал банкинд ханддаг гэж нийт оролцогчдын дийлэнх хариулжээ. Ялангуяа, хамгийн их хариултыг (68.1 хувь) дээд боловсролтой иргэд өгсөн байхад тусгай дунд боловсролтой иргэдийн 67.8 хувь, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 61.6 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 59.6 хувь тус тус хариултыг өгсөн байна. Үүнийг 2005 оны судалгааны дүнтэй харьцуулвал тусгай дунд боловсролтой иргэдийнх 0.2 нэгжээр буурч, бүрэн дунд боловсролтой иргэдийн хариулт хамгийн ихээр буюу 5.9 нэгжээр, дээд боловсролтой иргэдийнх 4.8 нэгжээр, бүрэн бус дунд боловсролтой иргэдийнх 3.6 нэгжээр тус тус өссөн байна.

Мөн хувь хүн, ломбардын үйлчилгээнд хандана гэж хариулсан иргэд багагүй байна. Тухайлбал, хувь хүнд ханддаг гэж дээд болон бүрэн дунд боловсролтой иргэдийн 25 орчим хувь, тусгай дунд болон бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 21 орчим хувь, ломбардын үйлчилгээнд ханддаг гэж бүрэн дунд боловсролтой иргэдийн 22 хувь, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 16 гаруй хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 18 хувь, дээд боловсролтой иргэдийн 15.4 хувь нь тус тус хариулсан байна. Энэ нь өмнөх судалгаатай харьцуулахад ломбардын үйлчилгээнд хандана гэсэн хариулт 1.1-4.2 нэгжээр, хувь хүнд хандана гэсэн хариулт 3.9-6.1 нэгжээр тус тус буурсан байна.

Нийт судалгаанд хамрагдсан бүх шатны боловсролын иргэд банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодыг ойролцоо хувьтайгаар (5-6 хувь) сонгожээ. Өмнөх оны судалгаатай харьцуулахад ББСБ-д хандана гэсэн хариулт 2.6 нэгжээр, ХЗХ 3.9 нэгжээр тус тус буурчээ. Бусад гэсэн хариултыг судалгаанд оролцсон иргэдийн 5-6 орчим хувийг сонгосон нь өмнөх судалгаанаас 1.7 нэгжээр багассан байна.

Хүснэгт IV.4.7. Та банк бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг үү?

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
Бүрэн бус дунд боловсролтой	2005	43.0	51.0	6.0
	2006	36.8	56.9	6.4
	<i>Өөрчлөлт</i>	-6.2	5.9	0.4
Бүрэн дунд боловсролтой	2005	38.4	57.1	4.4
	2006	34.0	62.3	3.7
	<i>Өөрчлөлт</i>	-4.4	5.2	-0.7
Тусгай дунд боловсролтой	2005	38.6	57.4	4.0
	2006	28.4	67.1	4.5
	<i>Өөрчлөлт</i>	-10.2	9.7	0.5
Дээд боловсролтой	2005	35.1	62.0	2.8
	2006	25.6	72.6	1.8
	<i>Өөрчлөлт</i>	-9.5	10.6	-1.0
Бүгд	2005	37.9	58.2	3.9
	2006	29.6	67.1	3.3

	<i>Өөрчлөлт</i>	-8.3	8.9	-0.6
--	-----------------	------	-----	------

Ямар ч боловсролын түвшинтэй иргэдийн дийлэнх буюу 67.1 хувь нь банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэггүй бөгөөд энэ хувь өмнөх судалгааны дүнгээс 8.9 нэгжээр илүү байна. Боловсролын түвшин өсөх тутам тэдгээрийн банк бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэггүй байдал өсөх хандлагатай байна (56.9-72.6 хувь). Харин банк бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг гэсэн хариулт боловсролын шатлал ахих тутам 36.8-25.6 болтлоо буурсан байна.

Боловсролын ангилал ахих тутам мэдэхгүй байдал нь 2005 онтой адил буурах хандлагатай байгаа ч өмнөх судалгааны дүнгээс бага хэмжээгээр буурсан байна. Ялангуяа, бүрэн болон дээд боловсролтой иргэдийн мэдэхгүй гэсэн хариулт 0.7-1.1 нэгжээр буурсан байна.

Хүснэгт IV.4.8. Та хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой юу?

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	33.5	41.0	25.4
	2006	26.9	47.6	25.5
	<i>Өөрчлөлт</i>	-6.6	6.6	0.1
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	36.7	41.0	22.2
	2006	30.0	49.0	21.0
	<i>Өөрчлөлт</i>	-6.7	8.0	-1.2
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	46.0	36.1	17.9
	2006	32.5	45.0	22.5
	<i>Өөрчлөлт</i>	-13.5	8.9	4.6
<b>Дээд боловсролтой</b>	2005	58.8	28.8	12.4
	2006	55.5	33.4	11.1
	<i>Өөрчлөлт</i>	-3.3	4.6	-1.3
<b>Бүгд</b>	2005	46.3	35.5	18.1
	2006	41.8	41.0	17.2
	<i>Өөрчлөлт</i>	-4.5	5.5	-0.9

Та хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой юу гэсэн асуултын тийм, үгүй гэсэн хариултуудын дүн ойролцоо 41 хувь байна. Үүнийг 2005 онтой харьцуулбал ХЗХ-ны талаар ойлголттой гэсэн бүх шатны боловсролын иргэдийн хариулт 4.5 нэгжээр буурч, ойлголтгүй гэсэн хариулт 5.5 нэгжээр нэмэгджээ. ХЗХ-ны талаар ойлголттой гэсэн хариулт боловсролын шатлал ахих тутам 26.9-55.5 болтлоо өссөн байна. Харин мэдэхгүй гэсэн хариулт ямарч боловсролтой иргэдийн багагүй хувийг эзэлж байгаа бөгөөд боловсролын шатлал ахих тусам 25.5-11.1 болтол буурсан байна.

Хүснэгт IV.4.9. Та хадгаламж зээлийн хоршооны гишүүн мөн үү?

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	12.3	80.4	7.3
	2006	9.8	84.1	6.1
	<i>Өөрчлөлт</i>	-2.5	3.7	-1.2
<b>Бүрэн дунд</b>	2005	10.9	83.7	5.4



<b>боловсролтой</b>	2006	9.3	87.7	3.1
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.6</i>	<i>4.0</i>	<i>-2.3</i>
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	12.5	82.6	4.9
	2006	10.7	85.5	3.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.8</i>	<i>2.9</i>	<i>-1.2</i>
<b>Дээд боловсролтой</b>	2005	14.0	81.8	4.2
	2006	10.3	87.8	1.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>-3.7</i>	<i>6.0</i>	<i>-2.3</i>
<b>Бүгд</b>	2005	12.6	82.4	5.1
	2006	10.1	86.9	3.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>-2.5</i>	<i>4.5</i>	<i>-2.1</i>

Мөн та хадгаламж зээлийн хоршооны гишүүн мөн үү гэсэн асуултыг нийт иргэдийн 85 гаруй хувь нь боловсролын байдлаасаа үл хамааран үгүй гэж адилхан хариулсан бол 10 гаруй хувь нь тийм гэж үлдэх 3 орчим хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал тийм, мэдэхгүй гэсэн хариултууд 2.1-2.5 нэгжээр буурсан байхад үгүй гэсэн хариулт 4.5 нэгжээр өсчээ.

IV.4.10. Та хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ?

		Зөв, хуулийн дагуу	Буруу, хууль бус	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	28.4	7.9	63.7
	2006	22.2	20.0	57.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>-6.2</i>	<i>12.1</i>	<i>-5.9</i>
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	29.3	10.1	60.5
	2006	19.1	23.6	57.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-10.2</i>	<i>13.5</i>	<i>-3.2</i>
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	32.0	12.1	56.0
	2006	19.1	28.9	52.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>-12.9</i>	<i>16.8</i>	<i>-4.0</i>
<b>Дээд боловсролтой</b>	2005	36.0	13.0	51.0
	2006	22.6	35.1	42.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-13.4</i>	<i>22.1</i>	<i>-8.7</i>
<b>Бүгд</b>	2005	32.2	11.3	56.5
	2006	21.1	29.3	49.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>-11.1</i>	<i>18.0</i>	<i>-6.8</i>

Та хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын дийлэнх мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байхад 20 орчим хувь нь зөв, хуулийн дагуу, 30 гаруй хувь нь буруу, хууль бус гэж үзжээ. Боловсролын ангилал ахих тусам буруу, хууль бус гэсэн хариулт 20.0-35.1 хувь болон нэмэгдсэн байхад мэдэхгүй гэсэн хариулт 57.8-42.3 болж буурсан байна.

Хүснэгт IV.4.11. Таны бодлоор гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь:

		Ач холбогдолтой	Ач холбогдолгүй	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	42.4	16.3	41.2
	2006	40.5	18.0	41.5
	<i>Өөрчлөлт</i>	-1.9	1.7	0.3
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	46.6	16.1	37.3
	2006	39.5	20.5	40.0
	<i>Өөрчлөлт</i>	-7.1	4.4	2.7
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	46.5	20.6	32.9
	2006	40.7	24.1	35.2
	<i>Өөрчлөлт</i>	-5.8	3.5	2.3
<b>Дээд боловсролтой</b>	2005	47.9	24.0	28.2
	2006	46.2	27.5	26.3
	<i>Өөрчлөлт</i>	-1.7	3.5	-1.9
<b>Бүгд</b>	2005	46.5	20.0	33.5
	2006	42.9	24.0	33.1
	<i>Өөрчлөлт</i>	-3.6	4.0	-0.4

Гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой гэж үзсэн иргэд ямарч боловсролтой иргэдийн ихэнх хувийг эзэлж байгаа хэвээрээ хэдий ч энэ хувь өмнөх судалгааны дүнгээс буурсан байна. Хамгийн их буурсан нь бүрэн дунд боловсролтой иргэдийн 7.1 нэгжээр буурсан хариулт байв.

Ач холбогдолгүй гэж дээд боловсролтой иргэд хамгийн их буюу тэдгээрийн 27.5 хувь, бүрэн бус дунд боловсролтой иргэд хамгийн бага буюу тэдгээрийн 18 хувь үзэж байгаа нь өмнөх судалгаанаас 1.7, 3.5 нэгжээр нэмэгдсэн байна. Харин мэдэхгүй гэж хариулсан иргэд нийт судалгаанд хамрагдагсдын 33.1 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөхөөс 0.4 нэгжээр буурчээ. Боловсролын ангилал ахих тусам мэдэхгүй гэж хариулагсдын хувийн жин 41.5-26.3 хүртэл буурч байна.

Хүснэгт IV.4.12. Та бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү?

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	13.3	74.4	12.4
	2006	18.4	73.5	8.1
	<i>Өөрчлөлт</i>	5.1	-0.9	-4.3
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	15.2	75.3	9.4
	2006	20.8	73.1	6.1
	<i>Өөрчлөлт</i>	5.6	-2.2	-3.3
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	24.3	68.6	7.1
	2006	23.6	69.1	7.4
	<i>Өөрчлөлт</i>	-0.7	0.5	0.3
<b>Дээд боловсролтой</b>	2005	27.6	66.3	6.1
	2006	43.4	54.4	2.3
	<i>Өөрчлөлт</i>	15.8	-11.9	-3.8
<b>Бүгд</b>	2005	21.4	70.5	8.1
	2006	31.3	63.9	4.8
	<i>Өөрчлөлт</i>	9.9	-6.6	-3.3

Нийт судалгаанд хамрагдсан бүх боловсролын ангиллаарх иргэдийн дийлэнх буюу 54.4-73.5 хувь нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийг хэрэглэдэггүй гэж хариулсан

боловч тус картыг хэрэглэгч хүмүүсийн тоо нэмэгдсэн байна. Тухайлбал, карт хэрэглэдэг дээд боловсролтой иргэдийнх 15.8 нэгжээр, бүрэн дунд боловсролтой иргэдийнх 5.6 нэгжээр, бүрэн бус дунд боловсролтой иргэдийнх 5.1 нэгжээр тус тус нэмэгдэж, дээд боловсролтой иргэдийн 43.4 хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 23.6 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 20.8 хувь, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 18.4 хувь нь бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг хэрэглэх болжээ. Мэдэхгүй гэсэн хариулт боловсролын түвшин ахих тусам (8.1-2.3) буурах хандлагатай хэвээр байна. Боловсролын түвшин ахих тусам бэлэн бус төлбөрийн хэрэгслийг хэрэглэдэг иргэд нэмэгдэж байхад хэрэглэдэггүй иргэдийн тоо боловсролын шатлал дээшлэх тусам буурах хандлагатай байна.

#### IV. 5. Хадгаламж хуримтлал

Хүснэгт IV.5.1. Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ?

		Банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг	Бусад зээлдүүлдэг	Худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг	Үнэт цаасанд байршуулдаг	Хувьцаа худалдаж авдаг	Бусад байдлаар зарцуулдаг
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	22.5	7.5	30.8	1.1	2.3	41.3
	2006	28.8	5.8	29.8	0.8	2.7	36.5
	<i>Өөрчлөлт</i>	6.3	-1.7	-1.0	-0.3	0.4	-4.8
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	24.7	7.8	34.4	1.2	1.8	38.8
	2006	28.1	7.8	31.2	1.8	2.4	35.7
	<i>Өөрчлөлт</i>	3.4	0.0	-3.2	0.6	0.6	-3.1
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	31.9	8.7	34.0	1.3	0.9	34.6
	2006	32.5	6.5	36.9	2.6	1.6	29.1
	<i>Өөрчлөлт</i>	0.6	-2.2	2.9	1.3	0.7	-5.5
<b>Дээд боловсролтой</b>	2005	40.0	10.3	25.7	1.7	1.5	34.1
	2006	44.9	8.7	24.2	1.4	2.4	29.1
	<i>Өөрчлөлт</i>	4.9	-1.6	-1.5	-0.3	0.9	-5.0
<b>Бүгд</b>	2005	31.6	8.9	30.7	1.4	1.6	36.5
	2006	36.7	7.8	28.7	1.6	2.3	31.7
	<i>Өөрчлөлт</i>	5.1	-1.1	-2.0	0.2	0.7	-4.8

Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын 36.7 хувь нь банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 31.7 хувь нь бусад байдлаар, 28.7 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг гэж хариулт өгсөн нь дийлэнх хувийг эзэлж байна. Хуримтлуулсан мөнгөө банк санхүүгийн байгууллагад хадгалуулах хандлага дээд болон тусгай дунд боловсролтой иргэдийн дунд илүү байгаа бол худалдаа арилжаа хийж эргэлдүүлэх явдал бүрэн болон бүрэн бус дунд, тусгай дунд боловсролтой иргэдийн дунд их байна.

Харин бусад зээлдүүлэх, хувьцаа худалдаж авах болон үнэт цаасанд байршуулах явдал нийт иргэдийн дунд бага байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бүх шатны боловсролтой иргэдийн бусад зээлдүүлдэг, худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, үнэт цаасанд байршуулдаг, хувьцаа худалдаж авдаг гэсэн хариултууд маш бага зэргийн өөрчлөлттэй байна.

Бусад байдлаар зарцуулдаг гэсэн хариулт ямар ч боловсролтой иргэдийн хувьд 2005 оныхтой адил өндөр буюу тэдний гуравны нэгээс дээш хувийг эзэлсэн хэвээр байна.

Хүснэгт IV.5.2. Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ?

		Бэлэн мөнгөөр	Бэлэн бусаар	Үнэт цаасаар	Хувьцаагаар	Бусад
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	69.1	11.3	3.8	4.3	20.3
	2006	70.2	10.0	1.9	3.3	17.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.1</i>	<i>-1.3</i>	<i>-1.9</i>	<i>-1.0</i>	<i>-3.1</i>
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	73.7	11.4	3.5	3.0	14.9
	2006	73.2	10.2	3.3	3.1	13.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.5</i>	<i>-1.2</i>	<i>-0.2</i>	<i>0.1</i>	<i>-1.3</i>
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	67.3	17.5	4.7	2.3	15.6
	2006	70.5	13.8	4.7	3.6	12.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>3.2</i>	<i>-3.7</i>	<i>0.0</i>	<i>1.3</i>	<i>-3.3</i>
<b>Дээд боловсролтой</b>	2005	65.8	21.9	6.1	5.2	13.7
	2006	64.9	21.1	4.7	5.4	10.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.9</i>	<i>-0.8</i>	<i>-1.4</i>	<i>0.2</i>	<i>-3.5</i>
<b>Бүгд</b>	2005	68.9	16.5	4.8	3.8	15.3
	2006	68.6	15.8	4.0	4.3	12.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.3</i>	<i>-0.7</i>	<i>-0.8</i>	<i>0.5</i>	<i>-3.1</i>

Ямар ч боловсролтой иргэдийн дийлэнх буюу 64.9-73.2 хувь нь мөнгөө бэлнээр хадгалах сонирхолтой хэвээр байна. Бэлэн бусаар болон үнэт цаасаар гэж хариулт өгсөн иргэд дээд, тусгай дунд боловсролтой иргэдийн дунд, хувьцаагаар гэсэн хариулт бүрэн бус дунд, дээд боловсролтой иргэдийн дунд арай өндөр байна. Боловсролын түвшин ахих тусам иргэд мөнгөө бэлэн бус, үнэт цаас, хувьцаагаар байршуулахыг илүүд үзэж байна.

Хүснэгт IV.5.3. Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ?

		Төгрөг	Ам.доллар	Бусад валютаар
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	85.4	5.6	9.0
	2006	88.7	5.9	6.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>3.3</i>	<i>0.3</i>	<i>-2.8</i>
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	89.1	5.4	5.5
	2006	89.3	7.0	6.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.2</i>	<i>1.6</i>	<i>0.5</i>
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	90.7	5.4	3.9
	2006	89.3	8.5	3.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.4</i>	<i>3.1</i>	<i>0.0</i>
<b>Дээд боловсролтой</b>	2005	88.1	7.9	4.0
	2006	90.0	10.2	3.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.9</i>	<i>2.3</i>	<i>-0.5</i>
<b>Бүгд</b>	2005	88.6	6.3	5
	2006	89.5	8.6	4.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.9</i>	<i>2.3</i>	<i>-0.5</i>

Нийт иргэдийн дунд мөнгөө төгрөгөөр хадгалах явдал өмнөх судалгааны дүнтэй ижил элбэг байгаа ба цөөнх буюу 8.6 хувь нь ам доллараар, 4.5 хувь нь бусад валютаар хадгалдаг гэж хариулжээ. Аль ч боловсролын түвшингээр авч үзэхэд энэ

хандлага ойролцоо байна. Өмнөх судалгааны дүнгээс тусгай дунд боловсролтой иргэдийн төгрөгөөр хадгалдаг гэсэн хариулт 1.4 нэгжээр буурсан ч бүх шатны боловсролын иргэдийн хариулт 0.9 нэгжээр өсчээ. Мөн ам.доллараар хадгалдаг иргэдийн тоо 2.3 нэгжээр нэмэгдэж, бусад валютаар хадгалдаг гэсэн хариулт 0.5 нэгжээр бууран байна. Боловсролын түвшин ахих тутам иргэд мөнгөө төгрөг, ам.доллараар хадгалах явдал ихсэх хандлагатай байна.

Хүснэгт IV.5.4. Хадгаламжийн хүү таны бодлоор?

		бага байна	боломжийн байна	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	46.9	30.9	22.2
	2006	49.6	29.2	21.2
	<i>Өөрчлөлт</i>	2.7	-1.7	-1.0
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	50.6	30.1	19.3
	2006	49.9	30.8	19.3
	<i>Өөрчлөлт</i>	-0.7	0.7	0.0
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	59.5	26.6	13.9
	2006	60.2	25.3	14.5
	<i>Өөрчлөлт</i>	0.7	-1.3	0.6
<b>Дээд боловсролтой</b>	2005	66.0	25.0	9.0
	2006	60.3	29.9	9.8
	<i>Өөрчлөлт</i>	-5.7	4.9	0.8
<b>Бүгд</b>	2005	57.6	27.6	14.8
	2006	56.3	29.3	14.4
	<i>Өөрчлөлт</i>	-1.3	1.7	-0.4

Судалгаанд хамрагдагсадын дийлэнх буюу 56.3 хувь нь хадгаламжийн хүүг бага, 29.3 хувь нь боломжийн, 14.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Үүнийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бага болон мэдэхгүй гэсэн хариулт 1.3, 0.4 нэгжээр буурсан бол боломжийн байна гэсэн хариулт 1.7 нэгжээр нэмэгдсэн байна.

Боловсролын түвшин ахих тусам хадгаламжийн хүүг бага гэж үзэгсдийн хувийн жин урьдын адил нэмэгдэж, боломжийн эсвэл мэдэхгүй гэж үзэгсдийн хувийн жин урьдын адил буурсан хэвээр байна.

## IV.6. Зээлийн талаар

IV.6.1. Танд зээлийн хэрэгцээ байдаг уу?

		тийм	үгүй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	81.4	15.5	3.2
	2006	80.5	12.7	6.8
	<i>Өөрчлөлт</i>	-0.9	-2.8	3.6
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	82.8	13.6	3.6
	2006	80.6	16.2	3.2
	<i>Өөрчлөлт</i>	-2.2	2.6	-0.4
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	85.6	11.8	2.6
	2006	85.8	11.4	2.7
	<i>Өөрчлөлт</i>	0.2	-0.4	0.1
<b>Дээд боловсролтой</b>	2005	83.7	13.7	2.6

	2006	83.1	15.0	1.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.6</i>	<i>1.3</i>	<i>-0.7</i>
<b>Бүгд</b>	2005	83.5	13.5	3.0
	2006	82.6	14.5	2.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.9</i>	<i>1.0</i>	<i>-0.1</i>

Нийт иргэдэд зээлийн хэрэгцээ их байдаг нь аль ч боловсролын түвшнээр авч үзсэн тийм гэсэн хариулт 80 хувиас дээш байгаагаас харагдаж байна. Судалгаанд оролцсон иргэдийн 82.6 хувь нь зээлийн хэрэгцээтэй, 14.5 хувь нь хэрэгцээгүй, 2.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсныг боловсролын ангиллаарх хариулттай харьцуулбал онцын ялгаа байхгүй байна. Харин 2005 оны судалгаатай харьцуулбал тусгай дунд боловсролтой иргэдийн хэрэгцээтэй гэсэн хариулт 0.2 нэгжээр өссөн байхад бусад боловсролтой иргэдийнх 0.6-2.2 нэгжээр буурсан байхад хэрэгцээгүй гэсэн бүрэн бус болон тусгай дунд боловсролтой иргэдийн хариулт 0.4-2.8 нэгжээр буурч, бүрэн дунд болон дээд боловсролтой иргэдийнх 1.3-2.6 нэгжээр нэмэгдсэн байга. Мэдэхгүй гэсэн хариулт аль ч боловсролын түвшнээр үзэхэд өмнөх оноос бараг өөрчлөгдөөгүй байна.

Хүснэгт IV.6.2. Зээл хүртээмжтэй юу?

		тийм	үгүй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	38.7	37.8	23.5
	2006	40.3	35.7	24.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.6</i>	<i>-2.1</i>	<i>0.5</i>
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	38.0	42.2	19.9
	2006	38.1	37.7	24.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.1</i>	<i>-4.5</i>	<i>4.3</i>
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	45.4	37.9	16.7
	2006	44.0	39.7	16.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.4</i>	<i>1.8</i>	<i>-0.3</i>
<b>Дээд боловсролтой</b>	2005	44.9	36.0	19.2
	2006	45.8	37.2	17.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.9</i>	<i>1.2</i>	<i>-2.2</i>
<b>Бүгд</b>	2005	42.1	38.5	19.4
	2006	42.8	37.5	19.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.7</i>	<i>-1.0</i>	<i>0.2</i>

Банк санхүүгийн байгууллагаас олгож буй зээл хүртээмжтэй байдаг гэж дээд боловсролтой иргэд хамгийн их буюу 45.8 хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 44.0 хувь, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 40.3 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 38.1 хувь нь үзсэн байна. Үүнийг өмнөх судалгаатай харьцуулбал тусгай дунд боловсролтой иргэдийнх 1.4 нэгжээр буурч, бүрэн бус дунд боловсролтой иргэдийнх 1.6, дээд боловсролтой иргэдийнх 0.9, бүрэн дунд боловсролтой иргэдийнх 0.1 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.

Зээл хүртээмжгүй гэж бүх шатны боловсролын иргэд ойролцоо хариултыг өгчээ. Тус асуултанд мэдэхгүй гэж хариулсан иргэдийн хувийн жин өмнөх судалгааны дүнгээс боловсролын ангилал бүрт зөрүү багатай байгаа бөгөөд тэдгээрийн 16.4-24.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт IV.6.3. Зээл авахад таны бодлоор хэцүү юу?

		хүндрэлгүй	хүндрэлтэй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	35.7	44.0	20.2
	2006	37.8	46.2	16.1
	<i>Өөрчлөлт</i>	2.1	2.2	-4.1
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	36.4	47.1	16.6
	2006	36.2	49.3	14.5
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	2.2	-2.1
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	41.0	46.1	12.9
	2006	37.6	50.5	11.9
	<i>Өөрчлөлт</i>	-3.4	4.4	-1.0
<b>Дээд боловсролтой</b>	2005	39.3	47.1	13.5
	2006	39.1	49.8	11.1
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	2.7	-2.4
<b>Бүгд</b>	2005	38.3	46.5	15.1
	2006	37.9	49.4	12.7
	<i>Өөрчлөлт</i>	-0.4	2.9	-2.4

Боловсролын ангиллаар нь авч үзвэл банк санхүүгийн байгууллагаас зээл авахад хүндрэлтэй гэж иргэдийн дийлэнх буюу 49.4 хувь нь үзэж байгаа бөгөөд өмнөх судалгааны дүнгээс 2.9 нэгжээр өссөн байна.

Харин зээл авахад хүндрэлгүй гэж бүрэн, бүрэн бус болон тусгай дунд боловсролтой иргэдийн 36-38 орчим, дээд боловсролтой иргэдийн 39 орчим хувь нь үзэж байна. Үүнийг 2005 оныхтой харьцуулбал бүрэн бус дунд боловсролтой иргэдийнх 2.1 нэгжээр нэмэгдэж, бусад боловсролтой иргэдийнх 0.2-3.4 нэгжээр тус тус буурчээ.

Хоёр оны судалгааны мэдэхгүй гэсэн хариулт аль ч боловсролын түвшинд ойролцоо байгаа бөгөөд 2005 оныхоос 2.4 нэгжээр буурсан байна.

Хүснэгт IV.6.4. Зээлийн хүүгийн талаар таны бодол?

		өндөр	боломжийн	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	64.8	19.9	15.3
	2006	68.3	20.5	11.2
	<i>Өөрчлөлт</i>	3.5	0.6	-4.1
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	65.9	21.9	12.2
	2006	66.7	23.1	10.2
	<i>Өөрчлөлт</i>	0.8	1.2	-2.0
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	69.6	21.0	9.4
	2006	72.5	19.8	7.7
	<i>Өөрчлөлт</i>	2.9	-1.2	-1.7
<b>Дээд</b>	2005	74.3	18.9	6.8

<b>боловсролтой</b>	2006	74.6	18.5	6.9
	<i>Өөрчлөлт</i>	0.3	-0.4	0.1
	2005	69.6	20.4	10.1
<b>Бүгд</b>	2006	71.4	20.1	8.4
	<i>Өөрчлөлт</i>	1.8	-0.3	-1.7

Аль ч шатны боловсролын иргэдийн хариултыг 2005 оныхтой харьцуулахад өндөр гэсэн хариулт 1.8 нэгжээр өсч, боломжийн, мэдэхгүй 0.3-1.7 нэгжээр буурчээ. Зээлийн хүүг өндөр гэж бүх шатны боловсролын олонх иргэд үзэж байгаа бөгөөд тус хариулт боловсролын түвшин нэмэгдэх тутам 68.3-74.6 болж өсөх хандлагатай байв.

Харин зээлийн хүүг боломжийн гэж бүрэн бус дунд боловсролтой иргэд хамгийн их (20.5 хувь) үзэж байсан бол дээд боловсролтой иргэд хамгийн бага (18.5 хувь) хариултыг өгчээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал тусгай дунд болон дээд боловсролтой иргэдийн хариулт 0.4-1.2 нэгжээр буурсан байхад бусад боловсролын түвшин дэх иргэдийнх 0.6-1.2 нэгжээр нэмэгдсэн байна.

Харин мэдэхгүй гэсэн хариулт 11.2-6.9 хооронд боловсролын түвшин ахих тусам буурах хандлагатай байгаа ба өмнөх судалгааны дүнгээс онцын ялгаа байхгүй байна.

#### IV.7. Бичил санхүүгийн талаар

Хүснэгт IV.7.1. Та бичил санхүүгийн талаар ойлголттой юу?

		тийм	үгүй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	53.8	24.3	21.9
	2006	50.8	26.3	22.9
	<i>Өөрчлөлт</i>	-3.0	2.0	1.0
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	57.2	22.7	20.1
	2006	55.1	27.5	17.4
	<i>Өөрчлөлт</i>	-2.1	4.8	-2.7
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	70.1	17.1	12.9
	2006	62.0	24.2	13.9
	<i>Өөрчлөлт</i>	-8.1	7.1	1.0
<b>Дээд боловсролтой</b>	2005	78.6	12	9.3
	2006	75.2	16.1	8.8
	<i>Өөрчлөлт</i>	-3.4	4.1	-0.5
<b>Бүгд</b>	2005	67.3	17.8	14.9
	2006	64.9	21.6	13.5
	<i>Өөрчлөлт</i>	-2.4	3.8	-1.4

Нийт санал асуулгад оролцсон иргэдийн дийлэнх бичил санхүүгийн талаар ойлголттой гэж хариулжээ. Ялангуяа, дээд боловсролтой иргэдийн 75.2 хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 62.0 хувь тийм гэж хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Мөн боловсролын ангилал ахих тутам энэ хариулт 50.8-75.2



болж өссөн байна. Харин бичил санхүүгийн талаар ойлголтгүй болон мэдэхгүй гэсэн хариулт боловсролын түвшин ахих тутам харилцан 26.3-161, 22.9-8.8 болж буурсан байна.

Хүснэгт IV.7.2.. Таны оршин сууж буй газарт бичил санхүүгийн үйл ажиллагаа хэр хөгжсөн бэ?

		Сайн	Дунд зэрэг	Огт хөгжөөгүй	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	21.8	37	13.4	27.8
	2006	19.5	40.9	13.1	26.5
	<i>Өөрчлөлт</i>	-2.3	3.9	-0.3	-1.3
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	20.5	41.6	13.6	24.3
	2006	18.8	43.8	13.1	24.2
	<i>Өөрчлөлт</i>	-1.7	2.2	-0.5	-0.1
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	26	41.3	14.1	18.6
	2006	24.4	39.1	13.8	22.7
	<i>Өөрчлөлт</i>	-1.6	-2.2	-0.3	4.1
<b>Дээд боловсролтой</b>	2005	26.3	46.2	11.2	16.3
	2006	28.4	46.9	10.4	14.2
	<i>Өөрчлөлт</i>	2.1	0.7	-0.8	-2.1
<b>Бүгд</b>	2005	24	42.6	12.8	20.6
	2006	24.2	44.1	12.0	19.6
	<i>Өөрчлөлт</i>	0.2	1.5	-0.8	-1.0

Таны оршин сууж буй газарт бичил санхүүгийн үйл ажиллагаа хэр хөгжсөн бэ гэсэн асуултанд сайн гэсэн хариултыг дээд болон тусгай дунд боловсролтой иргэд хамгийн их буюу 24-28 орчим хувь нь хариулсан бол бусад боловсролын түвшний иргэдийн 19 гаруй хувь нь тус хариултыг өгчээ.

Дунд зэрэг гэсэн хариултыг дээд боловсролтой иргэд хамгийн их буюу 46.9 хувь нь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 43.8 хувь нь, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 40.9 хувь нь, тусгай дунд боловсролтой иргэдийн 39.1 хувь нь тус тус өгсөн байна. Бүх шатны боловсролын ангиллаар огт хөгжөөгүй, мэдэхгүй гэсэн хариултын дүн нь 2005 оны түвшинд байна.

Хүснэгт IV.7.3. Танд бичил зээл авах боломж бий юу?

	Тийм	үгүй	мэдэхгүй	
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	50.2	26.4	23.4
	2006	50.8	26.3	22.9
	<i>Өөрчлөлт</i>	0.6	-0.1	-0.5
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	50.4	28.7	20.9
	2006	55.1	27.5	17.4
	<i>Өөрчлөлт</i>	4.7	-1.2	-3.5
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	61.6	22	16.4
	2006	62.0	24.2	13.9
	<i>Өөрчлөлт</i>	0.4	2.2	-2.5
<b>Дээд боловсролтой</b>	2005	68	17.8	14.2
	2006	75.2	16.1	8.8
	<i>Өөрчлөлт</i>	7.2	-1.7	-5.4

Бүгд	2005	59.1	23	17.8
	2006	64.9	21.6	13.5
	Өөрчлөлт	5.8	-1.4	-4.3

Тус судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг авч үзэхэд нийт иргэдийн дийлэнх хувь нь бичил зээл авах боломжтой гэжээ. Зээл авах боломжтой гэсэн хариулт иргэдийн боловсролын түвшин нэмэгдэх тутам 50.8-75.2 болж өсөв. Харин бичил зээл авах боломжгүй эсвэл мэдэхгүй гэсэн хариултыг бүрэн бус болон бүрэн дунд боловсролтой иргэд хамгийн их өгсөн байна.

Хүснэгт IV.7.4. Хэрвээ бичил зээл авч ашигладаг бол ямар бизнес эрхэлдэг вэ?

		Газар тариалан	Хүнсний ногоо	Мал аж ахуй	Худалдаа наймаа	Жижиг, дунд үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Зочид буудал	Үйлчилгээ	Бусад
Бүрэн бус дунд боловсролтой	2005	9.8	9.5	14.3	34.1	13	2.5	1.8	7.1	26.6
	2006	12.8	11.2	17.2	35.7	12.6	1.8	1.1	4.5	22.9
	Өөрчлөлт	3.0	1.7	2.9	1.6	-0.4	-0.7	-0.7	-2.6	-3.7
Бүрэн дунд боловсролтой	2005	7.9	8.3	13.7	38.4	14.4	4.2	2.2	8.9	25.8
	2006	8.5	9.5	12.2	38.3	11.6	2.1	1.5	8.6	25.0
	Өөрчлөлт	0.6	1.2	-1.5	-0.1	-2.8	-2.1	-0.7	-0.3	-0.8
Тусгай дунд боловсролтой	2005	8.8	10	9.3	39.9	13.6	3.5	1.4	9	27.5
	2006	9.9	9.0	10.7	41.4	14.6	3.3	1.7	6.7	22.4
	Өөрчлөлт	1.1	-1.0	1.4	1.5	1.0	-0.2	0.3	-2.3	-5.1
Дээд боловсролтой	2005	5.8	7.1	6.9	34.7	15.8	7.1	3.3	12.1	32.3
	2006	8.0	8.2	7.7	34.3	14.0	4.4	1.8	11.4	32.0
	Өөрчлөлт	2.2	1.1	0.8	-0.4	-1.8	-2.7	-1.5	-0.7	-0.3
Бүгд	2005	7.6	8.4	10.4	36.8	14.6	4.9	2.4	9.9	28.6
	2006	9.0	9.0	10.5	36.6	13.3	3.3	1.6	9.1	27.6
	Өөрчлөлт	1.4	0.6	0.1	-0.2	-1.3	-1.6	-0.8	-0.8	-1.0

Хэрвээ та бичил зээл авч ашигладаг бол ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд тусгай дунд боловсролтой иргэдийн 41.4 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 38.3 хувь, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 35.7 хувь, дээд боловсролтой иргэдийн 34.3 гаруй хувь нь худалдаа наймаа хийдэг гэж хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Үүний дараагаар жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг гэж аль ч боловсролын шатны иргэдийн 12-15 хувь, мал аж ахуй эрхэлдэг гэж бүрэн бус болон бүрэн дунд боловсролтой иргэдийн 17 орчим хувь, үйлчилгээ гэж дээд боловсролтой иргэдийн 11.4 хувь нь хариулсан байна. Харин ямар ч боловсролтой иргэдийн хувьд хамгийн бага хувийн санал авсан нь аялал жуулчлал, зочид буудлын бизнес байлаа.

Хүснэгт IV.7.5. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдийн хэмжээний төгрөг шаардагдах вэ?

		<100 мянга	100–250 мянга	250–500 мянга	0.5-1 сая	1–1,5 сая	1.5–2 сая
Бүрэн бус дунд	2005	10.7	9.8	18.6	18.1	13.9	71.2
	2006	7.6	11.4	15.6	19.3	15.9	30.2

<b>боловсролтой</b>	<i>Өөрчлөлт</i>	-3.1	1.6	-3.0	1.2	2.0	-41.0
	2005	6.8	9.2	16.5	21.8	13.7	68
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2006	5.9	9.2	15.7	22.6	14.8	31.9
	<i>Өөрчлөлт</i>	-0.9	0.0	-0.8	0.8	1.1	-36.1
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	4.5	8.3	15.2	20.8	15.3	64.2
	2006	4.6	7.0	14.8	22.2	15.5	35.8
	<i>Өөрчлөлт</i>	0.1	-1.3	-0.4	1.4	0.2	-28.4
<b>Дээд боловсролтой</b>	2005	3	-4.9	13.5	23	15.4	59.9
	2006	2.8	5.7	12.8	20.7	14.3	43.8
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	10.6	-0.7	-2.3	-1.1	-16.1
<b>Бүгд</b>	2005	5.4	7.5	15.4	21.6	14.7	64.6
	2006	4.4	7.5	14.2	21.3	14.8	37.9
	<i>Өөрчлөлт</i>	-1.0	0.0	-1.2	-0.3	0.1	-26.7

Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний төгрөг шаардагдах вэ гэсэн асуултанд 1.5-2 сая гэж хариулсан иргэд судалгаанд оролцогчдын дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь боловсролын түвшин нэмэгдэх тусам өсөх (30.2-43.8) хандлагатай байв. Үүний дараа 500 мянгаас 1 сая, 1-1.5 сая төгрөг, 250-500 мянга шаардлагатай гэсэн хариултауд орж байгаа бөгөөд нийт судалгаанд хамрагдагсадын харилцан 21.3, 14.8, 14.2 хувийг эзэлж байна. 100-250 мянга, 100 мянгаас доош гэсэн хариултауд харьцангуй бага хувийг эзэлж байна. Боловсролын түвшингээр авч үзэхэд 100 мянгаас доош, 100-250 мянга, 250-500 мянга гэсэн хариултауд боловсролын түвшин өсөх тусам багассан байна. 2005 оныхтой бүх шатны боловсролын нийт дүнг харьцуулахад 1.5-2 сая төгрөг гэсэн хариулт 26.7 нэгжээр буурч, бусад хариултын харьцангуй бага өөрчилттэй байна. Ялангуяа бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 1.5-2 сая төгрөг гэсэн хариулт хамгийн их буюу 41.0 нэгжээр багасжээ.

Хүснэгт IV.7.6. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар хугацаа шаардагдах вэ.

		3 сар хүртэл	3-6 сар	6-9 сар	9-12 сар
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	2005	9.7	15	16.5	58.9
	2006	9.4	13.9	17.3	59.4
	<i>Өөрчлөлт</i>	-0.3	-1.1	0.8	0.5
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	2005	8.7	14.1	19.6	57.5
	2006	8.6	14.8	18.6	58.1
	<i>Өөрчлөлт</i>	-0.1	0.7	-1.0	0.6
<b>Тусгай дунд боловсролтой</b>	2005	6.6	15.3	16.2	61.9
	2006	7.5	13.2	16.5	62.8
	<i>Өөрчлөлт</i>	0.9	-2.1	0.3	0.9
<b>Дээд боловсролтой</b>	2005	6.8	14.4	15.2	63.6
	2006	7.6	13.7	15.9	62.9
	<i>Өөрчлөлт</i>	0.8	-0.7	0.7	-0.7
<b>Бүгд</b>	2005	7.7	14.6	16.9	60.8
	2006	8.0	13.9	16.8	61.2
	<i>Өөрчлөлт</i>	0.3	-0.7	-0.1	0.4

Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9-12 сар шаардагдана гэж судалгаанд оролцсон ямар ч боловсролтой иргэдийн дийлэнх хариулсан бол 3 сар хүртэл хугацаа гэж хамгийн бага хувь нь хариулжээ. Харин 3-6 сар гэж санал асуулгад оролцогсодын 13.2-14.8 хувь, 6-9 сар гэж бүрэн дунд боловсролтой иргэдийн 18.6 хувь, бусад шатны боловсролын иргэдийн 15.9-18.6 хувь хариулсан байна.

Хүснэгт IV.7.7. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад банк санхүүгийн байгууллагын зүгээс ямар бэрхшээл байна вэ.

		Зээлийн хүү өндөр	Зээлийн хэмжээ бага	Зээл авах боломжгүй	Зээлийн хугацаа богино	Бусад
<b>Бүрэн бус дунд</b>	2005	55.2	9.6	15.4	10.2	9.6
	2006	61.9	16.1	17.1	18.6	9.0
<b>боловсролтой</b>	<i>Өөрчлөлт</i>	6.7	6.5	1.7	8.4	-0.6
<b>Бүрэн дунд</b>	2005	54.9	11	13.2	12.1	8.7
	2006	58.2	18.8	17.0	21.8	9.8
<b>боловсролтой</b>	<i>Өөрчлөлт</i>	3.3	7.8	3.8	9.7	1.1
<b>Тусгай дунд</b>	2005	60.2	10.2	10	13.6	6
	2006	62.0	22.8	15.6	24.3	7.4
<b>боловсролтой</b>	<i>Өөрчлөлт</i>	1.8	12.6	5.6	10.7	1.4
<b>Дээд</b>	2005	59.8	10.4	6.7	15.6	7.4
	2006	67.6	20.5	12.1	27.6	7.6
<b>боловсролтой</b>	<i>Өөрчлөлт</i>	7.8	10.1	5.4	12.0	0.2
<b>Бүгд</b>	2005	57.8	10.5	10.5	13.5	7.8
	2006	63.6	19.9	14.5	24.6	8.3
	<i>Өөрчлөлт</i>	5.8	9.4	4.0	11.1	0.5

Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад банк санхүүгийн байгууллагын зүгээс ямар бэрхшээл байна вэ гэсэн асуултанд зээлийн хүү өндөр гэж хариулсан иргэд судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 63.6 хувийг эзэлж байна. Үүний дараа зээлийн хугацаа богино, зээлийн хэмжээ бага, зээл авах боломжгүй гэсэн хариултауд орж байна. Аль ч боловсролын түвшний ангиллаарх иргэдийн хариулт 2005 оноос өссөн дүнтэй байна.

Мөнгөн дэвсгэртийн талаарх асуултуудыг энэ удаагийн санал асуулгад нэмж оруулсан тул 2005 оны байдалтай харьцуулах боломжгүй юм.

Хүснэгт V.7.8 Танд 1-т болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байдаг уу?

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	27.5	59.6	13.0
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	27.3	61.9	10.7
<b>Тусгай дунд боловсролтой</b>	26.6	65.1	8.4
<b>Дээд боловсролтой</b>	23.9	70.6	5.6
<b>Бүгд</b>	25.6	66.2	8.2

Танд 1-т болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байдаг уу гэсэн асуултыг сүүлийн судалгаанд нэмж оруулсан бөгөөд 1-т болон 5-тын дэвсгэрт хэрэгцээгүй гэж оролцогчдын дийлэнх буюу 66.2 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь боловсролын түвшин нэмэгдэх тусам өсөх (59.6-70.6) хандлагатай байв. Харин 1-т болон 5-тын дэвсгэрт хэрэгцээтэй, мэдэхгүй гэж үзсэн иргэдийн боловсролын түвшин дээшлэх тусам хувийн жин нь багасаж байна.

Хүснэгт V.7.9 Танд 50, 100, 200, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу?

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	32.8	50.3	16.9
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	32.9	52.4	14.7

<b>Тусгай дунд боловсролтой</b>	29.4	58.0	12.6
<b>Дээд боловсролтой</b>	29.0	60.6	10.4
<b>Бүгд</b>	30.5	56.8	12.6

Санал асуулганд дээрх асуултыг шинээр нэмж оруулсан ба 50, 100, 200, 500-тын зоосон мөнгө хэрэгцээгүй гэж оролцогчдын дийлэнх буюу 56.8 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь боловсролын түвшин нэмэгдэх тусам өсөх (50.3-60.6) хандлагатай байв. Харин 50, 100, 200, 500-тын зоосон мөнгө хэрэгцээтэй, мэдэхгүй гэж үзсэн иргэдийн боловсролын түвшин дээшлэх тусам хувийн жин нь багасаж байна.

Хүснэгт V.7.10 Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа юу?

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	38.2	46.2	15.6
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	35.1	50.2	14.7
<b>Тусгай дунд боловсролтой</b>	33.6	53.3	13.1
<b>Дээд боловсролтой</b>	37.9	53.3	8.8
<b>Бүгд</b>	36.5	51.6	11.8

Санал асуулганд шинээр оруулсан асуулт бөгөөд 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгт хэрэгцээгүй гэж судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь үзжээ. Энэхүү хариулт нь боловсролын түвшин нэмэгдэх тусам өсөх хандлагатай байна.

Хүснэгт V.7.11 Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг уу?

	тийм	үгүй	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	73.3	12.8	13.9
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	75.0	13.7	11.3
<b>Тусгай дунд боловсролтой</b>	71.6	15.0	13.3
<b>Дээд боловсролтой</b>	76.0	15.9	8.1
<b>Бүгд</b>	74.7	14.8	10.5

Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг уу гэсэн асуултыг сүүлийн судалгаанд нэмж оруулсан бөгөөд гүйлгээнд байгаа төгрөгийн хийц дизайн таалагддаг гэж бүх шатны боловсролын иргэдийн ихэнх хувь нь үзэж байна. Харин таалагддаггүй, мэдэхгүй гэж үзсэн иргэдийн хариулт ойролцоо байна.

Хүснэгт V.7.12 Таны 10, 20, 50, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу?

	тийм	үгүй	Мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	73.9	17.7	8.4
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	71.9	20.8	7.3
<b>Тусгай дунд боловсролтой</b>	70.1	22.8	7.1
<b>Дээд боловсролтой</b>	73.3	21.5	5.2
<b>Бүгд</b>	72.5	21.1	6.4

10, 20, 50, 100-тын дэвсгэртүүд таны хэрэгцээ хангагддаг уу гэсэн асуултанд хамрагдсан бүх боловсролын түвшний иргэдийн 70.1-73.9 хувь нь тийм гэж хариулжээ. Харин иргэд үгүй гэж 17.7-22.8 хувийн хариултыг өгчээ. Мэдэхгүй гэж үзсэн иргэдийн боловсролын түвшин дээшлэх тусам хувийн жин нь багасаж байна.

Хүснэгт V.7.13 Та гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг үү?

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	54.9	31.2	13.9
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	45.9	40.0	14.1
<b>Тусгай дунд боловсролтой</b>	47.3	40.2	12.4
<b>Дээд боловсролтой</b>	43.2	46.5	10.3
<b>Бүгд</b>	46.0	42.0	12.0

Та гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг үү гэсэн асуултанд аль ч боловсролын ангиллаар авч үзэхэд оролцогчидын 40 гаруй хувь нь тийм, мөн 40 гаруй хувь нь үгүй гэж ойролцоо түвшинд хариулжээ.

Хүснэгт V.7.14 Та хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг уу?

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	23.5	57.8	18.7
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	22.9	61.2	15.9
<b>Тусгай дунд боловсролтой</b>	24.5	59.6	15.9
<b>Дээд боловсролтой</b>	27.5	61.1	11.4
<b>Бүгд</b>	25.3	60.5	14.2

Судалгаанд хамрагдсан аль ч боловсролын ангиллаарх иргэдийн дийлэнх нь хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаасаа авч чаддаггүй гэж хариулжээ. Мэдээллээ авч чаддаг аль ч боловсролын түвшний иргэд 25 орчим хувь байна.

Хүснэгт V.7.15 Та мөнгөө түрийвчэнд хийж цэвэрхэн авч явдаг уу?

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Бүрэн бус дунд боловсролтой</b>	86.3	9.9	3.7
<b>Бүрэн дунд боловсролтой</b>	84.1	12.2	3.7
<b>Тусгай дунд боловсролтой</b>	83.9	10.8	5.3
<b>Дээд боловсролтой</b>	87.7	9.4	2.9
<b>Бүгд</b>	86.0	10.4	3.6

Та мөнгөө түрийвчэнд хийж цэвэрхэн авч явдаг уу гэсэн асуултанд бүх шатны боловсролтой иргэдийн 86.0 хувь нь тийм, 10.4 хувь нь үгүй, үлдсэн 3.6 хувь мэдэхгүй гэж хариулжээ.

## Дүгнэлт

Боловсролын ангиллаар авч үзсэн судалгааны ихэнх асуултын хариулт ойролцоо, өөрөөр хэлбэл аль ч боловсролын ангиллын хүмүүсийн ихэнх хариултын хувийн жин хоорондоо ижил төстэй байв.

Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдлыг 2005 оны судалгаанд сайжирсан гэж хамгийн бага хариултыг бүрэн дунд боловсролтой иргэд, хамгийн их хариултыг дээд боловсролтой иргэд өгч байсан бол 2006 онд иргэдийн үзэх бодол өөрчлөгдөөгүй байна. Аль ч боловсролын ангилал тус бүрт иргэдийн сайжирсан гэсэн хариулт 2005 оныхоос 0.9 нэгжээр өсч, муудсан гэсэн хариулт 0.4 нэгжээр буурчээ. Харин хэвэндээ болон мэдэхгүй гэсэн хариулт харьцангуй өөрчлөлт багатай байна. Өөрөөр хэлбэл боловсролын ангилал тус бүрт судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх эдийн засгийн өнөөгийн байдал хэвэндээ буюу муудсан гэсэн хариултыг 2005 онд өгч байсан бол сүүлчийн судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх өмнөх оныхтой адилхан хариултыг өгсөн байна. Ямар ч боловсролтой иргэдийн дийлэнх үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, татварын ачааллыг багасгах, зээлийн хүүг бууруулах арга хэмжээнүүдийг эдийн засгийн өсөлтийг хангахад чухал гэж өмнөх судалгаатай адил үзсэн хэвээр байлаа. Харин бизнесменүүдэд урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг сонгосон иргэд харьцангуй цөөн байв. Уул уурхай, хөдөө аж ахуйн салбарууд манай улсын эдийн засгийг түргэн хөгжүүлнэ гэж иргэд хамгийн их хариултыг өгсөн нь уул уурхайн салбар сүүлийн жилүүдэд эрчтэй хөгжиж улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь харагдаж байна. 2005 онд боловсролын ямар ч түвшин дэх ихэнх иргэд өргөн хэрэглээний барааны үнийг өсч байна гэж хариулж байсан ба 2006 онд мөн адил дүгнэжээ. Энэ нь нэг талаас дэлхийн зах зээлд нефтийн үнэ өсч, импортоор оруулж ирж буй бензин шатахууны үнэ дотооддоо нэмэгдсэнээс шалтгаалан өргөн хэрэглээний барааны үнэд нөлөөлж болох талтай.

Өөрийн өрхийн амьжиргааны түвшинг ямар ч боловсролын түвшин дэх иргэдийн ихэнх хувь нь хэвэндээ эсвэл доошилсон гэж үзэж байна. Хүн амын ядуурал болон ажилгүйчүүдийн тоо нэмэгдсэн гэж ямарч боловсролтой иргэдийн дийлэнх буюу 75 орчим хувь үзэж байгаа хэдий ч өмнөх судалгааны дүнгээс боловсролын бүх ангилалд хүн амын ядуурал нэмэгдэж, ажилгүйчүүдийн тоо өссөн гэж үзэж буй иргэдийн хувийн жин багасаж, энэ хэмжээгээр тэдний хэвэндээ, буурсан, мэдэхгүй гэсэн хариултууд нэмэгдсэн байна. Газар хувьчлалыг дэмжиж байгаа иргэдийн хувийн жин боловсролын түвшин ахих тусам нэмэгдэж, дэмжихгүй байгаа нь эсрэгээр буурч байна. Өмнөх судалгааны дүнгээс дэмжиж байна гэсэн хариулт боловсролын бүх шатны ангилалд багасаж, дэмжихгүй болон мэдэхгүй гэсэн хариулт өссөн байна. Энэ нь газар хувьчлах үйл ажиллагаа удааршиж, иргэд газар хувьчилж авахад чирэгдэл ихтэй, газрын холбоотой асуудлууд гарч байгаатай холбоотой юм.

Нийт иргэд (аль ч боловсролын ангиллаарх) татварын ерөнхий түвшинг өндөр, татварын ачаалал нэмэгдсэн, татвараас зайлсхийх явдал нийтлэг гэж үзсэн хэвээр байгаа ч өндөр, нэмэгдсэн гэж үзсэн иргэдийн хувийн жин бүх боловсролын шатанд багассан байна. Өөрөөр хэлбэл, өмнөх судалгаатай харьцуулахад татварын түвшинг боломжийн гэсэн хариулт аль ч боловсролын түвшин дэх иргэдийн хувьд өссөн ба энэ хэмжээгээр өндөр гэсэн хариулт буурсан байна. Харин татварын ачааллын талаархи асуултанд хариулсан байдал өмнөх судалгааны дүнгээс харьцангуй багаар өөрчлөгдсөн ба нэмэгдсэн гэсэн хариулт (3.5 нэгжээр) буурч, хэвэндээ, буурсан болон мэдэхгүй гэсэн хариулт бага зэрэг (0.5-1.5 нэгжээр) өсчээ. Татвараас зайлсхийх явдал 2005 оныхоос нийтлэг болон бага гэж боддог иргэдийн хувийн жин бүх боловсролын ангилалд нэмэгдэж, мэдэхгүй гэж үзсэн иргэдийнх буурсан

байна. Тайлант онд УИХ-аас ААН-н орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, НӨАТ болон онцгой албан татварын хуулиудыг шинэчлэн найруулж баталсан. Шинээр баталагдсан хуулиуд нь татварын хувь хэмжээг бууруулах, татварын ихэнх хөнгөлөлт, чөлөөлтийг хүчингүй болгож, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад татварын адил таатай нөхцөл үзүүлэх зэрэг замаар татварын тэгш, шударга байдлыг хангах, татварын ачааллыг багасгаж, татварын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэгдсэн байна. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх нь аж ахуйн нэгжүүд ажиллагсдын цалингаа нэмэгдүүлэх, хувь хүмүүс сайн дурын үндсэн дээр орлого, татвараа үнэн зөв тодорхойлж, татвараа төлдөг болох, татварын ачаалал болон татварын түвшин буурч улмаар иргэд хуримтлалтай болох чухал ач холбогдолтой юм.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банк, санхүүгийн байгууллагын тоог боломжийн гэж аль ч боловсролын түвшний иргэдийн дийлэнх хувь хэвээр үзэж байгаа байна. Олон гэж хариулсан иргэдийн хувь нэлээд хувийг эзэлж байгаа хэвээрээ байгаа ба бүрэн дунд болон дээд боловсролтой иргэдийн хариултын хувийн жин өмнөх судалгааны дүнгээс буурчээ. Боловсролын ангилал ахих тусам цөөн, мэдэхгүй гэсэн хариулт буурч байна. Бүх шатны ангиллын боловсролтой иргэдийн дийлэнх банк санхүүгийн үйл ажиллагааг найдвартай, тэдэнд итгэх итгэл нэмэгдсэн буюу хэвэндээ, тэдгээр нь өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна, тэдний үйлчилгээ хэвийн байна гэж үзжээ. Өмнөх оныхоос тэдэнд итгэх итгэл нэмэгдсэн, үйлчилгээ нь хувь хүнд хүрч, тэдгээр нь өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна гэсэн хариултууд ялимгүй буурсан байна. Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа нь эргэлзээтэй гэсэн хариулт ямарч боловсролтой иргэдийн хувьд харьцангуй өндөр хэвээр байгаа (31.2-35.0) хэдий ч 2005 оныхоос дунджаар 3.6 нэгжээр буурав.

Мөнгөний хэрэгцээ гарвал банкинд ханддаг гэж судалгаанд хамрагдсан ямар ч боловсролтой оролцогчдын дийлэнх хариулсан хэвээр байгаа төдийгүй 2005 оныхоос нэмэгдсэн байна. Харин банкнаас бусад санхүүгийн байгууллагад хандах хандлага аль ч боловсролын ангилалд өмнөх оныхоос буурчээ. Энэ нь сүүлийн үед зарим хадгаламж зээлийн хоршоодын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан байна. Боловсролын түвшин ахих тусам хүмүүсийн хадгаламж зээлийн хоршоодын талаархи мэдлэг нэмэгдэж байгаа бөгөөд нийт иргэдийн 41 хувь нь тодорхой хэмжээний ойлголтой, мөн тэр хэмжээгээрээ ойлголтгүй гэж хариулжээ. Харин мэдэхгүй гэсэн хариулт боловсролын шат ахих тусам 25.5-11.1 болтол буурсан байна. Судалгаанд хамрагдагсадын бүх шатны боловсролтой иргэдийн 10 гаруй хувь нь ямар нэгэн хадгаламж зээлийн хоршооны гишүүн байна. Тэдний үйл ажиллагааг ихэнх иргэд (49.7 хувь) дүгнэж чадахгүй байгаагийн дотор ялангуяа боловсролын түвшин буурах тусам энэ хандлага улам ажиглагдаж байна. Харин тэдний үйл ажиллагааг зөв, хуулийн дагуу эсвэл буруу хууль бус гэж үзэж буй хандлага боловсролын ангилал ахих тусам нэмэгдэж байв. Энэ нь нэг талаас иргэд болон ХЗХ-ны гишүүдийн санхүүгийн болон хуулийн мэдлэг хомс, хоршооны үйл ажиллагаа явуулах зарчим, дотоод ардчиллын талаархи мэдээлэл хангалтгүй, хоршооны үйл ажиллагаанд хууль, дүрэмд заасан эрхийнхээ дагуу оролцогдоггүй хяналт тавьдаггүй, зөвхөн мөнгөө хадгалуулж хүү авах, мөнгөө өсгөх төдий ойлголттой байгаатай холбоотой юм.

Гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой эсвэл мэдэхгүй гэсэн хариулт аль ч боловсролын түвшинд ихэнх иргэдийн саналыг авч байгаа хэвээр байгаа хэдий ч 2005 оны судалгааны дүнгээс ач холбогдолтой гэсэн хариулт бүрэн дунд боловсролтой иргэдийн хувьд хамгийн их, бусад



иргэдийн хувьд бага зэрэг буурч, мэдэхгүй гэсэн хариулт дээд боловсролтой иргэдийн хувьд л буурсан байна. 2005 оныхоос бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг хэрэглэдэг хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгаа ч нийт иргэдийн дийлэнх хэрэглэдэггүй хэвээр байгаа ба хэрэглэх хандлага нь боловсролын түвшин нэмэгдэх тусам ихэссэн байна. Хүмүүс бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийн талаар тодорхой мэдлэгтэй байгаа нь судалгаанд хамрагдагсадын ердөө 4.8 орчим хувь нь мэдэхгүй гэж хариулснаас харагдаж байна.

Хуримтлуулсан мөнгөө банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, бусад байдлаар зарцуулдаг гэсэн хариултыг боловсролын бүх ангилал дахь иргэд түлхүү сонгосон хэвээр байгаа бөгөөд ихэнх нь өмнөх оны хариултуудтай ойролцоо хувьтай байна. Харин өмнөх судалгааны дүнгээс дээд, тусгай дунд, бүрэн дунд боловсролтой иргэдийн банк санхүүгийн байгууллагад хадгалуулах гэсэн хариулт арай өндөр өсөлттэй хариулт байв. Бусдад зээлдүүлэх, хувьцаа худалдаж авах, үнэт цаасанд байршуулах явдал нийт иргэдийн дунд өмнөх судалгаатай адил бага байна. Мөнгөө бэлнээр үүн дотроо төгрөгөөр хадгалах сонирхол аль ч боловсролын түвшин дэх иргэдийн дунд өндөр хэвээр байгаа ба бэлэн бусаар, үнэт цаасаар гэсэн хариултууд ангилал тус бүрт бага зэрэг буурсан байна. Хадгаламжийн хүүг нийт иргэд бага, ялангуяа боловсролын түвшин ахих тусам ингэж үзэж буй иргэдийн хувийн жин нэмэгджээ.

Аль ч боловсролын түвшин дэх иргэдэд зээлийн хэрэгцээ их байгаа хэвээр байгаа ба тэдний ихэнх банк санхүүгийн байгууллагаас олгож буй зээлийг хүртээмжтэй гэж дүгнэдэг ч багагүй хувь нь хүртээмжгүй гэж үздэг байна. Мөн зээл авахад хүндрэлтэй, зээлийн хүү өндөр гэж үзэж байгаа хэвээр байна. Энэ нь 2005 оны судалгаанаас зээл авахад хүндрэлтэй, зээлийн хүү өндөр гэж үзсэн иргэдийн хувийн жин боловсролын бүх шатанд өссөн байна.

Ихэнх иргэд бичил санхүүгийн талаар ойлголтой ба энэ нь боловсролын ангилал ахих тусам нэмэгдэж байгаа бөгөөд аль ч боловсролоорх иргэдийн дийлэнх өөрийн оршин суугаа газрынхаа бичил санхүүгийн үйл ажиллагааг дунд зэрэг хөгжсөн гэж дүгнэж байна. Ямар ч боловсролтой иргэдийн олонхи бичил зээл авах боломжтой гэсэн хариулт өгсөн бөгөөд бичил зээл авдаг иргэдийн ихэнх худалдаа наймаанд зээлээ зарцуулдаг юм байна. Мөн жижиг дунд үйлдвэрлэл, мал аж ахуй, үйлчилгээ, хүнсний ногоо, газар тариаланд зарцуулдаг гэж хариулсан байна. Газар тариалан, хүнсний ногоо, мал аж ахуйн салбарт зээлээ зарцуулна гэсэн иргэдийн хариулт өмнөх оныхоос өсч, бусад салбарынх буурчээ. Энэ нь иргэд өөрсдөө хүнсний ногоо тарих, газар тариалан эрхлэх явдал ихэссэн, мөн газар тариалан, мал аж ахуй хөгжүүлэхийг дэмжсэн гадна дотны төслүүд хэрэгжиж байгаатай холбоотой юм. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 1.5-2 сая гэж судалгаанд оролцсон ямарч боловсролтой иргэдийн олонхи хариулсан бөгөөд энэ нь боловсролын түвшин нэмэгдэх тусам өсөх хандлагатай байв. Мөн 250-500 мянга, 500 мянгаас 1 сая, 1-1.5 сая төгрөг шаардлагатай гэж үзэж буй иргэд аль боловсролын түвшинд багагүй хувийг эзэлж байна. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 9-12 сар шаардагдах бөгөөд зээлийн хүү өндөр гэж аль ч боловсролын түвшинтэй иргэдийн дийлэнх үзэж байна. Өнөөдөр зээлийн хэмжээ бага, хүү өндөр, хугацаа богино гэж ихэнх иргэд үзэж байгаа нь зах зээл дээр зээлийн эрэлт хэрэгцээ их байгаагаас гадна банкнаас бусад санхүүгийн байгууллага буюу санхүүгийн зах зээл сайн хөгжөөгүйтэй холбоотой. Ялангуяа үнэт цаасны зах зээлийн хөгжил сул дорой, компаниуд жижиг, зах зээлд эзлэх байр сууриа сайн олоогүй, ашиг орлого нь доогуур, ашигтай ажиллаа ч ногдол ашиг хуваадаггүй, жижиг хувьцаа

эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан дүрэм журам байдаггүй, ард иргэдийн үнэт цаасны талаарх мэдлэг хомс зэргээс шалтгаалж байна.

Иргэдийн ихэнх хувь нь 1-т, 5-тын дэвсгэрт болон 50, 100, 200, 500-тын зоосон мөнгийг хэрэглэдэггүй гэж үзэж байгаа бөгөөд энэ нь боловсролын түвшин нэмэгдэх тусам өсөх хандлагатай байна. Энэ нь бага дэвсгэрт болон зоосон мөнгийг гүйлгээнд төдийлөн хэрэглэдэггүй, мөн иргэд зоосон мөнгийг хэрэглэж сураагүй, авч явахад хүндрэлтэй зэргээс шалтгаалж болох юм. Гүйлгээнд байгаа дэвсгэртийн хийц дизайн таалагддаг гэж аль ч шатны боловсролын иргэдийн ихэнх буюу 70 гаруй хувь нь хариулсан байна. Харин мөнгөн дэвсгэртүүдийн эдэлгээ даах чанарын талаар аль ч боловсролын ангиллаарх иргэдийн 40 гаруй хувь нь чанартай, мөн энэ хэмжээгээр чанаргүй гэж хариулжээ. Гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийн эдэлгээ даах чанартай гэж үзсэн иргэдийн боловсролын түвшин буурах тусам хувийн жин ихсэж байна. Харин аль ч боловсролын иргэдийн 80 гаруй хувь нь мөнгөө түүрийвчэнд хийж цэвэрхэн авч явдаг гэжээ. Шинээр удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгт хэрэгцээгүй гэж судалгаанд хамрагсадын талаас илүү хувь нь үзсэн байна. Хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаасаа авч чаддаггүй гэж аль ч боловсролын шатны иргэдийн дийлэнх нь хариулсан байна. Сүүлийн үед хуурамч мөнгөн дэвсгэрт, ялангуяа 5000, 10000-тын дэвсгэртүүд илэрч байгаа ба банкууд түүнээс сэргийлэх үүднээс олон нийт, харилцагчиддаа сайтар сурталчилж, мэдээлэл өгөх хэрэгтэй болов уу.

## V. АЖИЛ ЭРХЛЭЛТ

Нийгэм эдийн засаг болон банк, санхүүгийн салбарын талаархи иргэдийн бодол санаа ажил эрхлэлтийн байдлаас хамааран ялгавартай байж болох талтай. Энэ ялгааг гаргахын тулд судалгааны үр дүнг ажил эрхлэлтийн байдлаас нь хамааруулан ангилж гаргах нь зүйтэй юм. Монгол улсын суурин хүн ам 2005 оны эцсийн байдлаар 2562.4 мянгад хүрснээс хөдөлмөрийн насны хүн ам 1577.0 мянга, эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүч 1001.2 мянга, ажиллагсад 968.3 мянга болжээ.

## V. 1. Эдийн засгийн ерөнхий асуудлууд

## Хүснэгт V.1.1 Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал таны бодлоор (%)

		Сайжирсан	Муудсан	Хэвэндээ	Мэдэхгүй
Улсын байгууллагад	2005	29.6	26.9	38.2	5.3
	2006	32.8	24.2	37.6	5.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>3.2</i>	<i>-2.7</i>	<i>-0.6</i>	<i>0.1</i>
Хувийн байгууллагад	2005	26.1	29.4	37.8	6.7
	2006	25.1	30.5	37.2	7.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.0</i>	<i>1.1</i>	<i>-0.6</i>	<i>0.6</i>
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	2005	22.4	30.3	37.3	10.0
	2006	21.8	33.3	36.7	8.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.6</i>	<i>3.0</i>	<i>-0.6</i>	<i>-1.8</i>
Ажилгүй	2005	16.6	40.3	31.4	11.7
	2006	17.4	38.2	30.8	13.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.8</i>	<i>-2.1</i>	<i>-0.6</i>	<i>1.9</i>
Бусад	2005	30.0	25.2	32.3	12.5
	2006	30.0	25.8	32.2	11.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.0</i>	<i>0.6</i>	<i>-0.1</i>	<i>-0.6</i>
Бүгд	2005	25.1	30.3	36.2	8.3
	2006	25.9	30.0	35.9	8.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.8</i>	<i>-0.3</i>	<i>-0.3</i>	<i>-0.1</i>

Монгол улсын эдийн засгийн байдал сайжирч байна гэж нийт санал асуулгад оролцогчдын 25.9 хувь нь хариулсан бөгөөд 2005 онтой харьцуулахад 0.8 нэгжээр өссөн байна. Үүнийг ажил эрхлэлтийн байдлаар задалж үзье. Улсын байгууллагад ажилладаг иргэдийн 32. хувь нь сайжирч байна гэж хариулсан нь 2005 онтой харьцуулвал 3.2 нэгжээр өссөн байна. Харин хувийн байгууллагад ажилладаг болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд сайжирч байна гэсэн хариулт нь 2005 онтой харьцуулвал харгалзан 1.0, 0.6 нэгжээр буурсан байна. Харин эсрэгээр эдийн засгийн байдал муудаж байна гэж хариулсан хүмүүсийн хувь 2005 онтой харьцуулахад 0.3 нэгжээр буурсан бөгөөд ажил эрхлэлтийн байдлаар задалж үзвэл улсын байгууллагад ажилладаг болон ажилгүй иргэдийн дээрх хариултын хувь харгалзан 2.7, 2.1 нэгжээр буурсан бол хувийн байгууллагад ажилладаг болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн дээрх хариултын хувь харгалзан 1.1, 3.0 нэгжээр тус тус өссөн байна. Харин хэвэндээ байгаа гэж хариулсан байдлыг ерөнхийд нь болон ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл бүх бүлгийн хувьд 2005 онтой харьцуулахад буурсан байгаа нь иргэдийн амьдралын түвшин 2005 онтой харьцуулахад ямар нэг байдлаар өөрчлөгдөж байгааг харуулж байна.

Хүснэгт V.1.2 Таны бодлоор эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?(%)

		Татварын ачааллыг багасгах	Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх	Зээлийн хүүг бууруулах	Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих	Бизнесмэнүүдэд урамшуулал хөнгөлөлт үзүүлэх	Бусад
<b>Улсын байгууллагад</b>	2005	24.4	13.3	27.2	27.5	6.2	1.4
	2006	42.0	21.6	45.0	48.6	9.3	2.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>17.6</i>	<i>8.3</i>	<i>17.8</i>	<i>21.1</i>	<i>3.1</i>	<i>0.6</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	27.3	11.6	21.9	30.2	7.9	1.1
	2006	47.1	22.5	38.8	50.1	16.4	2.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>19.8</i>	<i>10.9</i>	<i>16.9</i>	<i>19.9</i>	<i>8.5</i>	<i>1.4</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	27.8	9.1	26.1	24.7	10.9	1.5
	2006	40.9	17.2	46.8	40.6	23.0	2.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>13.1</i>	<i>8.1</i>	<i>20.7</i>	<i>15.9</i>	<i>12.1</i>	<i>1.2</i>
<b>Ажилгүй</b>	2005	22.8	12.4	24.7	30.0	6.6	3.4
	2006	34.4	18.1	37.9	45.7	12.8	3.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>11.6</i>	<i>5.7</i>	<i>13.2</i>	<i>15.7</i>	<i>6.2</i>	<i>-0.2</i>
<b>Бусад</b>	2005	22.6	13.1	21.8	31.4	8.0	3.1
	2006	36.6	22.2	38.1	55.9	13.2	3.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>14.0</i>	<i>9.1</i>	<i>16.3</i>	<i>24.5</i>	<i>5.2</i>	<i>0.6</i>
<b>Бүгд</b>	2005	25.4	11.8	24.8	28.4	7.7	1.8
	2006	41.6	20.4	42.2	47.4	14.9	2.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>16.2</i>	<i>8.6</i>	<i>17.4</i>	<i>19.0</i>	<i>7.2</i>	<i>0.8</i>

Эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын 41.6 хувь нь татварыг ачааллыг багасгах (2005 онтой харьцуулвал 16.2 нэгжээр өссөн), 20.4 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх (2005 онтой харьцуулвал 8.6 нэгжээр өссөн), 42.2 хувь нь зээлийн хүүг бууруулах (2005 онтой харьцуулвал 17.4 нэгжээр өссөн), 47.4 хувь нь үндэсний үйлдвэрлэлтийг дэмжих (2005 онтой харьцуулвал 19.0 нэгжээр өссөн), 14.9 хувь нь бизнесмэнүүдэд урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх (2005 онтой харьцуулвал 7.2 нэгжээр өссөн), 2.6 хувь нь бусад (2005 онтой харьцуулвал 0.8 нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ. 2006 оны түүвэр судалгааны дүнг ажил эрхлэлтийн байдлаар задлан үзвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд зээлийн хүүг илүүд эрхэмлэсэн бол ажил эрхлэлтийн бусад бүлгийн иргэд үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийг эрхэмлэсэн байна.

#### Хүснэгт V.1.3 Таны бодлоор ямар салбар манай улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх вэ?(%)

		Уул уурхай	Хөдөө аж ахуй	Хөнгөн үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Банк санхүү	Худалдаа үйлчилгээ	Бусад
<b>Улсын байгууллагад</b>	2005	24.8	24.3	12.4	18.5	10.5	7.9	1.6
	2006	54.9	39.5	22.0	29.9	15.2	11.6	1.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>30.1</i>	<i>15.2</i>	<i>9.6</i>	<i>11.4</i>	<i>4.7</i>	<i>3.7</i>	<i>-0.1</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	25.1	24.7	14.4	17.8	9.4	7.2	1.4
	2006	52.5	38.4	23.2	29.5	16.2	12.8	3.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>27.4</i>	<i>13.7</i>	<i>8.8</i>	<i>11.7</i>	<i>6.8</i>	<i>5.6</i>	<i>2.3</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	22.4	25.5	15.2	14.8	9.9	10.6	1.5
	2006	44.9	39.0	21.8	26.2	15.3	17.4	3.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>22.5</i>	<i>13.5</i>	<i>6.6</i>	<i>11.4</i>	<i>5.4</i>	<i>6.8</i>	<i>2.4</i>
<b>Ажилгүй</b>	2005	21.5	25.1	14.3	16.3	10.2	9.0	3.7

	2006	45.7	37.8	21.1	23.9	12.5	12.6	3.1
	<i>Өөрчлөлт</i>	24.2	12.7	6.8	7.6	2.3	3.6	-0.6
<b>Бусад</b>	2005	21.6	26.0	11.6	21.8	7.5	6.8	4.7
	2006	52.7	40.4	19.6	29.8	12.0	13.3	5.3
	<i>Өөрчлөлт</i>	31.1	14.4	8.0	8.0	4.5	6.5	0.6
<b>Бүгд</b>	2005	23.6	24.9	13.7	17.5	9.8	8.4	2.1
	2006	50.6	38.9	22.0	28.1	14.9	13.4	3.1
	<i>Өөрчлөлт</i>	27.0	14.0	8.3	10.6	5.1	5.0	1.0

Ямар салбар манай улсын эдийн засгийг түргэн хөгжүүлэх вэ? гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 50.6 хувь нь уул уурхай, 38.9 хувь нь хөдөө аж ахуй, 22.0 хувь нь хөнгөн үйлдвэрлэл, 28.1 хувь нь аялал жуулчлал, 14.9 хувь нь банк санхүү, 13.4 хувь нь худалдаа үйлчилгээ, 3.1 хувь нь бусад гэж тус тус хариулжээ. 2006 оны түүвэр судалгааны дүнг ажил эрхлэлтийн байдлаар задлан үзвэл ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд 2005 онд хөдөө аж ахуйн салбарт нэлээд ач холбогдол өгч байсан бол 2006 онд уул уурхайн салбарт илүү ач холбогдол өгч байна. Тухайлбал, бүгд дүнгээр нь авч үзвэл 2005-2006 онд хөдөө аж ахуйн салбарыг сонгосон хариултын хувь 14.0 нэгжээр өссөн байхад уул уурхайн салбарыг сонгосон хариултын хувь 27.0 нэгжээр өссөн байна. Ажил эрхлэлтийн бүлэг тус бүрийн хариулсан байдлыг дээрх хүснэгтээс харж болно.

#### Хүснэгт V.1.4 Өргөн хэрэглээний барааны үнэ таны бодлоор

		Өсч байна	Буурч байна	Тогтвортой	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	92.6	1.1	5.4	0.9
	2006	92.7	1.2	5.0	1.1
	<i>Өөрчлөлт</i>	0.1	0.1	-0.4	0.2
<b>Хувийн байгууллагад</b>	2005	90.9	1.1	5.8	2.2
	2006	91.6	1.5	5.2	1.7
	<i>Өөрчлөлт</i>	0.7	0.4	-0.6	-0.5
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	89.3	2.3	7.0	1.4
	2006	89.3	3.0	5.7	2.1
	<i>Өөрчлөлт</i>	0.0	0.7	-1.3	0.7
<b>Ажилгүй</b>	2005	90.6	1.9	4.9	2.6
	2006	86.8	3.6	5.9	3.8
	<i>Өөрчлөлт</i>	-3.8	1.7	1.0	1.2
<b>Бусад</b>	2005	89.5	2.1	6.8	1.6
	2006	89.0	2.0	5.7	3.3
	<i>Өөрчлөлт</i>	-0.5	-0.1	-1.1	1.7
<b>Бүгд</b>	2005	90.8	1.6	5.9	1.7
	2006	90.5	2.1	5.4	2.0
	<i>Өөрчлөлт</i>	-0.3	0.5	-0.5	0.3

Өргөн хэрэглээний барааны үнэ таны бодлоор гэсэн асуултанд түүвэр судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 90.5 хувь нь өсч байна, 2.1 хувь нь буурч байна, 5.4 хувь нь тогтвортой байна, 2.0 хувь нь мэдэхгүй гэж тус тус хариулсан байна. 2005 оны судалгаатай харьцуулбал өсч байна гэсэн хариулт 0.3 нэгжээр буурч, харин буурч байна гэсэн хариулт 0.5 нэгжээр өссөн байна. Ажил эрхлэлтийн байдлаар задалж үзвэл ажилгүй иргэдээс бусад бүлгийн хувьд өсч байна гэсэн хариулт бага хэмжээгээр өссөн байна. Харин ажилгүй иргэдийн хувьд өсч байна гэсэн хариулт 2005 оноос 3.8 нэгжээр буурсан байна.

## V. 2. Нийгмийн тулгамдсан асуудлууд

**Хүснэгт V.2.1 Танай өрхийн амьжиргааны түвшин**

		Дээшилсэн	Доошилсон	Хэвэндээ	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	14.4	34.2	49.9	1.4
	2006	20.5	24.7	53.7	1.2
	<i>Өөрчлөлт</i>	6.1	-9.5	3.8	-0.2
<b>Хувийн байгууллагад</b>	2005	17.6	25.2	55.5	1.7
	2006	21.2	23.8	53.4	1.7
	<i>Өөрчлөлт</i>	3.6	-1.4	-2.1	0.0
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	21.3	26.1	50.2	2.5
	2006	22.8	23.5	51.9	1.8
	<i>Өөрчлөлт</i>	1.5	-2.6	1.7	-0.7
<b>Ажилгүй</b>	2005	9.8	46.4	41.1	2.7
	2006	10.2	38.2	48.4	3.1
	<i>Өөрчлөлт</i>	0.4	-8.2	7.3	0.4
<b>Бусад</b>	2005	22.2	31.4	43.2	3.2
	2006	21.3	26.5	47.4	4.8
	<i>Өөрчлөлт</i>	-0.9	-4.9	4.2	1.6
<b>Бүгд</b>	2005	16.5	32.0	49.4	2.1
	2006	19.6	26.4	52.0	2.0
	<i>Өөрчлөлт</i>	3.1	-5.6	2.6	-0.1

Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 19.6 хувь нь дээшилсэн (2005 оноос 3.1 нэгжээр өссөн), 26.4 нь доошилсон (2005 оноос 5.6 нэгжээр буурсан), 52.0 хувь хэвэндээ (2005 оноос 2.6 нэгжээр өссөн), 2.0 мэдэхгүй (2005 оноос 0.1 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Ажил эрхлэлтийн бүлгээр задалж үзвэл бусад гэсэн бүлгээс өөр бүх бүлгийн хувьд амьдралын түвшин дээшилсэн гэсэн хариулт нэмэгдсэн бол амьдралын түвшин доошилсон гэсэн хариулт бүх бүлгүүдийн хувьд буурсан байна. Харин амьдралын түвшин хэвэндээ гэсэн хариулт хувийн байгууллагад ажилладаг иргэдийн хувьд 2.1 нэгжээр буурсан бол, бусад бүлгүүдийн хувьд нэмэгдсэн байна.

**Хүснэгт V.2.2 Хүн амын ядуурал таны бодлоор**

		Нэмэгдсэн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	80.3	6.2	11.3	2.2
	2006	75.4	7.2	14.3	3.1
	<i>Өөрчлөлт</i>	-4.9	1.0	3.0	0.9
<b>Хувийн байгууллагад</b>	2005	79.1	5.7	12.5	2.7
	2006	77.3	6.2	13.5	3.0
	<i>Өөрчлөлт</i>	-1.8	0.5	1.0	0.3
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	77.6	5.7	12.9	3.8
	2006	75.8	6.4	15.0	2.8
	<i>Өөрчлөлт</i>	-1.8	0.7	2.1	-1.0
<b>Ажилгүй</b>	2005	78.1	7.0	9.7	5.2
	2006	73.7	8.9	12.0	5.4
	<i>Өөрчлөлт</i>	-4.4	1.9	2.3	0.2
<b>Бусад</b>	2005	72.9	9.2	13.1	4.8
	2006	72.1	6.4	16.5	5.1
	<i>Өөрчлөлт</i>	-0.8	-2.8	3.4	0.3
<b>Бүгд</b>	2005	78.5	6.3	11.8	3.4
	2006	75.5	7.0	14.1	3.5
	<i>Өөрчлөлт</i>	-3.0	0.7	2.3	0.1

Хүн амын ядуурал таны бодлоор гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 75.5 хувь нь нэмэгдсэн (2005 оноос 3.0 нэгжээр буурсан), 7.0 хувь нь буурсан (2005 оноос 0.7 нэгжээр өссөн), 14.1 хувь нь хэвэндээ (2005 оноос 2.3 нэгжээр өссөн), 3.5 мэдэхгүй (2005 оноос 0.1 нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ.

Нэмэгдсэн гэсэн хариулт 2005 онтой харьцуулбал 3.0 нэгжээр буурчээ. Үүнийг ажил эрхлэлтээр задалвал улсын байгууллагынх 4.9 нэгж, хувийн байгууллагынх 1.8 нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 1.8 нэгж, ажилгүй хүмүүсийнх 4.4 нэгж, бусад гэсэн бүлгийнх 0.8 нэгжээр тус тус буурчээ.

Буурсан гэсэн хариулт 2005 онтой харьцуулбал 0.7 нэгжээр өсчээ. Үүнийг ажил эрхлэлтээр задалвал бараг ялгаа харагдахгүй байна. Хэвэндээ гэсэн хариулт 2005 онтой харьцуулбал 6.2 нэгжээр буурчээ. Үүнийг ажил эрхлэлтээр задалвал ажилгүй иргэдийн хариултын хувь 1.9 хувиар өсч, бусад гэсэн бүлгийн хувьд 2.8 нэгжээр буурсан бол бусад бүлгүүдийн хувьд судалгаанд оролцогчдын нийт дүнтэй ижил байна.

Хэвэндээ гэсэн хариулт 2005 онтой харьцуулбал 2.3 нэгжээр өсчээ. Үүнийг ажил эрхлэлтээр задалвал улсын байгууллагынх 3.0 нэгж, хувийн байгууллагынх 1.0 нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 2.1 нэгж, ажилгүй хүмүүсийнх 2.3 нэгж, бусад гэсэн бүлгийнх 3.4 нэгжээр тус тус өссөг байна.

#### Хүснэгт V.2.3 Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор

		Өссөн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	81.9	4.3	10.6	3.2
	2006	76.9	6.6	12.4	4.1
	<i>Өөрчлөлт</i>	<i>-5.0</i>	<i>2.3</i>	<i>1.8</i>	<i>0.9</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	79.9	5.4	11.0	3.6
	2006	75.9	7.2	12.6	4.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.0</i>	<i>1.8</i>	<i>1.6</i>	<i>0.6</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	81.5	4.6	10.0	3.8
	2006	77.3	7.5	11.8	3.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.2</i>	<i>2.9</i>	<i>1.8</i>	<i>-0.4</i>
<b>Ажилгүй</b>	2005	83.8	4.9	7.2	4.1
	2006	77.1	6.8	10.6	5.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>-6.7</i>	<i>1.9</i>	<i>3.4</i>	<i>1.4</i>
<b>Бусад</b>	2005	75.2	8.4	10.7	5.7
	2006	71.2	8.0	13.5	7.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.0</i>	<i>-0.4</i>	<i>2.8</i>	<i>1.6</i>
<b>Бүгд</b>	2005	81.0	5.1	10.0	3.8
	2006	76.3	7.1	12.1	4.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.7</i>	<i>2.0</i>	<i>2.1</i>	<i>0.7</i>

Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 76.3 хувь нь өссөн (2005 оноос 4.7 нэгжээр буурсан), 7.1 хувь нь буурсан (2005 оноос 2.0 нэгжээр өссөн), 12.1 хувь нь хэвэндээ (2005 оноос 2.1 нэгжээр өссөн), 4.5 хувь нь мэдэхгүй (2005 оноос 0.7 нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ. Өссөн гэсэн хариулт ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд 4.0-5.0 нэгжээр буурсан байна. Харин буурсан гэсэн хариулт бусад гэсэн бүлгийн хувьд 0.4 нэгжээр буурч, өөр бүлгүүдийн хувьд 1.8-2.9 нэгжээр өссөн бол хэвэндээ гэсэн хариулт бүх бүлгүүдийн хувьд өссөн байна.

#### Хүснэгт V.2.4 Газар хувьчлалын талаархи таны бодол

		Дэмжиж байна	Дэмжихгүй байна	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	66.5	24.9	8.6
	2006	60.1	28.9	10.9

	<i>Өөрчлөлт</i>	-6.4	4.0	2.3
<b>Хувийн байгууллагад</b>	2005	64.0	25.1	10.9
	2006	57.4	29.8	12.7
	<i>Өөрчлөлт</i>	-6.6	4.7	1.8
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	63.6	23.8	12.7
	2006	56.2	30.5	13.3
	<i>Өөрчлөлт</i>	-7.4	6.7	0.6
<b>Ажилгүй</b>	2005	58.1	28.0	13.9
	2006	48.4	32.5	19.1
	<i>Өөрчлөлт</i>	-9.7	4.5	5.2
<b>Бусад</b>	2005	64.7	21.2	14.1
	2006	54.8	26.9	18.3
	<i>Өөрчлөлт</i>	-9.9	5.7	4.2
<b>Бүгд</b>	2005	63.6	25.0	11.4
	2006	56.4	29.9	13.7
	<i>Өөрчлөлт</i>	-7.2	4.9	2.3

Газар хувьчлалын талаархи таны бодол гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 56.4 хувь нь дэмжиж байна (2005 оноос 7.2 нэгжээр буурсан), 29.9 хувь нь дэмжихгүй байна (2005 оноос 4.9 нэгжээр өссөн), 13.7 хувь нь мэдэхгүй (2005 оноос 2.3 нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ. Дэмжиж байна гэсэн хариулт ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд 2005 онтой харьцуулахад 6.4-9.9 нэгжээр буурсан байна. Харин дэмжихгүй байна гэсэн хариулт 2005 онтой харьцуулахад бүх бүлгүүдийн хувьд 4-6.7 нэгжээр нэмэгдсэн бол мэдэхгүй гэсэн хариулт бүх бүлгүүдийн хувьд өссөн байна.

### V. 3. Татварын талаар

#### Хүснэгт V.3.1 Татварын ерөнхий түвшин таны бодлоор

		Өндөр	Боломжийн	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	74.3	16.8	8.9
	2006	73.2	16.5	10.3
	<i>Өөрчлөлт</i>	-1.1	-0.3	1.4
<b>Хувийн байгууллагад</b>	2005	80.7	10.4	8.9
	2006	78.7	12.2	9.1
	<i>Өөрчлөлт</i>	-2.0	1.8	0.2
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	77.3	13.9	8.8
	2006	74.7	14.6	10.7
	<i>Өөрчлөлт</i>	-2.6	0.7	1.9
<b>Ажилгүй</b>	2005	68.9	14.2	16.8
	2006	65.5	15.2	19.3
	<i>Өөрчлөлт</i>	-3.4	1.0	2.5
<b>Бусад</b>	2005	63.7	18.7	17.6
	2006	60.8	21.8	17.4
	<i>Өөрчлөлт</i>	-2.9	3.1	-0.2
<b>Бүгд</b>	2005	74.7	14.4	10.9
	2006	72.9	15.2	11.9
	<i>Өөрчлөлт</i>	-1.8	0.8	1.0

Татварын ерөнхий түвшин таны бодлоор гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 72.9 хувь нь өндөр (2005 оноос 1.8 нэгжээр буурсан), 15.2 хувь нь боломжийн (2005 оноос 0.8 нэгжээр өссөн), 11.9 хувь нь мэдэхгүй (2005 оноос 1.0



нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ. Өндөр байна гэсэн хариулт 2005 онтой харьцуулахад бүх бүлгүүдийн хувьд 1.1-3.4 нэгжээр буурсан байна. Харин боломжийн гэсэн хариулт 2005 онтой харьцуулахад улсын байгууллагад ажилладаг иргэдийн хувьд 0.3 нэгжээр буурч, бусад бүлгүүдийн хувьд 0.7-3.1 нэгжээр нэмэгдсэн бол мэдэхгүй гэсэн хариулт бусад гэсэн бүлгийн хувьд 0.2 нэгжээр буурч, өөр бүлгүүдийн хувьд 0.4-2.5 хүртэлх нэгжээр өссөн байна.

#### Хүснэгт V.3.2 Татварын ачаалал сүүлийн жилүүдэд

		Нэмэгдсэн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	67.7	2.7	18.9	10.7
	2006	63.9	3.9	20.2	12.0
	<i>Өөрчлөлт</i>	-3.8	1.2	1.3	1.3
<b>Хувийн байгууллагад</b>	2005	69.1	2.1	17.6	11.1
	2006	66.3	3.0	18.9	11.7
	<i>Өөрчлөлт</i>	-2.8	0.9	1.3	0.6
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	71.6	1.2	18.2	9.0
	2006	68.7	3.1	17.2	11.1
	<i>Өөрчлөлт</i>	-2.9	1.9	-1.0	2.1
<b>Ажилгүй</b>	2005	65.0	2.2	16.3	16.5
	2006	58.6	5.1	16.8	19.5
	<i>Өөрчлөлт</i>	-6.4	2.9	0.5	3.0
<b>Бусад</b>	2005	58.2	3.4	21.2	17.1
	2006	56.5	4.0	19.5	20.0
	<i>Өөрчлөлт</i>	-1.7	0.6	-1.7	2.9
<b>Бүгд</b>	2005	67.7	2.2	18.2	11.9
	2006	64.2	3.7	18.7	13.4
	<i>Өөрчлөлт</i>	-3.5	1.5	0.5	1.5

Татварын ачаалал сүүлийн жилүүдэд таны бодлоор гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 64.2 хувь нь нэмэгдсэн (2005 оноос 3.5 нэгжээр буурсан), 3.7 хувь нь буурсан (2005 оноос 1.5 нэгжээр өссөн), 18.7 хувь нь хэвэндээ (2005 оноос 0.5 нэгжээр өссөн), 13.4 хувь нь мэдэхгүй (2005 оноос 1.5 нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ. Нэмэгдсэн гэсэн хариулт ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд 2005 онтой харьцуулахад 1.7-6.4 нэгжээр буурсан байна. Харин буурсан гэсэн хариулт бүх бүлгүүдийн хувьд 0.6-2.9 нэгжээр өссөн бол хэвэндээ гэсэн хариулт бусад болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд харгалзан 1.0, 1.7 нэгжээр тус тус буурч, бусад бүлгүүдийн хувьд 0.5-1.3 нэгжээр өссөн байна.

#### Хүснэгт V.3.3 Татвараас зайлсхийх явдал таны бодлоор

		Нийтлэг	Бага	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	67.4	9.5	23.1
	2006	70.6	10.4	19.0
	<i>Өөрчлөлт</i>	3.2	0.9	-4.1
<b>Хувийн байгууллагад</b>	2005	72.5	8.1	19.3
	2006	72.9	8.5	18.5
	<i>Өөрчлөлт</i>	0.4	0.4	-0.8
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	64.0	11.4	24.6
	2006	63.9	12.4	23.7
	<i>Өөрчлөлт</i>	-0.1	1.0	-0.9
<b>Ажилгүй</b>	2005	58.9	10.1	31.0
	2006	61.0	12.4	26.5

	<i>Өөрчлөлт</i>	2.1	2.3	-4.5
<b>Бусад</b>	2005	67.0	7.8	25.2
	2006	67.2	9.5	23.3
	<i>Өөрчлөлт</i>	0.2	1.7	-1.9
<b>Бүгд</b>	2005	66.5	9.5	23.9
	2006	68.1	10.6	21.3
	<i>Өөрчлөлт</i>	1.6	1.1	-2.6

Татвараас зайлсхийх явдал таны бодлоор гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 68.1 хувь нь нийтлэг (2005 оноос 1.6 нэгжээр өссөн), 10.6 хувь нь бага (2005 оноос 1.1 нэгжээр өссөн), 21.3 хувь нь мэдэхгүй (2005 оноос 2.6 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Нийтлэг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээс бусад бүх бүлгүүдийн хувьд 2005 онтой харьцуулахад өссөн байна. Харин бага гэсэн хариулт судалгаанд оролцсон ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд 2005 онтой харьцуулахад 0.4-2.3 нэгжээр өссөн байна.

#### V. 4. Банк, санхүүгийн байгууллагын талаар

**Хүснэгт V.4.1 Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банк, санхүүгийн байгууллагуудын тоо таны бодлоор**

		Олон	Цөөн	Боломжийн	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	38.0	9.3	47.4	5.3
	2006	38.9	7.1	50.2	3.8
	<i>Өөрчлөлт</i>	0.9	-2.2	2.8	-1.5
<b>Хувийн байгууллагад</b>	2005	42.0	5.9	46.9	5.2
	2006	39.3	5.1	51.6	4.0
	<i>Өөрчлөлт</i>	-2.7	-0.8	4.7	-1.2
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	39.0	8.0	46.2	6.8
	2006	36.0	7.1	51.7	5.2
	<i>Өөрчлөлт</i>	-3.0	-0.9	5.5	-1.6
<b>Ажилгүй</b>	2005	40.0	8.7	40.9	10.5
	2006	41.0	7.2	42.9	8.9
	<i>Өөрчлөлт</i>	1.0	-1.5	2.0	-1.6
<b>Бусад</b>	2005	43.2	8.2	41.4	7.1
	2006	37.1	6.8	49.5	6.6
	<i>Өөрчлөлт</i>	-6.1	-1.4	8.1	-0.5
<b>Бүгд</b>	2005	40.0	8.0	45.5	6.6
	2006	38.6	6.5	49.7	5.1
	<i>Өөрчлөлт</i>	-1.4	-1.5	4.2	-1.5

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банк, санхүүгийн байгууллагуудын тоо таны бодлоор гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 38.6 хувь нь олон (2005 оноос 1.4 нэгжээр буурсан), 6.5 хувь нь цөөн (2005 оноос 1.5 нэгжээр буурсан), 49.7 хувь нь боломжийн (2005 оноос 4.2 нэгжээр өссөн), 5.1 хувь нь мэдэхгүй (2005 оноос 1.5 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Олон гэсэн хариулт улсын байгууллагад ажиллагсад болон ажилгүй иргэдийн хувьд 2005 онтой харьцуулахад 1.0 нэгжээр өссөн бол ажил эрхлэлтийн бусад бүлгүүдийн хувьд буурсан байна. Харин цөөн гэсэн хариулт бүх бүлгүүдийн хувьд 0.8-2.2 нэгжээр буурсан бол боломжийн гэсэн хариулт бүх бүлгүүдийн хувьд 2005 онтой харьцуулахад 2.0-8.1 нэгжээр нэмэгдсэн байна.

**Хүснэгт V.4.2 Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа таны бодлоор**

		Найдвартай	Найдваргүй	Эргэлзээтэй	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	46.2	5.7	39.7	8.4
	2006	50.5	6.4	36.4	6.6
	<i>Өөрчлөлт</i>	4.3	0.7	-3.3	-1.8
<b>Хувийн байгууллагад</b>	2005	50.0	6.1	36.2	7.8
	2006	59.6	6.5	29.1	4.7
	<i>Өөрчлөлт</i>	9.6	0.4	-7.1	-3.1
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	45.7	5.8	38.0	10.6
	2006	51.1	6.5	36.5	6.0
	<i>Өөрчлөлт</i>	5.4	0.7	-1.5	-4.6
<b>Ажилгүй</b>	2005	35.3	8.7	40.9	15.1
	2006	38.2	12.1	38.6	11.2
	<i>Өөрчлөлт</i>	2.9	3.4	-2.3	-3.9
<b>Бусад</b>	2005	42.1	7.3	40.3	10.3
	2006	45.6	7.7	40.4	6.4
	<i>Өөрчлөлт</i>	3.5	0.4	0.1	-3.9
<b>Бүгд</b>	2005	44.9	6.4	38.7	9.9
	2006	50.8	7.4	35.1	6.7
	<i>Өөрчлөлт</i>	5.9	1.0	-3.6	-3.2

Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа таны бодлоор гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 50.8 хувь нь найдвартай (2005 оноос 5.9 нэгжээр өссөн), 7.4 хувь нь найдваргүй (2005 оноос 1.0 нэгжээр өссөн), 35.1 хувь нь эргэлзээтэй (2005 оноос 3.6 нэгжээр буурсан), 6.7 хувь нь мэдэхгүй (2005 оноос 3.2 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Найдвартай гэсэн хариулт судалгаанд хамрагдсан бүх иргэдийн хувьд 2005 онтой харьцуулахад 2.9-9.6 нэгжээр өссөн бол найдваргүй гэсэн хариулт бүх бүлгүүдийн хувьд 0.4-3.4 нэгжээр мөн өссөн байна. Харин бусад гэсэн бүлгийг эс тооцвол бүх бүлгүүдийн хувьд 2.3-7.1 нэгжээр буурсан байна.

#### Хүснэгт V.4.3 Банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл

		Нэмэгдсэн	Буурсан	Хэвэндээ	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	45.1	8.3	37.4	9.2
	2006	42.8	9.7	40.8	6.6
	<i>Өөрчлөлт</i>	-2.3	1.4	3.4	-2.6
<b>Хувийн байгууллагад</b>	2005	49.8	8.7	31.9	9.6
	2006	51.6	8.6	34.2	5.6
	<i>Өөрчлөлт</i>	1.8	-0.1	2.3	-4.0
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	42.7	8.3	37.1	11.8
	2006	41.7	11.6	37.6	9.1
	<i>Өөрчлөлт</i>	-1.0	3.3	0.5	-2.7
<b>Ажилгүй</b>	2005	34.4	13.5	33.9	18.2
	2006	31.3	15.8	37.5	15.4
	<i>Өөрчлөлт</i>	-3.1	2.3	3.6	-2.8
<b>Бусад</b>	2005	43.7	9.6	33.0	13.7
	2006	37.9	12.1	39.0	11.0
	<i>Өөрчлөлт</i>	-5.8	2.5	6.0	-2.7
<b>Бүгд</b>	2005	43.9	9.4	34.9	11.7
	2006	42.8	10.9	37.8	8.5
	<i>Өөрчлөлт</i>	-1.1	1.5	2.9	-3.2

Банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 42.8 хувь нь нэмэгдсэн (2005 оноос 1.1 нэгжээр буурсан), 10.9 хувь нь буурсан (2005 оноос 1.5 нэгжээр өссөн), 37.8 хувь нь хэвэндээ (2005 оноос 2.9 нэгжээр өссөн), 8.5 хувь нь мэдэхгүй (2005 оноос 3.2 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Нэмэгдсэн гэсэн хариулт хувийн байгууллагад ажиллагсадын хувьд 2005 онтой харьцуулахад 1.8 нэгжээр өссөн бол бусад бүлгүүдийн хувьд буурсан байна. Харин буурсан гэсэн хариулт нь хувийн байгууллагад ажиллагсадын хувьд буурсан бол ажил эрхлэлтийн бусад бүлгүүдийн хувьд 2005 онтой харьцуулахад 1.5-3.3 нэгжээр өссөн байна. Судалгаанд хамрагдсан бүх бүлгүүдийн хувьд хэвэндээ гэсэн хариулт 2005 онтой харьцуулахад 0.5-6.0 нэгжээр нэмэгдсэн байна.

#### Хүснэгт V.4.4 Банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа

		Сурталчилж чадаж байна	Сурталчилж чадахгүй байна	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	65.4	22.5	12.0
	2006	65.7	23.1	11.3
	<i>Өөрчлөлт</i>	0.3	0.6	-0.7
<b>Хувийн байгууллагад</b>	2005	72.6	17.0	10.5
	2006	70.8	19.0	10.2
	<i>Өөрчлөлт</i>	-1.8	2.0	-0.3
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	64.5	19.6	15.9
	2006	61.9	25.4	12.8
	<i>Өөрчлөлт</i>	-2.6	5.8	-3.1
<b>Ажилгүй</b>	2005	60.8	20.2	19.0
	2006	57.8	21.3	20.9
	<i>Өөрчлөлт</i>	-3.0	1.1	1.9
<b>Бусад</b>	2005	64.8	19.3	15.9
	2006	62.5	22.8	14.7
	<i>Өөрчлөлт</i>	-2.3	3.5	-1.2
<b>Бүгд</b>	2005	66.2	19.8	14.0
	2006	64.8	22.2	13.0
	<i>Өөрчлөлт</i>	-1.4	2.4	-1.0

Банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж чадаж байна уу гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 64.8 хувь нь чадаж байна (2005 оноос 1.4 нэгжээр буурсан), 22.2 хувь нь чадахгүй байна (2005 оноос 2.4 нэгжээр өссөн), 13.0 хувь нь мэдэхгүй (2005 оноос 2.9 нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ. Сурталчилж чадаж байна гэсэн хариулт 2005 онтой харьцуулахад улсын байгууллагад ажилладаг иргэдийг эс тооцвол бүх бүлгүүдийн хувьд 1.8-3.0 нэгжээр буурсан байна. Харин бүх бүлгүүдийн хувьд сурталчилж чадахгүй байна гэсэн хариулт 0.6-3.5 нэгжээр өссөн байна.

#### Хүснэгт V.4.5 Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ

		Хэвийн	Чирэгдэлтэй	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	59.8	30.9	9.3
	2006	57.7	35.7	6.6
	<i>Өөрчлөлт</i>	-2.1	4.8	-2.7
<b>Хувийн байгууллагад</b>	2005	65.4	24.0	10.6
	2006	64.2	27.5	8.3
	<i>Өөрчлөлт</i>	-1.2	3.5	-2.3
<b>Хувиараа хөдөлмөр</b>	2005	58.3	30.1	11.6
	2006	56.8	33.6	9.6

эрхэлдэг	Өөрчлөлт	-1.5	3.5	-2.0
	2005	48.5	32.5	19.0
Ажилгүй	2006	46.4	36.0	17.6
	Өөрчлөлт	-2.1	3.5	-1.4
Бусад	2005	52.5	29.8	17.7
	2006	54.8	28.2	17.1
Бүгд	Өөрчлөлт	2.3	-1.6	-0.6
	2005	58.5	29.1	12.4
	2006	57.3	32.6	10.1
	Өөрчлөлт	-1.2	3.5	-2.3

Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ ямар байна гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 57.3 хувь нь хэвийн (2005 оноос 1.2 нэгжээр буурсан), 32.6 хувь нь чирэгдэлтэй (2005 оноос 3.5 нэгжээр өссөн), 10.1 хувь нь мэдэхгүй (2005 оноос 2.3 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Хэвийн бусад гэсэн бүлгийг эс тооцвол бүх бүлгүүдийн хувьд 1.2-2.1 нэгжээр буурсан байна. Харин бусад гэсэн бүлгийн иргэдийн хувьд хэвийн гэсэн хариулт 2.3 нэгжээр нэмэгдсэн байна. Чирэгдэлтэй гэсэн хариулт бусад гэсэн бүлгийг эс тооцвол бүх бүлгүүдийн хувьд 3.5-4.8 нэгжээр тус тус өссөн байна. Харин бусад гэсэн бүлгийн хувьд чирэгдэлтэй гэсэн хариулт 1.6 хувиар буурсан байна.

#### Хүснэгт V.4.6 Мөнгөний хэрэгцээ гарвал та хаашаа хандах вэ

		Банк	ББСБ	ХЗХ	Ломбард	Хувь хүн	Бусад
Улсын байгууллагад	2005	67.3	9.0	10.2	19.0	26.9	6.6
	2006	70.7	4.6	5.2	15.9	24.7	4.8
	Өөрчлөлт	3.4	-4.4	-5.0	-3.1	-2.2	-1.8
Хувийн байгууллагад	2005	65.0	6.5	8.6	17.5	26.6	5.9
	2006	68.5	7.0	5.2	16.3	21.8	4.9
	Өөрчлөлт	3.5	0.5	-3.4	-1.2	-4.8	-1.0
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	2005	65.9	8.4	10.5	18.2	26.8	5.9
	2006	68.0	4.6	5.1	14.4	23.5	4.8
	Өөрчлөлт	2.1	-3.8	-5.4	-3.8	-3.3	-1.1
Ажилгүй	2005	44.4	7.3	7.9	30.4	34.4	10.0
	2006	50.2	4.7	5.2	25.3	26.0	6.8
	Өөрчлөлт	5.8	-2.6	-2.7	-5.1	-8.4	-3.2
Бусад	2005	42.2	6.7	7.1	27.4	32.7	13.1
	2006	49.3	3.6	6.0	21.8	29.1	12.7
	Өөрчлөлт	7.1	-3.1	-1.1	-5.6	-3.6	-0.4
Бүгд	2005	60.6	7.8	9.2	21.0	28.5	7.4
	2006	64.9	5.2	5.3	17.5	24.2	5.7
	Өөрчлөлт	4.3	-2.6	-3.9	-3.5	-4.3	-1.7

Мөнгөний хэрэгцээ гарвал та хаашаа хандах вэ гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 64.9 хувь нь банк (2005 оноос 4.3 нэгжээр өссөн), 5.2 хувь нь ББСБ (2005 оноос 2.6 нэгжээр буурсан), 5.3 хувь нь ХЗХ (2005 оноос 3.9 нэгжээр буурсан), 17.5 хувь нь ломбард (2005 оноос 3.5 нэгжээр буурсан), 24.2 хувь нь хувь хүн (2005 оноос 4.3 нэгжээр буурсан), 5.7 хувь нь бусад (2005 оноос 1.7 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. 2005 онтой харьцуулахад банкнаас мөнгөний хэрэгцээгээ хангах нь ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд нэмэгдсэн байна. Хувийн байгууллагад ажилладаг иргэдийг эс тооцвол ББСБ-аас мөнгөний хэрэгцээгээ хангах явдал буурсан байна. Мөн ХЗХ, Ломбард, Хувь хүн болон бусад

эх үүсвэрээс мөнгөнийхөө хэрэгцээг хангах явдал хөдөлмөр эрхлэлтийн бүхий л бүлгүүдийн хувьд 2005 онтой харьцуулахад буурсан байна.

**Хүснэгт V.4.7 Та банк бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг үү**

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	37.6	59.2	3.2
	2006	29.8	67.8	2.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>-7.8</i>	<i>8.6</i>	<i>-0.8</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	37.9	59.2	2.9
	2006	27.9	69.5	2.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>-10.0</i>	<i>10.3</i>	<i>-0.3</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	42.9	52.5	4.6
	2006	32.6	64.8	2.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>-10.3</i>	<i>12.3</i>	<i>-2.0</i>
<b>Ажилгүй</b>	2005	34.5	60.3	5.2
	2006	29.4	64.3	6.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-5.1</i>	<i>4.0</i>	<i>1.1</i>
<b>Бусад</b>	2005	32.3	62.2	5.5
	2006	26.0	69.2	4.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>-6.3</i>	<i>7.0</i>	<i>-0.7</i>
<b>Бүгд</b>	2005	37.9	58.2	3.9
	2006	29.5	67.2	3.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-8.4</i>	<i>9.0</i>	<i>-0.6</i>

Та банк бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг үү гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 29.5 хувь нь тийм (2005 оноос 8.4 нэгжээр буурсан), 67.2 хувь нь үгүй (2005 оноос 9.0 нэгжээр өссөн), 3.3 хувь нь мэдэхгүй (2005 оноос 0.6 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. 2005 онтой харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн бүхий л бүлгийн хувьд ББСБ-аар үйлчлүүлэх явдал нэлээд хэмжээгээр багассан байна.

**Хүснэгт V.4.8 Та хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой юу**

		тийм	үгүй	мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	47.6	34.9	17.5
	2006	44.1	39.1	16.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>-3.5</i>	<i>4.2</i>	<i>-0.7</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	51.7	33.6	14.7
	2006	49.8	36.7	13.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.9</i>	<i>3.1</i>	<i>-1.2</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	45.4	35.0	19.6
	2006	36.1	44.9	19.1
	<i>Өөрчлөлт</i>	<i>-9.3</i>	<i>9.9</i>	<i>-0.5</i>
<b>Ажилгүй</b>	2005	36.4	41.6	22.0
	2006	30.2	49.4	20.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>-6.2</i>	<i>7.8</i>	<i>-1.6</i>
<b>Бусад</b>	2005	47.8	34.0	18.2
	2006	40.7	38.1	21.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-7.1</i>	<i>4.1</i>	<i>3.0</i>
<b>Бүгд</b>	2005	46.3	35.5	18.1
	2006	41.6	41.1	17.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.7</i>	<i>5.6</i>	<i>-0.8</i>

Та хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголттой юу гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 41.6 хувь нь тийм (2005 оноос 4.7 нэгжээр буурсан), 41.1 хувь нь үгүй (2005 оноос 5.6 нэгжээр өссөн), 17.3 хувь нь мэдэхгүй (2005 оноос 0.8 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. ХЗХ-ны талаарх иргэдийн ойлголт 2005 оноос 2006 онд ажил эрхлэлтийн бүхий л бүлгүүдийн хувьд багассан байна. 2005 онд ХЗХ-ны талаар харьцангуй ойлголт сайтай нь хувийн байгууллагад ажиллагсад байсан бол 2006 онд ч мөн адил өөрчлөгдөөгүй байна.

**Хүснэгт V.4.9 Та хадгаламж зээлийн хоршооны гишүүн мөн үү**

		Тийм	Үгүй	мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	13.2	81.3	5.4
	2006	10.3	87.1	2.6
	<i>Өөрчлөлт</i>	-2.9	5.8	-2.8
<b>Хувийн байгууллагад</b>	2005	11.9	84.5	3.5
	2006	10.7	86.8	2.5
	<i>Өөрчлөлт</i>	-1.2	2.3	-1.0
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	15.2	78.9	5.9
	2006	11.3	85.5	3.2
	<i>Өөрчлөлт</i>	-3.9	6.6	-2.7
<b>Ажилгүй</b>	2005	9.5	84.4	6.1
	2006	7.3	88.1	4.6
	<i>Өөрчлөлт</i>	-2.2	3.7	-1.5
<b>Бусад</b>	2005	11.7	84.2	4.1
	2006	8.4	88.4	3.1
	<i>Өөрчлөлт</i>	-3.3	4.2	-1.0
<b>Бүгд</b>	2005	12.6	82.4	5.1
	2006	10.0	86.9	3.0
	<i>Өөрчлөлт</i>	-2.6	4.5	-2.1

Та хадгаламж зээлийн хоршооны гишүүн мөн үү гэсэн асуултанд нийт түүврийн 10.0 хувь нь тийм (2005 оноос 2.6 нэгжээр буурсан), 86.9 хувь нь үгүй (2005 оноос 4.5 нэгжээр өссөн), 3.0 хувь нь мэдэхгүй (2005 оноос 2.1 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. ХЗХ-ны гишүүн байх нь 2005 онтой харьцуулахад ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд багассан байна. 2005 онд хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд ХЗХ-ны гишүүн байх явдал бусад бүлгээс харьцангуй их байсан бол 2006 онд ч дээрх үр дүн өөрчлөгдөөгүй байна.

**Хүснэгт V.4.10 Та хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ**

		Зөв, хуулийн дагуу	Буруу, хууль бус	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	33.8	11.0	55.3
	2006	21.6	27.5	50.9
	<i>Өөрчлөлт</i>	-12.2	16.5	-4.4
<b>Хувийн байгууллагад</b>	2005	33.9	12.8	53.3
	2006	23.2	31.3	45.6
	<i>Өөрчлөлт</i>	-10.7	18.5	-7.7
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	31.6	9.5	58.9
	2006	20.7	27.7	51.6
	<i>Өөрчлөлт</i>	-10.9	18.2	-7.3
<b>Ажилгүй</b>	2005	28.7	12.3	59.0
	2006	17.0	31.0	51.9
	<i>Өөрчлөлт</i>	-11.7	18.7	-7.1

<b>Бусад</b>	2005	30.8	10.6	58.6
	2006	21.8	30.5	47.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>-9.0</i>	<i>19.9</i>	<i>-10.9</i>
<b>Бүгд</b>	2005	32.2	11.3	56.5
	2006	21.1	29.3	49.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>-11.1</i>	<i>18.0</i>	<i>-6.9</i>

Та хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 21.1 хувь нь зөв хуулийн дагуу (2005 оноос 11.1 нэгжээр буурсан), 29.3 хувь нь буруу, хууль бус (2005 оноос 18.0 нэгжээр өссөн), 49.6 хувь нь мэдэхгүй (2005 оноос 6.9 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариулт буурснаас харвал ажил эрхлэлтийн хэлбэрээс үл хамааран бүх иргэд ХЗХ-ны үйл ажиллагааг дүгнэх чадамжтай болсон байна. Харин иргэд дүгнэхдээ ажил эрхлэлтийн байдлаас үл хамааран буруу хууль бус гэж дүгнэж байна.

**Хүснэгт V.4.11 Таны бодлоор гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь**

		Ач холбогдолтой	Ач холбогдолгүй	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	46.2	18.8	34.9
	2006	45.4	22.1	32.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.8</i>	<i>3.3</i>	<i>-2.4</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	48.2	23.7	28.1
	2006	44.2	26.6	29.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.0</i>	<i>2.9</i>	<i>1.1</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	48.0	17.0	35.0
	2006	43.5	23.3	33.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.5</i>	<i>6.3</i>	<i>-1.8</i>
<b>Ажилгүй</b>	2005	44.1	19.1	36.9
	2006	37.6	21.6	40.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>-6.5</i>	<i>2.5</i>	<i>3.9</i>
<b>Бусад</b>	2005	43.9	21.1	35
	2006	37.1	28.3	34.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>-6.8</i>	<i>7.2</i>	<i>-0.3</i>
<b>Бүгд</b>	2005	46.5	20	33.5
	2006	42.9	23.9	33.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-3.6</i>	<i>3.9</i>	<i>-0.3</i>

Таны бодлоор гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь ач холбогдолтой юу гэсэн асуултанд нийт түүврийн 42.9 хувь нь ач холбогдолтой (2005 оноос 3. нэгжээр буурсан), 23.9 хувь нь үгүй (2005 оноос 3. нэгжээр өссөн), 33.2 хувь нь мэдэхгүй (2005 оноос 0.3 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Мэдэхгүй гэсэн хариулт бага ч гэсэн буурсан (хувийн байгууллагад ажиллагсад болон ажилгүйчүүдийн хувьд өссөн) нь иргэдийн гадны банк санхүүгийн байгууллагын ач холбогдолыг ойлгож дүгнэх чадвар харьцангуй дээшилснийг харуулж байна. Судалгаанд оролцсон ажил эрхлэлтийн бүх бүлгийн иргэд ач холбогдолгүй гэж дүгнэсэн байна.

**Хүснэгт V.4.12 Та бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү**

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	21.2	71.3	7.4
	2006	35.6	60.9	3.5



	<i>Өөрчлөлт</i>	14.4	-10.4	-3.9
<b>Хувийн байгууллагад</b>	2005	32.3	62.2	5.6
	2006	46.4	50.4	3.2
	<i>Өөрчлөлт</i>	14.1	-11.8	-2.4
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	18.3	72.4	9.3
	2006	21.0	72.6	6.3
	<i>Өөрчлөлт</i>	2.7	0.2	-3.0
<b>Ажилгүй</b>	2005	11.2	78.1	10.6
	2006	15.9	77.5	6.7
	<i>Өөрчлөлт</i>	4.7	-0.6	-3.9
<b>Бусад</b>	2005	17.7	72.4	9.9
	2006	18.6	73.6	7.8
	<i>Өөрчлөлт</i>	0.9	1.2	-2.1
<b>Бүгд</b>	2005	21.4	70.5	8.1
	2006	31.3	64.0	4.8
	<i>Өөрчлөлт</i>	9.9	-6.5	-3.3

Та бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 31.3 хувь нь тийм (2005 оноос 9.9 нэгжээр өссөн), 64.0 хувь нь үгүй (2005 оноос 6.5 нэгжээр буурсан), 4.8 хувь нь мэдэхгүй (2005 оноос 3.3 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. 2005 онтой харьцуулахад бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох карт хэрэглэгчдийн тоо ажилгүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд харьцангуй багаар, бусад бүлгийнхний хувьд нэлээд хэмжээгээр нэмэгдсэн байна.

## V. 5. Хадгаламж хуримтлал

Хүснэгт V.5.1 Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ

		Банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг	Бусад зээлдүүлдэг	Худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг	Үнэт цаасанд байршуулдаг	Хувьцаа худалдаж авдаг	Бусад байдалаар зарцуулдаг
<b>Улсын байгууллагад</b>	2005	37.5	10.8	20.4	1.3	1.3	39.4
	2006	41.3	7.9	16.6	1.2	1.7	38.5
	<i>Өөрчлөлт</i>	3.8	-2.9	-3.8	-0.1	0.4	-0.9
<b>Хувийн байгууллагад</b>	2005	40.0	8.3	26.7	0.9	1.2	34.1
	2006	46.1	7.4	21.7	1.6	2.8	29.8
	<i>Өөрчлөлт</i>	6.1	-0.9	-5.0	0.7	1.6	-4.3
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	23.0	7.3	60.9	1.2	1.4	19.1
	2006	26.0	8.5	61.9	1.9	2.0	13.0
	<i>Өөрчлөлт</i>	3.0	1.2	1.0	0.7	0.6	-6.1
<b>Ажилгүй</b>	2005	20.4	7.9	25.6	1.8	2.7	48.5
	2006	27.7	7.4	24.8	2.6	2.8	39.7
	<i>Өөрчлөлт</i>	7.3	-0.5	-0.8	0.8	0.1	-8.8
<b>Бусад</b>	2005	28.5	9.6	13.2	2.6	2.1	54.1
	2006	32.7	6.5	14.4	1.4	2.3	50.3
	<i>Өөрчлөлт</i>	4.2	-3.1	1.2	-1.2	0.2	-3.8
<b>Бүгд</b>	2005	31.5	8.9	30.7	1.4	1.6	36.5
	2006	36.7	7.7	28.7	1.7	2.3	31.7
	<i>Өөрчлөлт</i>	5.2	-1.2	-2.0	0.3	0.7	-4.8

Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 36.7 хувь нь банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг (2005 оноос 5.2 нэгжээр өссөн), 7.7 хувь нь бусад зээлдүүлдэг (2005 оноос 1.2 нэгжээр буурсан), 28.7 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг (2005 оноос 2.0 нэгжээр буурсан), 1.7 хувь нь үнэт цаасанд байршуулдаг (2005 оноос 0.3 нэгжээр өссөн), 2.3 хувь нь хувьцаа худалдаж авдаг (2005 оноос 0.7 нэгжээр өссөн), 31.7 хувь нь бусад байдлаар зарцуулдаг (2005 оноос 4.8 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. 2005 онтой харьцуулахад банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг гэсэн хариулт ажил эрхлэлтийн бүлгээс үл хамааран нэмэгдсэн нь банкинд итгэх итгэл сайжирч байгааг, үнэт цаасанд байршуулдаг, хувьцаа худалдан авдаг гэсэн хариулт бага нэгжээр ч гэсэн нэмэгдсэн нь манай улсын үнэт цаасны зах зээлд нааштай үр дүн гарч байгааг харуулж байна.

**Хүснэгт V.5.2 Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ**

		Бэлэн мөнгө	Бэлэн бус	Үнэт цаас	Хувьцаа	Бусад
<b>Улсын байгууллагад</b>	2005	68.3	18.7	5.6	4.2	15.4
	2006	67.9	16.5	4.7	3.1	12.1
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.4</i>	<i>-2.2</i>	<i>-0.9</i>	<i>-1.1</i>	<i>-3.3</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	65.5	21.6	4.5	3.6	12.7
	2006	64.9	21.0	4.0	5.9	10.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.6</i>	<i>-0.6</i>	<i>-0.5</i>	<i>2.3</i>	<i>-2.2</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	73.1	13.8	5.0	3.8	15.1
	2006	71.5	14.3	3.6	3.5	11.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.6</i>	<i>0.5</i>	<i>-1.4</i>	<i>-0.3</i>	<i>-3.3</i>
<b>Ажилгүй</b>	2005	70.9	9.7	3.3	4.2	17.2
	2006	73.8	8.5	3.7	4.0	13.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>2.9</i>	<i>-1.2</i>	<i>0.4</i>	<i>-0.2</i>	<i>-3.6</i>
<b>Бусад</b>	2005	66	13.7	4.7	3.3	19.6
	2006	65.5	12.6	4.0	5.8	18.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.5</i>	<i>-1.1</i>	<i>-0.7</i>	<i>2.5</i>	<i>-1.4</i>
<b>Бүгд</b>	2005	68.8	16.6	4.7	3.9	15.3
	2006	68.6	15.8	4.1	4.2	12.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.2</i>	<i>-0.8</i>	<i>-0.6</i>	<i>0.3</i>	<i>-3.0</i>

Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 68.6 хувь нь бэлэн мөнгөөр (2005 оноос 0.2 нэгжээр буурсан), 15.8 хувь нь бэлэн бусаар (2005 оноос 0.8 нэгжээр буурсан), 4.1 хувь нь үнэт цаасаар (2005 оноос 0.6 нэгжээр буурсан), 4.2 нь хувьцаагаар (2005 оноос 0.3 нэгжээр өссөн), 12.3 хувь нь бусад (2005 оноос 3.0 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Ажил эрхлэлтийн бүлгээр задалж үзвэл мөнгөө байршуулах хэлбэрийн 2005 онтой харьцуулсан өөрчлөлт нь иргэдийн ажил эрхлэлтийн байдлаас хамаарын харилцан адилгүй байна. Тухайлбал, бэлэн мөнгөөр байршуулах явдал ажилгүй иргэдийн хувьд өссөн байхад бусад бүлгүүдийн хувьд буурсан байна. Бэлэн бус хэлбэрт байршуулах нь зөвхөн хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд л өссөн байна. Харин үнэт цаас хэлбэрт байршуулдаг гэсэн хариулт нь ажилгүй иргэдийн хувьд өссөн байхад хувьцаа хэлбэрээр байршуулна гэсэн хариулт нь бусад гэсэн бүлэг болон хувийн байгууллагад ажилладаг иргэдийн хувьд өссөн байна.

**Хүснэгт V.5.3 Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ**

	Төгрөг	Ам.доллар	Бусад валютаар
--	--------	-----------	-------------------

<b>Улсын байгууллагад</b>	2005	89.6	5.6	4.8
	2006	90.8	7.2	4.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.2</i>	<i>1.6</i>	<i>0.0</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	90.5	5.8	3.7
	2006	90.9	8.7	3.1
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.4</i>	<i>2.9</i>	<i>-0.6</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	87.1	8.6	4.3
	2006	88.7	10.4	3.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.6</i>	<i>1.8</i>	<i>-0.5</i>
<b>Ажилгүй</b>	2005	86.7	6.3	7.0
	2006	86.7	9.4	6.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.0</i>	<i>3.1</i>	<i>-0.4</i>
<b>Бусад</b>	2005	86.3	5.4	8.3
	2006	87.3	7.2	7.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.0</i>	<i>1.8</i>	<i>-0.6</i>
<b>Бүгд</b>	2005	88.6	6.3	5
	2006	89.5	8.6	4.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.9</i>	<i>2.3</i>	<i>-0.4</i>

Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан иргэдийн 89.5 хувь нь төгрөгөөр (2005 оноос 0.9 нэгжээр өссөн), 8.6 хувь нь ам доллараар (2005 оноос 2.3 нэгжээр өссөн), 4.6 хувь нь бусад валютаар (2005 оноос 0.4 нэгжээр буурсан) гэж тус тус хариулсан байна. Иргэдийн хувьд ажил эрхлэлтийн байдлаас үл хамааран төгрөг болон ам.доллороор хадгалах нь нэмэгдсэн байна. Гэвч ам.доллороор хадгална гэсэн хариулт харьцангуй өндөр нэгжээр өссөн байна. Харин ажил эрхлэлтийн ихэнх бүлгүүдийн хувьд бусад валютаар хадгална гэсэн хариулт 2005 онтой харьцуулахад буурсан байна.

#### Хүснэгт V.5.4 Хадгаламжийн хүү таны бодлоор

		Бага байна	Боломжийн байна	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	65.8	23.7	10.4
	2006	61.3	26.5	12.2
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.5</i>	<i>2.8</i>	<i>1.8</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	55.9	32.4	11.7
	2006	54.1	35.2	10.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.8</i>	<i>2.8</i>	<i>-1.0</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	54.8	29.1	16.0
	2006	57.1	28.3	14.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>2.3</i>	<i>-0.8</i>	<i>-1.4</i>
<b>Ажилгүй</b>	2005	50.4	27.6	22.1
	2006	53.0	25.1	21.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>2.6</i>	<i>-2.5</i>	<i>-0.2</i>
<b>Бусад</b>	2005	54.8	23.2	22
	2006	49.2	29.9	20.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>-5.6</i>	<i>6.7</i>	<i>-1.1</i>
<b>Бүгд</b>	2005	57.6	27.6	14.8
	2006	56.4	29.2	14.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.2</i>	<i>1.6</i>	<i>-0.4</i>

Хадгаламжийн хүү таны бодлоор гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 56.4 хувь нь бага байна (2005 оноос 1.2 нэгжээр буурсан), 29.2 хувь нь боломжийн (2005 оноос 1.6 нэгжээр өссөн), 14.4 хувь нь мэдэхгүй (2005 оноос 0.4 нэгжээр буурсан) гэж тус тус хариулсан байна. Хадгаламжийн хүү бага байна гэсэн хариулт хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд болон ажилгүйчүүдийн хувьд 2.3-2.6 нэгжээр өссөн бол боломжийн гэсэн хариулт ажил эрхлэлтийн бусад бүлгүүдийнх нь хувьд нэмэгдсэн байна.

## V. 6. Зээлийн талаар

### Хүснэгт V.6.1 Танд зээлийн хэрэгцээ байдаг уу

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	86.1	11.9	2.0
	2006	86.4	11.4	2.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.3</i>	<i>-0.5</i>	<i>0.3</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	84.6	13.2	2.2
	2006	84.9	13.5	1.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.3</i>	<i>0.3</i>	<i>-0.6</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	85.2	11.1	3.7
	2006	83.0	14.4	2.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>-2.2</i>	<i>3.3</i>	<i>-1.2</i>
<b>Ажилгүй</b>	2005	80.1	15.7	4.1
	2006	77.0	17.3	5.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>-3.1</i>	<i>1.6</i>	<i>1.6</i>
<b>Бусад</b>	2005	72.9	22.1	5.1
	2006	69.4	25.3	5.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>-3.5</i>	<i>3.2</i>	<i>0.2</i>
<b>Бүгд</b>	2005	83.5	13.5	3.0
	2006	82.6	14.5	2.9
	<i>Өөрчлөлт</i>	<i>-0.9</i>	<i>1.0</i>	<i>-0.1</i>

Танд зээлийн хэрэгцээ байдаг уу гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 82.6 хувь нь тийм (2005 оноос 0.9 нэгжээр буурсан), 14.5 хувь нь үгүй (2005 оноос 1.0 нэгжээр өссөн), 2.9 хувь нь мэдэхгүй (2005 оноос 0.1 нэгжээр буурсан) гэж тус тус хариулсан байна. Улсын байгууллагад ажилладаг иргэдээс бусад иргэдийн хувьд зээлийн хэрэгцээ багассан үр дүн харагдаж байна. Өөрөөр хэлбэл үгүй гэсэн хариулт улсын байгууллагад ажиллагсадаас бусад бүлгийн хувьд 2005 онтой харьцуулахад өссөн байна.

### Хүснэгт V.6.2 Зээл хүртээмжтэй юу

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	46.1	38.3	15.6
	2006	48.4	34.8	16.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>2.3</i>	<i>-3.5</i>	<i>1.1</i>
<b>Хувийн байгууллагад</b>	2005	45.9	35.7	18.3
	2006	47.4	35.5	17.1
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.5</i>	<i>-0.2</i>	<i>-1.2</i>
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	46.7	36.9	16.3
	2006	44.0	38.4	17.6
	<i>Өөрчлөлт</i>	<i>-2.7</i>	<i>1.5</i>	<i>1.3</i>
<b>Ажилгүй</b>	2005	28.8	46.0	25.3
	2006	27.9	45.9	26.2

	<i>Өөрчлөлт</i>	-0.9	-0.1	0.9
<b>Бусад</b>	2005	31.0	36.8	32.2
	2006	31.7	37.3	31.0
	<i>Өөрчлөлт</i>	0.7	0.5	-1.2
<b>Бүгд</b>	2005	42.1	38.5	19.4
	2006	42.9	37.6	19.5
	<i>Өөрчлөлт</i>	0.8	-0.9	0.1

Зээл хүртээмжтэй юу гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 42.9 хувь нь тийм (2005 оноос 0.8 нэгжээр өссөн), 37.6 хувь нь үгүй (2005 оноос 0.9 нэгжээр буурсан), 19.5 хувь нь мэдэхгүй (2005 оноос 0.1 нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ. 2005 онтой харьцуулахад зээл хүртээмжтэй байдаг гэсэн хариулт хувиараа хөдөлмөр эрхэлдэг болон ажилгүй иргэдийн хувьд буурсан байна.

#### Хүснэгт V.6.3 Зээл авахад таны бодлоор хэцүү юу

		Хүндрэлгүй	Хүндрэлтэй	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	42.3	45.9	11.8
	2006	43.0	47.7	9.2
	<i>Өөрчлөлт</i>	0.7	1.8	-2.6
<b>Хувийн байгууллагад</b>	2005	41.3	44.6	14.1
	2006	42.2	46.9	10.8
	<i>Өөрчлөлт</i>	0.9	2.3	-3.3
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	40.5	46.9	12.5
	2006	36.1	51.2	12.7
	<i>Өөрчлөлт</i>	-4.4	4.3	0.2
<b>Ажилгүй</b>	2005	27.1	50.7	22.2
	2006	27.1	54.8	18.1
	<i>Өөрчлөлт</i>	0.0	4.1	-4.1
<b>Бусад</b>	2005	30.6	45.6	23.7
	2006	29.7	47.7	22.6
	<i>Өөрчлөлт</i>	-0.9	2.1	-1.1
<b>Бүгд</b>	2005	38.3	46.5	15.1
	2006	38.0	49.3	12.7
	<i>Өөрчлөлт</i>	-0.3	2.8	-2.4

Зээл авахад таны бодлоор хэцүү юу гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 38.0 хувь нь хүндрэлгүй (2005 оноос 0.3 нэгжээр буурсан), 49.3 хувь нь хүндрэлтэй (2005 оноос 2.8 нэгжээр өссөн), 12.7 хувь нь мэдэхгүй (2005 оноос 2.4 нэгжээр буурсан) гэж тус тус хариулсан байна. 2005 онтой харьцуулахад хүндрэлгүй гэсэн хариулт улсын байгууллагад ажиллагсад болон хувийн байгууллагад ажиллагсадын хувьд нэмэгдсэн байна. Харин хүндрэлтэй гэсэн хариулт ажил эрхлэлтийн байдлаас үл хамааран 1.8-4.3 нэгжээр нэмэгдсэн байна. Мэдэхгүй гэсэн хариулт хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийг эс тооцвол 2005 онтой харьцуулахад буурсан байна.

#### Хүснэгт V.6.4 Зээлийн хүүгийн талаар таны бодол

		Өндөр	Боломжийн	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	74.2	18.3	7.6
	2006	75.1	18.7	6.3
	<i>Өөрчлөлт</i>	0.9	0.4	-1.3
<b>Хувийн</b>	2005	68.2	23.4	8.4

<b>байгууллагад</b>	2006	72.1	21.8	6.1
	<i>Өөрчлөлт</i>	3.9	-1.6	-2.3
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	67.4	23.3	9.3
	2006	72.4	20.2	7.4
	<i>Өөрчлөлт</i>	5.0	-3.1	-1.9
<b>Ажилгүй</b>	2005	69.9	16.6	13.6
	2006	67.2	18.4	14.4
	<i>Өөрчлөлт</i>	-2.7	1.8	0.8
<b>Бусад</b>	2005	62.7	18.7	18.7
	2006	61.1	23.3	15.6
	<i>Өөрчлөлт</i>	-1.6	4.6	-3.1
<b>Бүгд</b>	2005	69.6	20.4	10.1
	2006	71.5	20.1	8.4
	<i>Өөрчлөлт</i>	1.9	-0.3	-1.7

Зээлийн хүүгийн талаар таны бодол гэсэн асуултанд нийт санал асуулгад оролцогчдын 71.5 хувь нь өндөр (2005 оноос 1.9 нэгжээр өссөн), 20.1 хувь нь боломжийн (2005 оноос 0.3 нэгжээр буурсан), 8.4 хувь нь мэдэхгүй (2005 оноос 1.7 нэгжээр буурсан) гэж тус тус хариулсан байна. Зээлийн хүү өндөр гэсэн хариулт ажилгүй болон бусад гэсэн бүлэгт хамаарагдах иргэдийн хувьд буурсан бол боломжийн гэсэн хариулт улсын байгууллагад ажиллагсад, ажилгүйчүүд, бусад гэсэн бүлэгт хамаарагдах иргэдийн хувьд өссөн байна.

## V. 7. Бичил санхүүгийн талаар

### Хүснэгт V.7.1 Та бичил санхүүгийн талаар ойлголттой юу

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	2005	74.5	14.2	11.3
	2006	71.3	16.9	11.9
	<i>Өөрчлөлт</i>	-3.2	2.7	0.6
<b>Хувийн байгууллагад</b>	2005	73.1	15.1	11.8
	2006	72.9	17.5	9.6
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	2.4	-2.2
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	63.7	18.6	17.7
	2006	60.0	24.7	15.3
	<i>Өөрчлөлт</i>	-3.7	6.1	-2.4
<b>Ажилгүй</b>	2005	55.0	24.8	20.2
	2006	48.6	31.0	20.4
	<i>Өөрчлөлт</i>	-6.4	6.2	0.2
<b>Бусад</b>	2005	57.7	22.9	19.5
	2006	56.5	29.6	13.9
	<i>Өөрчлөлт</i>	-1.2	6.7	-5.6
<b>Бүгд</b>	2005	67.3	17.8	14.9
	2006	64.9	21.7	13.4
	<i>Өөрчлөлт</i>	-2.4	3.9	-1.5

Та бичил санхүүгийн талаар ойлголттой юу гэсэн асуултанд нийт түүврийн 64.9 хувь нь тийм (2005 оноос 2.4 нэгжээр буурсан), 21.7 хувь нь үгүй (2005 оноос 3.9 нэгжээр өссөн), 13.4 хувь нь мэдэхгүй (2005 оноос 1.5 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Ажил эрхлэлтээр авч үзвэл улсын болон хувийн байгууллагад ажиллагчид, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс харьцангуй илүү ойлголттой

байна. Гэвч 2005 онтой харьцуулахад бичил санхүүгийн талаархи ойлголт ажил эрхлэлтийн байдлаас үл хамааран буурсан байгааг дурьдах хэрэгтэй.

**Хүснэгт V.7.2 Таны оршин сууж байгаа газарт бичил санхүүгийн үйл ажиллагаа хэр хөгжсөн бэ**

		Сайн	Дунд зэрэг	Огт хөгжөөгүй	Мэдэхгүй
Улсын байгууллагад	2005	26.2	44.7	11.8	17.2
	2006	26.9	45.5	11.2	16.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.7</i>	<i>0.8</i>	<i>-0.6</i>	<i>-0.8</i>
Хувийн байгууллагад	2005	29.2	45.4	9.2	16.2
	2006	30.9	46.4	7.9	14.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>1.7</i>	<i>1.0</i>	<i>-1.3</i>	<i>-1.4</i>
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	2005	28.2	52.5	19.3	29.4
	2006	20.6	41.7	15.5	22.1
	<i>Өөрчлөлт</i>	<i>-7.6</i>	<i>-10.8</i>	<i>-3.8</i>	<i>-7.3</i>
Ажилгүй	2005	24.3	52.3	23.5	37.4
	2006	13.9	41.0	15.1	30.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>-10.4</i>	<i>-11.3</i>	<i>-8.4</i>	<i>-7.4</i>
Бусад	2005	24.4	57	18.7	38.6
	2006	19.3	43.7	13.5	23.5
	<i>Өөрчлөлт</i>	<i>-5.1</i>	<i>-13.3</i>	<i>-5.2</i>	<i>-15.1</i>
Бүгд	2005	24	42.6	12.8	20.6
	2006	24.2	44.1	12.0	19.7
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.2</i>	<i>1.5</i>	<i>-0.8</i>	<i>-0.9</i>

Таны оршин сууж байгаа газарт бичил санхүүгийн үйл ажиллагаа хэр хөгжсөн бэ гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 24.2 хувь нь сайн (2005 оноос 0.2 нэгжээр өссөн), 44.1 хувь нь дунд зэрэг (2005 оноос 1.5 нэгжээр өссөн), 12.0 хувь нь огт хөгжөөгүй (2005 оноос 0.8 нэгжээр буурсан), 19.7 хувь нь мэдэхгүй (2005 оноос 0.9 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Бичил санхүүгий үйл ажиллагаа сайн хөгжсөн гэж хувийн байгууллагад ажиллагсад хамгийн ихээр хариулсан бол огт хөгжөөгүй гэж хамийн их хариулсан нь хувиараа хөдөлмөр эрхлэгсэд байлаа.

**Хүснэгт V.7.3 Танд бичил зээл авах боломж бий юу**

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
Улсын байгууллагад	2005	65.3	19	15.8
	2006	64.3	18.6	17.0
	<i>Өөрчлөлт</i>	<i>-1.0</i>	<i>-0.4</i>	<i>1.2</i>
Хувийн байгууллагад	2005	64.7	19.8	15.4
	2006	64.8	21.9	13.3
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.1</i>	<i>2.1</i>	<i>-2.1</i>
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	2005	60.9	20.1	19.1
	2006	53.9	24.4	21.8
	<i>Өөрчлөлт</i>	<i>-7.0</i>	<i>4.3</i>	<i>2.7</i>
Ажилгүй	2005	44.7	35.2	20.1
	2006	40.1	35.7	24.1
	<i>Өөрчлөлт</i>	<i>-4.6</i>	<i>0.5</i>	<i>4.0</i>
Бусад	2005	44.5	30.1	25.4
	2006	44.5	30.1	25.4
	<i>Өөрчлөлт</i>	<i>0.0</i>	<i>0.0</i>	<i>0.0</i>
Бүгд	2005	59.1	23	17.8
	2006	59.1	23	17.8

2006	57.2	24.1	18.7
Өөрчлөлт	-1.9	1.1	0.9

Танд бичил зээл авах боломж бий юу гэсэн асуултыг судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 57.2 хувь нь тийм (2005 оноос 1.9 нэгжээр буурсан), 24.1 хувь нь үгүй (2005 оноос 1.1 нэгжээр өссөн), 18.7 хувь нь мэдэхгүй (2005 оноос 0.9 нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ. 2005 онтой харьцуулахад бичил зээл авах боломж байхгүй гэсэн хариулт зөвхөн улсын байгууллагад ажиллагсадын хувьд л буурсан байна.

**Хүснэгт V.7.4 Хэрвээ бичил зээл авч ашигладаг бол ямар бизнес эрхэлдэг вэ**

		Газар тариалан	Хүнсний ногоо	Мал аж ахуй	Худалдаа наймаа	Жижиг, дунд үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Зочид буудал	Үйлчилгээ	Бусад
<b>Улсын байгууллагад</b>	2005	7.6	9.7	9.8	30.6	13.1	5.6	2.9	8.9	35.6
	2006	9.5	10.7	9.5	29.0	11.7	3.4	1.7	8.1	36.6
	Өөрчлөлт	1.9	1.0	-0.3	-1.6	-1.4	-2.2	-1.2	-0.8	1.0
<b>Хувийн байгууллагад</b>	2005	6.5	7.9	8.2	35.4	14.6	4.8	1.8	10.8	32.5
	2006	8.4	7.9	9.0	33.3	12.5	4	1.5	9.6	33
	Өөрчлөлт	1.9	0.0	0.8	-2.1	-2.1	-0.8	-0.3	-1.2	0.5
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	6.7	7.4	10.5	54.1	17.4	4.6	2.3	10.8	11.4
	2006	8.6	6.9	9.3	56.2	16.1	2.6	1.2	8.8	11.4
	Өөрчлөлт	1.9	-0.5	-1.2	2.1	-1.3	-2.0	-1.1	-2.0	0.0
<b>Ажилгүй</b>	2005	10	8.9	14.2	33.8	14.9	4	1.9	9.5	27.3
	2006	11.3	11.0	16.2	33.7	14.8	1.8	2.1	9.7	19.5
	Өөрчлөлт	1.3	2.1	2.0	-0.1	-0.1	-2.2	0.2	0.2	-7.8
<b>Бусад</b>	2005	7.8	6.4	11.6	22.7	12.2	5	3.3	8.3	42.7
	2006	6.2	8.8	11.0	27.2	11.3	5.9	2.3	10.5	37.7
	Өөрчлөлт	-1.6	2.4	-0.6	4.5	-0.9	0.9	-1.0	2.2	-5.0
<b>Бүгд</b>	2005	7.5	8.4	10.4	36.8	14.6	4.9	2.4	9.8	28.7
	2006	9.0	9.1	10.4	36.6	13.3	3.3	1.6	9.1	27.6
	Өөрчлөлт	1.5	0.7	0.0	-0.2	-1.3	-1.6	-0.8	-0.7	-1.1

Хэрвээ бичил зээл авч ашигладаг бол ямар бизнес эрхэлдэг вэ гэсэн асуултанд 9.0 хувь нь газар тариалан (2005 оноос 1.5 нэгжээр өссөн), 9.1 хувь нь хүнсний ногоо (2005 оноос 0.7 нэгжээр өссөн), 10.4 хувь нь мал аж ахуй (2005 оноос өөрчлөгдөөгүй), 36.6 хувь нь худалдаа наймаа (2005 оноос 0.2 нэгжээр буурсан), 13.3 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл (2005 оноос 1.3 нэгжээр буурсан), 3.3 хувь нь аялал жуулчлал (2005 оноос 1.6 нэгжээр буурсан), 1.6 хувь нь зочид буудал (2005 оноос 0.8 нэгжээр буурсан), 9.1 хувь нь үйлчилгээ (2005 оноос 0.7 нэгжээр буурсан), 27.6 хувь нь бусад (2005 оноос 1.1 нэгжээр буурсан) гэж тус тус хариулжээ. Ажил эрхлэлтийн байдлаар задалж үзвэл Мал аж ахуй, хүнсний ногоо, газар тариалангийн бизнесийг ажилгүй иргэд, худалдаа наймаа, жижиг дунд үйлдвэрлэлийн бизнесийг хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд, аялал жуулчлал, зочид буудал, үйлчлгээний бизнесийг бусад төрлийн хөдөлмөр эрхэлдэг иргэд тус тус хамгийн ихээр эрхэлдэг байна.

**Хүснэгт V.7.5 Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний төгрөг шаардагдах вэ**

<100 мянга	100–250 мянга	250–500 мянга	0.5-1 сая	1–1,5 сая	1.5–2 сая
------------	---------------	---------------	-----------	-----------	-----------



<b>Улсын байгууллагад</b>	2005	5.2	7.7	14.1	24.7	13.8	65.5
	2006	5.0	6.7	14.9	20.7	15.9	36.9
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	-1.0	0.8	-4.0	2.1	-28.6
<b>Хувийн байгууллагад</b>	2005	4.6	6.8	16.6	22.5	14.5	64.9
	2006	2.9	7.2	14.0	22.5	15	38.4
	<i>Өөрчлөлт</i>	-1.7	0.4	-2.6	0.0	0.5	-26.5
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	5	6.1	13.8	16.8	14.6	56.4
	2006	4.0	6.0	11.8	21.2	13.1	44
	<i>Өөрчлөлт</i>	-1.0	-0.1	-2.0	4.4	-1.5	-12.4
<b>Ажилгүй</b>	2005	6.4	9.2	17.5	19.8	16	68.9
	2006	6.2	10.4	17.3	19.1	15.1	31.9
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	1.2	-0.2	-0.7	-0.9	-37.0
<b>Бусад</b>	2005	7.7	8.7	16.4	23.7	16.1	72.6
	2006	5.6	9.9	12.6	21.7	15	35.1
	<i>Өөрчлөлт</i>	-2.1	1.2	-3.8	-2.0	-1.1	-37.5
<b>Бүгд</b>	2005	5.4	7.5	15.4	21.6	14.7	64.6
	2006	4.4	7.5	14.2	21.1	14.9	37.9
	<i>Өөрчлөлт</i>	-1.0	0.0	-1.2	-0.5	0.2	-26.7

Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэсэн асуултанд ихэнх буюу 37.9 хувь нь 1.5-2 сая төгрөг (2005 оноос 26.7 нэгжээр буурсан), 14.9 хувь нь 1-1.5 сая төгрөг (2005 оноос 0.2 нэгжээр өссөн), 21.1 хувь нь 0.5-1 сая төгрөг (2005 оноос 0.5 нэгжээр буурсан), 14.2 хувь нь 250-500 мянган төгрөг (2005 оноос 1.2 нэгжээр буурсан), 7.5 хувь нь 100-250 мянган төгрөг (2005 оноос өөрчлөгдөөгүй), 4.4 хувь нь 100 мянгаас бага төгрөгийн (2005 оноос 1.0 нэгжээр буурсан) эх үүсвэр гэж тус тус хариулжээ. Ажил эрхлэлтийн бүлгээс үл хамааран 1.5-2 саяын хэмжээтэй зээлийн эх үүсвэр хэрэгтэй гэсэн хариулт нэлээд өндөр нэгжээр 2005 онтой харьцуулахад буурсан байна. 100 мянга хүртэлх зээлийн эх үүсвэр гэсэн хариулт бүх бүлгүүдийн хувьд буурсан бол 100-250 мянган төгрөгийн эх үүсвэр гэсэн хариулт улсын байгууллагад ажиллагсад болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд буурсан байна. 250-500 мянган төгрөгийн эх үүсвэр гэсэн хариулт зөвхөн улсын байгууллагад ажиллагсадын хувьд, 500-1000 мянган төгрөгийн эх үүсвэр гэсэн хариулт зөвхөн хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд өсч бусад бүлгүүдийн буурсан байна. 1-1.5 сая төгрөгийн эх үүсвэр гэсэн хариултын хувьд хувиараа хөдөлмөр эрхлэгсэд болон бусад гэсэн бүлгийн хувьд буурсан бол бусад бүлгүүдийн хувьд өссөн байна.

**Хүснэгт V.7.6 Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар хугацаа шаардагдах вэ**

		3 сар	3-6 сар	6-9 сар	9-12 сар
		хүртэл			
<b>Улсын байгууллагад</b>	2005	6.2	13.3	16	64.5
	2006	7.6	12.3	15.9	64.1
	<i>Өөрчлөлт</i>	1.4	-1.0	-0.1	-0.4
<b>Хувийн байгууллагад</b>	2005	7.4	16.4	17.8	58.4
	2006	7.0	13.5	17.1	62.4
	<i>Өөрчлөлт</i>	-0.4	-2.9	-0.7	4.0
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	2005	8	13.3	16.4	62.3
	2006	8.4	14.0	17.0	60.6
	<i>Өөрчлөлт</i>	0.4	0.7	0.6	-1.7
<b>Ажилгүй</b>	2005	7.7	14.4	16.4	61.6
	2006	8.5	15.3	17.5	58.6
	<i>Өөрчлөлт</i>	0.8	0.9	1.1	-3.0
<b>Бусад</b>	2005	12.4	17.9	19.8	49.9

Бүгд	2006	12.2	18.6	18.8	50.4
	<i>Өөрчлөлт</i>	-0.2	0.7	-1.0	0.5
	2005	7.7	14.6	16.9	60.8
	2006	8.1	13.9	16.9	61.2
	<i>Өөрчлөлт</i>	0.4	-0.7	0.0	0.4

Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар хугацаа шаардагдах вэ гэсэн асуултанд дийлэнх буюу 61.2 хувь нь 9-12 сар (2005 оноос 0.4 нэгжээр өссөн), 16.9 хувь нь 6-9 сар (2005 оноос өөрчлөгдөөгүй), 13.9 хувь нь 3-6 сар (2005 оноос 0.7 нэгжээр буурсан), 8.1 хувь нь 3 сар хүртэл (2005 оноос 0.4 нэгжээр өссөн) гэж тус тус хариулжээ. Улсын байгууллагад ажиллагсдын хувьд 3 хүртэлх сарын эрэлт, хувийн байгууллагад ажиллагсдын хувьд 9-12 сарын эрэлт, бусад гэсэн бүлгийн хувьд 3-6, 9-12 сарын эрэлт нэмэгдсэн байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгсэд болон ажилгүйчүүдийн хувьд 9-12 сарын эрэлт буурсан байна.

**Хүснэгт V.7.7 Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад банк санхүүгийн байгууллагын зүгээс ямар бэрхшээл байна вэ**

		Зээлийн хүү өндөр	Зээлийн хэмжээ бага	Зээл авах боломжгүй	Зээлийн хугацаа богино	Бусад
Улсын байгууллагад	2005	62	10	8.3	13.2	6.4
	2006	68.2	20.7	10.8	25.4	7.5
	<i>Өөрчлөлт</i>	6.2	10.7	2.5	12.2	1.1
Хувийн байгууллагад	2005	56.5	11	10	14.7	7.9
	2006	64.4	20.4	14.7	25.3	7.1
	<i>Өөрчлөлт</i>	7.9	9.4	4.7	10.6	-0.8
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	2005	58.7	11.6	7.6	14.7	7.4
	2006	65.9	23.0	12.1	24.2	6.7
	<i>Өөрчлөлт</i>	7.2	11.4	4.5	9.5	-0.7
Ажилгүй	2005	53.4	9.5	18.2	11.4	7.4
	2006	54.3	15.2	24.6	22.5	10.3
	<i>Өөрчлөлт</i>	0.9	5.7	6.4	11.1	2.9
Бусад	2005	53.4	8.8	10.6	13	14.2
	2006	56.6	15.3	15.3	23.8	16.4
	<i>Өөрчлөлт</i>	3.2	6.5	4.7	10.8	2.2
Бүгд	2005	57.8	10.5	10.5	13.5	7.8
	2006	63.8	19.9	14.6	24.5	8.3
	<i>Өөрчлөлт</i>	6.0	9.4	4.1	11.0	0.5

Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад банк санхүүгийн байгууллагын зүгээс ямар бэрхшээл байна вэ гэсэн асуултанд нийт түүврийн ихэнх буюу 63.8 хувь нь зээлийн хүү өндөр (2005 оноос 6.0 нэгжээр өссөн) 19.9 хувь нь зээлийн хэмжээ бага (2005 оноос 9.4 нэгжээр өссөн), 14.6 хувь нь зээл авах боломжгүй (2005 оноос 4.1 нэгжээр өссөн), 24.5 хувь нь зээлийн хугацаа богино (2005 оноос 11.0 нэгжээр өссөн), 8.3 хувь нь бусад (2005 оноос 0.5 нэгжээр өссөн) гэж тус тус хариулсан байна. Дээрх бүх бэрхшээлүүд ажил эрхлэлтийн байдлаас үл хамааран 2005 онтой харьцуулахад өссөн байна.

## V.8 Мөнгөн дэвсгэртийн талаар

**Хүснэгт V.8.1 Танд 1-г болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байдаг уу?**

	тийм	үгүй	мэдэхгүй
Улсын байгууллагад	23.5	69.3	7.2
Хувийн байгууллагад	26.1	67.5	6.4

<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	25.8	66.0	8.2
<b>Ажилгүй</b>	29.3	59.0	11.7
<b>Бусад</b>	25.6	63.6	10.8
<b>Бүгд</b>	25.7	66.1	8.1

Танд 1-т болон 5-тын дэвсгэртийн хэрэгцээ байдаг уу? гэсэн асуултанд нийт иргэдийн 25.7 хувь нь тийм, 66.1 хувь нь үгүй, 8.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Ажил эрхлэлтийн байдлаас онцын ялгаа харагдахгүй байна. Тийм гэж хариулсан хамгийн өндөр хувь нь ажилгүйчүүд бол үгүй гэж хариулсан хамгийн өндөр хувь нь улсын байгууллагад ажиллагсад байна.

**Хүснэгт V.8.2 Танд 50, 100, 200, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу?**

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	31.7	55.8	12.5
<b>Хувийн байгууллагад</b>	28.7	62.0	9.4
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	27.3	58.9	13.8
<b>Ажилгүй</b>	34.4	48.9	16.6
<b>Бусад</b>	36.0	50.8	13.3
<b>Бүгд</b>	30.7	56.7	12.6

Танд 50, 100, 200, 500-тын зоосон мөнгөний хэрэгцээ байдаг уу? гэсэн асуултанд нийт иргэдийн 30.7 хувь нь тийм, 56.7 хувь нь үгүй, 12.6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Ажил эрхлэлтийн байдлаас онцын ялгаа харагдахгүй байна. Дээрх зоосон мөнгөнүүд бусад гэсэн бүлгийн иргэдэд харьцангуй хамгийн их хэрэгцээтэй бол хувийн байгууллагад ажилладаг иргэдийн хувьд илүү хэрэгцээ багатай байдаг байна.

**Хүснэгт V.8.3 Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа юу?**

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	37.7	51.3	11.0
<b>Хувийн байгууллагад</b>	36.9	52.8	10.3
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	37.6	51.2	11.2
<b>Ажилгүй</b>	32.8	50.0	17.2
<b>Бусад</b>	35.0	54.1	10.9
<b>Бүгд</b>	36.5	51.7	11.8

Удахгүй гүйлгээнд гарах 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй мөнгөн тэмдэгтийн хэрэгцээ байгаа юу? гэсэн асуултанд нийт иргэдийн 36.5 хувь нь тийм, 51.7 хувь нь үгүй, 11.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Ажил эрхлэлтийн байдлаас онцын ялгаа харагдахгүй байна. Дээрх дэвсгэрт улсын байгууллагад ажиллагсад болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдэд харьцангуй хамгийн их хэрэгцээтэй байгаа бол ажилгүй иргэдийн хувьд хэрэгцээ харьцангуй багатай байна.

**Хүснэгт V.8.4 Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг уу?**

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	77.9	13.8	8.3
<b>Хувийн байгууллагад</b>	74.8	15.9	9.3
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	73.4	14.6	12.0
<b>Ажилгүй</b>	70.4	15.7	13.8
<b>Бусад</b>	74.8	13.6	11.6

<b>Бүгд</b>	74.8	14.8	10.4
-------------	------	------	------

Гүйлгээнд байгаа төгрөгийн дэвсгэртийн хийц дизайн таалагддаг уу? гэсэн асуултанд 74.8 хувь нь тийм, 14.8 хувь нь үгүй, 10.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Ажил эрхлэлтийн бүлгүүдийн хувьд том ялгаа харагдахгүй байна.

**Хүснэгт V.8.5 Таны 10, 20, 50, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддагуу?**

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	74.5	19.6	5.8
<b>Хувийн байгууллагад</b>	72.4	21.6	6.1
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	71.3	22.6	6.1
<b>Ажилгүй</b>	70.0	22.0	8.1
<b>Бусад</b>	72.6	20.6	6.7
<b>Бүгд</b>	72.5	21.2	6.4

Таны 10, 20, 50, 100-тын дэвсгэртийн хэрэгцээ хангагддаг уу? гэсэн асуултанд нийт иргэдийн 72.5 хувь нь тийм, 21.2 хувь нь үгүй, 6.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Ажил эрхлэлтийн байдлаас том ялгаа харагдахгүй байгаа боловч дээрх дэвсгэртүүд улсын байгууллагад ажилладаг иргэдэд харьцангуй хамгийн их хэрэгцээтэй байгаа бол мөн улсын байгууллагад ажилладаг иргэдийн хувьд илүү хэрэгцээ багатай байна.

**Хүснэгт V.8.6 Та гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг үү?**

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	49.2	39.3	11.5
<b>Хувийн байгууллагад</b>	40.5	48.9	10.7
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	46.8	42.4	10.8
<b>Ажилгүй</b>	47.9	37.1	15.0
<b>Бусад</b>	47.2	37.6	15.2
<b>Бүгд</b>	46.0	42.0	11.9

Та гүйлгээнд байгаа дэвсгэртүүдийг эдэлгээ даах чанартай гэж үздэг үү? гэсэн асуултанд нийт иргэдийн 46.0 хувь нь тийм, 42.0 хувь нь үгүй, 11.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Харин хувийн байгууллагад ажилладаг иргэд хамгийн ихээр эдэлгээ даах чадваргүй гэж хариулсан байна.

**Хүснэгт V.8.7 Та хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг уу?**

	тийм	үгүй	мэдэхгүй
<b>Улсын байгууллагад</b>	25.4	61.0	13.6
<b>Хувийн байгууллагад</b>	32.6	56.2	11.2
<b>Хувиараа хөдөлмөр эрхэлдэг</b>	23.3	62.5	14.2
<b>Ажилгүй</b>	19.5	64.0	16.5
<b>Бусад</b>	17.1	60.4	22.5
<b>Бүгд</b>	25.4	60.4	14.1

Та хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар сонирхсон мэдээллээ харилцагч банкнаас авч чаддаг уу? гэсэн асуултанд нийт иргэдийн 25.4 хувь нь тийм, 60.4 хувь нь үгүй, 14.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Харин хувийн байгууллагад ажилладаг иргэд хамгийн ихээр авч чаддаг гэж хариулсан бол ажилгүйчүүд хамгийн ихээр чаддаггүй гэж хариулсан байна.

#### Хүснэгт V.8.8 Та мөнгөө түрийвчэнд хийж цэвэрхэн авч явдаг уу?

	тийм	үгүй	мэдэхгүй
Улсын байгууллагад	88.1	9.1	2.8
Хувийн байгууллагад	86.1	10.1	3.8
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	87.2	9.2	3.7
Ажилгүй	81.6	13.7	4.7
Бусад	82.9	13.5	3.6
Бүгд	86	10.4	3.6

Та мөнгөө түрийвчэнд хийж цэвэрхэн авч явдаг уу? гэсэн асуултанд нийт иргэдийн 86 хувь нь тийм, 10.4 хувь нь үгүй, 3.6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Харин улсын байгууллагад ажилладаг иргэд хамгийн ихээр тийм гэж хариулсан бол мөн л улсын байгууллагад ажилладаг иргэд хамгийн ихээр үгүй гэж хариулсан байна.

#### Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдлыг сайжирч байна, өргөн хэрэглээний барааны үнэ буурч байна гэсэн хандлага 2005 онтой харьцуулахад ерөнхийдөө нэмэгдсэн байна. Гэвч хувийн байгууллагад ажилладаг иргэд болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд эдийн засгийн байдлыг сайжирч байна гэсэн хандлага буурсан байна. Эдийн өсөлтийг хангахын тулд хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд зээлийн хүүг бууруулахыг бусдаас эрхэмлэсэн бол ажил эрхлэлтийн бусад бүлгүүд үндэсний үйлдвэрлэлээ дэмжихэд илүү ач холбогдол өгсөн байна. 2005 онтой харьцуулахад иргэдийн хувьд уул уурхай салбар эдийн засгийг түргэн хөгжүүлнэ гэсэн хандлага нэлээд нэмэгдсэн байна.

Иргэд өөрийн өрхийн амьжиргааны түвшинг ажил эрхлэлтийн бүлгээс үл хамааран хэвэндээ байна гэсэн давамгайлал хэвээр хадгалагдсан боловч муудаж байна гэсэн хариулт ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд 2005 онтой харьцуулахад буурсан байна. Иргэд ажилгүйдэл, ядуурлын түвшинг дүгнэхдээ нэмэгдсэн гэсэн хандлага давамгайлж байгаа хэдий ч 2005 онтой харьцуулахад багассан байгаа нь сайшаалтай. Газар хувьчлалыг дэмжиж байна гэсэн хандлага 60 орчим хувийг эзэлсээр байгаа боловч ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд 2005 онтой харьцуулахад буурсан байна.

Татварын түвшин өндөр боловч татварын ачааллыг 2005 онтой харьцуулахад ажил эрхлэлтийн бүлгүүд бүгд буурч байна гэж дүгнэсэн байна. Татвараас зайлсхийх явдал ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн 60-70 орчим хувь нь нийтлэг гэж дүгнэсэн байна. Ялангуяа иргэдийн хувьд хувийн байгууллагад ажиллагсад хамгийн ихээр нийтлэг гэж дүгнэсэн байна. 2005 онтой харьцуулахад ч энэ хариулт нэмэгдсэн байна.

Банк санхүүгийн байгууллагын талаар иргэд банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл улсын байгууллагад ажиллагсадыг эс тооцвол ажил эрхлэлтийн ихэнх бүлгүүдийн хувьд өмнөх онтой харьцуулахад буурсан нь банк санхүүгийн байгууллагууд өөрийн үйл ажиллагааг сурталчилж чадахгүй байгаатай холбоотой гэж дүгнэж болохоор байна. Хэдийгээр ажил эрхлэлтийн ихэнх бүлгүүдийн (бусад гэсэн бүлэг тооцохгүйгээр) хувьд банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээний чирэгдэл гэсэн хандлага өссөн боловч мөнгөний хэрэгцээгээ банкнаас хангах явдал 2005 онтой харьцуулахад өссөн байна. ББСБ, ХЗХ-нд хандах иргэдийн хандлага, түүнд итгэх итгэл ажил эрхлэлтийн бүлгээс үл хамааран өмнөх жилтэй

харьцуулахад муудсан байна. Гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэхийг ач холбогдолгүй гэсэн хандлага нийт санал асуулгын дүнд бага хувь эзэлж байгаа боловч 2005 онтой харьцуулахад бүх бүлгүүдийн хувьд өссөн үр дүн харагдаж байна. Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээ 2005 онтой харьцуулахад нэлээд нэмэгдсэн байна. Ялангуяа улсын болон хувийн байгууллагад ажилладаг иргэдийн хувьд энэ бүтээгдэхүүний хэрэглээ эрс нэмэгдсэн байна.

Хуримтлуулсан мөнгөө зарцуулахад иргэдийн ажил эрхлэлтийн байдал нэлээд хүчтэй нөлөөлж байна. Тухайлбал, улсын болон хувийн байгууллагад ажилладаг иргэд банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг бол хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг гэж хариулсан байна. Харин ажилгүйчүүд болон бусад гэсэн бүлгийн иргэд өөр байдлаар зарцуулдаг байна. Бэлэн мөнгөөр мөнгөө байршуулах явдал ажилгүйчүүдийн бүлгийг эс тооцвол бусад бүлгүүдийн хувьд нэлээд багассан байна.

2005 онтой харьцуулахад зээлийн хэрэгцээ багассан боловч хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүйчүүдийн хувьд зээлийн хүртээмж багассан бөгөөд зээл авахад хүнтрэлтэй гэсэн хариулт ажил эрхлэлтийн бүлгээс үл хамааран нэлээд хэмжээгээр нэмэгдсэн байна. Харин зээлийн хүүг өндөр гэсэн хариулт ажилгүйчүүд болон бусад гэсэн бүлгийн хувьд өссөн боловч бусад бүлгүүдийн хувьд буурсан байна.

Бичил санхүүгийн талаар ажилгүй иргэдийн нэлээд нь ойлголтгүй байгаа бол улсын болон хувийн байгууллагад ажиллаж буй иргэдийн ихэнх нь ойлголттой байгаа боловч ажил эрхлэлтийн бүх бүлгүүдийн хувьд ойлголтгүй иргэдийн тоо өссөн байна. Бичил санхүүгий үйл ажиллагааны хөгжлийг ажил эрхлэлтийн байдлаас хамааран нэлээд өөрөөр дүгнэсэн байна. Тухайлбал, 2005 онтой харьцуулахад улсын болон хувийн байгууллагад ажилладаг иргэдийн хувьд сайн гэсэн үнэлгээ нэмэгдсэн байхад огт хөгжөөгүй гэсэн хариулт бүх бүлгүүдийн хувьд багассан байна. Харин бичил зээл авах боломж ажил эрхлэлтийн дийлэнх бүлгүүдийн хувьд ялангуяа ажилгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, улсын байгууллагад ажилладаг иргэдийн хувьд нэлээд багассан үр дүн харагдаж байна.

Мөнгөн дэвсгэртийн хувьд бага нэгжийн дэвсгэртүүд ажил эрхлэлтийн байдлаас хамаарахгүйгээр иргэдийн хэрэгцээг хангаж чадаж байгаа бөгөөд 20000-тын дэвсгэртээс илүү дүнтэй дэвсгэртийн хэрэгцээ судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 30 гаруй хувьд нь байгаа гэсэн үр дүн харагдаж байна. Харин мөнгөн дэвсгэртийн загвар дизайн эдэлгээ даах чадварыг иргэд харьцангуй сайн үнэлж байна.